

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 35
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	36 - 186
1. <i>Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай</i> Улсын Их Хурлын тогтоолын төсөл	37 - 39
2. <i>“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”</i> Улсын Их Хурлын тогтоолын төсөл	39 - 40
3. <i>Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	40 - 81
4. <i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/</i>	81 - 126
5. <i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	126 - 145
6. <i>Хуулийн төслүүдийг эцэслэн батална.</i>	145 - 147
7. <i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/</i>	147 - 167
8. <i>“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”</i> Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/	168 - 186

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 08-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны
товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 78 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, А.Ариунзаяа, Б.Дэлгэрсайхан, Д.Жаргалсайхан, О.Саранчулуун, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Р.Батболд, Б.Заяабал, Л.Оюун-Эрдэнэ, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга, Х.Болормаа, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, С.Одонтуяа;

Тасалсан: Д.Батбаяр, С.Лүндэг;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан – 1 цаг 35 минут, Т.Аубакир – 23 минут, Б.Батбаатар – 04 минут, Н.Батсүмбэрэл – 04 минут, Э.Болормаа – 14 минут, Ж.Галбадрах – 10 минут, А.Ганбаатар – 03 минут, Д.Ганбат – 10 минут, Л.Гантөмөр – 14 минут, Ц.Даваасүрэн – 38 минут, Т.Доржханд – 09 минут, Б.Жавхлан – 27 минут, Б.Жаргалан – 03 минут, Н.Номтойбаяр – 01 минут, Ц.Туваан – 03 минут, Б.Түвшин – 32 минут, Г.Тэмүүлэн – 04 минут, Х.Тэмүүжин – 03 минут, А.Ундраа – 03 минут, Ч.Ундрам – 06 минут, Н.Учрал – 25 минут, Г.Уянгахшиг – 08 минут, Ж.Чинбүрэн – 4 цаг 22 минут, Ж.Энхбаяр – 59 минут, Р.Эрдэнэбүрэн – 1 цаг 11 минут,.

Нэг. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 31
Бүгд: 92
66.3 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Д.Амарбаясгалан: “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 33
Бүгд: 93
64.5 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, П.Батчимэг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Васгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн

дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт С.Төрмөнх, Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Л.Соронзонболд, Ж.Баярмаа, М.Бадамсүрэн, Д.Энхтүвшин, Н.Номтойбаяр, А.Ганбаатар, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, М.Нарантуяа-Нара, С.Цэнгүүн, П.Мөнхтулга, Ч.Анар, Г.Тэмүүлэн, Б.Батбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт С.Төрмөнх, Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Б.Пунсалмаа, Да.Цогтбаатар, Д.Ганмаа, С.Ганбаатар, Д.Соронзонболд, Л.Мөнхбаатар, Б.Жаргалан, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үдийн завсарлагагүйгээр хуралдааныг үргэлжлүүлэх талаар мэдэгдэж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлэн хуралдуулахаар тогтов.

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Ц.Идэрбат, Б.Уянга, Д.Бум-Очир, Н.Алтанхуяг, П.Мөнхтулга, Д.Үүрийнтуяа, М.Энхцэцэг, М.Мандхай, Д.Энхтүвшин нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 13 цаг 35 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт С.Төрмөнх, Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 14 цаг 16 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Д.Энхтүвшин, П.Сайнзориг, Г.Очирбат нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Ч.Анар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.5-д заасны дагуу Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор гар өргөж санал хураалт явуулав.

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.14 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.14.Энэ хуулийн 22.5.22-т заасан төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	68
Татгалзсан:	40
Бүгд:	108

63.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “38.6” дахь хэсэг нэмэх:

“38.6.Энэ хуулийн 38.4-т хамаарах боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гүрав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн 12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 40
Бүгд: 108
63.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Төслийн 1 дэх заалтын “2025 онд” гэсний дараа “4.0 их наяд хүртэл төгрөгтэй тэнцэх хэмжээний” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 62
Бүгд: 106
60.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Төсөлд доор дурдсан агуулгатай “1 дэх заалт” нэмэх:

“1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник-эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн

цахим сан бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

2/нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийн, аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, саналаа 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	78
Татгалзсан:	28
Бүгд:	106

73.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн

хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт С.Төрмөнх, Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3, 10 дугаар зүйлийн 10.2, 10.5-д заасны дагуу санал хураалт явуулав.

Нэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Д.Амарбаясгалан: 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 32
Бүгд: 106
69.8 хувийн буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Хоёр. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн:

Д.Амарбаясгалан: 1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 78
Татгалзсан: 28
Бүгд: 106
73.6 хувийн буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 77
Татгалзсан: 29
Бүгд: 106
72.6 хувийн буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

3. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 78
Татгалзсан: 28
Бүгд: 106

73.6 хувийн буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 27
Бүгд: 106

74.5 хувийн буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 30
Бүгд: 106

71.7 хувийн буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

6.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 32
Бүгд: 106

69.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

7.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 27
Бүгд: 106

74.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

8.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 78
Татгалзсан: 28
Бүгд: 106

73.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт С.Төрмөнх, Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1, 10 дугаар зүйлийн 10.2, 10.5-д заасны дагуу санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай

“НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ,

төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 32
Бүгд: 106
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “2 дугаар зүйл.Монгол Улсын 2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Монгол Улсын 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78
Татгалзсан: 28
Бүгд: 106
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан:

**“ХОЁРДУГААР БҮЛЭГ
МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХӨРӨНГӨ,
ӨРИЙН УДИРДЛАГА**

3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлого төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	185.0 185.0
2	Монгол Улсын Их Хурлын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.0 100.0
3	Монгол Улсын Ерөнхий сайд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	106,372.5 101,600.0 4,772.5
4	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	510.0 510.0

5	Монгол Улсын Ерөнхий аудитор Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	831.3 831.3
6	Төрийн албаны зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	200.0 200.0
7	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,000.0 4,000.0
8	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,388.3 2,388.3
9	Монгол Улсын Шадар сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	21,934.3 21,934.3
10	Монгол Улсын Шадар сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	115.9 115.9
11	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	300.0 300.0
12	Гадаад харилцааны сайд Дипломат төлөөлөгчийн газрууд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	16,100.0 13,000.0 3,100.0
13	Сангийн сайд Татварын ерөнхий газар үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	21,597,298.5 12,876,186.8 608,889.9 8,046,540.0 248,209.1 417,000.0 9,362.6
14	Хууль зүй, дотоод хэргийн сайд Улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар Шүүх шинжилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	81,156.8 45,730.0 2,370.0 300.0 1,052.5 31,704.4
15	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ашигт малтмал, газрын тосны газар Үндэсний геологийн алба Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	412,848.1 407,301.1 120.0 5,427.0
16	Батлан хамгаалахын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	43,187.2 43,187.2
17	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,320.7 2,320.7
18	Боловсролын сайд	5,534.8

	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,534.8
19	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	304.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	304.0
20	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	75,221.6
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	1,000.0
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	3,035.1
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	71,186.4
21	Зам, тээврийн сайд	110,656.0
	Иргэний нисэхийн ерөнхий газар	80,000.0
	Зам, тээврийн хөгжлийн яам	300.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	30,356.0
22	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	54,173.6
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	54,173.6
23	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	8,663.3
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,663.3
24	Эрүүл мэндийн сайд	7,945.3
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	7,945.3

” Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 37
Бүгд: 106
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “4 дүгээр зүйл.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого 23,140,589.3 сая төгрөг байна.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “5 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх үндсэн төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	387,133.9
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	20,600.7

3	Боловсролын сайд	30,000.0
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	17,499.1

” Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 30
Бүгд: 106
71.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “6 дугаар зүйл.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсөв зарцуулна:

6.1.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	39,753.6 38,753.6 1,000.0
2	Монгол Улсын Их Хурлын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	191,022.2 175,422.2 15,600.0
3	Монгол Улсын Ерөнхий сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	630,245.6 370,196.5 260,049.0
4	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Урсгал зардал	6,068.7 6,068.7
5	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Урсгал зардал Хөрөнгийн зардал	32,895.7 27,295.7 5,600.0
6	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	343,468.2 276,428.7 67,039.5
7	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	15,574.9 12,184.9 3,390.0
8	Улсын ерөнхий прокурор Урсгал зардал Хөрөнгийн зардал	161,897.3 131,095.6 30,801.7
9	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Урсгал зардал	23,320.2 23,320.2

10	Монгол Улсын Ерөнхий аудитор Урсгал зардал Хөрөнгийн зардал	56,839.7 54,066.2 2,773.5
11	Авлигатай тэмцэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	58,246.7 55,540.4 2,706.3
12	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	22,425.0 22,175.0 250.0
13	Төрийн албаны зөвлөлийн дарга Урсгал зардал	21,881.0 21,881.0
14	Үндэсний статистикийн хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	36,935.1 34,435.1 2,500.0
15	Сонгуулийн ерөнхий хорооны дарга Урсгал зардал	18,561.5 18,561.5
16	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Урсгал зардал	1,436.2 1,436.2
17	Шүүхийн сахилгын хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	6,440.5 6,140.5 300.0
18	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	328,824.2 126,178.7 202,645.5
19	Монгол Улсын Шадар сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	404,765.9 333,245.5 71,520.4
20	Монгол Улсын Шадар сайд Урсгал зардал	8,558.7 8,558.7
21	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	153,264.5 128,433.8 24,830.7
22	Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	24,107.4 19,291.2 4,816.2
23	Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Хөрөнгийн зардал	31,893.0 31,893.0
24	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	15,893.5

	Урсгал зардал	6,723.2
	Хөрөнгийн зардал	9,170.3
25	Гадаад харилцааны сайд	275,902.5
	Урсгал зардал	245,381.8
	Хөрөнгийн зардал	30,520.7
26	Сангийн сайд	5,778,970.6
	Урсгал зардал	2,925,807.6
	үүнээс: Зээлийн хүүгийн төлбөрт	1,303,370.7
	Хөрөнгийн зардал	227,163.0
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	2,626,000.0
27	Хууль зүй, дотоод хэргийн сайд	1,817,187.0
	Урсгал зардал	1,687,438.3
	Хөрөнгийн зардал	129,748.7
28	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	70,836.1
	Урсгал зардал	29,606.1
	Хөрөнгийн зардал	41,230.0
29	Батлан хамгаалахын сайд	853,371.5
	Урсгал зардал	769,029.4
	Хөрөнгийн зардал	84,342.1
30	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	337,772.2
	Урсгал зардал	246,282.4
	Хөрөнгийн зардал	91,489.8
31	Боловсролын сайд	4,573,880.2
	Урсгал зардал	4,074,286.7
	Хөрөнгийн зардал	499,593.5
32	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	4,556,107.0
	Урсгал зардал	4,501,834.7
	Хөрөнгийн зардал	54,272.3
33	Зам, тээврийн сайд	1,598,809.3
	Урсгал зардал	25,815.3
	Хөрөнгийн зардал	1,572,994.0
34	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	596,006.7
	Урсгал зардал	432,332.7
	Хөрөнгийн зардал	163,674.0
35	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	495,329.5
	Урсгал зардал	101,157.2
	Хөрөнгийн зардал	394,172.3
36	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	830,563.9
	Урсгал зардал	777,483.4
	Хөрөнгийн зардал	53,080.5
37	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	130,343.2
	Урсгал зардал	90,086.8
	Хөрөнгийн зардал	40,256.4
38	Эрчим хүчний сайд	310,328.5

“ИХ ХУРАЛДАЙ” ТАНХИМ

	Урсгал зардал	115,835.3
	Хөрөнгийн зардал	194,493.2
39	Эрүүл мэндийн сайд	1,857,765.2
	Урсгал зардал	1,660,125.6
	Хөрөнгийн зардал	197,639.6

6.2.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр доор дурдсан хэмжээтэй санхүүжилт олгоно:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	41,165.2
2	Боловсролын сайд	31,036.3
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	99,831.9
4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	5,000.0
5	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	45,985.7

” Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 44
Бүгд: 106
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “7 дугаар зүйл.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 26,485,278.0 сая төгрөг байна.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 44
Бүгд: 106
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “8 дугаар зүйл.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 3,932,432.9 сая төгрөгөөр санхүүжүүлнэ.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 41
Бүгд: 106
61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “**9 дүгээр зүйл.**”Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд 131,200.6 сая төгрөгийн эргэн төлөлт хийнэ.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 40
Бүгд: 106
62.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “**10 дугаар зүйл.** 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл 1,596,178.2 сая төгрөг байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2025 оны төсвийн жилд 608,889.9 сая төгрөг хуримтлуулна.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 40
Бүгд: 106
62.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “**11 дүгээр зүйл.**2025 оны төсвийн жилд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг доор дурдсанаар баталсугай:

11.1.Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.1, 12.1.3, 12.1.6 болон 28¹.1-д заасан зориулалтаар хийх гадаад, дотоод зээллэгийн дээд хэмжээг 300,000.0 сая төгрөг хүртэл;

11.2.Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 2,209,000.0 сая төгрөг хүртэл.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 38
Бүгд: 106
64.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “**12 дугаар зүйл.**Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2025 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 1,932,825.6 сая төгрөг байна.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 38
Бүгд: 106
64.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “13 дугаар зүйл.Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ 2025 оны төсвийн жилд 3,500,000.0 сая төгрөг байна.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 38
Бүгд: 106
64.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “14 дүгээр зүйл.Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2, 12.1.4-т заасан зориулалтаар Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 37
Бүгд: 106
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан:

**“ГУРАВДУГААР БҮЛЭГ
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ОРОН НУТГИЙН
ТӨСВӨӨС ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН
САН БОЛОН УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ
ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ**

15 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэг олгоно:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	52,186.4
2	Баян-Өлгий	34,200.2

3	Баянхонгор	41,955.9
4	Булган	24,117.3
5	Говь-Алтай	34,310.4
6	Дорнод	2,424.5
7	Дундговь	24,007.4
8	Завхан	53,371.4
9	Өвөрхангай	42,994.9
10	Сүхбаатар	28,334.3
11	Төв	9,001.9
12	Увс	42,073.9
13	Ховд	19,295.9
14	Хөвсгөл	60,435.3
15	Хэнтий	47,348.3
16	Говьсүмбэр	11,725.4
Нийт дүн		527,783.5

” Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “16 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Дорноговь	10,478.0
2	Өмнөговь	1,754,708.7
3	Сэлэнгэ	94.8
4	Дархан-Уул	1,362.8
5	Орхон	136,487.8
Нийт дүн		1,903,132.1

” Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 36
Бүгд: 106
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “17 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Аймаг, хот	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	14,505.7
2	Баян-Өлгий	14,026.3
3	Баянхонгор	23,502.4
4	Булган	15,258.1
5	Говь-Алтай	24,990.2
6	Дорноговь	55,686.9
7	Дорнод	30,428.3
8	Дундговь	18,250.4
9	Завхан	17,294.9
10	Өвөрхангай	17,299.9
11	Өмнөговь	60,770.5
12	Сүхбаатар	26,562.7
13	Сэлэнгэ	31,299.0
14	Төв	28,947.2
15	Увс	16,422.8
16	Ховд	30,475.8
17	Хөвсгөл	20,848.6
18	Хэнтий	23,761.1
19	Дархан-Уул	21,288.8
20	Улаанбаатар	60,333.0
21	Орхон	38,727.7
22	Говьсүмбэр	8,374.3
Нийт дүн		599,054.5

” Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан:

“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл.“Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 36
Бүгд: 106
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “**19 дүгээр зүйл.**“Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 36
Бүгд: 106
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “**20 дугаар зүйл.**“Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд эргэн төлөлт хийх концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “**21 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2, 10 дугаар зүйлийн 10.2, 10.5-д заасны дагуу санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 37

Бүгд: 106

65.1 хувийн буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1, 10 дугаар зүйлийн 10.2, 10.5-д заасны дагуу Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншин сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай

“НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгох, хуримтлал үүсгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 37

Бүгд: 106

65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “2 дугаар зүйл.Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 37

Бүгд: 106

65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан:

**“ХОЁРДУГААР БҮЛЭГ
ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ОРЛОГО**

3 дугаар зүйл. Үндэсний баялгийн санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхий сайд	507,114.8
	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	507,114.8
	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.2-г заасан уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ногдол ашиг	507,114.8
	Үүнээс: Хуримтлалын санд	507,114.8
2	Сангийн сайд	1,849,712.5
	Татварын ерөнхий газар	1,849,712.5
	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.а-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгээс 40 хувь	1,849,712.5
	Үүнээс: Ирээдүйн өв санд	1,849,712.5
	Нийт орлого	2,356,827.3

” Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 37

Бүгд: 106

65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “4 дүгээр зүйл.2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 3,687,339.3 сая төгрөг байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу Ирээдүйн өв санд 2025 оны төсвийн жилд 1,849,712.5 сая төгрөг хуримтлуулна.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 36
Бүгд: 106
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “5 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу Хуримтлалын санд 2025 оны төсвийн жилд 562,125.2 сая төгрөг хуримтлуулна.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 37
Бүгд: 106
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “6 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562,125.2 сая төгрөгөөр баталсугай.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 37
Бүгд: 106
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “7 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 37
Бүгд: 106
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 38
Бүгд: 106
64.2 хувийн буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1, 10 дугаар зүйлийн 10.2, 10.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншин сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай

“НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 36
Бүгд: 106
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 36
Бүгд: 106
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан:

“ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	6,943,759.9
1.1	Ажил олгогчийн төлөх шимтгэл	2,844,337.7
1.2	Ажиллагчдаас төлөх шимтгэл	2,291,157.4
1.3	Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл	14,543.1
1.4	Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	146.6
1.5	Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	295,822.0
1.6	Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	6,158.8
1.7	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	2,353.8
1.8	Бусад орлого	36,740.6
1.9	Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас	1,452,499.9
Нийт орлого		6,943,759.9

” Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	67,232.2

” Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “5 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	5,882,758.8
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	5,391,992.2
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	281,082.7
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	66,698.6
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	142,985.3
Нийт зарлага		5,882,758.8

” Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсугай.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “7 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106

67.0 хувийн буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1, 10 дугаар зүйлийн 10.2, 10.5-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншин сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай

“НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 36
Бүгд: 106

66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн
2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106

67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан:

**“ХОЁРДУГААР БҮЛЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН
2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА**

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	2,525,575.8
	1.1 Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	1,156,409.8
	1.2 Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	353,036.7
	1.3 Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	966,297.8
	1.4 Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	49,831.5
Нийт орлого		2,525,575.8

” Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	77,600.0

” Дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “5 дугаар зүйл. 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	2,293,894.9
1.1	Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт	985,316.6
1.2	Төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	1,119,081.9
1.3	Эмийн санд олгох	171,485.3
1.4	Үйл ажиллагааны урсгал зардал	18,011.0
Нийт зарлага		2,293,894.9

” Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “6 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 35
Бүгд: 106
67.0 хувийн буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Найм.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн,

Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт С.Төрмөнх, Д.Гэрэлт-Од нар байлцав.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, О.Номинчимэг, Б.Бейсен, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, С.Ганбаатар, П.Сайнзориг нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.5-д заасны дагуу санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооноос “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах гэсэн горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	41
Бүгд:	106

61.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооноос гаргасан горимын саналыг гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 36

Бүгд: 106

66.0 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 18 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 108 гишүүн ирж, 85.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН

ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 05 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

78 гишүүн ирснээр 61.9 хувьтай ирц хүрсэн байна.

2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэнэ.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хоёр.“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Гуравдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

Тавдугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Зургадугаарт, хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Долдугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн дөрөв дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Наймдугаарт, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна.

Индэрт урьж байна.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Байнгын хороодоос ирүүлсэн саналуудыг тусган Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгах, хууль тогтоомжийн

хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, мэдээлэл сонсох, тайлан илтгэл хэлэлцэх, хяналт шалгалтын бусад асуудал зэрэг нийт 17 асуудлыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг асуулт асууж, хариулт авсан болно.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан:

О.Номинчимэг гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгөхийг хүсэж байна. Нийт гишүүд асуух эрхтэй.

2 гишүүнээр тасаллаа. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууна.

Х.Баасанжаргал:

Байнгын хороодоос санал авсан гээд байх юм. Эсвэл манай Байнгын хороо яг энэ асуудлаар нэгдүгээрт хэлэлцээгүй байгаа.

Хоёрдугаарт, Хүний эрхийн дэд хороодоос бас санал авсан юм болов уу гэдгийг тодруулж асуух гэсэн юм.

Манай Хүний эрхийн дэд хороо удирдлагаа томилоод удаагүй. Энэ асуудлаар ер нь санал өгөх ийм асуудал хэлэлцүүлэг бол ер нь болоогүй.

Тэгэхээр бусад Байнгын хороодоос санал авсан гэдгийг нь хэзээ яаж авсан юм болоо гэж асуух гэсэн юм.

Хуулиар бас намын бүлгээс санал авах гэдэг заалт байна.

Тэгэхээр намын бүлгээс санал авсан юм уу гэсэн ийм хоёр асуулт байна.

Д.Амарбаясгалан:

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ:

Хуулийнхаа дагуу Байнгын хороо, дэд хороо, нам, эвслийн бүлэг саналаа өгөх ёстой.

Саналаа өгөөрэй гээд Төрийн байгуулалтын байнгын хорооноос бичиг өгсөн.

Ер нь ээлжит чуулган завсарлахаас 10 хоногийн өмнө өгөх ёстой юм.

Тэгэхээр яах вэ, энэ удаадаа түрүүний ээлжит чуулганы үед өгөх боломж бололцоо байхгүй байсан тул бичиг явуулсан юм.

Тэгээд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Аж үйлдвэржилтийн байнгын хорооны санал ирээгүй. Бусад Байнгын хороодоос саналууд нь ирсэн.

Тэгээд тэр бүх саналуудыг тусгаад энэ цаглаврын төслийг боловсруулсан юм.

Д.Амарбаясгалан:

Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара:

Асуудал Баасанжаргал гишүүнийхтэй давхацсан учраас энүүгээр авчихъя.

Д.Амарбаясгалан:

Гишүүд нэг юмыг ойлгоно шүү.

Одоо 126 гишүүнтэй парламент бий болчихсон байгаа. 81 гишүүн шинээр гишүүн болж орж ирсэн. Энэ жилээс эхлээд шинэ хурлын дэг үйлчилж эхэлсэн байгаа.

Тэгээд энэ хурлын дэгээ бас бүрэн танилцаад, аливаа асуудалд хандахдаа дэгийн хууль болон тухайн асуудалтай холбогдсон хуулийг сайтар судалсны үндсэн дээр асуудалд хандаж байх нь зайлшгүй шаардлагатай байгаа.

Дэгийн тухай хуультай холбоотой зөрчилтэй зарим зарим зүйлүүд сүүлийн үед бас одоо энэ Улсын Их Хурал дээр өрнөж байна.

Хуулийн нөхцөл боломжгүй зүйлийг шахаж шаардаж байгаа тийм үг үйлдлүүд гардаг болсон.

Энэ нь өөрөө хуулиа хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа явуулах ёстой Улсын Их Хурлын гишүүний үүрэг.

Эрх нь хэтэрч байгаагийн хэлбэр болж байгаа шүү гэдгийг бас ташрамд хэлье.

Мэдээж Улсын Их Хурлын гишүүд чуулган дээр санал гаргана.

Санал заримдаа дэмжигдэнэ, заримдаа дэмжигдэхгүй, Байнгын хороон дээр зарим үед өөрөө байхгүй байна.

Байхгүй үед нь хэлэлцсэн асуудлаар асуудал болгож ярьдаг байдал зарим талаараа зарчимгүй үйлдлүүд болж байгаа гэдгийг бүх талаас ойлгох ёстой.

Өвчтэй байсан үед нь хэлэлцсэн асуудлыг намайг байхад хэлэлцээгүй гэж хандаж болохгүй.

Чөлөөтэй байхад нь хэлэлцсэн асуудлыг намайг байхгүй үед хэлэлцлээ гэдэг асуудлыг хөндөж байгаа байдал нь бусдын эрх ашиг хөндөгддөг гэдэг талыг нь илүү сайн харж хандаж асуудалдаа оролцоорой гэдгийг хэлье.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг явуулахаар байгаа.

Чуулганы танхимд гишүүд хангалттай байна. Төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Төхөөрөмжөөр санал хураана.

66.3 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүддээ талархал дэвшүүлье.

Дараагийн асуудалд орёе.

Хоёр. “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын

хорооны дарга Баярмагнайн Баярбаатар танилцуулна.

Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг үндэслэн “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг тус дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд 69.2 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт. /алх цохив/

64.5 хувиар.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн санал дэмжсэнд протоколд тэмдэглүүлье гэж байна. Пүрэвийн Батчимэг тэмдэглүүлье гэж байна.

Тогтоолын төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

Дараагийн асуудалд оръё.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай

хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзориг танилцуулна.

Индэрт урьж байна.

Төсвийн байнгын хорооноос гарч ирж байгаа юм байна.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Батбаатарын Амарбаясгалан

Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн ажлын хэсэг ирсэн байна.

Пүрэвжавын Ганзориг гишүүнийг индэрт урьж байна.

П.Ганзориг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга Дарханы арьс ширний үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, малчдын амьжиргааг дээшлүүлэх замаар макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг өсгөх, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг төсвийн зардал бууруулж, төсвийн орлого нэмэгдүүлэх,

тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг өсгөж байгаа нь Засгийн газрын гадаад өрийг нэмэгдүүлэхээр байгааг анхаарах талаар асуулт асууж, үг хэллээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2025 онд 8 хувь, 2026-2027 онд 6.5 хувь, эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах, өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэн инфляцыг бууруулж, 2025 онд 7.5 хувь, 2026 онд 5 хувь, 2027 онд 4 хувь хүргэхээр тооцсон.

Мөн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцож нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь 2025-2027 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэх, Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь 2025 онд 55 хувь, 2026 онд 50 хувь, 2027 онд 45 хувьтай тэнцэхээр байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг бэлтгэсэн төсөл, танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Д.Амарбаясгалан: П.Ганзориг гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.
/алх цохив/

Нийт 18 гишүүн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: 2025 оны төсвийн хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй олон санал гаргаж, энэ сайд нарын багц дээр ямар их илүү зардал байдгийг олон нийтэд таниулсан Ж.Баярмаа гишүүндээ баяр хүргэе.

Дээрээс нь төсвийн асуудлыг олон нийтэд оруулсан Д.Энхтүвшин гишүүнд бас баяр хүргэе.

Тэгэхээр Д.Энхтүвшин гишүүнд бас нэг зүйлийг хэлье гэж бодож байна.

Тэгэхээр 8 жилийн туршид би энэ төсвийг шүүмжилсэн. Тэгээд энэ 2024 оны төсвийг шүүмжилсэн шүүмжлэлийг би тан руу VIBER-аар одоо явуулчихна.

Тэгээд энэ дээр маш их олон санаанууд Та нэмж аваад, дахиад 2025 оны төсөв, ирэх жилийн төсөв хэлэлцэхэд энэ дээрээ ашиглаарай гэж зөвлөмөөр байна.

Тэгэхээр энэ жил ч гэсэн би энэ төсөв шүүмжлэх тэр ажлаа хойшоо тавиагүй. Бас л шүүмжилсэн. Өөрөөр хэлбэл 125 төсөл, арга хэмжээг царцаах юм бол 1.5 их наяд төгрөгийн хэмнэлт гарах юм байна. Үүнийгээ бизнесийг дэмжихэд зориулаач ээ гэсэн.

Дээрээс нь нэг сайдын зохион байгуулж байгаа нэг арга хэмжээ гэхэд л 500, 600 сая төгрөгөөр хурал, семинар хийдэг энэ явдал чинь хэрээс хэтэрлээ.

Одоо хэдэн зуугаар нь сонгуулийн жил, 2024 онд сонгуулийн жил баахан хурал, семинар хийсэн. Үүгээрээ сонгогчдын саналыг татах тэр ажлыг хийсэн.

Тэгээд энэ чинь буурахгүйгээр улам нэмэгдээд ороод ирчихсэн байна гэдгийг шүүмжилж хэлсэн.

Тэгэхээр өнөөдөр яг таны үг яагаад ингээд олон нийтэд хүрч байна вэ гэхээр энэ ард иргэдийн дургүйцэл асар их байгаад байгаа юм.

Өөрөөр хэлбэл өнгөрсөн 8 жилийн туршид ард иргэдийн амьдрал буурсан, дарга нарын халаас томорсон байхгүй юу даа.

Төсвийн хулгай хийсэн. КОВИД-ын үеэр далимдуулж янз янзын хулгайнууд хийсэн. Тэр нүүрсний хулгай. Хийгээгүй юм байхгүй.

Энэ бүхэнд чинь 2024 онд дүн тавина гээд байж байсан чинь танай нам дахиад ялчхангуут нь тэр үзэн ядалт чинь өнөөдөр тэр чигээрээ явж байгаа байхгүй юу даа.

Дээрээс нь таныг ингээд хэд хэдэн хүний нэр хэлчихээр танай намын доторх тэр далд зөрчил чинь ил болоод нэг нэгнийгээ буудах хэрэгсэл болж байгаа юм.

Тийм учраас таны энэ шүүмжлэл чинь маш их олон нийтэд хүрч байгаа гэдгийг хэлье.

Тэгээд миний тэр шүүмжлэлээс санаа аваад улам сайн шүүмжлээрэй гэж хүсье.

Тэгээд би нэг зүйлийг танд тодруулж бас хэлэх ёстой. Яагаад гэвэл төсөв дээр асуудал гаргасан хүн Б.Пүрэвдорж гээд нэрлэгдсэн.

Тийм учраас би яг ямар санал гаргаад яаснаа хэлье.

4, 5 жил дамнаж ашиглалтад орох дотуур байрны 1.7 тэрбум төгрөгийг бууруулаад тэгээд ирэх жил ашиглалтад орох Ховд аймгийн цэвэрлэх байгууламжид 1.7 тэрбумыг тавьсан юм.

Үүнийг С.Бямбацогт гишүүн 11 жилийн турш ярьж байгаа.

З.Мэндсайхан гишүүн сайд байхдаа төсвийн хөрөнгийг нь тавьсан.

Э.Болормаа гишүүн Засаг дарга байхдаа очсон хүн болгонд энэ хөрөнгийг тавьж өгөөч ээ гэж хүсдэг тэр хөрөнгө оруулалтыг энэ жил Ховд аймагт Ардчилсан нам ялсан учраас би тавьсан юм.

Энэ цэвэрлэх байгууламж ашиглалтад орвол түүхий эдийг боловсруулах төв ашиглалтад орно.

Түүхий эдийн төв ашиглалтад орвол баруун 5 аймгийнхан өндөр үнэтэйгээр түүхий эдээ боловсруулах боломж нэмэгдэж байгаа юм.

Тэгэхээр намайг шүүмжлэнгээ бас намайг Ховдынхоо төлөө зүтгэдэг Ховдын 3 гишүүн, дээрээс нь намайг

Ховд даяар алдаршиж өгсөн танд бас баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Жадамбын Баясгалан гишүүн алга байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн алга байна. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууна.

М.Нарантуяа-Нара: Өглөөний мэнд хүргэе. Бүгдэд нь.

Тэгэхээр ер нь энэ төсөв тойрсон маш олон хэлэлцүүлэг, тэр дундаа сошиал дээр ер нь ард түмний дунд тийм ээ, маш их зүйлээр өгөөш тавьж, өөрсдийнхөө өчнөөн их наядаар нэмэгдсэн асуудлуудаа бүр ингээд намжаад, хүүхдийн төлөө асуудлыг дэмжсэн биш надаар ер нь одоо бодоод байх нь зэрэг 2024 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцэхдээ ч гэсэн надаар бас мешок хийсэн.

Одоо ч гэсэн бас мешок хийгээд явж байгаа юм байна.

Ер нь энэ чухал асуудал. Тийм ээ. Шийдвэрлэх үедээ аль болох олны анхаарал татдаг хүмүүсээр урдаа могойд барьдаг мод болгочхоод ингээд цаагуураа нарийн юмаа хэлэлцээд явж байгаа гэдгийг нь ард түмэн мэдэх хэрэгтэй.

Энэ сэтгүүлч нар нь ч гэсэндээ бүгд ялангуяа архагчууд, манай архаг гишүүд өдий 3, 4, 5 удаагийн парламентад хүний амьдралын бүхэл бүтэн 20 жилийн настай тэнцэх энэ парламентад сууж байж тойргоо аятайхан болгоогүй, улсаа ч аятайхан болгоогүй. Өнөөдөр цэцэрлэг, сургууль нэхээд байж байгаа ард түмэн нь энэ хүмүүсээсээ бас нэхэх хэрэгтэй.

Хоёрхон жилийн дотор ер нь ингэж 60 хувиар тэлдэг ийм төсвийн тэлэлттэй байдаг улс орон дэлхийд ер нь байдаг юм уу? Энэ дээр мэдэх хүн нь хариулт өгөөдхөөрэй гэж хүсэж байна.

Тэгээд одоо энэ манай Монголын төр өөрөө хамгийн том ажил олгогч болчихсон, хамгийн том худалдан авагч нь болчихсон. Тэгээд энэ төсөв дээр чинь ядуурлын хэдэн хувиар буруулах юм.

Энэ хүчирхийлэл, архидалт, ядуурал, ажилгүйдлийг хэдэн хувиар багасгаж нэмэгдүүлэх асуудлыг яаж оруулж ирж байгаа юм? Ингээд нөгөө сайхан хэдэн гишүүдээ.

Ер нь анзаараад байхад урд өмнө нь ч гэсэн эмэгтэй гишүүдээ яг ингээд урдаа тавьчхаад явчихдаг байсан ийм асуудалтай байсан юм байна.

Тэгээд би бол энэ 4 жилд энэ парламентад энэ олон засгийн болон парламентын нэлээн асуудлуудыг хаагч нэг ийм гишүүн байх юм байна л даа.

Д.Амарбаясгалан:

М.Нарантуяа-Нара гишүүн нэгдүгээрт хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуултаа асуух цаг байгаа гэдгийг сануулъя.

Дэгийн тухай хуулиараа бүгдээрээ ажиллах ёстой. Их Хурал хуулиа дагаж мөрддөг байх ёстой гэдгийг бүх талдаа ойлгох ёстой шүү.

Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууна.

С.Цэнгүүн: Өглөөний мэнд хүргэе.

Тэгэхээр төсөвтэй холбоотой асуудал ерөнхийдөө хэдэн долоо хоногийн турш ард иргэдийн ч тэр, Их Хурлын гишүүдийн ч тэр анхаарлын төвд байж байна.

Д.Амарбаясгалан: Төсвийн асуудал дараачийн асуудлаар орно. Төсвийн хүрээ, 2026-2027 оны төсвийн төсөөлөл ярьж байгаа. Одоо.

Тэгэхээр төсвийн гуравдугаар хэлэлцүүлэг дараагийн асуудал дээр орж ирнэ. Тэр дээр үгээ хэлээрэй.

Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн асуулт асууна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт.

П.Мөнхтулга: Өнгөрсөн маш олон жил эдийн засгийг солонгоруулна л гэж ярьж байгаа.

90 хувь нь уул уурхайн орон болсон гээд. Жил жилийн төсвийн дандаа уул уурхайгаас хамааралтай. Ирэх жилүүдэд төсөв ашигтай гарах болов уу, яах бол гэж ингэж бурханд найдсан, дэлхийн эдийн засгийг түүхий эдийн зах зээл яах бол гэж түгшсэн ийм байдлаасаа хэзээ гарах юм болоо гээд.

Тэгээд эдийн засгаа солонгоруулна гэж олон жил ярьсан шүү дээ.

Хөдөө аж ахуйн орон болно, аялал жуулчлалаа сэргээнэ гээд олон жил ярилаа. Тэгээд энэ төсвийн хүрээний мэдэгдэл болон өнгөрсөн оны төсвүүд, одоо энэ батлагдаж байгаа төсөв ч гэсэн дандаа л үрэлгэн байдлаар хандах юм.

Тэгээд харамсалтай байгаа нь төсвийн хүрээний мэдэгдэл дээр ч гэсэн, төсөв дээр ч гэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах олон улсын зах зээл дээр гаргах тал дээр нэг ч хөрөнгө оруулалтууд тавигдсангүй.

Нийт манай хөдөө аж ахуй дотоодын нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувийг эзэлдэг.

Хүн амын ажиллах хүчний 21 гаруй хувийг эзэлдэг.

Сумд төрийн албанаас өөр ажил байхгүй шүү дээ. Ажлын байр байхгүй. 3 мянгаас 4 мянган хүн ам амьдарч байгаа. Дунджаар. Нэг сумд. Тэнд 40 хүрэхгүй төрийн албаны л ажил байдаг.

Тэгэхээр чинь суманд намчирхал үүсэж тэр улс төр халах нь аргагүй шүү дээ.

4 мянган хүний дунд 40-хөн ажлын байр байна гээд бод доо.

Тэгэхээр энэ малын гаралтай түүхий эдийг боловсруулах хөдөө аж ахуйн орон хэзээ болох юм бол оо. Тийм болохоор энэ Засгийн газар, сайд нар, ялангуяа хөдөө аж ахуйн сайд.

Би орон нутгийн, яг өөрийн тойргийн асуудал явцуурхаж яриагүй байна. Үндэсний хэмжээний бүх. Одоо энэ хөдөө орон нутгаас сонгогдсон олон гишүүд энд сууж байгаа.

Тэр Дарханы арьс ширний цогцолбор одоо хүртэл хөрөнгө оруулалт нь тавигдахгүй байгаа. Тийм болохоор одоо энэ төсвийг ямар ч байсан оноос

өмнө дахиж тодотгохоор сая Төсвийн байнгын хороо шийдчихлээ.

Тэгэхээр одоо энэ тодотголын үеэр Хөдөө аж ахуйн сайд аа, энэ Дарханы үйлдвэрээ явуулаарай. Танай тойрог.

Д.Амарбаясгалан: П.Мөнхтулга гишүүн ээ, хүрээгээ ярья.

П.Мөнхтулга: Гийм. Төсвийн хүрээний холбогдолтой л юм ярьж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Дэгээрээ өнөөдрийн хийсэн танилцуулгатай холбож асуудлыг ярих ёстой.

Тэгэхээр бүгд дэгээ зөв ойлгож ярина шүү.

П.Мөнхтулга: Холбоотой л юм ярьж байгаа шүү дээ.

Д.Амарбаясгалан: Хэлэлцэж байгаа асуудал ярья. Төсвийн тодотголоор бид энд яриагүй байна.

П.Мөнхтулга: Төсвийн хүрээний мэдэгдэлдээ хөдөө аж ахуйн салбараа дэмжсэн юм оруулж ирээрэй.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуух хоёр асуулт байна.

Энэ төсвийн хүрээний мэдэгдэл бөгөөд 2027 оны төсвийн төсөөлөл маань Монгол Улсын “Алсын хараа-2050”-тай хэрхэн нийцэж аль аль зорилтыг биелүүлэхэд илүү чиглэж байгаа вэ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, Энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу бид дунд хугацааны бодлогоо батлах ёстой байгаад байгаа. Энэ батлагдаагүй яваад байгаа.

Тэгэхээр ер нь үр дүнгээ хэмжихэд энэ өөрөө аягүй чухал. Дунд хугацааны бодлого.

Тэгэхээр энэ дунд хугацааны бодлого хэзээ батлагдаж орж ирэх вэ? Цаашид энэ бодлого маань өөрөө төсөвтэйгөө хэрхэн уялдах талаар ямар бодлого барьж байгаа вэ гэсэн ийм асуулт асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Идэшийн Батхүү.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү. Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Энэ төсвийн хүрээний мэдэгдэл нь өөрөө саяхан батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон өргөн барьсан төсөвтэйгөө уялдсан байгаа.

Баримт бичиг маань өөрөө 3 жилийн хугацаатай баримт бичиг байгаа. Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн хязгаарыг зааж өгдөг.

Энэ нь дунд хугацаандаа эдийн засгийн бодлогыг гол зорилтууд тогтвортой хадгалагдах нөхцөлийг бүрдүүлдэг.

Үүнээс гадна саяын таны дурдсан дунд хугацааны хөгжлийн бодлогын

баримт бичиг гэвэл “Шинэ сэргэлтийн бодлого” гээд 10 жилийн хугацаатай дэд бүтэц, эдийн засгийн чиглэлийн хөгжлийн бодлогын баримт бичиг байгаа.

Яг хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдтэй холбоотой гэвэл “2021-2025 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гээд хүчин төгөлдөр баримт бичиг байгаа. Энэ бүгд хооронд уялдаатай байгаа.

Асуултад хариуллаа.

Д.Амарбаясгалан:

Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуултаа асууя.

С.Цэнгүүн: Сая үг хэлж байхад яагаад тасалсныг ерөөсөө ойлгосонгүй.

Ерөнхийдөө Их Хурлын гишүүд яг өөрсдийнхөө бодож байгаа үзэл санааныхаа зүйлсийг ярих эрхтэй байх гэж бодож байна.

Тэгэхээр цаашид үг тасалмааргүй байна гэж хэлмээр байна.

Тэгэхээр энэ төсөвтэй холбоотойгоор ер нь эрчим хүчний асуудалтай холбож иргэд маш их бухимдал, дургүйцэл ирсэн.

Энэ маань үнэ нэмэх гэж байна гэдэг ойлголтоор хүмүүс ойлгосон. “Эрчим хүчний реформ” ганцхан үнэ нэмэх тухай асуудал биш юм. Эрчим хүчний реформтой хамт явж байгаа маш олон зүйлсүүдийн нэг нь төрийн өмчит компаниудын менежментийг шинэчлэх зүйл байгаа.

Тэгэхээр энэ төсөвтэй холбоотойгоор бид энэ зүйлүүдийгээ ч

гэсэн анхааруулж харах зайлшгүй шаардлага байгаа юм.

Тэгэхээр эрчим хүчний реформыг үргэлжлүүлж цааш нь маш хурдтайгаар хийх зайлшгүй шаардлагууд байгаа. Энэ дундаа бид шинэ эх үүсвэрүүд татах хөрөнгө оруулагч нартаа ч гэсэн ээлтэй хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж явж байгаа дээр Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн дэмжиж ажиллаж байгаад маш их баяртай байна.

Тэгэхээр манай эрчим хүчний реформ маань энэ 2024-2028 оны хооронд зайлшгүй хэрэгжих ёстой маш томоохон реформын зүйл.

Тэгэхээр энэ дээр би сэтгүүлч нарт хандаж хэлмээр байгаа юм.

Буруутайгаар, санаатайгаар энэ асуудлыг улс төржүүлмээргүй байна гэдгийг хэлмээр байгаа юм.

Тэгэхээр баттай болоогүй мэдээллүүдийг худал хуурмагаар цацахаа бас болиосой гэж хүсэж байна. Яагаад вэ гэхээр энэ хувь хүнтэй холбоотой асуудлууд биш.

Манай “эрчим хүчний реформ” бол үндэсний эрх хэмжээний манай эдийн засгийн хөдөлгүүр болох том асуудал байж байгаа юм.

Тэгэхээр эрчим хүчинд оруулж байгаа “1 төгрөгийн хөрөнгө оруулалт маань 4 төгрөг болж өсдөг” ийм том буюу манай эдийн засагт хамгийн томоор асуудлаа шийдэх боломжтой асуудал байгаа юм.

Тэгэхээр бид энэ эрчим хүчний реформтой холбоотой асуудал явагдаж

байхад улс төржилт хийж, эсвэл энэ төсөв хэлэлцэж байх үед санаатайгаар асуудлуудыг өөр тийш нь чиглүүлдэг байхаа болимоор байна гэдгийг бас хүмүүст хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

Л.Соронзонболд: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Бид 2024 оны 8 сарын 30-нд 2024 оны төсвийн тухай хууль, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулсан.

Өнөөдрийн манай төсвийн хүрээний мэдэгдэл болон 2026-2027 оны төсвийн төсөөллийг харахаар 2-хон сарын өмнөхөөсөө 10 хувийн өөрчлөлттэй байгаа юм.

Ялангуяа тэр дундаа нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ маань 10 хувиар өсчхөөд ороод ирж байгаа. Энэ дээр нэг тайлбар асуумаар байна.

Д.Амарбаясгалан:
Ц.Даваасүрэн гишүүн хариулах уу?
Ж.Ганбат дарга хариулах уу?

Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

2024 оны 6 сард болсон Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар шинэ парламент байгууламжтай холбогдуулан

шинэ Засгийн газар мөн байгуулагдсан. Ингээд төсвийн тодотгол орсон.

Төсвийн тодотгол дээр мөрийн хөтөлбөртэй уялдуулан шинээр төсвүүдийг нэмж баталсан.

Нийтдээ 3.2 их наяд төгрөгийн төсөв батлагдсан.

Үүнтэй холбоотойгоор бас мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мөн төсвийн тодотголоор суурь тавигдсан энэ зардлууд 2025 оны төсөв дээр зайлшгүй нэмэгдэх шаардлага үүссэн.

Урсгал зардлын хувьд 3.6 их наяд төгрөгөөр нэмэгдсэн. Хөрөнгө оруулалт 1.7 их наяд төгрөгөөр нэмэгдсэн.

Тэгэхээр өөрөөр хэлбэл тухайн үед төсвийн тодотголын өмнө батлагдсан байсан хүрээндээ саяын 2025 онд ингээд орж ирж байгаа нь зөрүүтэйгөөр нэмэгдэж орж ирсэн гэж хэлж болно.

Ер нь зарлагуудыг бүтцийг нь хараад үзэх юм бол урсгал зардлын нэмэгдэж байгаа зардлын 60 орчим хувь нь зөвхөн хүн амын тоо, статистик өсөлттэй холбоотой зардлууд нэмэгдэж байгаа. Үлдэж байгаа хэсэг батлагдсан хууль тогтоомжуудтай холбоотой ийм зардлууд нэмэгдэж орж ирж байгаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууна.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Төсвийн хүрээний мэдэгдэл уг нь 2025 оныхыг 6 сарын 05-нд баталсан

байгаа. Тийм ээ. Төсвийн нийт зарлагыг 30 гаруй их наяд гээд.

Тэгээд дахиад 8 сард нь бид тодотголоор 31.9 гэж оруулж ирсэн.

Тэгээд нэг өдөр хоёр төсвийн хүрээний мэдэгдэл бараг орсон шүү дээ.

Нэг нь 31.9. Нөгөөдөх нь 35.8 гээд. 9 сарын 01-нд 35.8 гэдгийгээ өргөн барьсан.

Тэгэхээр ер нь нэг өдөрт ийм аймаар зөрүүтэй юмыг яаж сэтгэж чадаж байгаа юм болоо л гэдгийг би гайхаад байгаа юм.

Төсвийн зарлагыг 31.9 гэж бодож тодотголоо баталж байж. Тэгээд яг нөгөө талдаа 35.7 гээд оруулаад ирээд байгааг ерөөсөө бүр гайхаад.

Тэгээд яах вэ бүх өмнө хэлсэн хүмүүсийнхтэй зэрэгцэж л байна л даа.

Тэгээд энэ төсвийн тэлэлт чинь яг хэн дээр очиж буух юм бэ гэхээр мэдээж Монголын ард түмэн, олон нийтийн нуруун дээр очиж бууна, аж ахуй эрхлэгчдийн нуруун дээр очиж бууна.

Одоо энэ төсвийн алдагдал энэ их тэлсэн байдлыг юугаар орлуулж ирэх юм гэхээр мэдээж зээл авч таарах байх. Ядаж хажууд нь өмч хувьчлал энэ тэр хийх юм огт байхгүй. Төрийн өмчит компаниудаа хувьчлах тухай ямар ч төлөвлөгөө, төсөв байхгүй.

Тэгээд л ерөөсөө алдагдал бөгөөд энэ зарлагыг ганцхан орлого болон татвартаа найдаад л сууж байгаа.

Гэтэл нөгөө тогтоосон ёсоор орлого нь орж ирэхгүй бол яах вэ? Тэгэнгүүт аж ахуйн нэгжүүдийнхээ татварыг нэмэх гэж байгаа юм уу? Эсвэл 500 гаруй тэрбумын өртэй байгаа тэр өрийг нь өдөр шөнөгүй нэхэж авах гэж байгаа юм уу?

Гэтэл чинь тэд нар чинь бүр сөхрөх гэж байна шүү дээ. Түрүүчийн долоо хоногт хэвлэлийн бага хурал хийсэн шүү дээ. Энэ долоо хоногт.

Тэгэхээр ийм хүнд нөхцөл байдалтай байхад яаж ингэж ийм том данхгар төсөв оруулж ирж энэ төсвийн хүрээний мэдэгдлийг ингэж нэмэгдүүлж болж байгаа юм бэ.

Тэгээд олон улсын байгууллагууд ч гэсэн хэлээд байгаа шүү дээ. Төсвөө хумиач ээ гээд. 10 сарын 01-нд IMF-ийн гаргасан дүгнэлт дотор байж байгаа шүү дээ.

Төсвөө хумихгүй тэлэх юм бол энэ эдийн засгийн макро үзүүлэлтүүд чинь балрах нь гээд.

Ирэх онд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 7.5-аар бодсон ч гэсэн 2026 онд 6 болоод, 2027, 2028 онд 5, 5 болно гээд дүгнэчихсэн байгаа шүү дээ. Төсөөлчихсөн байгаа шүү дээ. Унана, буурна гээд.

Тэгээд инфляц чинь ерөөсөө бараг энэ “шок” нь хавартаа илрээд 2 оронтой тоо руу орох нь гээд сануулаад байгаа шүү дээ. Олон улсын байгууллагууд.

Тэгээд инфляц чинь 2 оронтой тоонд ороод ирэхээр тэртээ тэргүй зовж байгаа олон түмэн чинь яах юм бэ?

Тэгээд бид нарын энэ хэлээд байгаа үг бол бид нараас гадна олон түмний хүсэл сонирхол, тэд нарын ашиг сонирхол. Бид төлөөлж л хэлж байгаа.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүдийн төсвийн хүрээний мэдэгдлээ уг нь жоохон хариуцлагатай хандаад ингэж их тэлэхгүйгээр, зарлагыг энэ их олон наядаар ихэсгэхгүйгээр, урсгал зардал 72 хувиар нэмэхгүйгээр, тэр олон гадаад айлчлалаа хасаад, тэр олон шинэ тавилга, тоног төхөөрөмжөө танаад, тэр олон бараа, бүтээгдэхүүнээ болиод ингээд энэ төсвийнхөө зарлагыг жоохон ханах тал дээр сэтгэл гаргаж ажиллавал яасан юм бэ?

Бид нарын тавьж байгаа саналыг дэмжвэл яасан юм бэ?

Энэ бол засгийн хариуцлагагүй ажил л гэж бодож байгаа.

Тэгээд энэ удаагийн парламент хэрвээ үүнд өөрчлөлт оруулахгүй түүхэндээ анх удаагаа төсөвт таналт хийгээгүй ийм парламент болох юм байна лээ шүү.

Өмнө нь 300, 400 тэрбумаар тасалж баталж байсан байна лээ.

Гэтэл энэ удаад 30 орчим тэрбумаар танах юм уу, үгүй юм уу?

Тэгэхээр үүгээрээ алдаршиж бид үлдмээргүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн гишүүн хариулья.

Ц.Даваасүрэн: Тийм. Би Ж.Баярмаа гишүүний хэлээд байгаатай санал нэг байгаа юм.

Ер нь төсөв орж ирэхэд би ч гэсэн саналаа хэлсэн шүү дээ.

2020-иод оны үед 11 их наяд байсан төсөв чинь одоо 2, 3 дахин нэмэгдчихээд байна.

Төсвийн орлого чинь ганцхан нүүрснээс хамаараад байна. Өндөр эрсдэлтэй байна гэж.

Би энэ үгийг зөвхөн энэ удаа ч хэлсэн биш, 2022 онд төсөв өсөхөд хэлж л байсан, 2023 онд хэлж л байсан.

Ганц нүүрснээс хамааралтай мөртлөө төсвөө яагаад 2 дахин нэмээд байгаа юм бэ. Нүүрс чинь орж ирэхээ больчихвол маш хүнд шокт орно шүү гэж.

Би Байнгын хорооны даргын ажлыг аваад 4 сар л болж байна шүү дээ.

Одоо энэ шүүмжлээд байгаа Г.Тэмүүлэн гишүүн маань тэр төсөв нэмэгдэж байсан 2022, 2023 онд Төсвийн байнгын хорооны дарга л байсан байгаа шүү дээ.

Тэгээд одоо төсөв өслөө гээд шүүмжлээд байдаг.

Энэ өсөж байгаа нь үнэн. Өсөж байгаатай би эвлэрэхгүй байгаа. Ажлын хэсэг дээр манай Б.Түвшин гишүүнээр ахлуулаад бид бас нэлээн сайн үзсэн.

Зүгээр механикаар шууд одоо ингээд 3.6 их наядыг шууд хасна гэвэл

эрүүл мэнд, боловсрол, цэрэг, цагдаа хэлмэгдэнэ.

Тийм учраас ер нь тодотгол хийгээд үүнийг нэг сайн үзэх хэрэгтэй.

Энэ мөнгө хаашаа ороод байгаа юм. 3 дахин өсчихсөн мөнгө хаашаа орчихоод байгаа юм. Юунаас болчихоод байгаа юм.

Үүнийг үзэх хэрэгтэй. Харин шинэ Их Хурал бас үүнийг ингэж ярьж байгааг би зөв гэж бодож байгаа.

Миний байр суурь яг тийм л байсан. Нэгхэн бүтээгдэхүүнээс хамаардаг эдийн засагтай байгаа байхгүй юу. Тэгсэн мөртлөө 3, 4 жилийн дотор төсвөө 3 дахин нэмээд хаячихсан.

Тийм учраас үүнийг бид үзээд аль нь нэмэгдээд, аль нь яагаад байгаа юм.

Б.Түвшин гишүүний ахалсан дэд ажлын хэсгээс гарсан урьдчилсан дүгнэлтийг харахад шинэ байшин, барилгууд их барьжээ. Тэрний

- ▶ урсгал зардал,
- ▶ тэрний цалингийн зардал,
- ▶ тэрний ажилчдын зардал,
- ▶ тэрний эд хогшлын зардал

энэ нийт өсөж байгаа зардлын 50 хувийг авсан байгаа байхгүй юу.

Тийм учраас ер нь цаашдаа энэ бүтцийн өөрчлөлт гэдэг юмыг бас хийхгүй бол болохгүй юм байна гэж хараад байгаа юм.

Аль салбар өсгөчхөөд байгаа юм.

Түүнээс биш одоо шууд механикаар хасчхаж болохгүй. Бид учир шалтгааныг нь олох хэрэгтэй.

- ▶ Хаана төсвөө нэмчхээд байна,
- ▶ Хаана орон тоогоо нэмчхээд байна,
- ▶ Хаана зардлаа өсгөчхөөд байна гэж.

Тэрийг нь олж л хасах хэрэгтэй.

Түүнээс биш 2011 он шиг нөгөө 10 хувиар шууд тайраад, тэгээд 12 хүүхэд хүйн халдвар авснаас болоод нас барсан. Яасан төсвийг нь хасаад хаячихсан.

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Саяын энэ хүчин зүйлсээс болоод нөгөө 33.8 их наядын орлого маань хэрвээ орохгүй бол яах юм бэ? Энэ дээр тооцоо судалгаа байдаг юм болов уу?

Биднээс хамаарахгүй шүү дээ. Нүүрсний үнэ буурлаа л бол мянга, хэдэн мянга, хэдэн сая тонныг гаргаад ч нэмэргүй. Хэмжээ ихсэхийн хэрээр үнэ буурахыг бас үгүйсгэхгүй.

Тэгэхээр үүнийг юугаар нөхөх юм бэ, яаж нөхөх юм бэ?

Тэгээд баахан энд тэндгүй төсөл хэрэгжүүлэх гээд жоохон жоохон мөнгө ч юм уу, ингээд жоохон жоохон юм тавьчихсан байдаг.

Гэтэл орлого нь бүрдэхгүй үүнийг ингэж ингэж нөхнө, ингэж ингэж хийнэ, тэндээс эндээс авна гэсэн тооцоо, судалгаа байдаг юм болов уу?

Нэг айл нэг байшин барихдаа хүртэл тооцоогоо хийдэг шүү дээ. Дорж, Дулмаагаас зээлээ авна. Хэрвээ тэр бүтэхгүй бол Дондоогоос авна ч гэдэг юм уу. Тэр бараагаа зарна, машинаа зарна гээд.

Яг түүн шиг орлого бүрдэхгүй тохиолдолд ингэнэ гэсэн тооцоолол байгаа юм болов уу?

Д.Амарбаясгалан: Чинбатын Анар гишүүн асуулт асууна.

Ч.Анар: Өглөөний мэнд.

Тэгэхээр Монгол Улсын энэ “Алсын хараа”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Засгийн газрын үйл ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр”. Эд нар нь бүгдээрээ хоорондоо уялдахгүй юм. Төсвийн хүрээний мэдэгдэл ямар ч уялдаа байхгүй.

Тэгээд сонгуулиар намын мөрийн хөтөлбөр дээрээ аягүй гоё гоё үгтэй. “Эдийн засгаа солонгоруулна” гээд.

Тэгээд бүгдээрээ өнөөдөр Монгол Улсын төсөв гээд 10 тэрбум доллар дээр

- ▶ 3.5 сая хүн амтай,
- ▶ 1.7 сая хөдөлмөрийн чадвартай хүн амтай,
- ▶ 1 сая хөдөлмөрийн харилцаанд орсон, засаг төр хувийн хэвшилтэйгээ хамаг ухаантай хүмүүс нь тэр нөгөө Харвард, Оксфорд, Токио сургуулиуд дээрээ сураад төгсөөд 10-хан тэрбум доллар дээр.

Яг том зургаар харах юм бол аймаар өрөвдөлтэй.

Тэгээд тэрийг нь бид бүтээдэггүй. Байгаль бүтээдэг. Тэндээсээ үүдсэн эдийн засгийн эргэлтийг нь зохицуулах гээд хэрэлдээд. Аймаар үрэлгэн төсвүүдтэй.

Тэгээд нөгөө намын мөрийн хөтөлбөр, уриа лоозон дээрээ бүгдээрээ гоё гоё юм биччихсэн.

Тэгэхдээ яг ингээд Төсвийн хүрээний мэдэгдэл, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр ерөөсөө тэр нь яаж хэрэгжих нь байхгүй.

Ганц нүүрсний үнээ л яриад байдаг. Нүүрсний үнэ унах юм бол одоо энэ данхар төсөв чинь уналаа шүү дээ, улс уналаа шүү дээ гээд яриад байдаг.

- ▶ Уялдаа нь байхгүй.
- ▶ Бодлого нь байхгүй.
- ▶ Бодлогоо гаргаагүй байж төсвийн хүрээнийх нь мэдэгдэл нь яваад байдаг.

Тэгээд сая Монгол Улсын Ерөнхий сайд урд айлчлахдаа төрийн бодлогоо хувийн компанитай хийлгэнэ. Хятадын төрийн өмчит хувийн компаниар хийлгэнэ гээд.

Тэгээд энэ бодлого дээр чинь хариуцсан Эдийн засаг, хөгжлийн яамны сайд Л.Гантөмөр сайд аа, Та энэ дээр чинь бодлогоо гаргаад, дуу хоолойгоо гаргах ёстой шүү дээ.

Тэр цахим мэдээллийн аюулгүй байдал дээр Ц.Баатархүү сайд нь тэнд ажлын хэсгийг нь ахлаад явж байх шиг.

Тэр төрийн протокол, дэг зарчмаа мэддэг юм уу, мэддэггүй юм уу. Улс орноо худалдаад яваад байх юм.

Тэгээд энэ дээрээ байр сууриа гаргаад нэг яам юм бол яам, сайд юм бол сайд шиг сайд байгаач ээ.

Тэгээд Л.Гантөмөр сайд нь энд тэнд очоод “ядуу улсын ядуу иргэд, ядуу удирдагч” гэж яриад яваад байгаа юм. Ийм удирдагч гэж байдаг юм уу.

Би одоо Эдийн засаг, хөгжлийн сайд, энэ Монгол Улсыг дэлхийд өрсөлдөх чадвартай улс болох дээр ганц нүүрс, зэснээсээ хараат бус болох дээр тантай хамтарч ажиллана гэж бодсон.

Тэгтэл та энд тэндгүй тийм юм яриад байх юм. Ийм лидертэй нам гэж байж болох юм уу? Тэгээд ийм хүнээр Эдийн засаг, хөгжлийн яамаа удирдуулаад байж болох юм уу?

Тэгээд энэ төсвийн төсөөллийн хүрээний бодлого, баримт бичиг, хуулиуд, Засгийн газрын дунд хугацааны мөрийн хөтөлбөр, “Алсын хараа”. Эд нар чинь хоорондоо огт уялдахгүй байна шүү дээ.

30 жил нөгөө нүүрс, зэсээ л яриад байдаг. Нийт яригдаж байгаа төсөв нь тэгээд бид нарын байж байгаа бүтээмж нь хамаг ухаантайгаа суулгачхаад нэг ийм.

Яг үзэх юм бол дэлхий дээр нэг тахиа зардаг ч юм уу, жижиг технологийн компанийн л олдог орлогыг л хэдүүлээ яриад байгаа шүү дээ.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байгаа учраас саяын. Л.Гантөмөр дарга хариулъя.

М.Бадамсүрэн гишүүн асуултаа асууя.

М.Бадамсүрэн: Ирэх онуудын төсөв дээр анхаарах ёстой зүйлүүд байна.

Тэгээд зарим дарга нар шинэ гишүүд ингэсэн тэгсэн гээд нэр гул бариад. Үүнийгээ болих хэрэгтэй.

Бид чинь бас тодорхой хэмжээний жижиг хүрээнд ч гэсэн туршлага байгаа шүү дээ.

Тэгээд том туршлагатайгаараа нэг их давуу байгаа юм шиг байдгаа болих хэрэгтэй.

Ер нь цаашдаа би бол шинэ гишүүдийг уриалж байна. Үг хэлэх ёстой.

Тэгээд Байнгын хороо энэ төсвийн ажлын хэсэг дээр зарим зүйл дээр санал хураая гэхээр хураалгаагүй шүү дээ.

Тэгээд би үүнийг шаардлагатай тэр Үндсэн хуулийн цэц, Их Хурлын даргад энэ асуудлаа тавьж болно.

Ер нь тэгээд хүндэтгээд бас туршлагатай зөв байх гээд ингээд л хараад яваад байгаа юм.

Тэгээд цаашдаа энэ зүйл дээр хэлж явах ёстой, дуу хоолойгоо илэрхийлэх ёстой гэдгийг би ялангуяа шинээр сонгогдсон гишүүддээ уриалж байна.

Тэгээд ийм юм яриад байгаа юм.

Хүүхдийн сургууль, цэцэрлэг барья. Гурван ээлжээр хичээллээд байна гэхээр ямар хариулт өгч байна гэхээр урсгал зардал нэмэгдүүлдэг сургууль,

цэцэрлэгийг барихгүй гэсэн юм ярьж байгаа шүү дээ.

Тэгээд нэг ангид 50, 60 хүүхэдтэй бага ангийн багш, цэцэрлэгийн багш чинь яаж эрүүл байх юм бэ. Яаж хүүхдүүдийн ханиад томуу хүрэхгүй байх эрүүл аюулгүй байдал хангагдах юм.

Тэгээд би энэ хариултыг сонсоод үндсэндээ маш их гутарсан. Тэгээд бага насны хүүхэдтэй хүмүүс маш сайн мэдэж байгаа. Ер нь хүнд байгаа шүү дээ.

Тэгэхээр ийм юм яриад байдаг. Тэгсэн мөртлөө урсгал зардал нь гадаад дотоод, томилот, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гээд тоолбол их наядад хүрч байгаа шүү дээ.

Тэгээд нөгөө талд нь бас нэг юм байгаа. Миний хувьд аймгийн Засаг даргаар ажиллаж байсан.

Аймагт бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэж хэдэн төгрөг байдаг юм бэ гээд Тамгын газрын даргаасаа би асууж байгаа юм.

5, 10 сая төгрөг байгаа юм уу, байхгүй юм уу. Мэдэхгүй. Бүхэл бүтэн нэг аймагт шүү дээ. Монгол Улсын засаг захиргааны нэгжид.

Тэгэхэд бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал чинь өнгөрсөн онд 1 их наяд байсан бол энэ 2025 оны төсвийн төсөл дээр 1 их наяд 470 тэрбум төгрөг болчихоод байгаа байхгүй юу.

Тэгээд үүнийг цаашдаа яах юм бэ? Төсвийн хүрээний мэдэгдэл, ирэх оны төсөв дээрээ үүнийг анхаарах хэрэгтэй.

Дараагийнх нь, жижиг, дунд бизнес, хувийн хэвшлийг дэмжихийн тулд хөнгөлөлттэй зээлийн бодлого л хэрэгтэй шүү дээ. Өөр юугаар дэмжих юм бэ.

- ▶ *Төр бизнес хийхгүй шүү дээ.*
- ▶ *Төр бизнес хийвэл дампуурна.*
- ▶ *Төр үйлдвэр барихгүй.*

- ▶ *Төр зөвхөн дэд бүтцээр дэмжинэ.*
- ▶ *Төр зөвхөн хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.*
- ▶ *Төр зөвхөн газар олголт, татварын бодлогоор л дэмжинэ.*

Тэгээд энэ уялдаа холбоогоо ер нь энэ олон жил дарга нар хийсэн хүмүүс маань сайн мэддэг байх л гэж би бодож байгаа юм.

Тэгээд зарим зүйл дээр зөв зүйтэй сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгачихсан зүйлүүдийг хэрэгжүүлэх гээд л явж байгаа.

Түүнээс тойргийн эрх ашигтай холбоотой юмыг миний хувьд, Их Хурлын гишүүнийхээ хувьд нэг ч асуудлыг ирэх оны төсвийн төсөл дээр яриагүй, санал дэвшүүлээгүй.

Зарчмын зөрүүтэй, улс оронд хэрэгтэй, орон нутагт тулгамдаад байгаа, иргэдийн амьдралд тулгамдаад байгаа, хувийн хэвшилд тулгамдаад байгаа асуудлуудаа шийдүүлье л гэдэг зорилго тавьж байгаа юм.

Зарим гишүүдийн энэ хэлээд байгаа, хэвлэл мэдээллээр яриад байгаа зүйл дээр үнэн зүйлүүд байгаа шүү дээ.

Ер нь Их Хурлын гишүүдийн саналаа өгөх эрхэд одоо ингэж халддагаа

болих хэрэгтэй. Өөрийн итгэл үнэмшлээрээ саналаа өгөх хэрэгтэй. Үүнийг дэмжинэ, үүнийг дэмжихгүй гээд. Ийм зүйл байж болохгүй гэдгийг энэ дээр хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Ер нь үүнийг бас хэлье гэж бодож байгаа юм.

Тэгээд орон нутгийн зардал хардаа. Энэ улсын төсөв дээр байгаа шүү дээ.

Монгол Улсын улсын төсөв дээр “Орон нутгийн хөгжлийн сан” гээд 599.0 тэрбум төгрөг. Нийслэл ороод 21 аймаг ороод.

Тэгэхэд өнөөдөр бусад урсгал зардал хэд байгаа билээ. Энэ нэг аймагт очсон 10, 20, 30 тэрбум төгрөгөөр тэр аймаг чинь яаж энэ хөрөнгө оруулалтаар сайн сайхан юм хийх гээд тэнд бодож төлөвлөж байна.

Тэгээд үүнийг ер нь цаашид энэ зардлын ялгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэлчихлээ дээ. Тийм ээ. Төсвийн байнгын хороон дарга Ц.Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: М.Бадамсүрэн гишүүний ямар санал хураагдаагүйг би мэдэхгүй юм байна.

Зүгээр ер нь 2 санал хураалгасан. Тэр нөгөө орон сууцжуулалтын асуудалтай холбогдолтой, тэр инженерийн дэд бүтцийг сум, улсын төсөв, орон нутгийн төсөв хамтарчихъя гэдэг асуудал. Энэ бол М.Бадамсүрэн гишүүний санал.

Тэгээд энэ дээр орон нутгийн эрхэд халдаж байна гэдэг зүйлийг Их Хурал дээр ярьсан.

Та бүхэн мэдэж байгаа байх. Энэ санал нь хураагдаад явсан.

Тэр нөгөө жижиг, дунд үйлдвэрийн 40 хэдэн тэрбумыг чинь зээлийн хүүгийн зөрүүнд өгье гэсэн. Энэ нь дэмжигдээд явсан. Гоншигноод байх юм бол уг нь байхгүй л юм байгаа юм.

Зүгээр нэг сургууль, цэцэрлэг санал хураалгасан юм байлгүй дээ.

Тэгэхдээ бүлгээрээ бид зарчим шийдсэн шүү дээ. Энэ жил том төслүүдээ явуулна. Тэр дэд бүтэц дэмжсэн ийм төслүүдээ л хийнэ.

Урсгал зардал хэтэрхий ихсээд байгаа учраас шинээр урсгал зардал бий болгох ийм хөрөнгө оруулалтыг хийхгүй гээд л Засгаас. Энэ чинь Засгийн бодлого шүү дээ. Миний бодлого биш. Тэгээд л энэ зарчмаараа л санал хураагдаад л явсан шүү дээ.

Ер нь зүгээр Их Хурлын индэр ашиглаад дур зоргоороо чалчилдаг гэж бодож байгаа бол тийм юм байхгүй шүү, миний дүү.

Д.Амарбаясгалан:
М.Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Энэ чалчиж байгаа асуудал биш шүү.

Би харин хэлээд байгаа шүү дээ. Төсвийн байнгын хорооны дарга гэдэг хүн бол Засгийн газрын өргөн мэдүүлсэн хуулийн төсвийн төсөл дээр болохгүй

байгаа зүйлүүдийг ажлын хэсэг, Төсвийн байнгын хорооны түвшинд хэлэлцэж үүнийг залруулдаг байх ёстой.

Ингэх гэж Монголын ард түмний парламент байгаа шүү дээ.

Олон зүйл дээр энэ дээр санал хураалгаагүй зүйл байгаа.

Би яах вэ бас ажлын хэсэг дотоод асуудал гээд энэ дээр нэг их яриагүй юм. Шаардлагатай бол үүнийг би ярьж болно.

Ямар ч санал хураалгаагүй шүү дээ. Бид зөндөө санал хураалаа гэж горимын саналууд гаргасан.

Тэгээд яаж байгаа нь мэдэгдэхгүй ингээд чимээгүй Байнгын хорооны дарга маань алга болчихдог.

Тэгээд бодвол бусад дарга нартай зөвлөдөг юм уу, яадаг юм.

Тэгээд л орж ирээд л тэгээд яаж байгаа нь мэдэгдэхгүй ингээд ийм байдалтай ингэж явсаар байгаад л энэ төсөв чинь яг үнэндээ Байнгын хороогоор гарсан шүү дээ.

Д.Амарбаясгалан:

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Тэгээд төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотойгоор нэг асуулт байна. Бид 35.8 их наядын зардалтай ийм төсөв ярьж байна.

Үүнээс гадна төрийн өмчит компаниуд гэж асар том юм байгаа.

Тэгээд үүнтэй холбоотой дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ 8 хувь гэж тооцсон байна.

Тэгээд төсвийн нийт зарлагатай холбоотой дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 37.7 гэж атгаж заасан байгаа.

Тэгээд үүнтэй холбоотой хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, төрийн өмчит компанийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын өсөлтүүд ирэх жилд ямар байдлаар төсөөлж байгаа вэ? Борлуулалтууд нь эдийн засагт ямар нөлөө авчрах гэж байгаа вэ?

Хоёрдугаарт, хүний нөөцийн зах зээл дээр төр томорно гэдэг чинь зөвхөн зардал томрохоос гадна нөөцийн зах зээл дээр өрсөлдөөн бий болж байгаа.

Өөрөөр хэлбэл

- ▶ санхүүгийн зах зээл дээр,
- ▶ хүний нөөцийн зах зээл дээр,
- ▶ дэд бүтцийн зах зээл дээр.

Тэгэхээр энэ дээр “хүний нөөцийн зах зээл” дээр ирэх жил энэ өсөлттэй холбоотой хүний нөөцийн тэлэлтүүд яаж явах гэж байгаа вэ? Энэ дээр төрийн өмчит компанийн болон төрийн оролцоотой хүний нөөцийн өсөлт ямар байдалтай явах гэж байгаа юм? Энэ талаар юу мэдээлэл авъя.

Гуравдугаарт, гадаад зээлийг намуудын мөрийн хөтөлбөр дээр дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувьд хүргэнэ гэсэн заалт байгаа.

Тэгэхээр ирэх жилийн төсвийн хүрээний мэдэгдэл дээр 55 хувь байна л даа.

Тэгээд ерөнхийдөө төсвийн зарлагатай харьцуулахад ер нь буусан трендтэй. 55, 2026 онд 50, 2027 онд 45 гээд ер нь энэ хурдаар 2028 он 40 хувь руу хүрэх ийм шинжтэй байна.

Тэгэхээр энэ жилийн хувьд Засгийн газрын өрийн нийт хэмжээг хэдээр нэмэгдүүлж байгаа энэ өөрчлөлтөө яаж хийх гэж байгаа вэ? Энэ талаар мэдээлэл авахыг хүсэж байна.

Тэгээд ер нь зарим хүмүүс төсвийг 3.6-аар танах хэцүү шүү дээ. Тэгээд та нар жишээлбэл процесс дээр саналаа өгөөгүй шүү дээ гэдэг байдлаар хандаж байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын тухай хууль дээр энэ саналаа гаргах эрх нь байхад одоо жишээлбэл ямар нэгэн жижигхэн шалтгаануудаар гишүүдийг бас дайрахгүй байхыг хүсэж байна.

“Хийх хүнд арга олддог, хийхгүй хүнд шалтаг олддог” гэдэг шиг ингэж нийтээрээ түрж санал бодлоо илэрхийлсэн хүмүүсийг жижиг асуудлуудаар нь дайрмааргүй байна.

Тэгээд энэ төсөв өнгөрсөн онтой харьцуулахад 13 их наядаар нэмэгдсэн. Үүнээс бид 3.6-г нь л хасаад өгөөч ээ гэж байгаа шүү дээ. Энэ дүн дээр нэмэгдсэн 3.6-г хассан ч гэсэн түүхэндээ байхгүй өндөр төсөв болно.

Тэгэхээр хэцүү гээд байгаа. Тэгэхдээ яг энэ асуултыг та хэд аж ахуй эрхлэгчдээс, энэ ард иргэдээсээ асуусан

юм уу? Энэ их тэлэлтийг чинь төлөх боломж байгаа юм уу? Бид нараас энэ танах боломж байхгүй гэж яриад байна. Энэ мөнгийг чинь төлөх боломж ард түмэнд байгаа юм уу?

Өөр нэмж нэг л асуулт. Улс даяараа нийт татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр ямар байгаа вэ тэр талаар мэдээлэл авъя.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн гишүүн хариулъя.

Ц.Даваасүрэн: Би тэр 3.2 их наядыг танах талаар хариулъя.

Ажлын хэсэг дээр болон Төсвийн байнгын хороонд ийм санал гараагүй.

М.Бадамсүрэн гишүүнээс болоод буруу ойлголт явах гээд байна л даа. Гишүүдийн саналыг хураагаагүй юм шиг. Тийм юм байхгүй. Бүх саналыг ажлын хэсэг дээр бид хураасан.

Ер нь зүгээр энэ индрийг ашиглаж бусдыг гүтгэж худлаа ярьж бас болохгүй. Бүх саналыг хураалгасан.

Энэ 3.6 их наядыг таная гэдэг асуудал хоёрдугаар хэлэлцүүлгээс хойш гарсан асуудал шүү.

Тэгэхээр гуравдугаар хэлэлцүүлэг дээр зөвхөн найруулгын шинж чанартай санал хураалт явагддаг. Төсөвт өртөгт нөлөөлөхүйц санал хураалт явуулахыг хориглосон байдаг учраас 3.6 их наядын асуудал гуравдугаар хэлэлцүүлэг дээр явах боломжгүй. Орж ирээгүй асуудал.

Тийм учраас би үүнийг сайн мэдэхгүй байна. Яагаад гэвэл ажлын хэсэг дээр яригдаагүй асуудал.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгөх хүн байна уу? Төрийн өмчит компаниудын өсөлтийг юу гэж тооцож байгаа талаар.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат. 20 дугаар микрофон.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя.

2023 оны байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн нийт хөрөнгө нь **64.2 их наяд төгрөгт** хүрч, өмнөх оноос **8 хувиар өссөн** ийм үзүүлэлттэй байгаа.

▶ Төрийн өмчийн компаниудаас нийтдээ **4.9 их наяд төгрөгийн орлого төсөвт 2023 оны байдлаар төвлөрүүлж байсан бол**

- татварын орлогоор **4.4 их наяд,**
- ногдол ашгийн орлогоороо **449.8 тэрбум** төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

▶ Эдгээр төрийн өмчийн компаниудаас ирэх **2025 онд 6.3 их наяд төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тооцсон. Үүнээс**

- татварын орлогоор **5.7 их наяд,**
- ногдол ашгийн орлогоор **607.1 тэрбум** төгрөгийг төвлөрүүлэхээр тооцохоор төсөвт тусгасан байгаа.

Д.Амарбаясгалан:

Ц.Даваасүрэн гишүүн сая Төсвийн байнгын хороон дээр хэлэлцсэн

тогтоолын талаараа нэмж хариулт өгөх юм уу?

Ц.Даваасүрэн гишүүнд хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Тийм. Одоо энэ урсгал зардлыг шууд хасъя гэдэг асуудал чинь нөгөө хоёрдугаар хэлэлцүүлгээс хойш болсон учраас хоёрдугаар хэлэлцүүлэг дээр дэгээрээ зөвхөн найруулгын чанартай засвар хийдэг санал гаргадаг.

Тэгэхээр үүнийг шууд хэлэлцэх боломжгүй байгаа учраас гишүүдтэй ярилцаад Тамгын газраас бас Төсвийн хэрэгжилтийг хангах тогтоол гаргая.

- ▶ Тогтоолын хүрээнд урсгал зардлын асуудлыг авч хэлэлцье.
- ▶ 12 сардаа багтааж тодотгол хийе

гэдэг ийм тогтоолын төслийг оруулж ирсэн байгаа. Тийм.

Тодотголын төслийг 12 сардаа багтаад өргөн бариад хэлэлцэх ёстой.

Ер нь зардал сүүлийн 3 жилд 3 дахин өссөн нь үнэн шүү.

Зүгээр харин энэ өсөж байх үед нь яагаад дуугүй байгаад байсан юм гэдэг асуудал байгаа юм. Би тухайн үед нь хэлдэг л байсан. Ганц нүүрснээс хамаарч байгаа эдийн засагтай мөртлөө ингээд төсвөө 2 дахин тэлээд байж болохгүй. 3 дахин.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя.

Тэр өртэй холбоотой. Энэ одоо яг хүрээ ярьж байгаа. Хүрээн дээр байгаа тоонууд тухайн эдийн засгийнхаа ангилал, үзүүлэлтийнхээ дандаа хязгаар тоонууд. Үүнээс хэтэрч болохгүй шүү гэдэг л ийм тоонууд шүү дээ.

Бид бараг сүүлийн 30-аад жил хэлэлцэж байгаа л ийм тоо.

Хэлэлцэх бүрд л ийм асуулт гардаг юм. Тэгээд энэ дээр ирэх жил 55 хувь. Өрийн хязгаар чинь 55 хувь шүү.

Төсвийн хууль дээр чинь болохоор гүйцэтгэл 42.6-аар бид гаргана гээд хуулиа өргөн барьчихсан.

Одоо ингээд батлах гээд байж байгаа. Юун 55. 42.6-аар гүйцэтгэл гаргана гээд.

Энэ жил жишээ нь 2023 оны гүйцэтгэлийг бид сарын өмнө ярилцсан, баталсан.

Тэр үед өрийн хязгаар хүрээгээрээ 60 хувь. Гүйцэтгэл 38.9 хувьтай гарсан шүү дээ. Бүр 20 хувийн зөрүүтэй ийм нөөцтэй.

Ирэх жил ер нь яах вэ, өнөөгийн үнэ цэнээр бодсон бол 40 хувьдаа багтаж гарна.

Д.Амарбаясгалан:

Ц.Даваасүрэн гишүүн асуулт дээр бас жоохон нэмээд тодруулчихъя гэж бодоод байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүд төсөв хэлэлцэж байгаа дэгтэй холбоотой

асуудал дээр бас зарим талаар эргэлзээ гараад байх шиг байгаа юм.

Дэгийн тухай хуулийн 32.1-ээр хэлэлцэж байгаа хуулийн төсөл нь аль ч шатнаас “татаж болно”, бас “буцааж болно” гэдэг ерөнхий ойлголт явж байгаа.

Гэхдээ дэгийн тухай хуулийн 9 дүгээр бүлгээр төсөв нь өөрөө тусгай дэгээр хэлэлцэгдэж байгаа. Төсөв хэлэлцэх дөрөв дэх хэлэлцүүлэг байгаа.

Нэгдүгээр хэлэлцүүлэг орж ирлээ. Нэгдүгээр хэлэлцүүлэг дээр төсвийн танилцуулга хийгдэнэ. Улсын Их Хурлын гишүүд бүгдээрээ асуултаа асууна. Үг хэлнэ.

Үүний дараа хөгжлийн бодлого төлөвлөлттэй орж ирсэн төсөв нь нийцэж байгаа эсэхээр санал хураалт явуулдаг.

Тэр санал хураалт дэмжигдсэн тохиолдолд төсөв цаашаа хэлэлцүүлэгт орно. Дэмжигдээгүй тохиолдолд төсөл санаачлагчид буцаана. Буцаагдсан тохиолдолд 3 хоногийн дотор Засгийн газар засварлаад дахин өргөн барих ийм процесстой.

Хоёрдугаар хэлэлцүүлэг. Улсын Их Хурлын байгуулагдсан ажлын хэсгийн түвшинд Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороодын түвшинд зарчмын зөрүүтэй саналууд гарч, санал хураагдаж, тэр хураагдсан санал нь Улсын Их Хурал руу “дэмжигдсэн” болон “дэмжигдээгүй” томъёоллоор орж ирж зарчмын зөрүүтэй санал хураалт явагдаж байгаа.

Ингээд үндсэндээ нэгдүгээр хэлэлцүүлэг дээр хөгжлийн бодлого төлөвлөлтөд өргөн барьсан төсөв нийцэж

байна гээд үзчихсэн тохиолдолд Засгийн газар эргүүлж татаж авах боломжгүй, Улсын Их Хурлаас төсвийг буцаах боломжгүй ийм нөхцөл рүү орчхож байгаа юм.

Тэгэхээр ийм тусгай дэгээр явж байгаа гэдэг ойлголт дутуу байсан учраас бас зарим гишүүд маань гаргасан шаардлагууд явж байгаа.

Мэдээж гаргасан шаардлага дээр яг хуулийн үндэслэл ярих юм бол бас хэцүү, боломжгүй.

Гэхдээ Улсын Их Хурлын гишүүдээс төсвийн урсгал зардлыг танах ёстой гэсэн байр суурь гарч, бас олон нийтэд мэдээлж, олон нийтийн тодорхой хэмжээнд байр суурийн хувьд урсгал зардлыг багасгах нь зүйтэй гэсэн ийм нөхцөл үүсэж байгаа учраас Улсын Их Хурлын зүгээс, Төсвийн байнгын хорооны зүгээс сая Ц.Даваасүрэн гишүүний танилцуулсан тогтоолын төслийг санаачилж өнөөдөр Төсвийн байнгын хороо хуралдаж батлаад, одоо төсвийн гуравдугаар хэлэлцүүлэг дээр энэ тогтоолын төсөл хамт орж ирж хэлэлцүүлэгдэж явахаар байгаа.

Уг тогтоолын төслөөр юу болж байна вэ гэхээр,

- **Нэгдүгээрт,** Монгол Улсын мөнгөний бодлого төсвөөс 2025 оны төсөвтэй уялдаж байгаа эсэх. Нэг дэх асуудал яригдана.
- **Хоёрдугаарт,** уг төсөвт Улсын Их Хурлын гишүүдийн шаардаж байгаачлан урсгал зардлыг бууруулах нөхцөл байдал байгаа учраас төсвийн тодотголыг энэ ондоо багтаж хий гэдэг

энэ тогтоолыг Төсвийн байнгын хороо сая баталж байгаа юм.

Одоо ямар чиглэл рүү явах вэ гэхээр төсөв эцэслэн батлагдсаны дараа Улсын Их Хурлын даргын захирамжаар Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг гараад Засгийн газраас төсвийн тодотголтой холбоотой асуудал дээр хамтарч ажиллана.

Улсын Их Хурлын ажлын хэсэгтэй аудитын байгууллага болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хамтарч ажиллана.

Засгийн газар, Сангийн яам төсвийн тодотголтой холбоотой асуудлаар батлагдсан төсөв дээр үнэлэлт өгч тодотгол хийх үндэслэл, шаардлагуудаа тодорхой болгож, энэ ондоо багтааж төсвийн тодотголыг өргөн барих ийм зохицуулалт руу орсон байгаа гэдгийг Та бүхэнд хэлмээр байгаа юм.

Мэдээж хэрэг нэг зүйлийг маш сайн ойлгох ёстой.

Бид хуульд л захирагдаж ажиллана.

Төсвийн тухай хуулийг хэлэлцэж байгаа дэг өөрөө нэг, хоёр, гурав, дөрөвдүгээр хэлэлцүүлэг яаж явах вэ гэдгийг маш нарийвчлаад хуульчлаад өгчихсөн.

Түүнээс гажих боломжгүй.

Одоо гуравдугаар хэлэлцүүлгийн түвшинд төсвийг буцаачих, төсвийг татаад авчих гэж гишүүд шаардаж байна. Гэтэл хуулийн зохицуулалт нь байхгүй.

Мэдээж хэрэг бусад хуультай адилхан төсвийг ингэж хэлэлцэх боломжгүй гэдэг нь тусгай дэгээр зохицуулж байгаагаас харагдаж байгаа юм.

Хэлэлцүүлгийн шат болгонд нь төсвийг буцааж ав, татаж ав гэдэг асуудал үүсдэг бол төсөв батлагдана гэдэг ойлголт байдаггүй учраас өмнөх өмнөх парламентаас олж авсан туршлагаар шинэ дэг ийм болсон байгаа гэдгийг бас бүрэн ойлгож гишүүд маань асуудалд хандахыг хүсэж байна.

Энэ тогтоолын төсөл дараагийн төсвийн гуравдугаар хэлэлцүүлэг дээр танилцуулагдаж, яригдаж явна гэдгийг хэлье.

Ингээд **Нямтайширын Номтойбаяр** гишүүн асуулт асууна.

Н.Номтойбаяр: Энэ төсөв хэлэлцэж байх явцад нэг зүйл ажиглагдаад байна.

Сая энэ М.Бадамсүрэн гишүүний хэлж байгаа бол үнэн шүү дээ.

Нөгөө хал цэрэг, шинэ цэрэг гэдэг шиг шинэ, хуучнаараа ялгагдаад л шинэ гишүүдээ дарамтлаад л. Үг, үзэл бодлыг нь илэрхийлэхгүй.

Тэгээд энэ төсвийн ажлын хэсэг 10.00 цагт хуралдана гээд л зарласан. 12.00 цаг болсон, 15 цаг болсон. Тэгээд тэр өдөртөө хуралдаагүй шүү дээ.

Тэгээд Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хуралдахаас өмнө хуралдсан болоод л явсан.

Тэгээд бүх сэтгэхүйгээ хаячихмаар байна. Нэг шинэ хуучин гээд л бөхийн дэг жаягийг нь тогтоох гээд байгаа юм уу, яах гээд байгаа юм. Тэгээд л нэг эрэмбэ дараа тогтоох гээд л.

Тэгээд ялангуяа энэ төсөв хэлэлцэж байхад Их Хурлын гишүүдийн энэ улс төрийнх нь эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандчихмаар байна.

Тэгээд л нэг үг хэлэнгүүт нь айлгаад л, дарамтлаад л, муухай муухай хараад л. Тэгж амжихгүй шүү.

Энэ төсөв хэлэлцэж байхад Ерөнхий сайд чинь орж ирдэггүй юм уу? Энэ хүн чинь л хар толгойгоороо хариуцах ёстой биз дээ. Энэ хүнээс л асуулт асуумаар байна шүү дээ.

Түүнээс Сангийн сайдаас юугаа асуух юм бэ? Төсвийн байнгын хорооны даргаас юугаа асуух юм. Тэртээ тэргүй энэ төсөв байна шүү дээ 0.7-хон хувийн өөрчлөлттэй орж ирсэн. Өөрөөр хэлбэл Засгаас өргөн барьсан төсөв Улсын Их Хурлаар 100 хувь дамжигдаад л гарч байгаа шүү дээ.

Тэгээд одоо төсөв батлагдмагц тодотголын асуудлууд орж ирнэ. Их Хурлын дарга бас нэг парламентын ардчилал, энэ нэг хэдэн гишүүдийн санал нэгдэж гаргасан 3.4 их наядын урсгал зардлыг хасъя гэдэг дээр тодотгол хийе гэж байгаа юм.

Тэгээд Засгийн байр суурь ямар байгаа юм. Б.Жавхлан сайд аа. Тэгээд Төсвийн байнгын хороо нь хуралдчихаад байгаа юм байна.

Сая Ц.Даваасүрэн гишүүн бас үнэний ортой л юм хэлж байна шүү дээ.

Зөвхөн нэг муу түүхий нүүрс экспортолдог. Үнэ ч унаад л байна. Өдрөөс өдөрт л унаад л байна.

Энэ төлөвлөсөн төсвийн орлого чинь худлаа шүү дээ.

Инфляц 2 оронтой тоонд хүрнэ гээд байгаа нь мэргэжлийн улсуудын үг бас үнэн шүү дээ. 20 мянган төгрөгөөр худалдаж авдаг адилхан бараа, үйлчилгээг тун удахгүй бид 40 мянган төгрөгөөр л худалдаж авна шүү дээ.

Долларын ханш тун удахгүй 3700 хүрнэ гээд л мэргэжлийн улсууд яриад л байна. Бас үнэн шүү дээ.

Тэгээд энэ тодотголын асуудал нэг гөлөг төөрүүлж байгаа юм шиг асуудалд ердөөсөө хандаж болохгүй ээ.

Тэгээд энэ дээр Засгийн газар өөрөө хэр итгэл үнэмшилтэй байгаад байгаа юм. Тэгээд энэ нэг мөрийн хөтөлбөр гэж нэг зүйл 3-хан сарын өмнө л Их Хурлын сонгуулиар бүгдээрээ л ярьсан.

Тэгээд сонгууль явагдсан. Энэ мөрийн хөтөлбөр гэдэг чинь уг нь иргэд сонгогчидтойгоо, улс төрчид байгуулж байгаа итгэлцлийн гэрээ л ухаантай юм шүү дээ.

Тэгээд энэ гэрээнээсээ ухарч байна шүү дээ. Залилан хийж байна шүү дээ. Шууд залилан хийнэ. Тэгээд дамнуулаад хулгай хийнэ. Тэгээд энэ Засгийн газар бүрдүүлсэн Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам нийлээд залилан хийж байна.

Тэгээд нэг ийм төөрүүлэх байдлаар ингээд нэг тийм нэг шинэ,

хуучин он цагийн ялгаа гаргаад л, шинэ гишүүдийгээ дарамтлаад л, тэр тусмаа жагсаалтаар ороод ирчихсэн нөхдүүдийгээ гөлөг болгох гээд л.

Ийм зүйл энэ парламентад байж болохгүй. Парламентын дархлаа гэж байна, улс төрийн эрх чөлөө гэж байна.

Ер нь хэзээ ч төсөв ингэж баталж байгаагүй шүү дээ. Хэзээ ингэж баталж байсан юм. Хуучин гишүүд бүгдээрээ л бид мэднэ шүү дээ. Хэзээ ч ингэж баталж байгаагүй. Энэ арай л хэтрээд байна л даа.

Энэ тодотголтой холбоотой асуудал дээр Засгийн газар ямар байр суурьтай байгаа юм? Дэмжих юм уу, дэмжихгүй юм уу?

Д.Амарбаясгалан: Нэгдүгээрт төсвийн хүрээ, 2026-2027 оны төсөөлөл ярьж байгаа.

Тэгэхээр энэ дээр Ерөнхий сайд заавал суух албагүй. Ажлын хэсэг, Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд нар орж ирээд энд өргөн барьсан, хариуцаж байгаа чиглэлийнхээ дагуу асуултдаа хариулаад явж байгаа.

Төсөв өргөн бариад нэгдүгээр хэлэлцүүлэг хийгээд хөгжлийн бодлого төлөвлөлтөд нийцэж байна гэж гишүүдийн олонх дэмжсэнээс хойш төсөв хэлэлцэх болон батлах, төсөвт өөрчлөлт оруулах бүх асуудал Улсын Их Хуралд шилжиж байгаа.

Тэгэхээр мэдээж Улсын Их Хурлын ажлын хэсэг, Байнгын хороодын ажиллагаа энэ дээрээ илүү анхаарлаа тавьж ажиллах ийм шаардлагууд өндөр байдаг.

Мэдээж энэ жил сонгуулийн жил. Олон олон гишүүд маань шинээр ороод ирчихсэн. Гишүүдийн саналтай нэг байна. Олон сонгогдсон, нэг сонгогдсон гэдэг ялгаа байх учиргүй.

Гэхдээ олон сонгогдсон гишүүд маань бас хуримталсан туршлагаасаа хуваалцаж, бусад гишүүддээ бас алдаж онож байгаа зүйлүүдээр нь засаж залруулахад нь тусалж, дэмжиж энэ парламентын хамтын ажиллагааг бэхжүүлэх тал дээр анхаарах ёстой.

Нөгөө талаараа бид Улсын Их Хурлын гишүүнийг “тойргоос сонгогдсон”, “жагсаалтаар сонгосон” гэж ялгаварлах асуудал байж болохгүй.

Монгол Улсын Үндсэн хуулиараа Улсын Их Хурлын гишүүн гэдэг нэг л ойлголт байдаг.

Тэгэхээр аливаа асуудалд бүгдээрээ эрх тэгш оролцоно. Үгээ хэлэхдээ эрх тэгш байна, асуултаа асуухдаа эрх тэгш байна, шийдвэр гаргахдаа бас эрх тэгш байх ёстой.

Хэн нэгний нөлөөлөлгүйгээр саналаа өгөх эрх нь бүх түвшинд нээлттэй байгаа.

Мэдээж энд улс төрийн намууд өөрсдийн улс төрийн бодлогын хүрээнд аливаа асуудал дээр яаж санал өгөх вэ гэдэг улс төрийн шийдвэрээ гаргаж оролцож байгаа.

Тэр шийдвэрийг ч гэсэн бусад нь хүндэтгэх ёстой. Улс төрийн намгүйгээр парламентын засаглал гэдэг ойлголт байхгүй. Өнөөдөр 5 нам, эвслийн бүлэг орчихсон парламент энэ асуудал дээрээ

төвлөрч, ярьж, ойлголцож сурах ёстой гэж ингэж бодож байгаа.

Тэгэхээр төсвийн тодотгол хийх асуудлыг мэдээж Төсвийн байнгын хороо шийдвэр гаргаж сая саналаа хурааж байгаа. Мэдээж Засгийн газар, Сангийн сайдаас энэ асуудалтай холбоотойгоор боломжтой эсэхийг нь тодруулж байж шийдвэр гаргаж байгаа.

Тэгэхээр Сангийн сайд энэ дээр товчхон хариулт өгчихье.

Б.Жавхлан: Н.Номтойбаяр гишүүний асуултад хариулъя.

Нэлээн дэлгэрэнгүй асуулт шүү. Их Хурлын дарга аа. Би тэгээд хариулахгүй бол бас болохгүй байх.

Засгийн газрын байр суурь маш ойлгомжтой.

9 сарын 01-нд бид шинэ цаглавраар төсөв өргөн барьсан.

Түүнээс хойш үндсэндээ 70 хонож байна. 70 хоног Улсын Их Хурал дээр хэлэлцэж байна гэсэн үг. Бид өмнөхөөсөө нэг сарын өмнө өргөн барьсан гэсэн үг.

Гэтэл одоо гарч ирж байгаа асуудал энэ яг гуравдугаар хэлэлцүүлгийн өмнө гарч ирж байгаад л бид гайхаад байгаа юм. 70 хоног хэлэлцэгдсэн шүү.

Гэнэт өчигдөр төсөв барьсан юм шиг асуудал ингэж үүсэж байгаад гайхаад байгаа юм. Асуудал эндээ л байгаа юм.

Түүнээс биш энэ хэлэлцүүлгийн явцад тэгж өөрчилнө, ингэж өөрчилнө.

Саяын гарч ирж байгаа тоо нэлээн тийм ажил хэрэгч байдлаар хэрвээ явсан бол энэ дээр чинь бүгдээрээ л тал талаасаа сууна шүү дээ.

Гэтэл ерөөсөө ийм юм болоогүй. 8 сард хийсэн тодотгол бол энэ шинэ Засгийн газрын энэ эхлэл дээр Улаанбаатар хотынхоо түгжрэлийг. Энэ бол Монгол Улсын өөрийн хямрал болчихоод байгаа юм. Эндээсээ нэг дорвитойхон гарья гэдэг ийм л тодотгол байсан.

3.2 их наядын тодотгол. 2.5 нь нийслэлд зориулж байсан.

Хэдхэн хоногийн дараа. Бараг хоногийн зөрүүгүй дээ. 9 сарын 01-нд өргөн барьсан 2025 оны төсөв бол одоо мөрийн хөтөлбөрөө баталмагц энэ мөрийн хөтөлбөрөө биелүүлэх эхний том төсөв.

14 мега төслөө явуулъя. 14 реформоо эхлүүлъя. Нэг хүнд ногдох үндэсний орлогоо 10 мянган долларт хүргэе гэдэг ийм л 2025 оны төсөв байсан.

Яг угсраад орж ирж байгаа учраас мэдээж одоо энэ дээр өсөлт байж л таарна. Өсөлтийг дагаад эрсдэл байдаг.

“Мөнгөний бодлоготой нийцүүлнэ” гэдэг нэг өгүүлбэр явж байна лээ.

Мөнгөний бодлоготой нийцүүлж төсөв хийнэ гэдэг ойлголт байж болохгүй. Эсвэл төсөвтэйгөө нийцүүлж мөнгөний бодлого хийнэ гэдэг ийм ойлголт байж болохгүй.

Энэ хоёр бодлого хоёр талаасаа өөрсдөө нийцтэй байхын төлөө зорих хэрэгтэй.

Гэтэл энэ жил ингээд төсөв нь 9 сарын 01-нд өргөн баригдаад, мөнгөний бодлого нь сарын дараа 10 сарын 01.

Төсөв өргөн баригдахад инфляцаа голч 6 хувь гэж байсан. Сарын дараа мөнгөний бодлого орж ирэхдээ 5 хувь болоод өөрчлөгдөөд ороод ирсэн.

Тэгэхээр хойтон энэ хоёрыгоо зэрэг өргөн барьдаг бас ийм хугацаатай болох дээр анхаармаар юм байна гэж харагдана лээ шүү.

Тэгээд энэ 14 мега төслөө бид явуулахын тулд маш олон зүйлийг бид хойш нь татсан.

Жил бүр ер нь дунджаар 500-аас 600 шинэ төсөл орж ирээд тойрог бүр дээр очдог, энэ орон даяар хийгддэг бүтээн байгуулалтууд явдаг байсан.

Тэгвэл энэ удаа 500, 600 биш 38-хан шинэ төсөл орж ирсэн. 38-хан шүү.

Мэдээж гишүүдийн тойрог дээр нь хөрөнгө оруулалтууд нэг жил завсарлах, хойшлуулах, энэ нэлээн хүнд байдалд оруулсныг бид ойлгож байна.

Гэхдээ дийлэнх гишүүд маань шинэ Их Хурал, шинэ хандлагаар энэ бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалыг тууштай дэмжээд явах нь гэдэг ийм итгэл үнэмшил бид.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Ийм итгэл үнэмшилтэйгээр ингээд явж байгаа.

Ингээд одоо Улсын Их Хурал ямар ч байсан төсвөө батална гэдэгт бид ингээд хүлээгээд сууж байна. Засгийн газар.

Ямар төсөв батална тэр нь бид үйл ажиллагаагаа явуулдаг л ийм л хуультай.

Тодотгол гэж яригдаж байна. Яах вэ, хуулиа харна биз. Хуультай зөрчилдөхгүй л байгаасай гэж хүсэж байна.

Тэгээд хуулийн зөрчил үүсэхгүй ийм янз бүрийн мухардалд орчихгүй бол тэгээд л Их Хурлаас тодотгол хий гэвэл бид хийгээд л явна.

Алдагдлаа бууруул гэж байгаа дээр бид 100 хувь санал нийлж байна.

Харин зарим нэг зүйлээ бид хойш нь тавихаас өөр арга байхгүй. Нөгөө 14 мега төсөл маань нэлээн л наанатай цаанатай болж ирэх байх.

Нэг хүнд ногдох үндэсний орлогоо 10 мянган долларт хүргэнэ гэдэг ойрын зорилго маань нэлээн хойшлох байх.

Гэхдээ алдагдалгүй төсөв батлаад гараа хумиад нэлээн тийм тайван алсуурхан ингээд л явсан ийм он жилүүдийг л бид явах болов уу л гэж харж байгаа юм.

Түүнээс биш алдагдалгүй төсөв батлахад сонголт байгаа бидэнд. Маш амархан.

Д.Амарбаясгалан: Тогтоолын төслийг тодорхой хуулийн заалтуудыг үндэслэж баталж байгаа.

Б.Жавхлан сайдад бас хариулт өгөхгүй бол. Бас хуулиа харахгүйгээр, хуульд нийцүүлэхгүйгээр бид тогтоол батлах боломжгүй. Тийм ээ.

Нэгдүгээрт нь, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу Улсын төсөв, макро эдийн засгийн төлөв байдалд болон төсвийн тусгай шаардлагыг баримтлахад нөлөөлөх талаар үнэлгээ хийж Улсын Их Хуралд танилцуулах.

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу төсвийн тодотголын төслийг 12 дугаар сард багтаах гэсэн ийм хоёр заалтаар сая Төсвийн байнгын хороо хэлэлцээд баталсан байгаа.

Үүнийг дараагийн гурав дахь асуудал дээр, танилцуулга дээр ярина.

Нямтайширын Номтойбаяр гишүүн тодруулж асууя.

Н.Номтойбаяр: Асуулт байхгүй үг хэлчихье.

Б.Жавхлан сайдын байр суурийг маш сайн ойлголоо.

Бодит байдлыг бас сайн мэдэж байгаа юм байна.

Тэгээд би яагаад урьдчилаад. Одоо энэ асуудлын чинь дараа Д.Амарбаясгалан даргын яриад байгаа Төсвийн байнгын хорооны тогтоолыг оруулж ирэх гэж байна.

Энэ дээр мэдээж дэлгэрэнгүй ярина.

Дээрээс нь Д.Энхтүвшин, Ж.Баярмаа, Г.Тэмүүлэн нарын гишүүдийн санаачилсан “төсвийн урсгал зардлаас 3.4 их наядыг хасъя” гэдэг асуудал мэдээж тодотголоор орж ирэх нь. Талархалтай хандаж байна.

Энэ асуудал дээр ер нь төсөв хэлэлцэж байхад Ерөнхий сайд байнга л байх ёстой байхгүй юу. Байдаг л тийм дэг жаягтай шүү дээ. Байх шаардлагагүй гээд байх хэрэггүй.

Яагаад би энэ асуудлыг хөндөөд байна вэ гэхээр нэг асуудал үүсэнгүүт нэг окопт орчихдог.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дараагийн гишүүн асуулт асууна.

Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууна.

А.Ганбаатар: Гишүүд та нарт өдрийн мэнд хүргэе.

Энд нэг тодорхой асуулт байгаа юм. Иргэд, татвар төлөгчид улсын төсвийг хэрхэн зарцуулж буйд хяналт тавьж, хуулийн төсөлд санал өгөх эрх нь хуулиар зохицуулагдсан байж байгаа.

Тухайлбал, Төсвийн тухай хуулийн 28.1-д заасны дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж гэсэн заалт жоохон зөрчигдөөд байх шиг байна.

Энэ жоохон бүдэг яваад байх шиг байна гэж би хараад байгаа юм.

Олон нийтээс санал авсан гэдгээ нөгөө “цахим парламент” гэдгээр санал авчихсан гэж тайлбарлаж магадгүй.

Энэ талаар ерөөсөө мэдээлэл өгөөгүй.

Бүх хэлэлцсэн хуулийн төслийн өмнө “цахим парламент”-аар хэдэн хүнээс, ямар салбараас, ямар саналууд ирсэн юм бэ?

“Дэмжсэн”, “дэмжээгүй” гэдэг тоо баримт хувь, процентоор гарсан юм уу?

Үүнийг мэдээлэхгүй болохоор шүүмжлэлтэй хандаж байгаа.

“Төсөв таная” гэж ярьж байгаа гишүүдийн барьж байгаа үндэслэл материал нь миний харж байгаагаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гарсан дүгнэлтүүд.

Аудитын гаргасан дүгнэлтийг барьж яриад байна шүү дээ. Энэ цаасыг уншаад байж болно л доо.

Тэгэхээр гишүүдээс гадна жинхэнэ татвараа төлж байгаа хувь хүн, хувийн хэвшил маань яах юм бэ?

Энэ хуульд чинь өөрсдийнхөө хүсэл санаагаа тусгаж чадсан юм уу гэдгийг.

Хэмжих нэгжгүй болчхоод байна л даа.

Энэ талаар мэдээлэл ерөөсөө орж ирэхгүй байна. Их Хурал дээр.

Монголын Үндэсний радио, телевиз биднээс хураамж авч байгаа.

Олон нийтийн радио, телевиз янз бүрийн хуучин баримтат кино гаргаж байхаар энэ төсвийн хуулийг нэг бүрчлэн, салбар салбараар нь, иргэд, иргэдээс нь авсан саналаар нь хэлэлцүүлгийг яг энэ төсөв хэлэлцэх энэ хугацаанд давхар явуулж баймаар байгаа юм.

Зөвхөн мэдээ төдий бусад телевизүүдээр гараад байна л даа.

Парламентын сурвалжлагч нар үнэнийг хүргэхэд хангалтгүй гэж харж байна.

Тэгэхээр үүнийг яаж зохион байгуулж байгаа юм бэ гэсэн нэгдүгээр асуулт байна.

Хоёрт нь, яах вэ зүгээр өөрийнхөө бодлыг хэлэхэд татвар бол төлөх ёстой. “Үхэх нь үнэн татвар төлөх нь үнэн” гээд бас үг байж байдаг.

Тэгээд хүн яах гэж татвар төлдөг юм бэ гэхээр амь амьжиргааг дээшлүүлье, ашиг орлогоо дээшлүүлье, амьдрах орчин, эрүүл мэнд, боловсролоо дээшлүүлье, батлан хамгаалуулья, дайн самуун гарвал батлан хамгаална гэх мэтээр.

Үүнд зориулж татвар төлж байгаа шүү дээ.

Тэгэхээр татварыг багагүй авч байгаа шүү дээ. Бидний хадгаламжийн хүүгээс хүртэл татвар авч байгаа.

Тэгэхээр ард иргэд, хувийн хэвшил татвараа хангалттай төлж байгаа.

Үүнийхээ хариуд төрөөс төсөвлөж байгаа, зориулж байгаа үйл хэрэг нь ард түмэндээ хүрч байгаа юм уу, яг хүндээ хүрч байгаа юм уу гэдэг дээр “хэмжих нэгж” байдаг юм болов уу даа.

Тэгээд л ганцхан “нүүрс” яриад байна. “Зэс”, “алт” гээд коммодити^[түүхий эд] юмнуудаас тогтож байна гэж яриад байна.

Үүнээс гадна орлого олох гэдэг юм уу, татвараа танахаас илүүтэйгээр орлого нэмэх зөндөө вариантууд байна гэж хараад байна л даа.

Тухайлбал, манай бүлгийн хурал дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл мэдээлэл хийхдээ төрийн өмчийн 100 гаруй, 108 компани байгаа.

Үүнээс олигтой ажиллаж байгаа нь “Эрдэнэт”, “Эрдэнэс Тавантолгой” байлаа. Ашигтай.

Тэгээд үндсэндээ бусад нь ашиггүй ажиллаж байгаа гэж байна лээ шүү дээ.

Тэгэхээр **ТЕМАСЕК**-ийн загвар барих гээд байгаа бол яг

- ▶ алиныг нь улсын үйлдвэр болгоод төр барьж явах юм,
- ▶ алиныг нь төр, хувийн хэвшилээр хийх юм,
- ▶ алиныг нь *public limited company*, олон нийтийн болгох юм.

Үүнийгээ тодорхой болгочихвол үүнээс орж ирэх орлого төсөв дээр чинь нэмэх болж харагдах юм.

Ингээд төсвийн тодотгол орж ирэх юм байна.

Тэгэхээр манай гишүүдийн өргөн барьж байгаа санал, гарын үсэг зурж байгаа асуудал шийдэгдэх юм байна.

Тэгээд нэг юмыг хэлэхийг хүсэж байна.

Гарын үсэг зурсан нь баатар болоод, зураагүй, төсөв дээр өөрсдийнхөө байр суурийг хэлээд, хамтарсан Засгийн газар том ажил хийхийг дэмжиж байгаа нь дайсан болж болохгүй л дээ.

Д.Амарбаясгалан: Төсвийн хэлэлцүүлгийг олон нийтийн дунд явуулсан, зохион байгуулсантай холбоотойгоор Их Хурлын Тамгын газар хариулах уу?

Б.Баасандорж дарга. 11 дүгээр микрофон.

Б.Баасандорж: Улсын Их Хурлын дарга, гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газар.

Монгол Улсын Засгийн газраас төсвийн тухай хуульд заасны дагуу 2024 оны 8 сарын 30-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг өргөн мэдүүлсэн.

Төсвийн төслийг өргөн мэдүүлсэнтэй холбоотойгоор дэгийн тухай хуульд заасан журмын дагуу

→ 2024 оны 9 сарын 01-нд “D-Parliament” цахим хаягт

байршуулсан. Төсвийн төслийг.

→ 2024 оны 9 сарын 02-ны өдөр Улсын Их Хурлын нийт 126 гишүүддээ “цахим хаягаар” хүргүүлсэн байгаа. 9 сарын 02-нд.

→ 2024 оны 9 сарын 13-ны өдөр “цаасаар” товхимол болгоод бүх 126 гишүүндээ мөн хүргүүлсэн байгаа.

→ Төсвийн төслийг өргөн мэдүүлсэнтэй холбоотойгоор Төсвийн байнгын хороо болон Улсын Их Хурлын Тамгын газраас 2024 оны 9 сарын 26-ны өдөр “Хөгжлийн бүтээн байгуулалтын онцлох төслүүд” сэдэвт хэлэлцүүлгийг олон нийтэд зохион байгуулсан.

→ Мөн “Эрүүл мэндийн салбарын 2025 оны төсөв” сэдэвт хэлэлцүүлгийг 9 сарын 26-ны өдөр зохион байгуулсан.

Ингээд Улсын Их Хурлын чуулганы хуралдаан маань дэгийн тухай хуульд заасны дагуу

▷ **Нэг дэх хэлэлцүүлгийг** чуулганы нэгдсэн хуралдаанаар

▷ 2024 оны 10 сарын 04-ний өдөр,
▷ 2024 оны 10 сарын 18-ны өдрүүдэд хоёр долоо хоног дамнаж нэг дэх хэлэлцүүлгийг хийсэн.

Ингээд нэг дэх хэлэлцүүлгийг хийж, Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжиж, Төсвийн байнгын хороо болон холбогдох Байнгын хороодод шилжүүлсэнтэй холбоотойгоор “Улсын

Их Хурлын даргын захирамж” 10 сарын 21-нд гарсан.

Өөрөөр хэлбэл “Ажлын хэсэг” гарсан. Төсвийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх.

Ингээд хоёр дахь хэлэлцүүлгийг бусад Байнгын хороо буюу 11 Байнгын хороо, Тусгай хяналтын дэд хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд салбар бүрээр нь төсвийн хоёр дахь хэлэлцүүлгийг Байнгын хороо тус бүр хийсэн.

Ажлын хэсэг 2024 оны 10 сарын 22, 23, 29-ний өдрүүдэд 11 Байнгын хороо дэд хороодоос гарсан, мөн гишүүдээс гарсан зарчмын зөрүүтэй санал тус бүрийг хэлэлцсэн.

Үүнийг хэлэлцэж дууссантай холбоотойгоор

▷ **Хоёр дахь хэлэлцүүлгийг** Төсвийн байнгын хороо

▷ 2024 оны 10 сарын 30-ны өдөр хийсэн.

→ Ингээд 10 сарын 30-ны өдөр Төсвийн байнгын хороо хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн танилцуулгыг мөн “D-Parliament” цахим хаягт байршуулсан.

Чуулганы нэгдсэн хуралдаан хоёр дахь хэлэлцүүлгийг

▷ 2024 оны 10 сарын 31,
▷ 2024 оны 11 сарын 01 буюу хоёр өдөр дараалж хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн.

▷ **Гурав дахь хэлэлцүүлгийг** Төсвийн байнгын хороо 2024 оны 11 сарын 05-ны өдөр хийсэн.

Төсвийн байнгын хороо гурав дахь хэлэлцүүлгийг хийсэн танилцуулгыг мөн “D-Parliament” цахим хаягт байршуулсан байгаа. Гишүүд ээ.

Ингээд чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр буюу 11 сарын 08-ны өдөр дэгийн тухай хуульд заасны дагуу гурав дахь хэлэлцүүлгийг хийхээр бэлтгэл ажил хангагдсан байгаа.

Өөрөөр хэлбэл 126 гишүүд болон олон нийт маань 9 сарын 01-нээс.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: А.Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Амгаланбаатарын Ганбаатар гишүүний микрофоныг өгье. Тодруулж асууя.

А.Ганбаатар: Баярлалаа. Б.Баасандорж даргын тайлбарыг ойлгож байна.

Энэ бол процедурын хувьд Байнгын хороо дамжаад нэг ийм захиргааны бүтцээр яваад байгаа ийм санал асуулгууд байгаа.

Их Хурлын гишүүдийн хүрээнд гэж би ойлгож байгаа.

Гол нь үүнийгээ олон нийт рүү яаж сурталчилсан юм бэ л гэж асуугаад байгаа юм л даа.

Татвар төлж байгаа хүн чинь бидний гаргаж байгаа хуулийг хэр ойлгож байгаа юм бэ?

Их Хурал дээр орж ирж байгаа маргаанууд чинь тэр доороо жинхэнэ татвараа төлчихсөн байгаа хувь, хүн аж ахуйн нэгжүүд дээр хэр өгөөжтэй байгаа юм бэ? Тэд нарын чинь санал эргэж яаж тусаж байгаа юм бэ гэдгийг л асуугаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр хурал, форум хийхээс илүүтэйгээр тэр олон нийт чинь ямар саналтай байгааг судалгаа, дүгнэлтээр гаргаж ирсэн юм байна уу л гэж асуугаад байгаа юм.

Яг ямар хууль дээр ямар салбарын хүмүүс хэдэн хувийн санал өгөөд дэмжигдсэн юм бэ гэдгийг л асууж байгаа болохоос Байнгын хорооны тэр дүгнэлтүүд, Их Хурлын гишүүдийн байр суурь арай жоохон мэргэжлийн талтай. Арай өөр асуудал шүү дээ.

Яг тэр масс дээр юу болж байна гэдгийг л асууж байгаа юм.

Д.Амарбаясгалан:

Б.Баасандорж дарга нэмж хариулах уу? 11 дүгээр микрофон.

Б.Баасандорж: Гишүүний асуултад хариулья.

Яг төсвийн төслийг боловсруулах ажил бол яг боловсруулахаасаа эхлээд Засгийн газар дээр яг ямар ямар ажлууд хийгдэх вэ, Их Хурлын түвшинд ямар ямар ажлууд хийгдэх вэ гэдэг нь Төсвийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар маш сайн нарийвчилж зохицуулж өгсөн байдаг.

Жишээ нь, төсвийн төслийг боловсруулах ажил Төсвийн тухай хуульд заасны дагуу тухайн жилийн төсвийг боловсруулахдаа 6 сарын 01-нээсээ эхэлдэг.

Яг Их Хуралд өргөн мэдүүлэхээсээ өмнө мөн Засгийн газрын түвшинд шат бүр дээр олон нийтэд танилцуулаад, саналыг нь аваад, хэлэлцүүлэг зохион байгуулаарай гэдэг зүйлүүд нарийвчилж зааж өгсөн байдаг.

Тэгэхээр гишүүн ээ, энэ ажил мөн Засгийн газрын түвшинд маш сайн хийгдэж өгсөн байгаа. Хууль өөрөө ингэж шаарддаг.

Засгийн газар бүрэн эрхийнхээ дагуу 9 сарын 01-нд багтааж өргөн мэдүүлэх үүрэгтэй байдаг.

Их Хурал өргөн мэдүүлж авсан төслийг энэ оны төсөв яг 9 сарын 01-нээс анх удаа өргөн мэдүүлж эхэлж байгаа.

Өмнөх бүх төслүүд 10 сарын 01-нд өргөн мэдүүлээд, өмнө нь 12 сарын 01-ний дотор баталдаг байсан бол сүүлд өөрчлөлт ороод.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ер нь А.Ганбаатар гишүүний асууж байгаа маш зөв асуулт байгаа юм.

Яг олон нийтийн дунд хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа ажлын үр дүн гэдэг талаасаа яриад байгаа юм.

Хэдийг зохион байгуулсан бэ гэхээсээ илүүтэйгээр. Тийм ээ. Ямар үр дүн гарав. Ард иргэдийн дунд ойлголт

өгч чадсан юм уу, төсвөө ойлгуулсан юм уу гэдэг асуудал яваад байгаа юм.

Тэгээд яах вэ, мэдээж яг өнөөдөр зохион байгуулж байгаа төрийн байгууллагаас хийж байгаа ажил буруутгахад хэцүү. Гэхдээ учир дутагдалтай байна гэдэгтэй санал нэг байгаа юм.

Тэгэхээр одоо 11 сарын 15-ны өдөр ажлын хэсэг байгуулья гээд бид бараг төсөв хэлэлцэж эхлэхдээ ярьсан.

- ▶ *Төсвийн хууль,*
- ▶ *төсвийн хүрээ хэлэлцэж байгаа нөхцөл байдал,*
- ▶ *мөнгөний бодлогын асуудал,*
- ▶ *төсвийн тодотгол,*
- ▶ *тайлан, гүйцэтгэл*

гээд эдгээр зүйлүүдийг хэлэлцэхэд цаг хугацааных нь интервалыг зөв болгож өгөхгүй бол зөрчилтэй зүйлс байна.

Улсын Их Хурал цаг хугацаанд шахагдаж дутуу хагас хэлэлцээд баталж байгаа нөхцөлүүд ч өнгөрсөн хугацаанд гарч байсан тохиолдол байна.

Тэгэхээр үүнийг засах энэ ажлын хэсгийг албан ёсоор 11 сарын 15-нд байгуулна.

Харин энэ ажлын хэсэгт орж ажиллах Улсын Их Хурлын гишүүд Тамгын газарт өөрсдийнхөө нэрсийг, хүсэлтийг өгөх хэрэгтэй.

Мэдээж нэр хүсэлт өгч байгаатай холбогдуулан намын бүлгүүдийн төлөөлөл, бусад намуудын төлөөллийг харгалзан үзээд хэдэн гишүүнтэй ямар ажлын хэсэг байгуулах асуудлаа шийднэ.

Ингээд 01 сарын 01-нээс эхлээд 12 сарын 31 хүртэлх хугацаанд энэ графикийг бүгдээрээ бүх талдаа нэг мөр ойлгомжтой болгоё.

Одоо нэг жишээ байна шүү дээ. 9 сарын 01-нд Засгийн газар төсвөө өргөн барьчихаж байгаа юм.

10 сарын 01-нд Улсын Их Хуралд хэлэлцэж эхэлж байгаа юм.

Яг энэ хооронд жишээ нь Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсгээ байгуулаад, олон ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг тогтвортой явуулах боломж хуулиараа зохицуулагдахгүй байгаа юм.

Нэгдүгээр хэлэлцүүлгийг хийгээд дэмжсэн тохиолдолд ажлын хэсэг байгуулагдана гэдэг асуудал энд явагдчихаж байгаа байхгүй юу.

Харин ажлын хэсгүүд нь байгуулаад нэгдүгээр хэлэлцүүлэг дээр дэмжих эсэх асуудлаа шийддэг болох тэр боломжийг жишээлбэл нээх хэрэгтэй байгаа байхгүй юу.

Тэгэхээр бүгдээрээ энэ дээр маш их ажил хэрэгчээр асуудалд хандъя. Гишүүд өөрсдөө саналаа ирүүлээрэй гэдгийг бас хэлье.

Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

Г.Тэмүүлэн: Төсвийн хүрээнд мэдэгдэл хэлэлцэж байгаатай холбогдуулаад би зарим Байнгын хороон дээр гишүүдийн гаргасан саналыг дэмжиж байгаа.

- ▶ *Төсвийн зардлыг бууруулах,*
- ▶ *төсвийн орлогыг нэмэгдүүлэх,*

▶ *төсвийн тэнцлээ сайжруулах*

гэдэг асуудлуудыг хөндөж гаргаж тавьсан байгаа.

Надад асуух асуулт байхгүй.

Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулаад би онцолж хэлэх гэж байгаа зүйл л байгаа юм.

Төсвийн хүрээний мэдэгдэл буюу үүний Үндсэн хууль нь болсон Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бол үндсэндээ бид бүхний төсөв, санхүү, эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалах Үндсэн хууль болсон хууль байгаа юм. Үндсэн хууль болсон хууль байгаа юм. Үндсэн хууль болсон.

Энэ хуулийн үндсэн зорилт маань өөрөө юу юм бэ гэхээр энэ

- *эдийн засгийнхаа тогтвортой орчин, макро эдийн засгаа яаж хамгаалах юм бэ,*
- *инфляцаас бид хэрхэн хязгаарлаж хамгаалж, сэргийлэх юм бэ.*
- *төсөв, санхүүгийнхээ талаар ямар бодлоготой байх юм бэ гэдгээ л гаргадаг бодлогын асуудлууд байгаа. Бодлогын хууль.*

Тэгэхээр манай гишүүд дараа дараагийн удаа төсвийн хүрээний мэдэгдэл дээр онцгой хатуу анхааралтай хандаж, онцгой хатуу энэ асуудал дээр хандаж байх ёстой байгаа юм.

Би буруу санаагүй бол энэ жил бид “Төсвийн хүрээний мэдэгдэл”-ийг гурав дахь удаагаа өөрчилж баталж байна.

Хоёрхон сарын өмнө бид төсвийн тодотголоор төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилж байсан.

Энэ өөрөө юуг харуулж байна вэ гэхээр үндсэндээ нөгөө улаан шугам болсон, хязгаар болсон тэр тоог чинь бид үндсэндээ мөрддөггүй. Байнгын өөрчилдөг. Ингээд үүнээс үүдээд Монгол Улсын төсөв, санхүү, эдийн засгийн тогтворгүй байдал чинь үргэлжлээд байгаа юм.

Магадгүй сүүлийн 15 жилийн хамгийн том бодлогын алдаа эндээ байна гэж хараад байгаа.

Энэ ч үүднээс бид өмнөх парламентын 35 гишүүн энэ төсвийн шинэчлэлийг хийгээд, төсвийн тогтвортой байдлаа яаж хамгаалах юм бэ гээд хамгаалалтын заалтуудыг хийж өгч байсан юм.

- ▶ *Олон нийтийнхээ оролцоог яаж хангадаг байх юм.*
- ▶ *Хэлэлцүүлэг яаж хийдэг байх юм.*
- ▶ *Олон нийт маань бүр төсвийн төлөвлөлтөөс нь авхуулаад анхан шат, баг, сум дээр хүртэл яаж саналаа өгдөг байх юм гэдэг асуудлыг хуульчилж оруулж өгч байсан юм.*

Хариуцлагагүй этгээдүүд дээр төсвийг

- ▶ *үр ашиггүйгээр зарцуулсан,*
- ▶ *ангилалд зөрүүлсэн,*
- ▶ *хариуцлага алдсан бүх төсвийн ерөнхий захирагч нар дээр анх удаагаа төсвийн хуулиар бид “хариуцлага тооцох эрх”-ийг нь нээж өгсөн байгаа.*

“Гадаад өр, зээлийг хязгаарлах бодлого”-ыг ч гэсэн энэ хууль дээр бас оруулж өгч байсан юм. Энэ зарчмын асуудал.

Дөнгөж энэ хууль анх удаагаа энэ жилээс хэрэгжиж эхэлж байна.

Үүнийг бид хатуу шаардаж байх ёстой. Засгийн газраас.

Харин би нэг зүйлд харамсаж байгаа. Өнгөрсөн тодотголын үеэр бид энэ хуулийнхаа хамгийн амин сүнс болсон нэг заалтыгаа анзааргагүй байж байгаад Засгийн газрын саналаар байхгүй болгочихсон. Сангийн яамны саналаар.

Тэр юу вэ гэхээр хуучин байсан 6.1.3 буюу энэ хуулийн амин сүнс болсон “Монгол Улсын эдийн засгийг уул уурхайн савлагаанаас хамгаалах, гэнэтийн орлогоос хамгаалах” заалт байсан юм.

Гэнэт их орлоготой болохоороо дагаж зарлагаа өсгөдгийг нь хязгаарлачихсан байсан заалт байсан юм. Тэрүүгээр тэгж наадахгүй шүү. “Уул уурхайн бус зөвхөн бусад салбарынхаа эдийн засгийн өсөлтөөр зарлагаа дараа жил нь өсгөдөг байя” гэсэн заалт байсныг одоо байхгүй болгочихсон.

Үүний төлөөс нь юу юм бэ гэхээр өнөөдөр бид магадгүй энэ жил өмнөх жилээсээ 2 их наядаар нэмэгдүүлэх байсан зүйлийг 5.6 их наядаар нэмэгдүүлж орж ирж байгаа.

Энэ заалтыг байхгүй болгосон төлөөсөнд нь бид үндсэндээ магадгүй даблдаж, 2 дахин нэмэгдүүлж энэ зардлыг өсгөж оруулж ирж байгаа. Засгийн газар нь эрхээ авчихсан.

Тэгэхээр одоо бид цааш цаашдаа төсвийн хүрээний мэдэгдэл дээр хатуу байх хэрэгтэй байгаа юм.

Ирэх жил 35, тэрний дараа 37.3, тэрний дараа жил 40 их наяд болно гэж төсвийн зарлагыг оруулж ирж байгаа асуудлууд байгаа.

Энэ дээр бид хатуу хяналт тавьж, зөвшөөрөл өгдөггүй байх Улсын Их Хурал Засгийн газрын хүссэн болгоноор нь тэр зардлыг нь баталдаг болтлоо би жижгэрч болохгүй гэж үзэж байгаа.

Тэгэхээр энэ дээр манай гишүүд маань анхааралтай байгаарай.

Бид үндсэндээ уул уурхайн орлогоос хамааралтай болчхож байгаа. Энэ заалт байхгүй болсноос болоод. Баялгийн хараалаас хамгаалалтгүй болчхож байгаа.

Үндсэндээ олон улсад бол “Dutch disease” буюу “Голланд өвчин” гээд байдаг. Валютын нөөц нь өсдөг, инфляц өсдөг.

Ингээд уул уурхайн хамаарал өсөлтөөс болоод бусад салбарууд нь дампуурдаг л ийм асуудал руу л орох гээд байгаа байхгүй юу.

Энэ бол зарчмын асуудал. Энэ үүднээсээ л бид саяын тэр урсгал зардал дээр чинь “3.6 их наядаар бууруулья” гэдгийг нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Хариулт өгөх юм уу? Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Г.Тэмүүлэн гишүүний санал дээр үг хэлье.

Хамаагүй тэгж бас гүтгэж болохгүй шүү. Г.Тэмүүлэн гишүүн ээ.

Та өөрөө Төсвийн байнгын хорооны дарга 2 жил хийсэн хүн. Сүүлийн 2 жилийн төсвийг Улсын Их Хурал дээр өөрөө баталсан хүн шүү.

6 сарын 05-нд юу болж өнгөрснийг чинь би зөндөө л дурдсан. Энэ удаа больё.

Харин сая тэр орлогын хязгаарлалттай холбоотой зүйлийг Та бүр өөрөө ч сайн ойлгоогүй байна шүү.

2025 оны төсвийн орлогыг тодорхойлохдоо саяын таны дурдсанчлан тэр дүрмийг яг таг баримталсан байгаа.

“Тэнцвэржүүлсэн орлого” гэдгийгээ бид яг наад дүрмээр чинь байгаа.

Сүүлийн 12 жил, тухайн гүйцэтгэлийн жил, дараагийн 3 жил гээд үндсэндээ 15 жилийн дунджаар авсан орлогын түвшин байгаа.

“Тэнцвэржүүлсэн үнэ” гээд зэс, нүүрс гээд гол стратеги хоёр бүтээгдэхүүн дээрээ “зах зээлийн үнэ”, “тэнцвэржүүлсэн үнэ”-ийнхээ аль багаар нь буюу нөөцдөө аваад, байж болох өндөр орлогын хамгийн багаар нь авсан ийм төсвийн орлого гэсэн үг.

9 сарын 01-нд өргөн баригддаг болсон. Та үүнийг өөрөө маш сайн мэдэж байгаа. Өөрөө хийсэн.

70 хоног хэлэлцэх ёстой.

Одоо таны ярьж байгаа зүйлүүд чинь ерөөсөө өчигдөрхөн төсөв өргөж авсан юм шиг, хүлээж авсан юм шиг л ийм л юм яриад байгаа шүү. Үүнийгээ бас эргэж хараарай.

Мөнгөний бодлоготойгоо бид хугацаагаа зөрүүлчихсэн. Гэх мэтчилэн ингээд янзлах юмнууд байгаа.

Ирэх жилийн төсөв дээр бид өмнөх тусгай шаардлагуудаасаа нэг том дэвшилттэй өөрчлөлт орсон нь суурь тэнцэл 2 хувийн ашигтай байх ёстой гэдэг ийм хатуу заалтыг зөрж оруулж ирсэн байгаа.

Үүгээрээ Засгийн газрын өрийг барагдуулна гээд урьд өмнө байгаагүй маш том ийм эрсдэлийн хаалт босго тавьж өгсөн байгаа.

Ирэх жилийн “зээлийн төлбөр” 1.4 их наяд. Харин “суурь тэнцлийн ашиг” маань 2 их наяд байгаа.

Өөрөөр хэлбэл 600.0 тэрбум төгрөгийн нөөцтэйгөөр бид өрөө барагдуулна гэсэн үг.

Гэх мэтчилэн төсвөө, тэнцлээ ингээд сайжруулаад явж байгаа.

Гагцхүү бид сарын өмнө баталсан Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрийг энэ 4 жил хий эргээд зогсох уу, амжилттай гараанаасаа хөдлөх үү л гэдэг ийм л сонголтын асуудал байгаа.

Би түрүүн хэлсэн. Алдагдалгүй батлах амархан. Сонголтын л асуудал.

► Бүтээн байгуулалтуудаа больё,

► *цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжээ, нэмэгдлүүдээ зогсооё.*

Ингэхэд л гараад ирнэ.

Харин бид нарын том зорилтууд дахиад л тэр хэмжээгээр хойшилно. Дахиад мөрөөдөл болоод цаасан дээр үлдэнэ л гэсэн үг.

Тэгээд ийм зүйлүүдийг л нэмж хэлэх гэсэн юм. Тийм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя. Тодруулж асууна гэж байна. Г.Тэмүүлэн гишүүн. Тодруулга.

Г.Тэмүүлэн: Би уг нь асуулт асуугаагүй байгаа юм.

Тэгээд одоо яах вэ, над руу ингээд субъектив байдлаар хандаад асуудлыг нааж байгаа бол ёстой нөгөө Баяраа өөрөө л гэдэг шиг өөрөө л энэ өрийн таазгүй болгочихсон.

6.1.3-ыг байхгүй болгосон, уул уурхайн савлагаанаас хамгаалалтгүй болгосон хүн бол манай Сангийн яам, та өөрөө байгаа юм.

Ийм хариуцлагагүй хандаж болохгүй. Ийм сэтгэлгүй байж болохгүй гэж л би хэлэх гээд байгаа юм.

Энэ дээр сүүлийн 2 жил ямар нэг байдлаар төсвийн үзүүлэлтүүд бүгд сайжирч байсан шүү дээ.

Ямар ч бай бид Сангийн яамнаас асуухгүйгээр төсвөө харин баталдаг байсан юм шүү.

Урсгал зардал дээрээс нь хувьчлаад хасдаг байсан. Хэрэгцээгүй, үр ашиггүй зардлуудыг бид танаад явдаг байсан. Ажлын хэсэг ажилласан шиг ажилладаг байсан. Энэ бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх шүү.

Түүнээс одоо юу гэдэг юм өмнөх парламентын 35 гишүүдийн хийсэн шинэчлэлийн тогтвортой байдалтай холбоотой заалтыг нь эхнээс нь оруулж ирээд, хасаад, байхгүй болгоод, улс орны эдийн засгаа хамгаалалтгүй болгож, хазаарлалтгүй болгоод байж болохгүй.

Д.Амарбаясгалан: Болно оо, одоо.

Сангийн сайд Болдын Жавхлан. Тэгээд хэрүүл хийгээд байв даа. Та хэд маань.

Б.Жавхлан: Г.Тэмүүлэн гишүүн ээ, одоо хэлэхээс өөр аргагүй байна шүү. Дахиж хэлье.

6 сарын 05-нд хийсэн өөрчлөлтөөр Та Монгол Улсыг өрийн хязгааргүй болгочихсон байсан шүү.

Үүнийг чинь харин сануулъя. Та одоо сандраад хэрэггүй. Тэрийг чинь харин сая тодотголоор бид буцаагаад тавьсан.

Тийм учраас тэр хязгаарын хүрээнд 2025 оны төсөв харин ч бүр эрсдэлгүй болчихсон байсныг бид хязгаартай болгож оруулж ирсэн байгаа гэдгийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болно. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Өнөөдөр уг нь яг одоо 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулиа л хэлэлцээд байгаа.

Тэгээд нөгөө төсөв рүүгээ явж орчхоод, төсвийн асуудал яриад байдаг.

Нэгэнт төсвийн асуудал яриад, дээрээс нь зарим нь энэ бүх олон зүйлүүд бие биедээ хэлээд байгааг дахиж сануулахгүй бол болохгүй юм шиг байна.

Засгийн газар байгуулагдсан цаг мөчөөс эхлээд Иргэний Зориг Ногоон намын даргын хувьд, Их Хурлын гишүүний хувьд, цөөнхийн хувьд байнга хэлсэн.

118-ын бүлэгтэй ийм бүдүүн дэмжлэгтэй Засгийн газар байгуулагдаж байгаа тохиолдолд энэ мөрийн хөтөлбөрөө яах юм.

Тэр мөрийн хөтөлбөрийн төсвийг дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувиас хэтрүүлэхгүй буюу 23 их наядад багтаж байх ёстой гэдгийг төсвийн тодотгол дээр ярьж л байсан. Төсөв өргөн мэдүүлэхэд ярьж л байсан.

Төсвийн хэлэлцүүлэг өөрөө дэгийн тухай хуультай. Их Хурлын онцгой 4 шат дамжиж, хууль хэлэлцдэг 2 л зүйл байгаа шүү дээ.

- Үндсэн хууль,
- Төсвийн тухай хууль.

Тэгээд үүнийгээ анхаарах нь яасан юм.

Танин мэдэхүйн шинж чанартай асуултууд, танин мэдэхүйн шинж

чанартай зүйлүүд яваад байна. Зарчмын зөрүүтэй саналууд дээрээ ажиллаач ээ гээд хэлж байсан.

Сангийн сайд сайн мэдэж байгаа. Тэгээд байнга хариулаад байсан. Бид төсвөө тэлж байгаа нь, төсвөө нэмэгдүүлж байгаа нь эдийн засгийн хөгжлийн тулд бид энэ улс орныг хөгжүүлэх том мега төслүүдийг явуулахын тулд юм л гээд хариулаад байсан.

Миний асуугаад байсан зүйл 40 их наяд байж болно. Төсөв.

Хэрвээ 40 их наядын төсөвтэй бол дотоодын нийт бүтээгдэхүүн чинь 160-аас 200 их наяд байвал нөгөө зохистой харьцаанд хадгалагдах байхгүй юу.

Одоо энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл хоёр дээр болохоор 40 их наядтай 2027 онд очих юм байна. Тэр нь болохоор 35 хувь дотоодын нийт бүтээгдэхүүнд.

Дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувьдаа оруулах боломжгүй юм уу? Нэг бол тэр дотоодын нийт бүтээгдэхүүнээ бид 160 их наяд болгож чадна гэдэг тийм төсөөлөлтэй байж чадах уу?

Оруулж ирж байгаа хувиар нь тооцохоор энэ бол их бага байгаад байгаа юм.

Бид төсөв хэлэлцэж байхад төсвийн тодотгол 7 сард хэлэлцэх, сая чуулган эхлээд төсөв хэлэлцэж байх явцад Төсвийн байнгын хорооны дарга төсвийн ажлын хэсгийн даргад зарчмын зөрүүтэй 53 санал явуулсан.

Ажлын хэсэг дээрээ санал хураагаагүй байна лээ. Хураагаагүй өнгөрсөн.

Байнгын хорооных нь зөвлөхөөс нь асуусан. Зарчмаа ажлын хэсэг хоорондоо тохирчихсон гэсэн. Санал хураахгүй гэсэн гээд.

Тэр 53 санал хэрвээ хэлэлцэгдсэн бол. Дэмжих, дэмжихгүй нь Их Хурлын гишүүдийн асуудал.

Онцгой албан татвар 700.0 тэрбумаар нэмэгдээд цалинтай ээжийн 50 мянга чинь 250 мянга байхаар тийм төсөөллөөр хийж өгсөн. Хүлээж аваагүй.

Ер нь өнөөдөр үүсээд байгаа энэ нөхцөл байдал сайхан хэдүүлээ төсөв хэлэлцэж байна, ард түмний татварын мөнгийг хэлэлцэж байна. Ийм байх ёстой гэж ярьж байгаа боловч зүгээр л сайхан иргэдээс оноо авчихлаа гээд л гуяа алгадаад л гараад гүйх л ажил хийгээд байгаа шүү дээ.

118-ын бүдүүн бүлэг байгуулна, хамтарсан засгийн газар байгуулна, том мега төслүүдээ хэрэгжүүлнэ, улс орон урагшаа алхана.

Зөв сонсогдож байгаа хэрнээ үүнийг дагаад эрх мэдэл очно. Эрх мэдлийг дагаад хөрөнгө санхүү, орон тоо нэмэгдэнэ.

Баахан ТЭЗҮ гэдэг зузаан цаастай үлдчихээд нөгөө төслүүд нь хэрэгжээгүй байх вий.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн.

Уучлаарай. Батын Батбаатар гишүүн 1 минут нэмж тодруулга.

Б.Батбаатар: Тэгээд яах вэ, Их Хурлын гишүүдийг энэ 15, 16 гишүүн шаардлага дээрээ гарын үсэг зураач л гээд байгаа юм байна лээ.

Гэхдээ энэ бол төсвөө баталчхаад, батлагдсан төсөв 01 сарын 01-нээс эхэлж хэрэгжиж эхэлнэ.

Наана нь тодотгоно гэж юу байдаг юм. Хэзээ ийм байсан юм, ер нь.

Харин Засгийн газар төсөв дээр батлагдсан зүйл дээрээ ард олны шүүмжлэл, иргэдийн шүүмжлэл, Их Хурлын гишүүдийн санал, шүүмжийг аваад зарим зүйлийг нь хэрэгжүүлэхээ больё. Царцаая. Ирэх хавар бид төсвийн орлого, төсөөллөө харж байгаад энэ өөрчлөлтөө төсвийн тодотголоор оруулж ирье л гэж яригдах болохоос биш Их Хурал маань өөрөө ингээд.

Засаг орлого, зарлагаа хянаж тодотгол оруулж ирдэг зүйлийг Их Хурал энд тодотгол хийдгээр ингэж баталж болохгүй шүү дээ.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотойгоор өглөө бас нэлээн эрт чуулган дээр цаг авсан байсан. Асуулт асуухаар.

Өглөө 09.00 цагаас Төсвийн байнгын хороо “2025 оны төсөв батлагдаж байгаатай холбогдуулаад авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ гээд

цаг давхардаад цаг дээрээ асууж чадаагүй.

Дахин асуух боломж олгосонд талархаж байна.

2025 оны төсөв бөөн хэл ам, хэрүүл шуугиан дунд батлагдах юм шиг байна.

Засгийн газрын өргөн барьсан төсөв үнэхээрийн дэндүү данхар, урсгал зардал, гадаад томилолт гээд асар их асуудал байгаа нь үнэн.

Нөгөө талдаа Засгийн газар төсвийн хуулиа бас татах боломжгүй болсных нь дараа нэлээн хэдэн гишүүд гарын үсэг зуруулаад, улс төр хийгээд явж байгаа нь ч бас үнэн.

Тийм байсан юм бол төсвийн хоёрдугаар хэлэлцүүлэг батлагдахаас өмнө Ж.Баярмаа гишүүн бид хоёр төсвийн энэ өргөн барьсантай холбоотойгоор ямар их зардал, ямар их 3.6 их наяд хэмнэж болох тухай бид өнгөрсөн төсвийн хоёрдугаар хэлэлцүүлэг батлагдахаас өмнө хэвлэлийн бага хурал хийхэд хамтраад энэ асуудлаа, энэ үйлдлээ хийж байхгүй яасан юм бол гэсэн бас бодол төрж байна.

Энэ дотор төсвийн талаар нэлээн туршлагатай бас хоёр, гурав сонгогдсон гишүүд ч явж байгаа харагдана.

Ерөнхийдөө яах вэ, нийгмийн баялаг дахин хуваарилалт, нийтийн төсвийг яаж хуваарилдгийг бид чамгүй их төсвийн хэлэлцүүлэг болсон хойно харж байна.

Одоо яах вэ тэгээд хуулийнхаа хүрээнд төсвөө батлаад л явах байх.

Удахгүй тодотгол хийх юм шиг байна. Өнөө өглөөний Төсвийн байнгын хорооны хурал дээр иймэрхүү тогтоолын төсөл батлагдаж байна.

Асуулт. Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой. Сангийн сайдаас.

Түрүүн төсвийн хүрээний мэдэгдэлд ер нь хязгаар байгаа шүү. Сайн ойлгоорой л гээд байгаа харагдана.

Би өнгөрсөн Баасан гарагт Засгийн газрын өртэй холбоотой асуулт асуухад Б.Жавхлан сайд яг иймэрхүү хариулт хариулсан болоод өнгөрчихсэн юм.

Нэгдүгээрт, тэр асуултаа давхар.

Хоёрдугаарт нь, бас төсвийн алдагдалтай ажиллаж байгаа төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой.

Би тэр Баасан гарагт асуусан асуулт чинь бол ер нь яах вэ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Засгийн газрын нийт өрийн хэмжээ 2023 оны гүйцэтгэлээр 30.7 их наяд. Ингэж 2024 он, 2025 оны төсвийн төсөөллөөр 40.4 их наяд хүрэх нь.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1.8-д төсвийн хүрээний мэдэгдэлд Засгийн газрын өрийн нийт хэмжээг тусгана гэж заасан байхгүй юу.

Гэтэл Та бүхэн өргөн мэдүүлж байгаа төсөл чинь Засгийн газрын өрийн нийт хэмжээ дээд түвшнээр гэж оруулж ирсэн чинь хууль зөрчиж байна шүү гэсэн нэг асуулт.

Хоёрдугаарт нь, төсвийн хүрээний тэнцвэржүүлэлтийн тэнцэл 2025 онд 1.9

их наядын алдагдалтай. Одоо бид нарын баталж байгаа төсөв. Тийм ээ. 1 их наяд 930 тэрбум.

- 2026 онд 2 их наяд 94 тэрбум,
- 2027 онд 2.3 их наяд гээд.

Бид ер нь яагаад заавал улсын төсвийг алдагдалтай батлаад байх ёстой юм. Тэр бүтээн байгуулалт, тэр боломжуудыг энэ хүрээнд хийх боломжтой гэж сая ярьж байх шиг харагдаж байна.

Гэхдээ манай улс чинь яг үнэндээ эдийн засаг нь нүүрснээс хамааралтай. Нүүрсний үнэ унаад байна.

Хоёрдугаарт нь, энэ нэг жоохон нүүрс үнэтэй байгаа үед бид ядаж төсвөө яагаад алдагдалгүй баталчхаж болохгүй байгаа юм бэ гэсэн асуулт тэр Засгийн газрын өрийн нийт хэмжээ дээд түвшнээр гэсэн хуулийн заалт зөрчсөн асуултыг Сангийн сайдаас энэ хоёр асуултыг асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: А.Ганбаатар гишүүний асуултад хариулья.

Тэр үзүүлэлт заалтууд дотор нэг ч хууль зөрчиж орж ирсэн зүйл огт байхгүй шүү гэдгийг танд бүр албан ёсоор хэлье.

Яг ямар заалт зөрчихсөн зүйл тодорхой юм байвал та хэлээдхээрэй. Олж харахгүй байгаа. Нэгдүгээрт ийм.

Хоёрдугаарт, энэ төсвийн хүрээтэй төсвийн хүрээний мэдэгдлийн энэ асуудлууд дээр Сангийн яам огт оролцдоггүй шүү. Оролцдог, оролцдог

юмаа, хариуцдаг, хариуцдаг юмаа л хариуцъя.

Хэрвээ төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хүрээний төсөөлөлтэй холбоотой асуудлыг Сангийн яам мэдээд хариулдаг хариуцдаг бол хариуцсан шиг хариуцаад энэ Эдийн засаг, хөгжлийн яам гэдгийг тэгвэл байхгүй болгох хэрэгтэй.

Эсвэл Эдийн засаг, хөгжлийн яам бүгдийг нь хариуцаад явдаг байх хэрэгтэй.

Тэгэхээр гишүүд маань үүнийг нэг жоохон ялгаад салгаад ингээд нэг асуулт хариултуудаа авчхаж байгаасай гэж хүсэж байна.

Хэрвээ улс төр хийх гэж байгаа бол бас тэрийгээ хэлж байгаад асуучих хэрэгтэй.

Тэгэхээр саяын асуулт дандаа Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой асуултууд.

Сангийн яам хариулах боломж байхгүй. Тийм.

Д.Амарбаясгалан: Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр хариулт өгье.

Л.Гантөмөр: Яах вэ, бид энэ яам тэр яам гэхээс илүү Засгийн газар чинь өөрөө кабинетын зарчимтай.

Засгийн газар дээр ярьж байгаад ер нь төсвийн зарлага бууруулж чадахгүй юм байна.

Тал талаасаа л ярьсан шүү дээ.

Яагаад гэвэл өнгөрсөн жил

→ “Цалин нэмсэн”.

Хөөе. Их Хурлын гишүүд ээ,

4 сараас цалин нэмээд өнөөдөр тэр нэмсэн цалингийнхаа буянд сонгогдоод сууж байгаа.

→ “Тэтгэвэр нэмсэн”.

Нэмсэн тэтгэврийнхээ буянд сонгогдоод сууж байгаа.

▷ *Асар ихээр нэмсэн зардал нь өнгөрсөн жилдээ “хагас жилээр” орсон байхгүй юу даа.*

▷ *Ирэх жил “бүтэн жилээр” орох гээд байгаа юм.*

Тэгэхээр нэгэнт нэмчихсэн халамж.

→ “Хүүхдийн мөнгийг нэмсэн”.

Өөр ямар халамж байдаг юм.

▪ *Бүх халамжуудыг тултал нь тавьчихсан.*

Одоо ажил хэрэгч санал гаргаач ээ гэж л хүсмээр байгаа юм.

Аль халамжийг нь зогсоох юм. Хэлмээр байна.

→ Ээжүүдийн мөнгийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Л.Гантөмөр даргад нэмж минут өгье.

Л.Гантөмөр: Одоо тэтгэврээ бууруул гэвэл энэ саналаа гаргамаар байна. Яг орон тоо хэмнэнэ гэх юм бол

үүнийгээ гаргамаар байна. Хэний орон тоог хасах юм.

- ▶ Цагдаагаа цөөлөх үү,
- ▶ шүүхээ цөөлөх үү,
- ▶ прокуророо цөөлөх үү.

Яамд дээр ажиллаж байгаа нийт мянга хэдэн зуун хүн байгаа. Энэ чинь олон харагдаад байна уу. Энэ дээр хэдүүлээ ажиллая л даа.

Ажил хэрэгч байхыг л би хүсмээр байна.

Тэлэхийн хувьд асар их тэлчихсэн.

Хэмнэе гэж байгаа саналыг бүгдээрээ дэмжинэ.

Тэгэхдээ хаанаас нь юуг хэзээ хэмнэх вэ гэдгээ ажлын хэсэг гаргаад ярья гэдгийг өнгөрсөн тав дахь өдөр цөмөөрөө ярьсан шүү дээ.

Тэгэхгүй зүгээр тоо өндөр байвал дургүй байна, бага байвал дуртай байна гээд.

Тэгээд зардлын саналыг гаргуулсангүй гэдэг бухимдал яваад байгаа юм.

Аль болохоор Их Хурал өөрөө санаачилгаа аваад хэмнэлтийнхээ саналуудыг тодорхой оруулж ирээд батлуулчих юм бол энэ дээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл,

2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийг эцэслэн батлах бэлтгэл

хангуулахаар Төсвийн байнгын хороонд
шилжүүлээ. /алх цохив/

Дараагийн асуудалд орно.

**Дөрөв.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,
гурав дахь хэлэлцүүлэг/**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Цэдэнпилийн Даваасүрэн танилцуулна.

Индэрт урьж байна.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 31, 11 дүгээр

сарын 01-ний өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 11 сарын 05-ны өдрийн хуралдаанаараа чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийх үед олонхын дэмжлэг авсан саналуудыг төсвийн төсөл болон холбогдох хавсралтуудад тусган гурав дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулгыг хийх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд дараах өөрчлөлтүүдийг тусгалаа.

1.Төсвийн төсөлд тусгагдсан зарим төсвийн ерөнхийлөн захирагч нарын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах чиг үүргийн дагуу урсгал болон хөрөнгийн зардлын хооронд нь шилжүүлэх замаар тэдгээрийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

2.Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах шаардлагатай барилга байгууламж, тоног төхөөрөмжийн санхүүжилтийн эх үүсвэрийг төсвийн төсөлд нэмж тусгалаа.

3.Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэн эрсдэлийн санд тусгагдсан санхүүжилтийг шилжүүлсэн.

Монгол Улсын 2025 оны төсвийн жилд нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 36 их наяд 830 тэрбум 456 сая төгрөг байхаар.

Үүнээс Тогтворжуулалтын санд 608 тэрбум 889.9 сая төгрөг, Үндэсний баялгийн санд 2 их наяд 356 тэрбум 827 сая төгрөг хуримтлуулахаар төсвийн төсөлд тусгалаа.

Ингэснээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 33 их наяд 864 тэрбум 738.8 сая төгрөг болохоор байна.

Нийт зардал ба цэвэр зээлийн дүн 35 их наяд 771 тэрбум 913.2 сая төгрөг хүрэхээр байгаа бөгөөд нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1 их наяд 932 тэрбум 825.6 сая төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцвэржүүлсэн орлогод тооцон төсвийн тэнцэл хасах 1 их наяд 907 тэрбум 174.4 сая төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэхээр буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэхээр байна.

Түүнчлэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг дотоод гадаадын үнэт цаас гаргах замаар нөхөх боломжтой гэж үзсэн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд дээрх өөрчлөлтүүдийг тусгахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудад заасан шаардлагыг баримталсан.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдэд өөрчлөлт оруулсан төслийн эцсийн хувилбарыг нэгдсэн хуралдаанд танилцуулж, төслүүдийг батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын

сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн эцсийн хувилбар болон холбогдох хавсралт тооцоог Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулья.

Сангийн сайд Болдын Жавхлан, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт,

хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга.

Дэгийн тухай хуулийн 72.2-т нэгдсэн хуралдаанаар гурав дахь хэлэлцүүлэг явуулахад зөвхөн Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгын талаар гишүүд тайлбар хийх, түүнтэй холбогдуулан асуулт асууж болох бөгөөд санал хураалт явуулахгүй гэсэн дэгийн хуулийн заалт байгаа.

Энд нэг үг байгааг Та бүхэн анзаарах хэрэгтэй.

Нэгдсэн хуралдаанаар гурав дахь хэлэлцүүлгийг явуулахад “зөвхөн Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгын хүрээнд тайлбар хийх, асуулт асуух” гэж тодотгож өгсөн дэгийн хуулийн заалт байгаа.

Тэгэхээр би хурал даргалагчийн хувьд дэг сахиулна.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асуухдаа Төсвийн байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух нь гэдгийг анхаарах нь зүйтэй.

Ингээд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан тайлбар

хийх, асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Мөнхчулууны Энхцэцэг гишүүнээр тасаллаа. 23 гишүүн асуулт асууна. Ирсэн ирцийн дарааллаар Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууна.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Өмнө нь чуулган дээр нэг ийм зүйл хэлж байсан юм. Тэр дэмжигдээгүй явчихсан.

Улсын төсөв орж ирэхдээ өмнө нь ямар бичиг баримт орж ирсэн гэхээр “2025 оны хөгжлийн хөтөлбөр” орж ирсэн.

Хөгжлийн хөтөлбөр нь

- ▶ *Нэгдүгээрт нь, “эдийн засгийг чадавхжуулах”,*
- ▶ *Хоёрдугаарт нь, “бүсчилсэн хөгжил”,*
- ▶ *Гуравдугаарт нь, “монгол хүн”,*
- ▶ *Дөрөдүгээрт нь, “хүний эрх, эрх чөлөө”*

гэсэн эрэмбэтэй орж ирсэн юм.

Энэ үед Аудитын газраас төсөв дээр хяналт тогтоогоод дүгнэлт хийхдээ “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэхийг хянаж чадаагүй” гэдэг зүйлийг тэр дүгнэлт дээрээ биччихсэн байсан.

Яагаад гэсэн чинь “хэмжих нэгж байхгүй” гэсэн.

Тэгэхээр ер нь ингээд гараад байгаа асуудлууд, Д.Энхтүвшин гишүүн тэргүүтэй гишүүдийн санал болгоод байгаа асуудал бол “төсвийн эрэмбийн асуудал” байгаад байгаа юм биш үү.

Өөрөөр хэлбэл сая тэр соёлын яамтай холбогдуулаад л баахан асуудлууд гараад байгаа. Энэ бүхэн чинь юу гэхээр энэ төсвийн эрэмбийн асуудлыг тавиад байна.

Тэгэхээр энэ “төсвийн эрэмбийн асуудал” цаашдаа ер нь. Бид яах вэ, тоон дээр яриад л тодотголын тухай яриад байна л даа.

Гэхдээ ер нь яг энэ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дээр Монгол Улсын язгуур ашиг сонирхол, монгол хүний эрүүл, аюулгүй орчинд эрхээ эдэлж амьдрах энэ зүйл дээр энэ шалгуурыг ер нь яаж тавих юм бэ?

Энэ тал дээр тодотголын үеэр яригдах юм уу? Тэгэхгүй болохоор яаж байна гэхээр маш их популизм явж байна. Зарим нь ортой. Зарим нь улс төржилт явж байдаг.

Ингээд олон нийтийн эсэргүүцлээс ч гэдэг юм уу болгоомжлоод, олон нийтэд яаж ойлгогдох вэ гэдгээ харгалзан үзээд бодлого маань хуулийн дагуу биш, янз бүрийн шугамаар явчих гээд байдаг.

Эцсийн дүндээ энэ чинь Монгол Улсад хэрэгтэй, ач холбогдолтой, эрэмбэ тогтоох тухай асуудал юм биш үү.

Эдийн засаг, хөгжлийн яаман дээрээс ч тэр, Сангийн яаман дээрээс ч тэр энэ эрэмбийн тухай асуудал юм биш үү.

Ингэхгүй болохоор салбарыг бүхэлд нь үгүйсгэдэг ч гэдэг юм уу, аль эсвэл PR-ийн нөлөөллөөс энэ чинь ингээд яваад байна.

Тэгэхээр эцсийн дүндээ цаашдаа Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал монгол хүний эрх ашигт энэ төсөв маань нийцэж байгаа эсэх талаар яаж хяналт тавих вэ? Энэ дээр хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хороон дарга Цэдэнпилийн Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: С.Эрдэнэболд гишүүн ээ, гуравдугаар хэлэлцүүлэг төсөв тусгай дэгээр явдаг.

Зөвхөн төслийн нэр өөрчлөхтэй холбогдолтой асуудлуудыг л бид хэлэлцэж шийдвэрлэсэн байгаа.

Түүнээс биш өөр бусад асуудал хэлэлцээгүй.

Таны яриад байгаа асуудал хоёр дахь хэлэлцүүлгийн үед голлож ярилцах ёстой. Мөн зарим нэг асуудал нь төсвийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж гарах тогтоолын төсөл үүний дараа хэлэлцэгдэнэ.

Тэгэхэд наад асуудлыг чинь асууж болно хөндөгдөж болно.

Гуравдугаар хэлэлцүүлэг зөвхөн тийм юм билээ. Зөвхөн “нэр, байршил өөрчлөх” ийм л санал хураалт, хэлэлцүүлэг явагддаг юм байна.

Д.Амарбаясгалан: Дэгийн тухай хуулиар би түрүүн тайлбарлаж байсан.

Төсөв хэлэлцэх чинь өөрөө тусгай дэгээр зохицуулагдаж байгаа.

▷ **Нэгдүгээр хэлэлцүүлэг дээр** “хэлэлцэх эсэх” асуудал шийдэгдэж байгаа.

▷ **Хоёрдугаар хэлэлцүүлэг дээр** “зарчмын зөрүүтэй саналууд гарч, санал хураагдаж дэмжих, дэмжихгүй” асуудал шийдэгдэж байгаа.

▷ **Гурав дахь хэлэлцүүлэг дээр** “хөрөнгө оруулалтын хэмжээг хөндөхгүйгээр төсөл, хөтөлбөрийн нэр, утга, агуулгыг алдагдуулахгүйгээр санал гаргаж, санал хурааж” шийдэгдэнэ гэж байгаа юм.

Тэгэхээр энэ өөрөө асар хязгаарлагдмал хэмжээнд гуравдугаар хэлэлцүүлэг чинь явж байгаа гэдгийг гишүүд маань их сайн ойлгож, асуултаа тавих ёстой.

Мэдээж хариулж байгаа ажлын хэсэг бүх асуудал дээр дэлгэрэнгүй хариулах боломжгүй гэж Ц.Даваасүрэн гишүүний сая хариулж байгаа нь зөв.

Яг л энэ гуравдугаар хэлэлцүүлэг Байнгын хороон дээр хэлэлцэгдсэн асуудалтай холбогдуулж, сая Ц.Даваасүрэн гишүүний хийсэн танилцуулгатай холбогдуулж асуултаа асуух ёстой гэдгийг анхааруулж хэлье.

Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара: Төсвийн байнгын хорооны хэлэлцсэн асуудлын гуравдугаар асуудал дээр Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзээд эрсдэлийн санд тусгагдсан

санхүүжилтийг шилжүүлсэн юм байна шүү дээ.

Нийт дүнгээр нь хэд гэж үзсэн юм бол оо?

Тэгээд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитад тусгасан дүн нь 250.0 тэрбум гэж байгаа.

Тэгэхээр энэ асуудалд хэн хариуцлага хүлээх юм бэ? Өмнө нь үүссэн зөрчилтэй асуудлыг дараа дараагийнхаа төсвөөс, дараа дараагийнхаа парламент, дараа дараагийнхаа юмнаас нөхөөд яваад байх юм уу? Хэнд ч хариуцлага тооцохгүйгээр яваад байх юм уу, эсвэл ар араас нь нөхөөд явах юм уу?

Дээрээс нь “Нийгмийн даатгалын сан” гэхэд жишээлбэл,

- ▶ *Капитал* банканд **66.0 тэрбум**,
- ▶ *Чингис хаан* банканд **93.0 тэрбум**,
- ▶ *Үндэсний хөрөнгө оруулалтын* банканд **35.0 тэрбум**

гээд **нийтдээ 195.0 тэрбум төгрөг**.

“Эрүүл мэндийн даатгалын сан”

- ▶ *Капитал* банканд **59.0 тэрбум**,
- ▶ *Чингис хаан* банканд **30.0 тэрбум**,
- ▶ *Үндэсний хөрөнгө оруулалтын* банканд **30.0 тэрбум**

гээд **нийтдээ 119.0 тэрбум** төгрөг төлөгдөхгүй явж байгаа энэ нөхцөл байдалд хэн хариуцлага хүлээх юм бэ? Ер нь.

Хэнд ч хариуцлага хүлээхгүйгээр ингээд дараа дараагийнхаа төсвөөс

эрсдэлийн сангаас энэ бүх юмыг нөхөөд яваад байх юм бол одоо энэ чинь ер нь ямар учиртай юм бэ?

Ахмадууд өөрсдийнхөө даралтын эмийг хүртэл авч чадахгүй ийм нөхцөл байдалтай явж байхад улсын Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан 314 тэрбумын асуудлаа шийдэж чадахгүй явж байна гэдэг чинь хэний хариуцлага юм бэ?

Д.Амарбаясгалан:

Ц.Даваасүрэн дарга хариулъя.

Ц.Даваасүрэн: М.Нарантуяа-

Нара гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр эрүүл мэндийн эрсдэлийн санд байсан 56.0 тэрбум төгрөгийг нэр бүхий Улсын Их Хурлын гишүүний саналаар Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний зардалд шилжүүлэх санал хоёрдугаар хэлэлцүүлгээр дэмжигдсэн учраас бид энэ залруулгыг хийж байгаа юм. 56.0 тэрбумыг шилжүүлсэн байгаа.

Гишүүдийн дийлэнх чуулганы нэгдсэн хуралдаанаар шилжүүлэх саналыг дэмжсэн юм байна.

Д.Амарбаясгалан: Сандагийн

Бямбацогт гишүүн асуулт асууна. Алга байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна.

О.Номинчимэг: Бүгдэд нь энэ

өдрийн мэнд хүргэе.

Би Төсвийн хуулийн агуулгатай гэхээсээ илүү процессын асуулт асуумаар байгаа юм.

Иргэд олон нийтийн хувьд ч гэсэн, энэ сошиалаар явж байгаа мэдээллийн хувьд ч гэсэн ер нь бид мэдээллээ зөв олон нийтэд нээлттэйгээр өгч байхгүй бол буруу зөрүү ойлголтууд их гарч байна. Санаатай, санаандгүй янз бүрийн мессежүүдийг өгч байна.

“Улсын Их Хурал 11 сарын 15-ны дотор төсвөө батлахгүй бол тарна” ч гэж байх шиг. Тийм ээ. “Хууль зүйн янз бүрийн үр дагавартай байна” гэдэг ийм мессежүүдийг олон нийтэд тарааж байна.

Тэгэхээр энэ дээр бид чуулган дээр олон нийтэд үүнийгээ, төсвөө гуравдугаар хэлэлцүүлэг дээр байгаагийн хувьд процессын асуудлаар илүү тодорхой хариултуудыг нь өгчихмөөр байна.

Нэгдүгээрт, Төсвийн байнгын хорооны даргаас.

Энэ төсвийн хуулийг бид ер нь буцаагаад, яаралтай. Олон нийт ч гэсэн дэмжиж байгаа, гишүүд ч гэсэн дэмжиж байгаа энэ урсгал зардлыг танаад, илүү үр ашигтай байх, төсвийн тэнцлээ сайжруулсан байдлаар төсвийг оруулж ир ээ.

Тэгээд үүнийгээ бид долоо хоногийн дотор гурав, дөрвөн хэлэлцүүлгээрээ хийчихье гээд явахаар болохгүй байгаа юм уу? Цаг хугацааны хувьд үнэхээр болохгүй байгаа юм уу? Уг нь бол энэ бас шийдэл шүү дээ. Заавал тэр оны дотор дахиж төсвийн тодотгол явуулж байхаар.

Буцааж байгаад дахиад дөрвөн шатын хэлэлцүүлгийг ирэх долоо хоногтоо яг фокуслаад хийж болохооргүй

байгаа юм уу? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Хоёрдугаарт, төсвийн хэлэлцүүлгийн процессыг дэг дээр юу гэдэг юм, 15 оны дотор Улсын Их Хурал баталж чадахгүй яах юм? Ямар үр дагавар гарах юм?

Ингээд харахаар зүгээр он гарахад төсөв батлагдаагүй байх юм бол ийм үр дагавар гарна, ийм зохицуулалт байна л гэдэг юм байгаад байдаг.

Тэгээд 15 онд батлахгүй 23-нд баталчихвал ямар үр дагавар гарах гээд байгаа юм. Энэ талаас нь бид яг зөв зүйтэй хэлэлцүүлээд, төсвөө сайжруулахын тулд процессын хувьд ямар хязгаарлалтууд байгаад, ямар хууль эрх зүйн орчинд бид ийм шийдлүүдээ гарах гээд байгаа гэдгийг нарийвчлаад тайлбарлаад өгвөл их сайн байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хуулийн заалттай, горимтой холбоотой дэгийн зохицуулалттай учраас дэгийн хуулийн тайлбарыг хуулиараа албан ёсны тайлбар хийх эрх бүхий субъект нь Их Хурлын Тамгын газрын дарга буюу Ерөнхий нарийн бичгийн дарга тайлбар хийх эрхтэй.

Тэгэхээр Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж дарга энэ дээр ямар нөхцөлүүд байгаа талаар дэлгэрэнгүй тайлбар өгье.

Б.Баасандорж: О.Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасны дагуу Ерөнхий нарийн бичгийн дарга дэгийн

асуудлаар гишүүдэд зөвлөх үүрэгтэй, гишүүд бол эрхтэй субъектүүд байгаа.

Тэгэхээр О.Номинчимэг гишүүн сая хоёр үндсэн асуултыг асуулаа.

Нэг дэх нь, “татаж авах” асуудал, эсхүл “буцаах” асуудлыг ярилаа. Тийм ээ.

Тэгэхээр төсвийн төслийг Их Хурал дээр хэлэлцэхэд бусад хуулийг хэлэлцдэг дэгээр хэлэлцдэггүй.

Өөрөөр хэлбэл бусад ердийн хуулийг бол

- хэлэлцэх эсэх,
- анхны хэлэлцүүлэг,
- эцсийн хэлэлцүүлэг

гэж хэлэлцдэг, бас хязгаартай асуулт асуудаг.

Бүлгээс энэ хуулиар хэн хэн асуулт асуух вэ, хэн хэн үг хэлэх вэ гэж асуулт асуух, үг хэлэх гишүүдийг хуульд кодолж өгдөг. Тийм ээ.

Дэгийн хуулийг нэг дэх хэлэлцүүлэг, хоёр дахь хэлэлцүүлэг дээр Улсын Их Хурлын 126 гишүүнээс хүссэн гишүүд чөлөөтэй асуулт асуух, үг хэлэх боломж нь нэг дэх, хоёр дахь хэлэлцүүлэг дээр байдаг.

Өөрөөр хэлбэл 9 сарын 01-нд Засгийн газраас төсвийн төслийг өргөн мэдүүлсэн.

11 сарын 1-нд чуулганаар төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж дууссан.

Маш товчхондоо олон нийт болон гишүүд маань чөлөөтэй зарчмын

зөрүүтэй санал гаргах, үг хэлэх, санал бодлоо илэрхийлэх хугацаа нь 2 сарын хугацаанд байсан.

Тэгэхээр төсвийн төслийг дэгийн тухай хуульд заасны дагуу 9 дүгээр бүлэг буюу 69, 70, 71, 72, 73 дугаар зүйл. Ийм 5 зүйлээр

- хэрхэн яаж хэлэлцэх юм бэ,
- хэрхэн яаж асуулт асуух юм бэ,
- хэрхэн яаж санал хураах юм бэ

гэдэг асуудлыг бүх зүйлийг нарийвчилж зохицуулж өгсөн.

Тэгэхээр “буцаах тухай асуудал” байсан уу гэвэл байсан. Их Хурал дээр.

Өөрөөр хэлбэл нэг дэх хэлэлцүүлэг дээр байсан.

Нэг дэх хэлэлцүүлгийг хийхэд дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.7-д энэ хуулийн 70.5-д заасан санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол төсвийн төслийг ажлын 3 өдрийн дотор хуульд нийцүүлэн өргөн мэдүүлэх чиглэл өгөх асуудал нь Засгийн газарт байсан.

Өөрөөр хэлбэл Их Хурал нэгдүгээр хэлэлцүүлэг дээр л энэ асуудлыг хийх бүрэн боломж нь байсан шүү.

Парламент олонхоороо асуудлыг шийдвэрлэдэг.

Нэгдүгээр хэлэлцүүлгийг хийгээд Их Хурлын гишүүд маань энэ 2025 оны төсвийн төсөл нь Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг

тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэж үзээд хоёрдугаар хэлэлцүүлэгт шилжүүлсэн. Их Хурлаас.

Хэрвээ хууль, энэ төсвийн төсөл батлагдахгүй бол яах вэ гэж сая гишүүн ярилаа.

Тэгэхээр 69.1 болон Төсвийн тухай хууль дээр Улсын Их Хурал 10 дугаар сарын эхний долоо хоногт багтаан хэлэлцэж эхлэх ёстой. Хуулиараа.

Мөн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлаарай гэдэг үүргийг хуулиараа Их Хуралд өгсөн байгаа.

Тэгэхээр хуулиараа хэрвээ батлахгүй бол нэгд Их Хурал хууль зөрчинө, Засгийн газрын мөн хууль зөрчинө гэсэн үг. Их Хурал хуулиа зөрчиж болохгүй. Их Хурал Үндсэн хуулиараа хууль дээдлэх зарчмыг баримталж ажиллана.

Тэгэхээр хуулиараа 11 сарын 15-ны дотор батлаарай гэсэн үүрэг байгаа учраас 126 гишүүн буюу хууль тогтоогчид маань хуулийн дагуу 11 сарын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж мэдээлэл өгье. Б.Баасандорж даргын микрофоныг өгье.

Б.Баасандорж: Сая тодруулсан дээр хариульа.

Хэрвээ Улсын Их Хурал маань 11 сарын 15-ны дотор 2025 оны төсвийг батлах юм бол хууль батлагдаж хүчин төгөлдөр болж байгаа.

Хэрэгжих хугацаа л 01 сарын 01-нээс хэрэгжиж байгаа.

Саяхан ээлжит бус чуулганаар бид Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль 01 сарын 01-нээс хэрэгжиж эхлэх байсан. Хууль батлагдаад хүчин төгөлдөр болчихсон. Тэр хуульд бид өөрчлөлт оруулсан шүү дээ.

Тэгэхээр энэ бол нээлттэй байдаг. Хууль 11 сарын 15-ны дотроо батлагдаад хүчин төгөлдөр болж байгаа шүү.

Хэрэгжиж эхлэх хугацааг нь л 01 сарын 01 гэж байгаа.

Тэгэхээр хүчин төгөлдөр хуульд өөрчлөлт оруулах асуудал нь хууль тогтоомжийн хууль, бусад хууль тогтоомжоороо нээлттэй гэж үзэж байгаа. Б.Пүрэвдорж гишүүн ээ.

Д.Амарбаясгалан:

Ц.Даваасүрэн гишүүн нэмж хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Яах вэ, ийм тохиолдол 2 удаа болсон юм.

Их Хурал төсвөө баталж чадахгүй яах вэ гэж.

Тэгээд одоо манай хамгийн олон сонгогдсон Д.Лүндээжанцан гишүүний тайлбарыг бид тухайн үедээ яг зөв гэж үзсэн юм.

Их Хурлын үндсэн ажил бол төсөв батлах.

Их Хурал баталж чадахгүй бол “үндсэн ажлаа хийж чадаагүй”, “чадамжгүй болжээ” гэж үзэж байгаа юм.

Тийм учраас чадамжгүй болсон Их Хурал гарах ёстой.

Тийм учраас Их Хурал батлахгүй бол яах вэ гэдэг дээр цааших зохицуулалт ерөөсөө хуулиар байхгүй.

Одоо буцааж өргөн барихтай холбогдолтой байдаг юм уу, тийм зохицуулалт хийсэн юм байхгүй.

Дараагийн чадамжтай Их Хурал бүрдүүлэх ёстой.

Д.Амарбаясгалан: Тийм. Б.Баасандорж дарга нэг зүйлийг дутуу хариулчих шиг боллоо.

Одоо яагаад богино хугацаанд хэлэлцэж болохгүй юм гэж байгаа юм.

Саяын дэгийн тухай хуулийн 69.1 дээр 10 дугаар сарын эхний долоо хоногт төсвийн нэгдүгээр хэлэлцүүлгийг хийнэ гэдэг энэ асуудал үүсэж байгаа.

Төсвийг өргөн барихдаа 9 сарын 01-нд өргөн барина гээд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар зохицуулчхаж байгаа.

Ингэхээр төсвийг буцаах боломжгүй байгаа дэг дээр төсвийг батлаагүй тохиолдолд 2025 оны улсын төсөв байхгүй болно л гэсэн үг.

Засгийн газрын тусгай горим гаргаж, зөвхөн Засгийн газрын түвшинд урсгал зардалтай холбоотой асуудлыг шийдэх боломж үүснэ. Цалинтай холбоотой асуудал.

Бусдаар улсын төсөв бол ингээд тусгай горимоор зохицуулагдах нөхцөл

рүү орчхож байгаа учраас асуудал тэр хэмжээнд шийдэгдэнэ.

Дахиад төсөв өргөн барих хугацаа дараа жилийн 9 сарын 01 хүртэл.

Одоо өнөөдрийн хэрэгжиж байгаа хуулиараа явна л гэж ингэж ойлгох хэрэгтэй.

Өнөөдөр буцаалаа гэхэд буцааж орж ирэхэд яагаад болохгүй юм бэ гэж асуугаад байгаа юм. Буцаагаад өргөн барих хугацаа 9 сарын 01 гэдэг цаг хугацааны хуулийн заалттай.

Нэгдүгээр хэлэлцүүлгийг 10 дугаар сарын эхний долоо хоногт хийнэ гэсэн хуулийн заалттай. Энэ өөрөө эргээд буцчихаад юм уу, буцаачхаад дахиж хэлэлцэх нөхцөл боломжийг бүгдийг нь хязгаарлаж байгаа хуулийн заалт юм.

Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Пунсалмаа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнөөдөр төсөв ярилцаж байгаа энэ цаг хугацаатай холбогдуулаад асуулт асуугаад, саналаа хэлчихье.

Өнөөдөр ер нь иргэд ажил хийгээд, цалин аваад, татвараа төлөөд, зардлуудаа гаргаад хуримтлал юу ч үүсэхгүй байна. Ипотекээ төлөөд юу ч хуримтлал үүсэхгүй байна.

Аж ахуйн нэгжүүдэд мөн адил. Цалингаа тавилаа, татваруудаа төллөө, нийгмийн даатгалын шимтгэл, НӨАТ-аа төллөө. Ямар ч хуримтлал үүсэхгүй байна.

Зүй нь бол энэ чинь зардлаа гаргалаа, татваруудаа төллөө. Бас нэг 30 хувь нь хуримтлал болж үүсэх ёстой. Энэ нь иргэдэд баялаг бүтээж байгаа хэлбэр нь тэр.

Гэтэл бүх баялгаа бүгдийг нь улсад татвар болгож төлөөд байна. Татвар нь үнэхээр дарамттай болчихоод байна.

Гэтэл нөгөө талд нь энэ татварын мөнгийг цуглуулж байгаа манай төсөв маань нийт татвараасаа төсвийнхөө 80 хувийг бүрдүүлж байгаа байхгүй юу. Улам л их.

Төсөв томроод байна гэдэг тэр хэмжээгээрээ татвар улам нэмж аваад байгаа байхгүй юу. Ийм аймаар.

Төсвийг ард иргэд ганц үг ган хийхгүй төлж байгаа, аж ахуйн нэгжүүд төлж байгаа. Тэд нар томрохгүй байсан ч гэсэн, өсөхгүй байсан ч гэсэн төлсөөр байгаа.

Яагаад гэхээр энэ Засгийн газрыг зөв зүйтэй сайхан зүйл хийнэ гэж хүлээж байгаа байхгүй юу.

Гэтэл одоо энэ Засгийн газрын төсөв дотор, урсгал зардал дотор 1.9 их наяд төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гээд 1.9 их наяд төгрөг байгаа байхгүй юу.

Энэ бол асар аймшигтай том тоо.

Манай Монгол Улсын Улаанбаатар хотын хэмжээнд цахилгаан станц 300 мегаваттын цахилгаан станц барихад 2 их наяд төгрөг л хэрэгтэй юм билээ шүү дээ. 2 их наяд төгрөг.

Тэгэхэд 1.9 их наяд төгрөг бид урсгал зардал дээрээ тавьчихаад сууж байна.

Улаанбаатар хотын хэмжээнд бид III, IV цахилгаан станц, Бөөрөлжүүтийн цахилгаан станц гээд дахиад нэг сайхан станц барьчихад л ерөөсөө бид нүүрс түлэхгүй, өвөл сайхан цэнгэг агаартай байх боломж байна.

Энэ урсгал зардал яагаад ийм аймаар.

Задалж онгойлгож үзсэн.

400 орчим тэрбум төгрөг нь боломжтой. Яах вэ, зарцуулж болохоор. 1.4 их наяд төгрөгийг ерөөсөө учрыг нь ойлгоогүй.

Тэр хаана, юунд зарцуулагдаад байгаа нь ойлгомжгүй.

Энэ зардлыг бид түр царцаагаад цахилгаан станцдаа оруулмаар байна.

Д.Амарбаясгалан: Б.Пунсалмаа гишүүн ээ, дэгээ сахья.

Гуравдугаар хэлэлцүүлэг дээр Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгатай холбоотой асуулт асууна. Түүнд хариулах боломжтой.

Б.Пунсалмаа: Тэгэхээр ер нь бид энэ зардлыг үр дүнтэй зүйлд зарцуулах ямар боломж байна вэ? Цаашдаа ч гэсэндээ 2026 оны төсөв дээр. Тийм ээ. Тодотгол дээр ч гэдэг юм уу, ямар боломж байна вэ? Асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үүнийг Ц.Даваасүрэн гишүүн хариулт өгөх үү? Ц.Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Одоо энэ чинь дэгээрээ би зөвхөн танилцуулгатай холбогдолтой хариулахаар юм байна.

Тэгэхээр дэг дээр хөндөгдөөгүй учраас би хариулж болохгүй байна.

Тэгэхээр бас нэг ийм юмыг гишүүд маань ойлгомоор байна.

Энэ дэг хэрвээ зөрчих юм бол харин ёстой цэцэд очвол асуудал үүсдэг.

Би дураараа яриад байж болохгүй. Одоо зохиогоод, тэр хүний яриагүй юмыг яриад байж болохгүй.

Тэгээд дэг сахих гэхээр, хууль мөрд гээд тэгэхээр дарамталаа гээд байгаа байхгүй юу. Зарим нь.

Дэгийг сахиулахаас өөр арга байхгүй. Тэгэхгүй бол бид нар чинь болохгүй шүү дээ.

Киргиз 126 гишүүдтэй байсан. Парламенттай байсан. Тарсан. 90 болсон. Яагаад гэвэл сүүлдээ хяналтгүй болж эхэлсэн байхгүй юу. Дур дураараа ингээд л ерөөсөө дэгээ сахихаа больцгоогоод л.

Тэгэхээр ер нь манай парламент Киргизийн энэ юу руу явах нь уу дээ л гэж зүгээр би саяын энэ төсвийн процессыг харахад тэгж харж байна.

Ер нь ингээд нэг тийм. Бидний чинь зохицуулж байгаа юм нь дэг байхгүй юу. Дэгийн тухай хууль байхгүй юу.

Тэгэхээр бид дэгээ л барихаас өөр арга байхгүй. Түүнээс биш би одоо

зохиож ярьж болохгүй. Хэрвээ яриагүй юмыг бол.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Энэ жилийн улсын төсвийн хэлэлцүүлэг нэлээн өргөн хүрээнд, тэр тусмаа төсвийн тэлэлттэй холбоотой санал шүүмжүүд их гарч байна л даа.

2020 оноос, 2021 оноос нааш үндсэндээ 3 дахин ихэсчхэж байгаа юм. Тэгээд энэ жил олон нийт анхаарч байгаа нь их сайн хэрэг.

Ер нь төсөв тэлчхээр юу нь болохгүй болчихдог юм бэ гэдэг дээр бид бас нэг ойлголтоо нэгтгэмээр байгаа юм.

Миний хувьд тэлсэн төсвийн эсрэг үргэлж л дуугардаг.

Ер нь зарим монголчууд чинь төрийн минь сүлд өршөө, төр хүчтэй, төр бярттай, төр мөнгөтэй л байхаар сайхан гэж боддог хэсэг байдаг.

Тэгэхээр төсөв их тэлснээр яг юу болох гээд байгаа юм бэ цаана нь гэдэг нэг ийм үндсэн суурь асуудал бид нарт бас тулгараад байгаа юм.

Төсөв тэллээ. Төсвийг дагаад ирэх жил юмны үнэ өснө. Юмны үнэ өснө. Төсвийг дагаад тэр төсвийн алдагдал нэмэгдэнэ. Төсвийн алдагдлыг дагаад үүнийг өр зээлээр санхүүжүүлнэ. Монгол Улсын өр өснө.

Үүний нөгөө талд зээлийн хүү өснө. Бизнес эрхлэгчдийн, хувийн хэвшлийн, иргэдийн орон зай хумигдана. Төрийн орон зай нь ихэснэ.

Гэх мэтээр үүний цаана асар олон зүйлсийг бид ярьж дурдаж болно.

Дахиад төсвийн тэлэлттэй холбоотой асар их хэмжээний худалдан авалтууд хийгдэнэ. Валютын ханш чангарна. Төгрөгийн ханш суларна.

Дахиад энэ бүгдийг биелүүлэхийн тулд татвар нэмэхээс өөр аргагүй болно. Татварын ачаалал ирнэ. Татварын ачаалал ирэхээр нөгөө бизнесүүд чинь улам хүндэрнэ.

Дахиад энэ их том зохицуулалтуудын араас нэмээд яалт ч үгүй нөгөө төрийн зохицуулалт, төрийн оролцоо их байгаа учраас авлига гэдэг асуудал үүний ард гарч ирнэ.

Дахиад үүнийг дагаад түүхий эдийн үнийн өсөлтийг дагасан төсвийн тэлэлт чинь эдийн засгийн болоод, улс оронд тогтворгүй байдлыг үүний цаана авчирна гээд.

Яг энэ тэлж байгаа төсвийн чинь цаана асар олон нийгэм, эдийн засгийн урхагтай, тэр тусмаа бид нарын сонгож авсан замд халтай ийм л нөхцөл байдал энэ том төсвийн цаана гарч байгаа учраас олон нийт болоод гишүүд энэ дээр анхаарал хандуулж байгаа нь үнэхээр зөв зүйтэй асуудал.

Суурь асуудал маань том төсөв олон олон зүйлийн, олон олон тийм урхагтай асуудлын эхлэл.

Дахиад төрийн орон зай томорсон, иргэдийн орон зай, бизнесүүдийн орон зай хумигдсан ийм л авлигалын хөрс суурь болсон нөхцөл бид үүний цаана хумигдаж байгаа гэдгийг л тал талдаа бид

ойлгож, бас олон нийт энэ дээр хэлэлцүүлгээр хандаж байгааг зөв зүйтэй л гэж бодож байгаа.

Тэгээд яг энэ дээр асуулт алга. Үг хэлчихье.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе.

Төсвийн хүрээний мэдэгдэл дээр 2 хувийн алдагдалтай байж болно гээд улсын төсөвт заагаад байгаа юм.

Тэгээд бид одоо миний энэ урд биччихсэн байгаагаар Ардчилсан нам бид 8 сайд томилж ажилд нь оруулсан. Ардын нам 12 сайд.

Бид 20 сайд гээд дунджаар бодох юм бол.

Тэгээд энэ чинь 1.9 их наядын алдагдалтай төсөв батлах гээд суугаад байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурлын даргаас асуух гээд байгаа асуулт. Яг энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулаад.

126 гишүүнтэй анхны парламент бид заавал төсвийн хүрээний мэдэгдэлд заачихсан байна гээд алдагдлынх нь дээд хязгаар луу алдагдлыг нь зааж шахаж өгч ях гээд байгаа юм.

Бид нэг ийм жоохон амбицтайхан шиг байж байгаад энэ улсын төсвөө алдагдалгүй батлаад түүхэндээ анх удаагаа 126 болж чадсан юм бол алдагдалгүй төсөв баталчих юм бол бид

нарт гарч ирэх эерэг өөрчлөлтүүд нь маш их байгаад байна.

Адаглаад манай Монгол Улсын зээлжих зэрэглэл улсаа дагаад хувийн хэвшлиүүдийнх нь зээлжих зэрэглэл ч гэсэн чөдөрлөгдчихсөн. “В хасах” гэдэг чинь бас нэг тийм сайхан үзүүлэлт биш шүү дээ.

Зээлжих зэрэглэл өөрөө өсчих юм бол дагаад хувийн хэвшлийн оруулж ирэх гээд байгаа санхүүжилтийн эх үүсвэрийн зардал хүртэл буурах гээд байгаа юм.

Тэгээд 1 их наядын зардал дээр инфляцын 1 хувь ер нь ойролцоогоор оногдож явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид энэ төсвийг чинь энэ чигээр нь алдагдалтай хэвээр нь батлаад байна гэх юм бол ирэх оны тооцоод байгаа тэр “6 нэмэх, хасах 2” гэдэг инфляц чинь өөрөө дахиад магадгүй “10 нэмэх, хасах 2”, араас нь бид валютын ханшны асуудал бас дахиад яригдаж байгаа байхгүй юу.

Тэгээд араас нь яг энд хувийн хэвшил, одоо энэ яригдаад байгаа 33.8 их наядын орлогыг чинь бид нарт 31 их наядыг нь хувийн хэвшлийн татвараар цуглуулж өгнө.

Тэгээд хувийн хэвшил үүнийг чинь даах уу, үгүй юу?

Тийм учраас Улсын Их Хурал өөрөө нэг жоохон амбицтай байхгүй бол оруулж ирж байгаа, Засгаас оруулж ирж байгаа энэ 35.7 гэдгийг чинь сая Сангийн сайд өөрөө энд сууж байгаад хэлж байна шүү дээ.

Улсын Их Хурал хэд гээд батлаад өгнө, бид тэр хүрээнд нь ажлаа явуулна гээд.

Тэгээд бид өөрөө төсвийн хүрээний мэдэгдэл дээр чинь 2 хувийн алдагдал байна гэж зааж өгөөд. Түүнд нь засаг ойлгомжтой. Бид тэр хуулийнхаа хүрээнд алдагдал руугаа явъя л гэдэг юм санал болгож орж ирээд.

Улсын Их Хурал өөрөө эндээ ярихгүй бол.

Зарлагын хяналтын дэд хорооны дэгийн тухай хууль дээр бас байна лээ. Бид энэ асуудлуудаа хэлэлцсэн болоод 3 минут үг хэлээд л.

Өнгөрсөн жилийн тэр төсвөөр бид юу хийсэн бэ гэдгийг хэлэлцүүлж амжихааргүй хугацаанд л бид хэлэлцүүлэх ийм дэгтэй юм билээ.

Тэгэхээр бид дэгийнхээ тухай хуулийг нэг жоохон ажил хэрэгч байгаад.

Ядахдаа Зарлагын хяналтын дэд хороон дээр ярих асуудлуудаа хүртэл нэг жоохон дэгийнхээ хуульд өөрчлөлт хийж өгөх талаас нь.

Зүгээр нэг үг хэлж попрох биш, ажил хэрэгч хандах талаас нь нэг тийм санал гэх юм уу. Та өөрөө хариулах юм уу. Би мэдэхгүй байна. Нэг ийм санал байна.

Д.Амарбаясгалан: Одоо нөгөө дэгээ л барихгүй бол болохгүй дээ.

Хэлэлцэж байгаа асуудлаас гадуур явчихлаа.

Гэхдээ зүгээр яах вэ асуудал дотор чинь Их Хурлын дарга төсвийн таналтыг ганцаараа шийддэг субъект ерөөсөө биш.

Их Хурал 9 сарын 01-нээс эхлээд төсөв хүлээж авсан. Өнөөдөр 11 дүгээр сарын 08-ны өдөр буюу 70 хоног өнгөрчхөж.

Энэ хооронд бид ажлын хэсэг байгуулсан. Байнгын хороод ажилласан. Нэгдүгээр хэлэлцүүлэг хийсэн. Хоёрдугаар хэлэлцүүлэг хийсэн.

Энэ бүх процесс дунд бид бүгдээрээ саналаа чөлөөтэй гаргах, олонхынхоо зарчмаар асуудлаа шийдэх бүх боломж нээлттэй.

Мэдээж байгаа дэгийнхээ хуульд хязгаарлагдаж ажиллана.

Сая зарим хариулт өгч байгаа зүйлтэй бид санал нийлэх ёстой. Дэгийн тухай хуулиараа хоёрдугаар хэлэлцүүлгээ хийгээд, төсвөө боочоод, тэрний ард буцаад задалъя гээд санал гаргаад явж байгаа нь өөрөө зарчим ярих юм бол буруу зүйл.

Бид өөрөө өөрсдөө ажилдаа хариуцлагагүй хандчихаад, өөрсдөө хуулиас гадуур шаардлага тавиад явж байгаа байдал өөрөө буруу болж байгаа юм.

Гэхдээ үүнийг энэ удаа сонгуулийн жил, шинэ дэг хэрэгжиж эхэлж байгаа 126 гишүүнийх. Гишүүд маань дэгээ бүрэн танилцаж чадаагүй байгаа сул талууд гээд олон талын учир шалтгаанууд байгаа учраас бид үүнийг засаж залруулья.

Улсын Их Хурлын гишүүдээс тодорхой зарчмын саналууд гарч байна. Энэ нөхцөл байдлыг бид дуугүй өнгөрч болохгүй юм.

Тэгэхээр Төсвийн байнгын хороон дээр тогтоолын төсөл дэмжигдээд, энэ тогтоолын төслийн дагуу төсвийн тодотгол хийх шаардлага үүсэж байна гэдгээр шийдвэрлээд алхам хийж байгаа.

Алдаа дутагдал байвал энэ болгоныг цаг хугацаанд нь засаж залруулья.

Цаашдаа улам бүүр төгөлдөржүүлье л гэдэг энэ бодлого дээрээ л бид анхаарч төвлөрч ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Да.Цогтбаатар гишүүн тодруулж асууя. Дэгээ барья. Да.Цогтбаатар гишүүн ээ. Танилцуулгатай холбоотой асуулт.

Да.Цогтбаатар: Энэ төсвийн алдагдалтай холбоотой л яриад байгаа.

Тэгээд хүссэн хүсээгүй одоо бид тодотгол яриад энэ ондоо багтаагаад шийднэ гэж байгаа.

Таны тэр Улсын Их Хурлын үйл ажиллагааг төгөлдөржүүлье, сайжруулья гэж байгаатай санал нэг байгаа.

Тэгээд одоо энэ ажлын хэсэг шинээр байгуулаад төсвийн тодотгол орж ирэхэд албан ёсоор дахиад ажлын хэсэгт нь орж ажиллая гэдэг энэ нэрээ албан ёсоор өгөх гэсэн юм.

Тэгэхгүй би өмнө нь ажлын хэсэгт орж ажиллая гээд 2 удаа саналаа өгөөд хасагдчихсан байсан юм.

Тэгээд манай энэ хангайн бүсийн тойргоос яг энэ төсвийн зарлагын төсөвтэй холбоотой 2025 оны төсвийн төсөл дээр бид бүсээсээ хүн оруулж чадаагүй хоцорчихсон.

Тэгээд одоо бол албан ёсоор нэр ажлын хэсэгт оруулаад өгөөрэй гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан:

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Төсөв урьд өмнөх жилүүдээс нэлээн дуулиантай, нэлээн мэтгэлцээнтэй байна.

Миний хувьд юу гэж харж байна гэхээр Улсын Их Хурал 76 биш, 126 болсон. Парламент дээр хэлэлцдэг асуудлууд хайрцаглагддаг биш мэтгэлцээн явагддаг болж байна.

Энэ бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхийн төлөө тухайн үед гишүүдийн тоог нэмнэ гэж хэлээд загнуулаад явж байсан хүний хувьд зөв зүйтэй, Монгол Улсын парламент дэвшилтэт хямрал руугаа явж байна л гэж миний хувьд харж байгаа.

Төсөвтэй холбоотой юм яривал нэлээн юм байна. Гэхдээ нэг том ололт нь тойрог тойрог руугаа хуваадаг биш, бүсчилсэн хөгжил, энэ томоохон юм руугаа хийе гэсэн энэ том Засгийн газрын оруулж ирсэн саналыг би дэмжээд явж байгаа.

Дээрээс нь дутуу барилгуудаа дуусгая гэсэн ийм том юм энд явж байна.

Иргэдийн, гишүүдийн шүүмжлээд байгаа энэ урсгал зардалтай холбоотой асуудал дээр нэлээн авах гээхийн ухаанаар хандах хэрэгтэй байх.

Сайд нар та нар Сангийн яам руу саналаа явуулахдаа энэ урсгал зардал, бүх юмнуудаа явуулчихаад, тэгээд түүгээр нь орж ирсэн төсвөө манай дээр урсгал зардал ингээд нэмэгдэж байгаа юм гээд хэлэх ёстой байхгүй юу.

Жишээ нь, бусдаар гүйцэтгүүлэх ажлын хүрээнд мал эмнэлгийн тэр баахан төлбөрүүд, хот тохижилтынхон, IT-ийн компаниуд, төр IT хийдэг биш IT-ийн компаниар хийлгэе гэсэн юмнууд чинь энэ дотор улсын хэмжээний том зардал ороод явж байгаа шүү дээ.

Мэдээллийн төв барих гээд л байна гээд л уурлаад л байгаа. Тэр чинь сумын Засаг даргын Тамгын газрын байшингууд шүү дээ. Мөөгөнцөртсөн байшинд л сууж байгаа шүү. Тэд нар.

Их Хурлын гишүүд болохоор өрөө тасалгаагаа том, жижиг гэж голоод байдаг хэрнээ тэр суман дээр төрийн алба хийж байгаа хүмүүс яагаад эрүүл мэндийн шаардлага хангасан юманд сууж болдоггүй юм.

Тэгэхээр үүнийг бид улсын дүнгээр нь томоор нь авч үзээд тэдэн төгрөгөөр төсөв нэмэгдээд байна гэж мэдээлэхээсээ өмнө яг юу юун дээр байгаад байна вэ гээд.

Сая Л.Гантөмөр дарга ажил хэрэгч санал тавьж байна шүү дээ. Зүгээр том тоо яриад, шүүмжлээд байхаасаа илүүтэйгээр төсвөө танах саналаа гаргаж ирээч ээ гэж хэлээд байгаа нь би бараг

бидний төсөв тойрч хэрэлдээд байгаа юмны гол агуулга ч байж магадгүй.

Тэгэхээр үүнийг бас нэг авах гээхийн ухаанаар хандах хэрэгтэй.

Өнөөдөр надтай Биндэр сумын цэцэрлэгийнхэн ирж уулзлаа. Зөөлөн эдлэл, тоног төхөөрөмж, гал тогооны хэрэгсэл байхгүй гэж. Гэтэл тэр нь боловсролын, манай төсвийнхний яриад байгаа тавилга, эд хогшил дээр нь явж байгаа байхгүй юу. Улсын хэмжээний энэ бүх юмнууд чинь явж байгаа энэ төсөв чинь том зургаараа л тэгж харагдаад байгаа юм даа.

Тэгэхээр энэ дотор харин тэр томилолтын зардал юмнуудыг ингэж өсгөснийг би сайн ойлгож өгөхгүй л байгаа юм. Гадаад томилолт юмнуудыг.

Тэгэхээр би сайд нарыг энэ дээр жоохон тийм нэг тэр төсвийнхөө зардлыг яагаад нэмэгдэж орж ирснийг.

Одоо энэ цалин, тэтгэвэр нэмчихсэн. 6 хувиар нэмнэ гээд өнгөрсөн жил шийдчихсэн шүү дээ. Тэрний зардал гэхэд хэчнээн төгрөг орж ирж байгаа юм гээд.

Ингээд нэг тос, усаар нь ялгаад үнэхээр үндэслэлгүй юм нэмсэн бол тэрийгээ бид тойрч ярихаас биш одоо ингээд автоматаар юмаа хасчихвал тэгвэл малынхаа вакциныг яаж хийлгэх юм.

Тэр хүний эрх ярьж байна. Цагдаагийн мөрдөн байцаалтын өрөөнд аудио бичлэг хийдэг тэрийг хувийн компаниар хийлгэнэ гээд л энд туссан юм билээ шүү дээ.

Ингээд нэг жоохон ялгаж салгаж ингэхгүй бол төсвөө ярьсан хүн, хэмнэе гэсэн хүн нь мундаг. Үүнийг баталъя гэсэн хүн нь дайсан юм шиг попордог байж болохгүй.

Би бас орон нутагт сумын дарга хийж байсан хүн. Энэ төсвөөс хэдэн төгрөг нь тэнд очдог вэ, яадаг вэ, ийдэг вэ гээд бас гадарлах хүний хувьд юмаа жоохон ялгаж салгаж яримаар байна. Ажил хэрэгч хандмаар байна гэж би хэлэх гэж байгаа юм.

Нөгөө талдаа төсөв хэлэлцэж байгаа зүйлийг энэ дэгийн хуулиараа зохицуулагдаж байгаа. Бид энэ дээрээ дарга дэгийн хууль дээр жоохон шинэ мөрдөгдөж байгаа учраас тэр болгон өөрчлөөд баймааргүй байна гэж ингэж хэлдэг. Тэр ч зөв байх.

Гэхдээ яг энэ төсөвтэй холбоотой асуудал энэ 126-тай парламентад орж ирж байгаа энэ цаг үед хуучин 76.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ц.Идэрбат гишүүнд 1 минут.

Ц.Идэрбат: Хуучин 76-тай явж байсан дэгээр хоёрдугаар хэлэлцүүлгээс хойш юм өөрчилж болохгүй гэдэг энэ юм маань явахгүй болж эхлээд байна.

Тэгээд дээрээс нь хоёрдугаар хэлэлцүүлгээр нэгдүгээр хэлэлцүүлэг дээр дэмжээд явж байтал хоёрдугаар хэлэлцүүлэг дээр огт дэмжихгүй юмнуудыг дундуур нь оруулж ирээд байна шүү дээ.

Одоо тэр “Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын, Эрдэнэцагаан сумын, Баяндэлгэр сумын сургууль,

цэцэрлэгүүдийг хасаад, цэцэрлэгт хүрээлэн, гэрэлтүүлэг болгоно” гэдэг нь яаж байгаа юм.

Үүнийг би дэмжмээргүй байгаа юм.

Гэтэл би саналаа хэлье гэхээр дэгээр хориотой учраас эндээс гараа сарвалзуулаад л ангалзаад байхаас өөр юм байхгүй болчихож байгаа байхгүй юу.

Гэтэл тэндээс сонгогдсон гишүүн байдаг.

Тэгэхээр цаашдаа бид асуудлаа томоор харья гэвэл энэ дэгийн зохицуулалт дэг дотроо энэ төсвийн зохицуулалтыг хийж байгаа энэ 9 дүгээр заалтаа бас нэг эргэж хармаар юм уу даа гэж би бодож байгаа юм.

Нөгөө талдаа тэгвэл Их Хурал заавал 10 сарын 01-нд биш 9 сарын 01-нд ажлаа эхэлж болно шүү дээ. Төсвөө бид 10 сард.../минут дуусав/

Д.Амарбаясгалан:

Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууна.

Д.Ганмаа: Сайн байцаана уу?

Бид асуудлыг ярилцаад л, асуудал тойрч ярьсаар байгаад нэг тийм шийдэл бас их удаан яриад, маш удаан суугаад байдаг асуудлууд харагдаж байна.

Тэгээд би энэ 2000 оны төсөвтэй холбогдуулан Улсын Их Хурлын тогтоолын төсөл санаачилж байгаа тухайгаа яриад дэгийн дагуу асуулт болгоё.

Өнгөрсөн жилүүдэд Үндэсний аудитын газраас Монгол Улсын төсвийн талаар гаргасан аудитын дүгнэлт, улсын төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, мөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжүүд жил бүр төсвийн төсөлд тусгагдаж буй хөрөнгө оруулалтын сонголт, ач холбогдол, эрэмбэ дараалал тогтоох асуудал дээр учир дутагдалтай. Хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн явц нь удаашралтай. Өртөг зардал нь өсдөг, сунжирч он дамждаг. Үүний цаана магадгүй авлига, хээл хахуулийн асуудал байгааг салбар салбарын төлөөллүүд ярьж байна.

Иймээс бусад улсын сайн туршлага жишээнд тулгуурлан “улсын төсвийн хөрөнгө оруулалт” гэж юу вэ, “улсын төсвийн хөрөнгө оруулалтад тавигдах шаардлага” гэж юу вэ, аль шатны төсвөөс ямар хэмжээний ямар төслийг санхүүжүүлж байх вэ гэсэн тодорхой шалгуур, хүрээ хязгаарыг Улсын Их Хурлаас тогтоож өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Ийнхүү тогтоосноор жил бүрийн төсвийн төслийг боловсруулахад зөвхөн Сангийн яаманд бүхий л хөрөнгө оруулалтын төсвийн саналуудыг төвлөрүүлж, нэг талаасаа хэт ачаалал үүсгэдэг. Үүнтэй ижил бус, харин ч тухайн орон нутгийн төсвийн хэмжээнд сонгон шалгаруулалтыг явуулаад хэрэгжүүлж болохуйц бага дүнтэй, нарийн төвөгтэй бус энгийн хийцтэй барилга, байгууламж, төслүүд, орон нутгийн төсвийн хэмжээнд авч шийдэж байдаг ийм болох талаар хөрөнгө оруулалтын төслийг сонгох, эрэмбэлэх үйл явцыг илүү тодорхой болгож өгөх боломжтой гэж бодож байна.

Тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтын төслүүдийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд шилжүүлснээр тухайн аймаг ирэх жил хийгдэх хөрөнгө оруулалтын төслүүдийг аль суманд ямар эрэмбэ дарааллаар хэрэгжүүлэх вэ гэдгийг өөрсдөө хэлэлцэн сонгоод шийдвэр гаргах боломж бүрдэж, орон нутгийн засаг захиргааны эрх, үүрэг нэмэгдэх давуу талтай болно.

Тэд нар байгаа нөхцөл байдлаа ч гэсэн бид нараас илүү мэдэж, төсөөлж байгаа.

Засгийн газраас баримталж буй бодлогод цаашид улс орны хөгжилд илүү хувь нэмэр оруулахуйц чухал ач холбогдол бүхий аж үйлдвэр, дэд бүтэц, нийгмийн нэн чухал томоохон төслүүдэд илүү анхаарч. Одоо энэ реформ, мега төсөл шиг. Ингэж хандуулахаар зорьж байгаа тул энэхүү зорилгод нийцүүлэн улсын төсвийн хөрөнгийн хуваарилалтыг үүнд түлхүү чиглүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй байна.

2025 оны төсөв ийнхүү батлагдаж тодотголдоо орж ирэхээр шийдэж байх шиг байна.

Ингэхээр өнөөдрийн төсвийн тэлэлттэй холбоотой бидний хэлэлцэж байгаа эдгээр асуудлыг дахин давтагдуулахгүй, үүнээс урьдчилан сэргийлэх нэг арга хэмжээ болгон Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа бүрэн эрхийн дагуу тогтоолын төслийг холбогдох хуулийн дагуу боловсруулж өргөн барих ажлыг хийе.

Энэхүү тогтоолоороо Улсын хөрөнгө оруулалтын тухай хууль гэсэн төслийг боловсруулж 2025 оны чуулганд танилцуулахыг Монгол Улсын Засгийн

газарт үүрэг даалгавар болгохоор санал тусгана гэж бодож байна.

Ийм ижил төстэй хууль өргөн баригдахаар бэлтгэгдэж байгаа юу гэдэг л асуулт байна.

Д.Амарбаясгалан:

Ц.Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн:

Гишүүн ээ, дэгийнхээ юугаар би зөвхөн танилцуулга дээр байгаа хөндөгдсөн асуудлуудыг л ярих ёстой юм билээ л дээ.

Тийм болохоор хөндөгдөөгүй асуудлуудыг ярихаар би өөрөө дэг зөрчих болчхоод байгаа байхгүй юу.

Ер нь гишүүд энэ асуугаад байгаа юмнууд, яриад байгаа юмнууд дотор ярьчихмаар юм байна л даа.

Гэхдээ дэг зөрчигдөөд байгаа учраас би тайлбар хийгээд дураараа байж болохгүй болчхоод байна.

Д.Амарбаясгалан:

Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга:

Энэ өдрийн мэнд хүргэе.

2025 оны төсвийн тухай хууль дээр харахад аймгуудад үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэг, тэгээд орон нутгийн төсвөөс буцаагаад төвлөрүүлж байгаа орлогуудыг харахад ер нь уул уурхайн төслүүд хэрэгжиж байгаа аймгууд төсөвт орлого бүрдүүлээд, тэгээд ямар нэгэн уурхайн төслүүд хэрэгжихгүй байгаа аймгууд руу хуваарилагдаж байгаа дүр зурагтай байгаа.

Тэгээд ер нь зарчим нь тухайн уурхайн төсөл хэрэгжиж байгаа аймагт нь хамгийн их үр шим нь хүртэгдэж байх ёстой. Энэ зарчмыг бүгдээрээ баримталдаг байх хэрэгтэй байна.

Тэгээд ер нь манай салбар төсвийн 34 хувийг нь доор хаяж бүрдүүлээд. Шууд утгаараа. Дам нөлөөгөөрөө 50-аас дээш хувийг бүрдүүлдэг байхад ер нь Ховд аймаг, Завхан аймаг, Хөвсгөл аймагт уул уурхайн төслүүд хараахан амжилттай хэрэгжээгүй байгаа, орон нутаг нь дэмждэггүй байгаа аймгууд руу дэмжлэгээ нэхэхээр явж байгаа нь шударга бус байна гэдгийг заавал хэлэхийг хүсэж байна.

Ховд аймгийн бүх сумд хар замаар холбогдох биш Өмнөговь аймгийн сумдууд хар замаар тэргүүн ээлжид холбогдох ёстой байтал энэ байдал өнөөдөр эсрэгээрээ байгаа.

Тэгээд сүүлийн өдрүүдэд манай эрдэс баялгийн салбарынхны эсрэг маш их зохион байгуулалттай тийм дайралтууд болсон.

Ховд аймгийн Мянгад сумынхан тухайн газар төсөл дээр ажиллаж байгаа манай салбарын мэргэжилтнүүд, хүний сайхан хань, хүүхдүүдийн хайртай аав, ээж нарыг гэмтээж бэртээж нэлээд олон байдлаар дарамталсан. Тэд нар уг нь тэнд дараагийн Эрдэнэтийг бий болгох гээд ажиллаж байгаа салбарын инженерүүд байгаа байхгүй юу.

Тэгтэл ямар учраас дараагийн Эрдэнэт бий болох боломжоосоо татгалзаж байгаа юм бэ?

Тэгэхээр энэ байдлаар манай салбарыг дэмжихгүй байж дараагийн

Эрдэнэт хаана байгаа юм, дараагийн Тавантолгой хаана байгаа юм гэж асуух эрх байхгүй болно.

Тэгээд одоо хэрэгжиж байгаа бүх төслүүд өөрийн гэсэн настай. Тэгээд үйл ажиллагаа нь дуусахаар яах вэ. Нүүрсний үнэ бүр унаад манай Монгол Улсад орж ирэх мөнгө байхгүй яах вэ.

Тэгэхээр өнөөдөр бид янз бүрийн мэдээлэл урдаа тавиад төсөв их байна, бага байна, танана гээд ярих боломжгүй байх нөхцөл манай салбартай шууд хамааралтай байхад дараа дараагийнхаа боломжийг бий болгох гэж зүтгэж байгаа инженерүүд рүү ийм байдлаар их олон жил дайрч байгаа. Тийм.

Тэгэхээр ирээдүйгээ харж шийдвэр гаргадаг байх хэрэгтэй байна. Тэгээд манай энэ Их Хурлын танхимд Ховдоос гаралтай олон гишүүд байдаг.

Тэгэхээр өөрөө уул уурхайн салбарын төлөөллийн хувьд, эрдэс баялгийн салбарын төлөөллийн хувьд, энэ салбарын инженер хүний хувьд албан ёсны шаардлагыг бүх Ховдоос гаралтай гишүүдэд хүргэнэ.

Одоо ойрын хугацаанд болсон асуудлаас үүдэж бэртэж гэмтсэн бүх инженерүүдэд Та бүгд өөрсдийнхөө зүгээс дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Манай иргэд асуудлыг маш сайн ойлгох чадвартай гэж боддог.

Тэгэхээр түүн дээр нь ойлголцоход дэмжлэг үзүүлж ажиллахыг хүсэж байна.

Тэгэхээр үүнтэй холбоотой хоёр асуулт байгаа юм.

Тэгэхээр Сангийн яамныхнаас, Б.Жавхлан сайдаас эхний асуулт. Ер нь уул уурхайн төсөл хэрэгжиж байгаа сум, аймагт ямар давуу байдал төсөв дээр бий болж байгаа вэ?

Ц.Туваан сайдад үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор асуулт асуухыг хүссэн юм.

Тэгээд яах вэ, дэгээ зөрчөөд асууж байж магадгүй. Гэхдээ та хариулбал их сайн юм байна.

Тэгэхээр Ховд аймгийн Мянгад суманд үүссэн нөхцөл байдал уг нь салбарын яам нь гаргасан шийдвэрээ цээжээрээ хамгаалаад явах ёстой.

Тэгэхээр энэ дээр ямар ажлууд хийж байна вэ?

Д.Амарбаясгалан: Үндсэндээ Б.Уянга гишүүн үг хэллээ. Дэгээ барьж ажиллахгүй бол болохгүй.

Тэгэхээр төсвийн гуравдугаар хэлэлцүүлэг дээр Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгатай холбогдуулж асуулт асууна.

Тэгэхээр би таны асуусан асуулт нь яг энэ хүрээнд биш учраас хариулт өгүүлэх боломж алга.

Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууя.

Д.Бум-Очир: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

3.6 их наядаар таная гэдэг санал тодорхой тооны гишүүд гаргаад явж байгаа.

Яг юу юунаас гаргахаа, яаж хасахаа Хэвлэлийн бага хурал дээрээ энэ гишүүд маань ярьсан. Гэтэл сая хариулт дээр шууд зүгээр хаанаас нь ч хамаагүй 3.6 их наядыг авчих гээд байгаа юм шиг, эсвэл нөгөө 14 мега төсөл чинь хийгдэх боломжгүй болчихно гэх мэтчилэнгийн хариултаар тойруулаад ч гэх юм уу, ацаглаад байх шиг байх юм.

Их тодорхой санал тэр хэвлэлийн бага хурал дээр хийчихсэн.

Би энэ саналыг дэмжиж байгаа гэдгээ нэгд илэрхийлэх гэсэн юм.

Дараагийн нэг зүйл. Сая Д.Ганмаа гишүүн хэлчихлээ.

Аудитын дүгнэлт гээд тов тодорхой юм гарчихсан байгаа. Энэ аудитын дүгнэлт дээр ярьсан нэг ноцтой зүйл юу гэхээр энэ чухлын эрэмбэ дараалал нь хаана байгаа юм бэ гэдэг ийм асуудлыг ярьсан.

Эрэмбэ нь байхгүй байна, эрэмбэ алдагдчихаад байна гэж ярьсан.

Засгийн газрын ч тэр, Их Хурал ч тэр “Хүн төвтэй бодлого хэрэгжүүлнэ” гээд байгаа.

Тэгвэл “Хүн төвтэй бодлого” гэдгийн чинь төв нь юу юм бэ? Боловсрол, эрүүл мэнд шүү дээ.

Гэтэл 2025 оны төсөв дээр шинээр сургууль, цэцэрлэг, эмнэлэг барих төсөв суугаагүй. Хуучнуудаа дуусгах л төсөв тавигдсан.

Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Монгол Улсын хүн ам өсөж байгаа. Сургууль, цэцэрлэгийн эрэлт хэрэгцээ

одоо ч хүрэхгүй байгаа. Бид заавал сургууль, цэцэрлэг, эмнэлэг төсөв дээрээ тавьж явах ёстой.

Бүсийг нь чангалж болдог салбар байдаг байх. Болдоггүй салбарууд байдаг.

Хэрвээ бид “Хүн төвтэй бодлого”, хүний хөгжлөө барьж байгаа юм бол энэ хүний хөгжлийн цөм болсон энэ төсвүүдээ. Төсөв томорсон мөртлөө шинэ сургууль, цэцэрлэг, эмнэлэг байхгүй байгаа нь харамсалтай байна.

Дараагийн нэг зүйл. Энэ төсөв хэлэлцдэг процедур, аргачлал энэ юмаа бид нэг анхаарах ёстой болчихсон юм шиг.

Өнгөрсөн хугацаанд манай нийгэмд юу болж өнгөрөв гэхээр энэ боож оруулж ирсэн төсөвт чинь ард иргэд итгэхгүй байгаа юм биш үү. Итгэлээ алдаж байгаа юм биш үү.

Дотор нь юу юу хаана нь оруулчихсан байгаа юм. Янз бүрийн мөнгө оруулаад ирдэг л гэж байна. Гишүүд өөрсдөдөө мөнгө тавиулчихсан байдаг гэдэг асуудал өнгөрсөн долоо хоногт яригдлаа шүү дээ.

Энэ бүхэн өнөөдөр юунд хүргэж байна вэ гэхээр энэ олон нийт, тэр битгий хэл Их Хурлын гишүүд миний бие ч гэсэн ялгаагүй энэ төсөв дотор ер нь өөр юу юу байгаа юм бэ гэдэгт итгэх итгэл алдарч байна шүү дээ.

Дэмжих боломжгүй нөхцөл байдал руу хүргэж байна шүү дээ.

Дотор нь юу боогоод, хаана нь хэн юугаа оруулчихсан байгаа гэдэг нь

тодорхойгүй байдаг гэдэг ийм зүйлийг гишүүд зөндөө ярьсан.

Тэгэхээр энэ төсвийг дэмжихгүй байх, ялангуяа олон нийт шүүмжлэх бас нэгэн том шалтгаан энэ төсөвт чинь итгэхгүй байгаа байдал болчихоод байна шүү гэдгийг онцлон хэлмээр байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Энэ жилийн төсөв бол. Би их олон төсөв сонссон. Би Сангийн сайд байсан. Төсөв ч оруулж байсан хүн л дээ.

Энэ жил яагаад ингэж их анхаарал татаад ийм болчихоод байна вэ гэхээр угаасаа Засгийн газрын оруулж ирж байгаа төсөв нь төсөв биш.

Ийм төсөв би амьдралдаа үзээгүй. Ийм дампуу, ийм алдагдал ихтэй.

Тэгээд хавар гэж бараг зун шахуу юм даа. Манай Их Хурлын гишүүдийг шинэвтэр байхад нь төсвийнхөө тодотгол хүртэл хийсэн юм шүү дээ.

Төсвийнхөө хүрээний мэдэгдлийг хүртэл шинэчилсэн шүү дээ.

Тэгж тэгчхээд тэрийгээ хүртэл зөрчөөд давхиж оруулж ирж байгаа болохоор энэ шүүмжлэл дагуулна.

Дээр нь сонгууль дөнгөж саяхан болсон шүү дээ. Тэгээд сонгуулиар юу юу амлалаа. Тэгээд одоо энэ аж ахуй

эрхлэгчдийн итгэл алдардаг нь аргагүй л дээ.

Нийгмийн даатгалын шимтгэл жаахан буугаад орхидог болов уу, НӨАТ-ын буцаан олголт жаахан тэгдэг болов уу, үгүй яадаг бол доо гэсэн ийм хүлээлт байж байсан чинь энэ орж ирж байгаа төсөв нь Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрийг зөрччихсөн.

Намуудын Их Хурлын сонгуульд амлаад байсныг баахан л бүгдийг нь гоё болгоод өгнө гэсэн. Тэр мөрийн хөтөлбөрүүдийг зөрччихсөн болохоор дурын дуракийн сэтгэл, итгэл алдарч байна. Бүх хүмүүс сэтгэл алдарч байна.

Энэ ёстой ямар муухай худлаа ярьдаг юм бэ. Яагаад суурин дээрээ эргэдэг юм бэ. Юу болоод байгаа юм бэ.

Уг нь бас олуулаа нийлж байгаад гайгүй юм хийчих байх гэсэн. Ийм л юм болж байх шиг байна даа. Та нар минь дээ.

Би тэгээд манай Их Хурлын харин гишүүд, энэ Д.Энхтүвшин нарын гишүүд их зөв санаачилга гаргалаа.

Юмыг зөв болгоё гэж байгаа хүмүүсээ дэмжээч. Тэд нарыг битгий ингэж буланд шахаж хашраах гэж янз бүрийн арга хэмжээ авч байдаг чинь буруу байна.

Би энэ 4 гишүүний төсвийн урсгал зардлыг 3.6 их наядаар тана гэдэг дээр 100 хувь санал нэгтэй байгаа. Би өөрөө энэ урсгал зардлын ажлын хэсэгт орж ажилласан байхгүй юу.

Энэ урсгал зардлыг 3.6 их наядаар ихэсгэхгүйгээр амьдарчих боломж байна.

Би Сангийн сайд буюу Ерөнхий сайд байсан хүний хувьд хэлж байна. Юу дутаж байна, юу байхгүй байна. Сэтгэл зүрх байхгүй байна.

Улс орныхоо хөгжил, хүмүүсийнхээ ахуй амьжиргаа, аж ахуйн нэгжүүдийнхээ хөл дээрээ босох тэр бодлого байхгүй байна. Энэ Засгийн газарт.

Тийм учраас аймаар муйхар юм оруулж ирээд тэр муйхар юмаа худлаа нэг аргацаасан байдлаар Их Хурал дээр хэлэлцэж байгаа дүр үзүүлээд, эсгээд, тэгээд одоо ингээд ямар ч өөрчлөлтгүйгээр гараа өргөөд баталж байна. Чи гараа өргөхгүй бол одоо бараг бүлгийнхээ шийдвэрийг биелүүлээгүй гэдэг хэрэгт орж байгаа юм биш үү манай хэд. Ингэж болохгүй.

Тэгэхээр энэ төсөв батлагдах юм бол ямар муу үр дагаварт хүрэх вэ гэдгийг сая О.Цогтгэрэл гишүүн хэлчихлээ шүү дээ.

Аж ахуйн нэгжүүд чинь сөхөрчихнө. Ахуй амьдралын юмны үнэ нэмэгдэнэ, валютын ханш ингэнэ. Мэдэхгүй ээ. Маш муу үр дагавартай юм хийж байгаа юм.

Тэгээд одоо дахиад манай Их Хурлын гишүүд бид нарыг нэг молигодож л байгаа юм байна л даа.

Тайван амгалан байцгаа. Тоогүй юм боллоо. Одоо удахгүй төсвийн тодотголыг дахиж оруулж ирээд алаад өгнө гэж.

Итгэл алдарчихсан шүү дээ. Хүмүүсийн итгэл алдарчихсан.

Улсын Их Хурлын гишүүд ээ, та нар хариуцлагагүй, хоёрдугаар хэлэлцүүлэг, гуравдугаар хэлэлцүүлэг дээр тэгсэнгүй гээд яллаад байх юм.

Засаг чинь сайн юм хийчихсэн бол Их Хурлын гишүүд, ер нь бүх Их Хурал дээр гишүүд нэг иймэрхүү юм ярьдаг, шүүмжилдэг. Тэр байдаг шүү дээ.

Тэгэхдээ цаад орж ирж байгаа юм чинь рам нь зөв байсан тэгээд л энэ хавьд шийдэгдээд л явах байсан.

Болохгүй байгаа учраас л Б.Жавхлан, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ээ, төсвөө татаж аваад янзлаад буцааж оруулаад ир гэж би зөндөө хэллээ. Болсонгүй.

Д.Амарбаясгалан:

Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн.

Асуулт асуугаагүй учраас нэмж минут өгөх боломжгүй байна.

П.Мөнхтулга: Түрүүн 11 сарын 15-наас өмнө бид төсвөө баталж чадахгүй бол тарах үндэслэл байгаа гэж Ц.Даваасүрэн гишүүн хэлж байна.

Тэгээд ер нь хэдүүлээ тарья даа. Одоо энэ танхимаа ч хар л даа. Тарчихсан юм биш үү, бараг.

Үг хэлэх гэхээр үг хэлүүлэхгүй. Ер нь жоохон субъектив хандаад байна.

Шинэ сонгогдсон гишүүдийг үг хэлэх гэхээр дундуур нь ярьдаг, микрофоныг нь тасалдаг.

Зүгээр ажиглаад байхаар нэг намын харьяалал гаргаад, шинэ хуучнаар нь ялгаад байх юм бол энэ чинь угаасаа

Их Хурал биш юм биш үү. Энэ чинь намын Их Хурал биш энэ чинь Улсын Их Хурал биз дээ.

Тэгээд түрүүн яах вэ сэдвийн хүрээнд л гээд л таслаад байгаа юм. Их Хурлын гишүүдийн хэлэх үгийг Их Хурлын даргын зөвлөл баталж байгаа шүү дээ. Минутаар нь.

Сөрөг хүчинд бүр цаг ч байхгүй байгаа шүү дээ. Хэлэх үг ч байхгүй байгаа.

Тэгэхээр түрүүн олон гишүүдээс харж байна. Энэ дэгийн тухай хууль дээр бид өөрчлөлт оруулж, энэ ард түмний өгсөн саналыг.

Энэ төсвийн тухай хууль ийм болж байгаа нь бас олон Их Хурлын гишүүд үгээ хэлээгүйгээс болж байгаа шүү дээ.

Тийм болохоор энэ алдаа хаана байна вэ гэхээр бүгдээрээ нийлж хэлэлцээгүйгээс л ийм төсөв гарч ирж байгаа юм. Их Хурлын гишүүд өөрсдөө хуучин дэгээрээ кнопоороо үгээ хэлэх эрхээ авдаг байсан бол ийм төсвийн хууль батлагдахгүй.

Хэлэх үгийг нь даргын зөвлөл баталж боомилж байгаад, сөрөг хүчний дуу хоолойг хааж байгаад хийсэн төсөв чинь энэ.

Тийм болохоор энэ баталсан 3 минутдаа бүтэн үг хэлүүлчихдэг баймаар байна. Тэгээд хамгийн сүүлийн 20, 30 секунд дээр хүн хэлэлцэх асуудлынхаа асуудлыг ярьж болно шүү дээ.

126 гишүүдээс өнөөдөр 25 нь л үг хэлэх хүсэлт өгсөн байна. Энэ 25-ыг

бүтэн хэлүүлчих л дээ. 3-хан минут шүү дээ.

Тэгээд асуудалдаа оръё. Ямар ч байсан урсгал зардлыг хэмнэх дээр дэмжиж байгаа. Дэмжих дэмжихдээ бүр тодорхой саналтай дэмжиж байгаа.

Дахиад хэлье. Бид уурхайн түүхий эдүүд өдрөөс өдөрт унаж байна. Дэлхийн эдийн засгийн байдал сайжрахгүй байна.

Тийм болохоор өөрсдийн шавхагддаггүй нөөц хэзээ ч үнэ нь тогтвортой байдаг хөдөө аж ахуйн энэ салбар луугаа энэ 3.6 их наядаа үйлдвэр болгож оруул аа. Аж үйлдвэрийн салбараа хөгжүүлэе.

Америкийн Нэгдсэн Улс өнөөдөр дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн салбарын 20 хувийг нийлүүлдгээрээ тогтвортой эдийн засагтай явдаг.

Өнөөдөр бид 70 сая малтай, нийт хүн амын хөдөлмөрийн зах зээлийн чинь 21 хувь нь эндээс амьжиргаагаа болгож байхад бид энэ салбартаа ерөөсөө хөрөнгө оруулалт хийхгүй.

Тийм болохоор маш тодорхой. 3.6 их наядыг танана. Хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийнэ. Аж үйлдвэрээ босгоно.

Тэгээд өнөөдрийн хэлэлцэх асуудал дээр би өнөөдөр өөрөө Төсвийн байнгын хороонд сууж санал өгсөн.

Сая Ц.Даваасүрэн даргын хийсэн мэдэгдлийг дэмжиж байгаа. Оноос өмнө төсвөө тодотгох ёстой. Төсвийн байнгын хорооны байр суурийг дэмжиж байгаа.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Төсөв хэлэлцэх үед би асууж байсан. Яагаад Засгийн газраас орж ирж байгаа материал дээр ард иргэдтэй зөвлөлдөх, санал авах ёстой хуулийн хугацаанд нэг ч санал ирсэнгүй гэж бичсэн байгаа юм. Энэ танилцуулга дээр.

Яагаад ингэж нэг ч санал ирээгүйгээр 100 хувь дэмжигддэг байна гэж асууж байсан.

Өнөөдөр асуудлыг хэлэлцэх ёстой, ярих ёстой зүйлүүдээ гурилдсан, маш арчаагүй байдалтай байснаас болж өнөөдөр асуудал үүсэж байгаа. Үүнийг хойшид анхаарч байх ёстой.

Одоо нэгэнт гуравдугаар хэлэлцүүлгийн үед энэ орж ирсэн материалтай л холбогдуулж ярихаас өөр аргагүй.

Төсвийн хэлэлцүүлгийн яг хэлэлцэх эсэх үед нэгдүгээр хэлэлцүүлэг дээр цахилгаан, дулааны асуудал дээр их ярьсан.

Түрүүн маш чухал зүйл Засгийн газраас ярьж байна. Төрөөс барих мөнгөний бодлогын тал дээр мөн энэ төсвийн материал хоёр сарын зөрүүтэй орж ирж байгаагаас болж мөнгө хүүлэлтийн асуудлуудаа бид ярьж чадахаа больсон.

Хамтруулж ярих ёстой байтал чинь ингээд сарын дараа орж ирдэг. Энэ асуудлаа засья гэж орж ирж байгаа нь түрүүн Засгийн газрын зүгээс байр сууриа илэрхийлж байна.

Миний асуух асуулт их тодорхой. Өнөөдөр 1 их наяд 907 тэрбум төгрөгийн алдагдалтай. Төсвийн тэнцэл алдагдалтайгаар орж ирж байгаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэхээр байна гэж орж ирж байгаа.

1.9 их наядыг төсвийн алдагдалтай батална гэдэг бол цаанаа нэргүй татвар. Монголын ард түмний нуруун дээр тавьж байгаа л татвар гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг дотоод, гадаадын үнэт цаас гаргах замаар нөхөх боломжтой гэж үзлээ гэж бичсэн байна.

Үүнийгээ Монголын ард түмэнд тайлбарлаж өгөөч ээ. Тэр үнэт цаас гаргах боломжтой дотоод, гадаадын үнэт цаасыг яаж гаргах гэж байгаа юм? Ямар хүүтэй юм? Бүр нэмээд хүү төлөх гэж байна шүү дээ. Ард түмэн.

Хэдий хэмжээний хүүгийн дарамт учрах вэ гэдэг дээр тодорхой хариулт хэлнэ үү?

Энэ орж ирсэн материалтай холбогдуулаад.

Хоёрдугаар зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагч нараас зарцуулах зардлын өөрчлөлтийг төсөлтэй харьцуулсан дүн дээр би ярих гэж байна. Энэ 12.1.5-д заасан гадаадын төслийн зээлийн дээд хэмжээг 2 их наяд 209 сая төгрөг хүртэл гэсэн байгаа.

Дээр нь өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 1 их наяд 932 тэрбум төгрөг. Засгийн газрын өрийн баталгааны дээд

хэмжээ 2025 оны төсвийн жилд 3.5 их наяд төгрөгөөр гэсэн байгаа.

Энэ орлого энэ бүхэн дээр зохицуулалтын үйл ажиллагааг нь авч үзэх юм бол ер нь үүнийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас нь зөвлөмж авсан талууд бий юу? Энэ өрийн асуудлууд дээр л би санаа зовж асууж байна.

Эцэст нь нэг ч санал олон нийтээс ирээгүй гэдэг дээр би асууж байсан асуулт байгаа.

Яг энэ дээр тодруулж асууя. Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Үйлдвэрчний эвлэл, Ажил олгогч эздийн холбоо, ахмадын байгууллага, татвар төлөгчдийн байгууллагуудаас энэ асуудал дээр албан ёсоор асууж тодорхой саналуудыг авсан уу? Сангийн яамнаас асууя. Сангийн яам энэ дээр хариулах ёстой.

Энэ тоо баримтуудыг тэр татвар төлдөг улсууд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: С.Ганбаатар гишүүний асуугаад байгаа тэр төсвийн тэнцэл хасах 2 хувь гэдэг танилцуулга дээр байгаа асуудал.

Тийм учраас би хариулъя.

Энэ 2 хувь, 1.9 их наяд гэдэг яг нөгөө Тогтвортой байдлын тухай хуульд тавьсан шаардлага, төсвийн хүрээнийхээ мэдэгдэлд тавьсан шалгууртай нийцэж байгаа.

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх. Дотоод, гадаад үнэт цаас гаргах замаар нөхнө гэж.

Тэр төсвийн тэнцлийн эх үүсвэр талд нь доод талд нь яг ингээд төсвийнхөө алдагдалтай тэнцүүлээд дотоод, гадаадаас ямар бонд гаргах вэ гэдэг нь тэр баланс дээрээ бүгд байж байгаа. Жишээлбэл, дотоод бонд 300 гээд биччихсэн байж байгаа.

Засгийн газраас орж ирсэн төсөлд Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасыг хэмжээгүй ороод ирсэн байхгүй юу.

Тийм учраас бид хэмжээ тавьж 4 их наяд хүртэл гэж болгосон байгаа. Яагаад гэвэл тэр “Номад” бонд энэ тэрийг урьдчилж төлөх ийм нөхцөл байдал үүсэж болзошгүй гэж үзсэн учраас зах зээлийн нөхцөл байдал ч сайжраад хүүгийн хувьд ашигтай болох юм бол урьдчилж төлөх боломжуудыг тооцож үзээд бид 4 их наяд хүртэл гэж хязгаарыг нь тавьж өгсөн байгаа. Хязгааргүй орж ирснийг болгоомжлоод.

Ер нь өрийн тааз, төсвийн хүрээний мэдэгдэлд байгаа энэ шалгууруудыг барих нь зүйтэй гэж үзсэн байгаа.

Тэр сүүлийн асуудал танилцуулгад байхгүй. Ганцхан үйлдвэрчний эвлэлээс бичиг ирсэн байна лээ. Жичид нь би танилцуулья.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

Л.Соронзонболд: Байнгын хорооны даргаас нэг асуулт асууя.

Одоо энэ сүүлийн хэлэлцүүлэгт оруулж ирэхдээ төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөлгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулга хийгдсэн гэж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр төсөвт өртөг, санхүүжилт нь өөрчлөгдөөгүй мөртлөө хүчин чадал нь буурч өөрчлөгдсөн хэдэн төсөл байгаа вэ гэж асуулт байгаад байна.

Д.Амарбаясгалан:

Ц.Даваасүрэн гишүүн хариулья.

Ц.Даваасүрэн: Энд ерөөсөө байршил, нэр өөрчилсөн 5 санал л байгаа юм байна.

“Биотехнологийн лаборатори” гэдгийг “Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн биотехнологийн лаборатори” гэж нэг санал байна.

“Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв” гэснийг байршлыг нь “Улаанбаатар, Баянгол дүүрэг” гэж өөрчилсөн байна.

“Цаг уурын радарын станц, бүсүүдэд” гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Байгаль орчин цаг уурын салбарын орон нутаг дахь өртөө, харуул, байгаль хамгаалагчийн байр, бүсүүдэд” гэж өөрчилсөн байна. Нэр өөрчилсөн байна.

“Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгө бүсүүдэд” гэснийг төсөл, арга хэмжээний “улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт” гэдгийг “улсын төсвийн хөрөнгө” гэснийг “улс, аймаг, сумдад

хэрэгжүүлэх шаардагдах улсын төсвийн хөрөнгө” гэж өөрчилсөн байна.

“Төрийн албан хаагчдын орон сууц цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт” гээд энэ орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрхэд халдсан гэж үзсэн учраас “үе шатыг аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах улсын төсвийн хөрөнгө” гэж нэрийг өөрчилсөн байна.

Ийм 5 саналыг л нэр өөрчлөх санал хэлэлцэгдсэн юм байна.

Д.Амарбаясгалан:

Д.Соронзонболд гишүүн тодруулъя.

Д.Соронзонболд: Ерөнхийлөн захирагч нарын эрхлэх асуудлын хүрээнд урсгал болон хөрөнгийн зардлыг хооронд нь шилжүүлсэн гэж байгаа.

Тэгэхээр энэ дээр би хөрөнгийн зардлыг нь бууруулаад урсгал зардлыг нь нэмэгдүүлсэн юм гэж ойлгож байгаа. Зөв үү?

Д.Амарбаясгалан:

Ц.Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Та бүхэн анзаарсан бол гишүүд жишээлбэл Ж.Батсуурь гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн ч гэдэг юм уу санал хураалгаад л бөөн маргаан болоод л байхад тэр чинь нэг зардлаас нь зардал нь шилжүүлсэн байгаа.

Тэрийг энд нэгтгэж оруулсан хэлж байгаа юм.

Энэ зардлаас аваад энэ зардал шилжүүлээ гээд хураалгаад байгааг хэлж байгаа юм.

Д.Амарбаясгалан: 13.00 цаг болсон байна. Үдийн завсарлагагүйгээр хурлаа үргэлжлүүлье. Олон гишүүд асуулт асууж байгаа. Хэлэлцэх асуудал хэд хэд байгаа учраас цагаа ашиглах нь зөв байх.

Доржсүрэнгийн Үүрийнтуяа
гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Надад хоёр асуулт байна.

Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам хариулах болов уу гэж бодож байна.

2025 оны төсөв Засгийн газраас танилцуулахдаа гол онцлог бол бүсчилсэн хөгжлийн бодлогод суурилсан төсөв гэж танилцуулсан.

Ингээд зардлыг харахаар хөрөнгө оруулалтын зардлыг жишээлбэл аваад үзэхээр нийтдээ бид ирэх оны төсөв дээр 633 арга хэмжээнд 4.1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа юм.

Үүний 25.0 хувь нь нийслэл дээр, 57.1 хувь нь орон нутгийн бүсүүд дээр, 18.0 хувь нь улсын шинж чанартай хөрөнгө оруулалтын ажил байгаа.

Орон нутагт хуваарилагдаж байгаа, бүсүүд дээр хуваарилагдаж байгаа энэ хөрөнгө оруулалтын зардлыг харахаар 6 бүс дээр

- ▶ хангай 12.4 хувь,
- ▶ баруун 19.3 хувь,

- ▶ хойд бүс 7 хувь,
- ▶ төвийн бүс 24.4 хувь,
- ▶ говийн бүс 10.1 хувь,
- ▶ зүүн бүс 26.5 хувь

гэж харагдаж байгаа.

Эргээд орлого төвлөрүүлж байгаа. Улсын төсөвт орлого төвлөрүүлж байгаа 5-хан аймаг байгаа.

Энэ аймгуудыг бүсээр нь хуваагаад аваад үзэхээр

- ▶ говийн бүсээс 1.7 их наяд,
- ▶ төвийн бүсээс 1.4 тэрбум,
- ▶ хойд бүсээс буюу Орхон аймгаас 136.0 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлж байгаа.

Хамгийн өндөр орлого төвлөрүүлж байгаа 2 бүс говийн бүс, хойд бүс хамгийн бага хөрөнгө оруулалттай.

Энэ ингээд орлого, зарлагын хувьд уялддаггүй юм уу?

Бүсчилсэн хөгжлийн бодлого дээр бүс нутгийн тэнцвэртэй байдлыг барьж Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хөрөнгө санхүүгийн төлөвлөлтийг хийхгүй юм уу, хийдэггүй юм уу? Нэг ийм асуулт.

Хоёр дахь асуулт. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөлтэй холбоотой асуулт байна.

2021 оноос эхлээд Эрүүл мэндийн даатгалын санд өр үүсэж эхэлсэн.

Өнөөдөр Эрүүл мэндийн даатгалын сан мөнгөгүй болсон, хаагдсан

гэдэг шалтгаанаар хүмүүс Эрүүл мэндийн даатгалаар эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх боломжгүй, маш их бухимдал үүсэж байна, чирэгдэл үүсэж байна гээд орон нутгаас, ард иргэдээс их гомдол ирж байна.

→ Эрүүл мэндийн даатгалын сан

- ▶ 2022 онд 60.6 тэрбум төгрөгийн өртэй гарсан.
- ▶ 2023 онд 218.3 тэрбум төгрөгийн өртэй гарсан.

▶ 2024 онд ямар хэмжээний өртэй гарах юм бэ?

▶ 2025 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв дээр энэ өрийг барагдуулахаар хэдэн төгрөг нь тусгагдсан юм?

▶ Одоо 2024 онд хэдэн төгрөгийн өртэй гарах юм?

▶ 2025 онд төлөвлөж байгаа төсөв дээр тэнцэл нь сангийн тэнцэл хэдээр тооцож төлөвлөж байгаа юм?

▶ 2025 онд бид ямар тэнцэлтэй энэ сан маань гарах гэж байгаа юм бэ гэсэн ийм асуулт байна.

Д.Амарбаясгалан: Энэ чинь хэлэлцэж байгаа асуудлаас гадуур асуулт асуучихлаа.

Төсвийн гуравдугаар хэлэлцүүлэгтэй холбоотой 2 хуудас танилцуулга байгаа. Зөвхөн танилцуулгын дагуу асууна гэсэн хурлын дэгтэй.

Тэгэхээр яг энэ хүрээндээ яригдана.

Саяын Д.Үүрийнтуяа гишүүний асуусан асуулттай холбоотойгоор манай Сангийн яамнаас бичгээр хариулт өгчхөөрэй гэдгийг хүсэж байна.

Энэ хэлэлцэж байгаа асуудал чинь. Тийм. Гишүүд ээ, ийм байхгүй юу. Төсвийн байнгын хороонд хэлэлцээд гарсан саналаар санал хураалт хийгээд шийдсэн талаараа танилцуулгаа өнөөдөр Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа юм.

Түүнээс нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг шиг төсвийн хэлэлцүүлэг явагдах ямар ч дэгийн зохицуулалт байхгүй.

Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууна.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Би асуулт гэхээсээ илүү санал хэлье. Гурван төрлийн саналыг хэлье гэж бодож байна.

Өнөөдөр бид улс орны амин чухал асуудал болсон төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцэж байна.

Тэгээд миний асуулт болохоор бид нарын хэлэлцэж байгаа яг эцсийн зорилго нь юу юм бэ? Эцсийн зорилго нь.

Эцсийн зорилго нь энэ төсвийг сайжруулж чамбайруулах биш юм уу?

Улсын Их Хурлын гишүүд өчнөөн цаг хөдөлмөрөө гаргаад, олон хоногоор суугаад, төсөв дээр байгаа “но”-той

цэгүүдийг, шаардлагагүй төслүүдийг, нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай байгаа төслүүдийг гаргаж ирээд ярих юм, асуух юм.

Тэгэхээр энэ дээр үнэхээр ач холбогдол өгөөгүй, маш их хөдөлмөрийг үнэгүйдэж байгаа байдал эндээс харагдаад байна л даа.

Ингэж нэгэнт энэ асуултуудад, энэ асуудлуудад ингэж халти мөлт, хурдан шуурхай, оновчтой оновчгүй хариулаад өнгөрөхийн оронд энэ гишүүд чинь нээрээ юу яриад байна гээд ач холбогдол өгөөд, судалж шинжлээд энэ асуудлуудыг төсвөө сайжруулахдаа ашиглах нь хэлэлцүүлгийн зорилго биш юм уу?

Түүнээс биш энэ хэлэлцүүлэг чинь энэ төсөв дээр ямар ч өөрчлөлт оруулах боломжгүй юм байна. Одоо байгаа хуулиараа.

Нэг зарчмын зөрүүтэй санал гээд гаргаад явдаг юм байна. Энэ нь бараг худлаа юм. Яагаад худлаа гэхээр хэрвээ та энэ төсөв дээр өөрчлөлт оруулах гэж байгаа бол та тэр хасах гэж байгаа төсвөө өөрөө гаргаж ир гэдэг юмыг гишүүдэд тавьдаг.

Энэ үнэхээр гишүүдээ хүнд байдалд оруулсан ийм арга барил. Өөрөөр хэлбэл энэ арга барил буруу байна. Бид чинь сайжруулахыг л хүсэж байгаа хүмүүс.

Тэгэхээр төсөв боогдчихсон. Боогдсон төсвийг засаж болохгүй гээд.

Тэгэхээр яаж бид энэ төсвийг сайжруулах юм бэ? Төсвийг сайжруулах

үнэхээр боломж байхгүй байгаа байхгүй юу. Энэ хуулиараа.

Тэгэхээр яагаад энэ хуулийг чангатгасан гэдэг нь өнгөрсөн хугацаанд өнгөрсөн хуучин Улсын Их Хурлууд яадаг байсан гэхээр төсөв задарчигуут нөгөө хуучин гишүүд нь одоо тойрогтоо бүр хамаа замбараагүй төсөв тавиад төсвийг бүр алиныг нь алдуулаад, юу нөгөө сайжруулах нь битгий хэл муутгачихдаг байсан учраас ингэж хуулийг чангатгасан юм байна.

Гэтэл өнөөдөр чинь бид шинэ 126 гишүүнтэй шинэ Улсын Их Хурал шүү дээ. Бид шинэ арга барилаар ажиллах ёстой шүү дээ. Бид тэгж хуучин гишүүд шиг энэ төсвийг данхайлгаад, энэ улс орноо сүйрэлд хүргэх ийм хүмүүс биш шүү дээ.

Тэгэхээр бид сайжруулахад саад болоод байгаа энэ хуулиа өөрчлөөч. Маш олон саналууд гарч ирж байна. Гэтэл тэр үед ерөөсөө нэг агаарт хийсэж байгаа, яг л нэг ийм хаданд хашхирч байгаа юм шиг ийм байдал энэ хэлэлцүүлгээс харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хэлэлцүүлэг чинь зүгээр л нэг нь асуусан болж, нэг нь хариулсан болж, нэг ийм дүр эсгэсэн ийм ёс төдий ийм үйл ажиллагаа болоод байна.

Гэтэл эцсийн зорилго чинь энэ төсвийг улам сайжруулаад, чамбайруулах биш юм уу гэж би ингэж хэлээд байгаа юм.

Хоёрдугаар асуудал болохоор энэ төсвийг боловсруулахдаа улс орны асуудлыг ерөнхий дүнгээр нь хараад үнэхээр улс орны өмнө тулгарсан амин

чухал асуудлуудыг шийдэхэд төсвөө зарцуулдаггүй юм уу.

Зарцуулаагүй байна гэдэг юмыг гишүүд ч гаргаж ирээд байна, ард түмэн ч хэлээд байна шүү дээ.

Өнөөдөр эрүүл мэндийн салбар, эрчим хүчний салбар, боловсрол гээд үнэхээр хүзүү хоолойнд нь тулгарсан амин чухал ийм асуудлууд байхад тэнд ерөөсөө зарцуулахгүй.

Хэн үнэхээр идэвх зүтгэлтэй, хэн салбарынхаа төлөө илүү төсөв авах гээд гүйгээд тэр лобби юу байдаг юм тэрийг нь хийгээд явдаг хүмүүс нь салбартаа ахиу төсөвтэй.

Тэгэхээр улс орныг ингэж болохгүй шүү дээ.

Хэрвээ үүнийг боловсруулж байгаа тэр сангийн салбар чинь улс орныхоо тулгамдсан асуудал дээр төвлөрч ажиллах, улс орныхоо асуудлыг ерөнхий зургаар нь харж энэ төлөвлөлтөө хийдэггүй юм уу?

Үүнийг гишүүд ч хүсээд байна, ард түмэн ч хүсээд байна шүү дээ.

Хэрвээ үнэхээр Та бүхэн минь ус нь арилсан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Зарим талаараа М.Энхцэцэг гишүүний хэлж байгаа зөв.

Тэгэхдээ нэг зүйлийг маш зөв ойлгох ёстой шүү.

Улсын Их Хурлын гишүүд төсөв сайжруулж байгаа гэдэг нэрийн доор төсөл, хөтөлбөрөөр санал гаргаад

зарчмын зөрүүтэй санал нь унахаар төсөв сайжрахгүй байна гэж ойлгож болохгүй байгаа юм.

Төсөв сайжруулах гэдэг ойлголт, Улсын Их Хурал дээр шийдвэрлэгдэх асуудал хоёрыгоо маш сайн хэдүүлээ ялгаж салгах ёстой.

Засгийн газрын мэргэжлийн яам өөрөө нэгдүгээрт ажлаа хийх ёстой. Тийм ээ.

Хуульдаа нийцүүлсэн төсвөө төлөвлөөд, төслөө боловсруулаад оруулж ирж хэлэлцүүлнэ.

Тэр нөхцөл дээр нь Улсын Их Хурал ажиллах бүрэн боломжтой байсан гэдгийг Та бид бүгдээрээ мэдэж байгаа.

Өргөн барьснаас хойш 70 хоног боллоо. Өнөөдөр нэгдүгээр хэлэлцүүлэг дээр ямар дэгээр явах юм, хоёрдугаар хэлэлцүүлэг ямар дэгээр явах юм гэдгийг бид бүх талаас ярилцлаа шүү дээ.

Ний нуугүй хэлэхэд манай Их Хурал талаас зарим талаар ажлын хэсгийн түвшинд, Байнгын хорооны түвшинд төсвийн нэгдүгээр хэлэлцүүлэг, хоёрдугаар хэлэлцүүлгийн түвшинд сөхөж чадаагүй, хөндөж чадаагүй, шийдэж чадаагүй сэдвүүдээ, асуудлуудаа хоёрдугаар хэлэлцүүлгээр төсөв боогдсоны дараа гуравдугаар хэлэлцүүлгийн үед гаргаж ирж тавьж асуудал хөндөж байгаа нь өөрөө бид бас дэгээ зөрчиж л байгаа хэлбэр байгаа шүү дээ.

Тэгэхээр би яах вэ, мэдээж ойлгож байгаа юм.

Сонгуулийн жил 126 гишүүнтэй анхны парламент бүрдсэн. Дэг шинээр хэрэгжиж эхэлж байгаа. Дэгээ бүрэн хэрэгжүүлж үзээгүй, сураагүй байгаа нөхцөлүүд энэ дээр асуудал үүсгэж байна гэдгийг бид өөрсдөө их сайн ойлгож авах ёстой.

Засаж залруулах нь зөв. Яг тулгамдаж байгаа асуудлыг бид халуун дээр нь ажлын хэсгүүдээ байгуулаад ажиллаад засаж залруулах чиглэл дээрээ анхаарч ажиллах нь зөв гэсэн ийм байр суурьтай байгаа.

Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаатар: Төсөв хэлэлцэх энэ явцад манай Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүд ер нь ажил хэрэгч, хариуцлагатай хандах шаардлага байгаа нь харагдаж байна.

9 сарын 31-нд төсөв өргөн барьснаас хойш аудитын дүгнэлт гараад ер нь бүх нийтэд 9 сарын 02-ноос хойш бүх гишүүдэд хүргэгдсэн, танилцсан. Олон нийтэд ч танилцуулагдаад явж байгаа.

Төсөв яаж хэлэлцэгддэг вэ гэхээр төсөв дээр ажлын хэсэг байгуулагдана.

21 хүнтэй парламентад суудалтай 5 намын төлөөлөл орсон ажлын хэсэг байгуулагдсан.

Энэ хүмүүсийн гол үүрэг төсвийг сайжруулах, төсөв батлах Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ийм ажлын хэсэг шүү дээ.

Ингээд хэрэггүй зардлуудыг танах, гэвчиж болох зардлуудыг, мөн хойшлуулж болох арга хэмжээнүүд юу байна. Төсвийн зардлаа багасгах гэдэг юм уу, олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үүрэгтэй ажлын хэсэг энэ 5 намын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгээс байгаа.

Түүнээс гадна Улсын Их Хурлын бүтцийн 11 Байнгын хороогоор хэлэлцсэн шүү дээ. Бүгдээрээ хэлэлцсэн.

Сүүлд нь төсөлд нь Төсвийн байнгын хороон дээр нэгтгээд хэлэлцэж байгаа. Тэгээд чуулганаар хэлэлцэж байгаа.

Энэ олон хэлэлцүүлгүүд явсан.

Тэгээд энэ дотор одоо яриад байгаа энэ төсвийн зардлыг танах, багасгах талаар хэдэн санал гарав. Хэдэн санал гарав. Ерөнхий л яваад байдаг.

Ерөнхийдөө зардлаа багасгах хэрэгтэй шүү дээ. Тийм. Орлогоо нэмэгдүүлэх хэрэгтэй, зарлагаа багасгах хэрэгтэй гээд.

Энэ ерөнхий явсаар байгаад бид чинь тодорхой юмгүй сүүлдээ энэ чуулганы хэлэлцүүлэг чинь яваад өнгөрч байна шүү дээ.

- ▶ Ямар зардлыг хасах гэж байгаа юм,
- ▶ ямар арга хэмжээг хойшлуулах гэж байгаа юм,
- ▶ ямар нь үргүй зардал гэж үзэж байгаа юм,
- ▶ ямар нь давхцаж байгаа юм гэдэг юм уу.

Ингээд үр ашигтай зүйлд зарцуулах хэрэгтэй.

Жил болгоны төсөв батлахад 300-аас 400 тэрбумын зардлуудыг танаад, төсвийн тэнцлээ сайжруулаад л явдаг ийм уламжлалтай шүү дээ. Олон жил төсөв баталж байна. Ингээд явдаг.

Гэхдээ энэ жил энэ хэлэлцүүлгүүд их үр дүн багатай явагдлаа.

Ийм учраас Улсын Их Хурлын эрхэм гишүүд маань бүгдээрээ өөрсдөө энэ дээр их хариуцлагатай хандах шаардлага байна гэдгийг би энд хэлье гэж бодож байгаа.

Хоёрдугаарт яг тодорхой саналууд гаргаад явсан гишүүд байна.

Зарчмын зөрүүтэй санал гаргаж байж л явна. Түүнээс биш ерөнхийдөө муу төсөв байна шүү дээ гээд л яваад байвал энэ сайжрахгүй шүү дээ.

Үүнийг иргэд шүүмжилж болно. Их Хурлын гишүүн гэдэг бол эрх, мандатаа авчихсан. Түүнийг засаж залруулах, сайжруулах үүрэг бүхий хүн орж ирчихсэн байгаа юм.

Тэгээд тэр хүмүүс маань ажлаа хийдэггүй. Ерөнхийдөө муу, зардал ихтэй байна шүү дээ, зардлаа багасгах хэрэгтэй гээд яриад яваад байвал энэ сайжрахгүй.

Яаж сайжруулдаг вэ гэхээр энэ механизм бий.

Бүх Байнгын хороонд байгаа гишүүд өөрсдөө зарчмын зөрүүтэй саналаа гаргаад энэ зардлыг ингэж хасаж үүнийг багасгая, энэ зардлаа хяная, төсвөө сайжруулья.

Энэ саналаа гаргах эрх нь байгаа шүү дээ. Үүнийг эдэлсэн хэдхэн гишүүн байна.

Г.Тэмүүлэн гишүүн байна, Ж.Баярмаа гишүүн байна, Б.Түвшин гишүүн байна лээ. Ч.Анар гишүүн байсан.

Хэд хэдэн гишүүд санал гаргаад тодорхой зүйлүүдийг хасаж байгаа юм.

Ж.Баярмаа гишүүн гэхэд 18.3 тэрбум төгрөгийн тэр Соёлын яамны ваучерыг хасъя гэдэг саналаа гаргаад ирсэн учраас хэлэлцэгдээд дэмжигдээгүй ч гэсэн энэ асуудлаа чуулган дээр хамгаалаад явж байна.

Б.Түвшин гаргасан, Г.Тэмүүлэн гишүүн гаргасан.

Засгийн газрын өрийн баталгааг 30 хувиар бууруулья гэсэн. Дэмжигдсэн шүү дээ. Г.Тэмүүлэн гишүүний санал дэмжигдсэн.

Тодорхой зардлуудыг багасгая гээд явж байгаа.

Гэтэл огт санал гаргаагүй Д.Энхтүвшин гишүүн байна.

Энд зардал бууруулья гэдэг талаар нэг ширхэг ч санал гаргаагүй. Ажлын хэсэг дээр ч гаргаагүй, бүх Байнгын хороон дээрээ гаргаагүй.

Тэгсэн мөртлөө яг ингээд бүх хоёрдугаар хэлэлцүүлэг дууссаны дараа, яг тэрийг алх цохиод дуусангуут нь хэвлэлийн бага хурал хийгээд энэ зардлыг хасах хэрэгтэй, шаардлагатай гээд явчхаж байгаа юм.

Яг энэ чиглэлээрээ л бид ажил хэрэгч хандаад, Улсын Их Хурлын гишүүнийхээ эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах нь л бидэнд чухал байгаа шүү.

Ер нь цаашдаа бид энэ хэлэлцүүлэг дээр анхаарах зүйлүүд их олон байна.

Ер нь Улсын Их Хурлын гишүүд маань энэ зардлыг бууруулах гэдэг бол мэдээж бүх цаг үед яригддаг чухал зүйл. Яг тодорхой саналуудаа гаргаад явдаг байх зүйл бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан:

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулья.

Ц.Даваасүрэн:

Тийм. Л.Мөнхбаатар гишүүн маш чухал асуудал хөндлөө.

Сая хэлэлцүүлэг явахад саналаа ирүүлсэн гишүүн яг зардалтай холбоотой 4, 5-хан д гишүүн байгаа юм.

Г.Тэмүүлэн гишүүн, Ж.Баярмаа гишүүн. Энэ хоёр үүнийхээ хойноос эрчимтэй байж.

Б.Түвшин гишүүн угаасаа ахалсан юм.

Тэгээд Түвшин ахлаад тэгээд дараа нь шууд ингээд хасаад хаячих гэхээр энэ чинь ерөөсөө болдоггүй юм байна гээд байгаа байхгүй юу. Бас зөв.

Ямар нэг байгууллага хохирчхож болзошгүй шүү дээ.

Тийм учраас судалж үзэх хэрэгтэй юм байна гээд.

Тэгээд 300 гаруй тэрбум төгрөгийн асуудлыг ажлын хэсэг рүү оруулж ирж ярьсан боловч 32 тэрбумыг бид шууд хасчихад болох юм байна. Цаана нь ямар нэг асуудал хөндөгдөхгүй юм байна гэж.

Үндэслэлгүйгээр аль нэг байгууллагыг бид хохироож болохгүй байгаа учраас үндэслэлтэй хасаж болно гэсэн 32 тэрбум. Тэр дотор тэр 18 тэрбум явсан юм. Ж.Баярмаа гишүүний хөндөөд байгаа.

Түүнээс өөр зардал хасъя гээд орж ирсэн юм уг нь байхгүй байгаа юм л даа.

Тэгэхээр би зүгээр сүүлд яг хоёрдугаар хэлэлцүүлэг яваад зардал хасах бүх юм дууссаны дараа энэ асуудал хөндөгдөөд байгаад гайхаад л байгаа юм.

Тэгэхдээ энэ зардал өссөн асуудал чинь 2021 оноос хойш эрчимтэй явсан байгаа байхгүй юу. 2021 оноос хойш. Зөвхөн энэ жил ч биш байгаа юм.

Би энэ төсвийн хэлэлцүүлэг эхлэхэд хэлсэн шүү дээ. 11 их наяд байсан төсөв 3 дахин өсчхөөд байна. 3, 4 жилийн дотор. Ганцхан нүүрснээс хамааралтай эдийн засаг ингэж 3 дахин өсөж болохгүй гэж.

Тэгэхээр эхний нэг, хоёрдугаар шатны хэлэлцүүлгийн явцад бид засах талаараа ярих ёстой байсан байхгүй юу.

Тэгэхээр өнгөрсөн борооны хойноос цув нөмөрнө гэдэг л болоод байгаа юм л даа. Бүх юмаа баталчхангуутаа бараг одоо ингээд хасъя гээд унаж байгаа байхгүй юу.

Одоо эвгүй байдалд орно. Хэрвээ бид төсвөө 12 сард тодотгож чадахгүй байдаг ч юм уу, ингээд баталж чадахгүй байдалд ч орох юм уу тэгвэл энэ 126 хүнтэй парламент гэдэг чинь дампуу юм байна гэдэг ийм юм руу бид орно шүү.

Яагаад гэвэл яг ажиллах цагт нь ажиллаагүй, саналаа өгөөгүй, тэгсэн мөртлөө бүх юм болоод өнгөрсний дараа болохоо больчихлоо гээд унаж байгаа байхгүй юу.

Тэгээд энэ бол бодитой зүйл болоод байна гэдгийг хаана хаанаа анхаарахгүй болохгүй.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Ер нь Улсын Их Хурлын гишүүд асуулт асуухдаа дэгийн хуулиар нэлээд хязгаарлагдмал байгаа.

Ажил хариуцсан мэргэжилтнүүдээс асуултынхаа хариуг яг өнөөдрийг хүртэл энэ нэг сарын хугацаанд энэ төсөв хэлэлцэх асуудал дээр бид тодорхой авч чадаагүй ирсэн.

Өөрсдийнхөө харьяалагдах Байнгын хороонд тухайн төсвийн зардлыг бууруулахтай холбоотой үнийн дүнтэй, хувьтайгаар маш тодорхой саналуудыг илэрхийлсэн.

Тэгэхээр Ц.Даваасүрэн гишүүн 5-хан хүн саналаа өгсөн гэдэг дээр би яг үнэнээ хэлэхэд энэ хэлж байгаа саналтай зөрчилдөж байна. Маш сайн тодорхой бид ярьж ирсэн.

Тэгэхээр Байнгын хорооны протокол хөтлөгдөж явсан. Тодорхой зардал бууруулах саналуудыг ажил хэрэг

болгож, өнөөдрийг хүртэл ажиллахгүйгээр бид нэг сарын хугацаанд хэлэлцээд одоо ингээд ямар ч шийдвэр гаргаж чадахгүй өөрсдөө хуваагдалтай байж байна.

Гэхдээ яах вэ миний хувьд хэлж ирсэн Засгийн газраас энэ эдийн засгийг тэлэх, хөгжлийн томоохон бүтээн байгуулалт болон мега төслүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэдэг дээр энэ санаачилгыг дэмжиж ажиллаж байгаа.

Гэхдээ 2025 оны төсвийн тэлэлт хэт өндөр байна. Анхаарах ёстой асуудлууд төрийн оролцоог бууруулах. Яагаад гэхээр төрөөс маш их өндөр хэмжээний төсөвтэй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээд. Хэрэгжээд хэн хүлээж аваад ажиллуулах вэ гэдэг нь өөрөө тодорхой бус.

Дээрээс нь татвар төлөгч, тэр дундаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийг татварын дарамтыг хэрхэн бууруулах талаар ямар нэгэн суурь судалгаа, дээрээс нь яг яаж хийх зохицуулалтууд нь тодорхой бус байгаа дээр шүүмжлэлтэй хандаж байгаа.

Тэгэхээр миний хувьд илүү төсвийн зардлын өсөлт, төсвийн орлогын бүрдүүлэлтэд энэ суурь шинжилгээг хийдэг байх. Алдаа оноог яаралтай засах. Шаардлагатай тохиолдолд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох тал дээр анхаарч 2026 оны төсөв илүү боловсронгуй байх дээр бид анхаарч ажилладаг.

Тэгээд үүнийг Улсын Их Хурлаар энэ судалгаа шинжилгээг нь дорвитой танилцуулдаг, тодорхой бус байдлыг арилгах дээр анхаарч ажиллавал зохилтой гэж харж байгаа.

Нөгөө талдаа Ц.Даваасүрэн гишүүнтэй санал нэг байгаа нь одоо шууд бид жишээлбэл энэ төсвийг том дүнгээр нь бууруулах нь өөрөө зохисгүй байх.

Яагаад гэхээр энэ том дүнг буулгалаа гэснээрээ цаана бусад төрийн үйл ажиллагаа өөрөө доголдох ёсгүй.

Тэгэхээр бусад хэвийн хэрэгжээд явж байгаа төсөвт тусгагдчихсан асуудлууд том үнийн дүнг зүгээр буулгаснаараа доголдол үүсэх эрсдэл байгаа учраас бид харин ирэх 4 жилийн хугацаанд яаж төслүүдээ амжилттай явуулах вэ, эргээд дараагийн Засгийн газар хүлээж авахад нь нөгөө хүсээд байгаа дотоодын нийт бүтээгдэхүүний нийт улсын зардлыг 25 хувиас хэтрүүлэхгүй байх энэ түвшинд нь аваачиж хүлээлгэж өгөх нь зүйтэй юм болов уу гэсэн саналтай байгаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Би яах вэ зүгээр над руу дайрч л байх шиг байна л даа. Саналаа хэлээгүй гээд Ц.Даваасүрэн гишүүн. Өөр сая хэн хэллээ.

Тэгэхдээ юу шүү дээ, би зүгээр бид нарыг сонгосон сонгогчдын амьдрал гундуу байна, ахуй хэцүү байна. Би тэрийг л сануулсан.

Гурав, дөрөвхөн сарын өмнө та нар юу гэж амлаж ирснийг чинь бид нараас асуугаад байна шүү дээ.

Би тэрийг чинь сануулсан.

Засгийн газрын оруулж ирж байгаа төсөл дээрээ саналыг нь авах гэж хэдхэн сарын өмнө бид ч гэсэн тойргуудаар явж байсан. Очоод яг энэ мөрийн хөтөлбөрүүдийг чинь ярьж байсан. Тэгээд бид буцаад ирэхээр одоо энэ Засгийн газрын гэж барьж байна. Үүгээр орж ирж байгаа төсөл чинь сонгогчдыг үл тоож байна шүү дээ.

Тэгэхээр энэ чинь өөрөө буцаад энэ төрийн институцэд итгэх итгэлийг байхгүй болгож байна. Зөвхөн энэ Улсын Их Хурал биш Засгийн газрын энэ байдлуудаа өөрчлөхгүй бол энэ чинь өөрөө буцаад иргэдийн амьдралд наалдахгүй болохоор.

Одоо жишээлбэл оруулж ирсэн төслөөс өнөөдөр 35-хан тэрбумаар л багасгаж байна.

Тэгэхээр энэ байдал чинь бодит байдлаас тасраад байна. Хэдүүлээ газардъя. Засгийн газар үүнийг ойлгохгүй бол дэгээр хязгаарлаад, одоо жишээлбэл ингэж болохгүй, тэгж болохгүй, тэгэх байсан шүү дээ.

Яг бодит байдал дээр орж ирээд явах ямар ч боломжгүй байна шүү дээ. Сангийн яамны хариулж байгаа байдлууд нь.

Тэгээд бид тэр хасах байдал дээр нэг зардлыг хасъя гэхээр талд нь нэмэх орлого эх үүсвэр гэхээр бид тэр доторх деталь юмнуудыг чинь мэдэхгүй байна шүү дээ. Нэг ижилхэн нэртэй ерөнхий гарчиг, дэд гарчиг байна.

Дэд гарчигийг нь асуухаар ерөнхий гарчгийг нь тайлбарлаад. Тэгээд яг энэ хэлэлцүүлгийн явцад Сангийн

яамны энэ асуудал чинь ил тод байдал, тодорхой хариу ерөөсөө ярихгүй байна.

Өнгөрсөн оноос харьцуулахад 13.3 их наядаар төсөв чинь нэмэгдэж байна шүү дээ. Үүнийг төлөх татвар төлөгч иргэдийн орлого, амьдрал тийм сайн биш байна шүү дээ. 60 хувь нэмэгдэж байна.

Тэгэхээр одоо жишээлбэл үүнийг бууруулах боломжгүй гэж яриад байна. Нөгөө талд нь иргэдэд энэ мөнгийг чинь төлөх боломж байгаа юм уу гэж асуумаар байгаа байхгүй юу.

Тэгэхээр Улсын Их Хурлын тухай хууль дээр тодорхой аль ч үе шатад татаж авах бололцоо боломжууд байгаа.

Тэгэхээр сая энэ хэлэлцүүлгийн явцад анзаарсан юм гэвэл Төсвийн хуулийг нэлээн сайжруулах хэрэгцээ байгаа харагдаж байсан. Одоо хэрвээ гацвал яах юм? Хэрвээ Ерөнхийлөгч хориг тавьчихвал энэ асуудал чинь тэртээ тэргүй дахиад л асуудал явна шүү дээ.

Тэгэхээр боломжгүй болохгүй юм шиг шалтаг тоочоод. “Хийх хүнд арга олдоно, хийхгүй хүнд шалтаг мундахгүй” гэдэг шиг зүгээр шалтаг тоочоод л дэгээр ингэж хязгаарлаж болохгүй шүү дээ.

Д.Амарбаясгалан даргад талархсанаа илэрхийлж байна. Энэ дэг дээр Улсын Их Хурлын энэ хэлэлцэж байгаа байдал дээр шийдэл гаргаж, төсвийн тодотголын асуудлуудыг бас ярьж оруулж ирж байгаад их баярлаж байна.

Энэ дээр шийдэл гаргаж, Улсын Их Хурлын гишүүдийг ч гэсэн бас эвгүй байдалд оруулахгүй байдлаар.

Тэгээд энэ оруулж ирсэн танилцуулгатай холбоотой асуулт байна. Энэ дээр дотоод, гадаадын бонд, үнэт цаас гаргах замаар энэ төсвийн алдагдлыг санхүүжүүлнэ гэж байсан.

Тэгэхээр энэ дээр дотоодын төгрөгийн бонд гаргах чиглэлээр, өөрөөр хэлбэл төгрөгийн ханшийг сайжруулах дэмжих чиглэлээр ямар бодолтой байхаар байгаа вэ гэж асуумаар байна.

Дээр нь энэ дээр нэг санал. Төсвийн ил тод байдлыг сайжруулах хэрэгтэй харагдаад байгаа.

Тэгэхээр энэ төсвийг аккурэль суурьтай болгох чиглэлээр өмнө нь хийж байсан судалгаа байдаг юм болов уу? Энэ чиглэлээр Ц.Даваасүрэн дарга нэлээн туршлагатай энд ажиллаж байсан учраас.

Энэ төсвийн суурийг мөнгөн суурьтай биш, аккруэл суурьтай болгох талаар та юу гэж бодож байгаа вэ? Энэ дээр хийгдэж байгаа ажил байвал та мэдээлэл өгч болох уу.

Д.Амарбаясгалан: Тийм. Д.Энхтүвшин гишүүн. Ер нь гишүүдээс энэ төсвийн урсгал зардлыг хэмнэхтэй холбоотой асуудал хөндөгдөөд явж байгаа. Энэ зүй ёсны хэрэг.

Ер нь зардлыг хэмнэх чиглэл дээр мэдээж анхааралтай хандах ёстой. Тэлж байгаа бодлогын хүрээнд зардал дагаад өсөж байгаа нь ч яг бодитой харагдаж байгаа юм.

Гэхдээ үүнийг яг гишүүдийн хэлээд байгаачлан орж ирснээр нь асуудалд хандахаас илүүтэйгээр сайжруулах гэдэг дээр анхаарал хандуулж, Их Хурал үүргээ гүйцэтгэх

ёстой гэсэн энэ байр суурийг дэмжээд байгаа юм.

Тэгэхээр одоо энэ төсвийн тодотголыг хийх үүрэг, чиглэлийг Засгийн газарт өгч байгаа.

Засгийн газар өөрөө батлагдсан төсөвтөө үнэлгээ өгөх Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 15.1-ээр зохицуулагдаж байгаа.

Харин Улсын Их Хурал, Төсвийн байнгын хороо тэр ажилд нь хяналт тавихыг Төсвийн байнгын хороонд үүрэг чиглэл болгож явж байгаагаараа онцлогтой.

Харин дараа дараагийн удаа, дараа дараагийн жилүүдэд энэ төсөв яг энэ хэлэлцэх процесстэй холбоотой асуудал үүсээд байгаа нөхцөлийг л бид хуулиараа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар энэ ондоо багтаж хийх ёстой.

Тэр ажлын хэсгийг харин 11 сарын 15-ны өдөр байгуулаад энд 7, 8 хууль холбогдохоор байгаа юм. Тийм ээ. Төсвийн тухай хууль, төсвийн хүрээ хэлэлцэхтэй холбоотой зохицуулалт, дэгийн тухай хууль, мөнгөний бодлого олон зүйлүүдийг бид олон талаас нь харж нэг шугам дээр цаг хугацааных нь хувьд байрлуулж, цаг хугацааных нь график нь зөв байгаа эсэхийг Улсын Их Хурал бүрэн дүгнэж энэ асуудлыг нэг цэгцлэх нь энэ Их Хурлын үүрэг гэж байгаа юм.

Тэгэхээр Их Хурал дээр энэ ажлын хэсэг байгуулагдаад, Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсгүүд нь ажиллаад байгаа нөхцөл байдал энэ бүгдийг засаж сайжруулахад оршино.

Гишүүд маань санал санаачилга гаргаж байгаа дээрээ энэ өөрчлөлт, энэ сайжруулалтад харин идэвхтэй орох ёстой.

Одоо жишээ нь Д.Энхтүвшин гишүүн төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх чиглэлээр Улсын Их Хурал тогтоолын төсөл гаргая гээд та ажлын хэсгээ ахалчихсан явж байгаа. Тийм ээ.

Жишээ нь, хувийн хэвшлийн хийж болох төр ажил, үйлчилгээг төр хийдэггүй байх чиглэл дээр. Одоо тогтоолын төслийг яаралтай боловсруулаад энэ ондоо багтаж батлуулах хэрэгтэй.

Хувийн хэвшлийн хийж болох маш олон төрлийн үйл ажиллагааг төр хийгээд байгааг л бид таслан зогсооё гээд л.

Иймэрхүү зарчмын зүйлүүд дээр нь парламент бүх түвшиндээ санал нэг байгаа гэдгийг Та бүхэндээ хэлэх нь зүйтэй байх.

Тэгээд гишүүдийн санаачилгуудыг дэмжиж ажиллана гэдгийг илэрхийлье.

Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууна. Алга байна.

Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Улсын төсвөө хэлэлцэн батлах Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх.

Үүн дээр манай гишүүд маш их идэвх санаачилгатай, хариуцлагатай байх

ёстой гэдэг талаар удаа дараа өмнө нь ярьсан.

Тэгээд бид шинэ 126 гишүүнтэй парламентын анхны гишүүд.

Тэгээд энэ утгаараа иргэдийн хүсэл зоригийг илэрхийлэх ёстой, төлөөлөх ёстой. Тэр утгаараа ч тэр энэ улсын төсвийн энэхүү хэлэлцүүлэг маш чухал байлаа.

Гэтэл яг үнэндээ энд төсөв хэлэлцэх процесс яг дэгийн хүрээнд ч гэсэндээ маш хангалтгүй явагдсаныг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Яг одоо ч гэсэн гуравдугаар хэлэлцүүлэг эхэлчихсэн явж байхад олонхын бүлгээс 5 хүн энэ танхимд сууж байна. Засгийн газраас нь нэг ч хүн алга. Ерөнхий сайд ерөөсөө энэ төсвийн бүхий л хэлэлцүүлгийн үе шатад танхимд суугаагүй.

Тэгэхээр гэх мэтчилэн гишүүд үг хэлээд байдаг. Ялангуяа манай шинэ гишүүд төсвийн номыг бараг цоортол нь үзээд, бүх бөөс, хуурсыг нь түүгээд, тэгээд бүх зүйлээ энэ хурлын танхимд ч тэр, Байнгын хороон дээр ч тэр ярьсан.

Гэтэл засаг бол ерөөсөө маш хариуцлагагүй хандсан үүн дээр.

Тэгээд энэхүү төсвийг 9 дүгээр сарын 01-нд өргөн барих ёстой байсан гэдэг утгаараа улиран ажилласан Сангийн яамны сайд Б.Жавхлан өргөн барьсан.

Тэгээд л төсвийн хэлэлцүүлгийн бүхий л цаг явцад Б.Жавхлан сайд өөрийгөө өмөөрөөд гишүүдийг загнаад л, тэгээд л ийм тодорхой, бодитой асуултад

ерөөсөө хариулахгүй ийм байдлаар л энэ хэлэлцүүлгийг үрэн таран хийсэн шүү дээ.

Тэгэнгүүт одоо ингээд яачхав ийчхэв, одоо бид эндээс ямар гарц байна гээд ингээд хараад сууж байгаа нь аягүй харамсалтай байна.

Мөн Төсвийн байнгын хорооны дарга байна. Ц.Даваасүрэн гишүүн ээ, та бол одоо энэ парламентад суугаа маш олон удаа сонгогдсон хашир туршлагатай, энэ дэг бүх зүйлийг маш сайн мэдэх ёстой ийм хүн шүү дээ.

Тэгээд та өнөөдөр Төсвийн байнгын хороог ахалж байна, даргалж байна. Тэр битгий хэл одоо энэ төсвийг хэлэлцүүлэгт бэлдэх ажлын хэсгийг ахлаад ажилласан.

Гэтэл танай ажлын хэсгээс ерөөсөө дорвитой санал санаачилга оруулж ирсэнгүй шүү дээ.

Тэгээд та өчигдөр юу яриад сууж байгаа юм бэ? Зах зээлд итгэдэггүй, хувийн хэвшилд итгэдэггүй, тэгээд хаашаа юм тойрогтоо тавиулсан бяслагийнхаа үйлдвэрийн төлөө тэгээд л ерөөсөө энэ төсвийнхөө тэр ажлын хэсгийн ажилд, Байнгын хорооны ажилд ийм хариуцлагагүй хандаж болохгүй шүү дээ.

Тэгээд бусад нөхдүүдийг та нар саналаа оруулж ирээгүй гээд загнаад суучих юм уу. Энэ чинь таны хариуцлагын асуудал шүү дээ.

Тэгээд жишээлбэл хардаа, Засгийн газраас орж ирсэн урсгал зардал 26 их наяд 508 тэрбум 592 сая төгрөг байсныг 26 их наяд 485 тэрбум 278 сая төгрөг л

гэж оруулж ирж байна шүү дээ. Энэ гурав дахь хэлэлцүүлэг дээр.

23.3 тэрбумаар танасан байна. Гэтэл нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг дээр Их Хурлын дийлэнх гишүүд энэ төсөв хэт данхайж байна, хувийн хэвшилд орон зай үлдэхгүй нь, урсгал зардал хэт их байна гээд бүх зүйл яригдсан шүү дээ. Ажлын хэсэг яагаад ажилладаггүй юм бэ?

Тэгэхээр нэг тодорхой асуулт байгаа нь ажлын хэсэг дээр яг хэдэн төгрөгөөр энэ төсвийг танах асуудал орж ирсэн юм бэ? Ер нь ажлын хэсэг дээр ямар, ямар зүйл дээр санал хураалт явагдсан юм бэ? Тэр тойргийн гишүүд 5 тэрбум энэ тэр болсон тийм зүйл яригдсан юм уу? Тэр болгон дээрээ та хариулт өг л дөө.

Тэгээд одоо ингээд энэ төсвийн хэлэлцүүлгүүд шувтарч байдаг. Тэгээд энэ нийгмийн хүлээлт ийм байж байдаг. Тэгээд энд хээвнэг өөрийгөө өмөөрөөд сууж байж болохгүй шүү дээ. Ц.Даваасүрэн дарга аа.

Б.Пүрэвдорж: Ц.Даваасүрэн дарга Б.Жаргалан гишүүний асуултад хариулья.

Ц.Даваасүрэн: Тэр ямар зардлын саналууд орж ирсэн бэ гэхээр Б.Түвшин гишүүнээр би ахлуулаад, залуу хүн, тэгээд нягтлан бодох чиглэлээр нэлээн мэргэшсэн залуу юм билээ.

Тэгээд чи ер нь нэг яригдаад байгаа асуудлыг нэлээн сайн судлаад, ингээд оруулж ир гээд Б.Түвшин гишүүнээр ахлуулаад урсгал зардлын төсөв дээр ажиллуулсан байгаа.

Тэгээд 306 тэрбум орчим төгрөгийн асуудлыг ажлын хэсэг рүү оруулж ирсэн.

Тэгээд ингээд яг хэлэлцүүлгийн явц дунд үзээд байхаар бид цаанаа яг үндсэн ямар ажил, үүрэг гүйцэтгэж байгааг нь мэдэхгүй болчхоод байгаа учраас шууд хасаад хаячих ямар ч боломжгүй болчхоод байсан.

Тэгээд л нэг сайд нь ороод ирнэ. Манай ийм юм болохгүй боллоо, тийм юм болохгүй боллоо гээд.

Тэгээд бид яг эцэстээ 32 тэрбум бол цаанаа ямар нэг үр дагавар алга, шууд хасаад хаячхаж болох юм байна гэдэг ийм саналыг оруулсан байгаа.

Түүн дотор тэр 18 тэрбум нь тэр нэг хүүхдийн ваучер гээд байгаа асуудал чинь. Тийм. Тэр ихэнхийг нь эзэлж байгаа юм.

Ийм саналууд зардал хасах дээр гарсан. Мөн урсгал засвартай холбогдолтой. Мөн тоног төхөөрөмжийн ер нь зардал нэлээн өсчихсөн юм байна лээ.

Бүгдийг нь 30 хувиар таная гээд дэмжигдээгүй байхгүй юу. Уг нь 30 хувиар бүгдийг нь таная гэсэн юм.

Тэгэхээр л эмнэлэг дээр ийм юм хийх гэж байгаа, тэнд ийм юм хийх гэж байгаа, шинэ сургууль, цэцэрлэгүүд ашиглалтад орж байгаа гээд л.

Яах вэ хүүхдийн тоо 2000 оны эхээр 60 мянган хүүхэд сургуульд ордог байсан бол одоо 100 гаруй мянган хүүхэд ордог болчихсон юм байна. Тэгээд шинэ

сургууль, цэцэрлэг их ашиглалтад орж байгаа юм байна.

КОВИД-ын дараа нэлээн сургууль, цэцэрлэгүүдийг, ялангуяа цэцэрлэгийн асуудал дээр их хөрөнгө оруулалт хийгдсэн. Тэрний тоног төхөөрөмжийн зардлууд энэ тэр их өсчихсөн юм байна гээд. Ингээд бас тэр 30 хувийн санал маань дэмжигдээгүй юм.

Тийм учраас би ер нь нэлээн ул суурьтай, үндэслэлтэй үзээд ямар төсвийн эрх захирагч нь орон тоогоо нэмчхээд байгаа юм, зардлаа өсгөчхөөд байгаа юм гэдгийг нь олж харахгүй бол зүгээр харанхуйгаар шууд ингээд аваад хаячхаж болохгүй.

Би Та бүхэнд хэлсэн шүү дээ. Тэгж байж бид 12 хүүхдийн аминд хүрсэн байхгүй юу, хүйн халдвар тусаж. 10 хувиар бүх салбарын төсвийг хассан чинь ариутгалын бодисоо авахгүй болоод, тэгээд хүйн халдвар гараад.

Түүн шиг зүгээр нүдэн сохор тэгж шууд таналт хийж болохгүй.

Тийм учраас ажлын хэсгүүд гаргаад хугацаа өгөөд ингээд ажиллах хэрэгтэй. Тэгж байж шийднэ үү гэхээс болохгүй.

Ер нь тэр бяслагийн үйлдвэрийн хувьд би хөдөө аж ахуйг би гол эх үүсвэр гэж боддог.

Би зөвхөн бяслагийн үйлдвэрээр тогтохгүй, бүх сумдад орчин үеийн нядалгааны цех, хөргөгчтэйгөө байх ёстой гэж боддог.

Бид ерөөсөө нүүрснээс өөр юугаар амьдарч чадах юм хөдөө аж ахуй, сүү,

сүүн бүтээгдэхүүнээ боловсруул, арьс ширээ боловсруул. Нөгөөдөх нь аялал жуулчлал. Өөр бидэнд хийж чаддаг юм байхгүй.

Б.Пүрэвдорж: Батбаярын Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Тэгэхээр өнөөдөр үндсэндээ Улсын Их Хурал ямар шийдэлд хүрч байна вэ гэхээр нэгэнт төсвийн хэлэлцүүлэг гурав дахь хэлэлцүүлэг рүүгээ орчихсон.

Тийм учраас Засгийн газарт төсвөө энэ ондоо багтаагаад дахиад тодотгоод ир энэ тэр гээд нэг стандарт бус нэг тийм шийдэл рүү орж байна шүү дээ.

Тэгэхээр үүн дээр энэ ажлын хэсгийг маш хариуцлагагүйгээр ахалсан ажлын хэсгийн дарга.

Энэ Төсвийн байнгын хороо чинь мэргэжлийн Байнгын хороо. Тэнд бүх зүйл боогдож байх ёстой. Тэр зүйл дээрээ таныг би хариуцлага хүлээх ёстой гэж харж байна.

Яагаад вэ гэхээр бид улсын төсөвт ингэж хариуцлагагүй хандаж болохгүй шүү дээ.

Одоо тэгээд нэгэнтээ тодотгол хийнэ гэсэн үүрэг даалгавар өгч байна гэдэг чинь ер нь зардал танах боломж нь байна гэдэг дээр бүгдээрээ хүлээн зөвшөөрөөд явж байна л гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр танай ажлын хэсэг маш муу ажиллажээ.

Тэгэхээр та үүн дээр хариуцлага хүлээгээрэй гэж хэлэх байна.

Б.Пүрэвдорж: Ц.Даваасүрэн гишүүн хариулъя.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, ингээд шууд. Би хэлээд байна шүү дээ. Б.Түвшинг би сайн ажилласан гэж бодож байна.

Тэр зардлын хяналтын дэд хэсэгт ажилласан залуучуудыг би сайн ажилласан гэж бодож байна. Би тэд нарыг ерөөсөө буруутгахгүй. Зүгээр хүнийг шууд тэгж дүгнэж болохгүй. Би тэд нарыг сайн ажилласан гэж.

Гол нь нүдэн сохор ингэж хасаж хаяж болохгүй. Аав чинь чамайг бодоход ухаантай байсан. Ааваасаа жоохон очоод асуу, Н.Батбаяраас.

Амьдрал гэж юм байдаг байхгүй юу. Би чамд хэлээд байна шүү дээ. Ламбаа гишүүнийг сайд хийж байх үед бид ингэж хасаж байж 12 хүүхдийг эндүүлсэн байхгүй юу. Тэнэгтэж байж, нүдэн сохор хасаж байж.

Тийм учраас болохгүй. Тэр харин хэн зардлаа өсгөөд байгаа юм гэдгийг олох ёстой. Хэн орон тоогоо нэмээд байгаа юм, тэрийг нь олох ёстой.

Түүнээс биш чи одоо ингээд ордны цонхоор харж байгаад шууд ингээд хийгээд байж болохгүй шүү дээ.

Юм чинь амьдрал цаанаа наана чинь энэ төсвөөр ямар нэг байгууллага ажиллаж байгаа. Зөв явж байгаа байгууллагыг бид шууд танаад хаячхаж болохгүй.

Тийм учраас энэ ажил.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Чинбатын Ундрам гишүүн асуулт асууя. Алга байна.

Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Байр сууриа илэрхийлэхэд бид энэ төсвийн зардлыг танах ёстой гэдэг байр суурь дээр нэгдэж байгаа.

Гэхдээ гурван асуудал байгаа юм.

Нэгдүгээр асуудал болохоор шинэ, хуучин гишүүд гэдэг бас нэг юм яриад байх шиг байгаа юм.

Бид энэ хуулийн дэг, Улсын Их Хурлын дэгийн сургалтыг жоохон хийх хэрэгтэй юм шиг байна.

Аль шатад цөмөөрөө энэ зарчмын зөрүүтэй саналаа өгөх вэ, саналаа хураалгах вэ, энэ бүгдээрээ нээлттэй байгаа шүү дээ, дэгээрээ.

Тэгээд энэ асуудлуудаа нэг сургалт эд нар явуулаад явахгүй бол яг тэр хэлэлцэж байх явцад нь асуудлаа дэвшүүлээгүй, зарчмын зөрүүтэй саналаа гаргаагүй болоод энэ юм чинь тэр чигээрээ явчаж байгаа байхгүй юу.

Тэгээд өнөөдөр явчихсаных нь дараа цөмөөрөө энэ болохгүй байна гэдэг ийм асуудлыг яриад сууж байгаа асуудал өнөөдөр болохгүй л асуудал.

Яагаад гэхээр төсөв яагаад энэ онцгой, тусгай дэгээр явдаг вэ гэхээр энэ чинь бүгдээрээ цаг хугацаатай байдаг.

Ирэх жилийн ажлууд бүгдээрээ цаг хугацаатай байдаг.

Бид төсөв батлагдсаны дараа орон нутгийн төсөв бүгдээрээ батлагддаг хугацаатай.

Тийм учраас энэ арай жоохон өөр зохицуулалттай, бүр өөр дэгээр явдаг. Тийм болохоор зардал танахыг чинь дэмжиж байгаа. Дэгийн холбоотой асуудал дээр яг шинэ гишүүддээ сургалт явуулах ёстой юм болов уу гэж бодож байна. Б.Пүрэвдорж дарга аа.

Хоёрдугаар асуудал бол энэ төсвийн ил тод байдлыг бид илүү сайн сайжруулах ёстой юм болов уу гэж харж байгаа юм.

Ангилал. Бусдаар хийж гүйцэтгүүлэх ажил гээд 1.9 их наяд руу тавьчихсан яваад байгаа юм л даа.

Энэ одоо ямар ч ажил байж болно. Хөрөнгө оруулалтын ч ажил байж болно, гэрээгээр гүйцэтгэх ажил ч байж болно.

Нягтлан бодох бүртгэлээр голцуу гэрээгээр гүйцэтгэх ажлыг л бусдаар гүйцэтгэх ажил, үйлчилгээ гэж оруулдаг. Энэ ангилалдаа оруулдаг.

Манайх болохоор чинь нэг том дүнгээр тавиад, тэгээд яг түүгээр юу хийх гэж байгаа нь тодорхойгүй. Тэгээд хэлэлцүүлгийн явцад задарч тайлбар өгөгдөөгүйгээсээ болоод өнөөдөр үл ойлголцолыг бий болгочоод байгаа асуудал байна.

Гуравдугаар асуудал бол энэ хариуцлагын асуудлыг цөмөөрөө нэг жоохон сайжруулмаар байгаа юм.

Төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэх явцад асар олон зөрчил илэрдэг, зөрчлүүд гардаг.

Одоо миний санаж байгаагаар 2023 оны төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор 900 гаруй тэрбум төгрөг байх анхан шатын баримтгүйгээр худалдан авалт хийгдсэн асуудал байдаг.

Тэгээд түүнтэй холбоотойгоор ямар ч хариуцлага хүлээсэн хүн байдаггүй.

Тэгэхээр энэ төсөвтэй холбоотой, төсвийн зарцуулалттай холбоотой асуудалд бид энэ хариуцлагын асуудлыг чангатгаж өгөхгүй бол энэ гишүүдийн яриад байгаа үнэн шүү дээ. Одоо хасья л гэж санал оруулахгүй бол бид дараа нь тэр төсвийг хянах ямар ч боломж байдаггүй.

Гуравдугаар асуудал. Энэ сайд нартай холбоотой асуудал байна л даа.

Ер нь ямар ч шатад ямар ч хуулийн төсөл орж ирэхэд энэ Засгийн газрын гишүүд нь орж ирж бужигнуулдаг Засгийн газрынхаа өргөн барьсан төслийг. Баахан зарчмын зөрүүтэй саналууд гаргадаг.

Засгийн газар дээр орохдоо асуудлаа хэлэлцдэггүй. Тэгээд Засгийн газар дээр болохоор Засгийн газрынхаа малгайг өмсөж баахан юм ярьчихаад л, энд орж ирээд Их Хурлын гишүүн нь малгай өмсчхөөд тэгээд л тэрийг өөрчилнө, ийм санал гаргана гээд явчихдаг.

Тэгээд энэ Их Хурлын хэлэлцүүлгээ дандаа бужигнуулдаг. Засгийн газрын гишүүдтэй холбоотой асуудал шүү дээ.

Энэ асуудлыг Засгийн газрын түвшин дээр яримаар байгаа.

Дөрөв дэх асуудал. Энэ тойргийн асуудлуудыг манай шинэ гишүүд нэлээн ярьсан байна лээ.

Тойрог дээр хөрөнгө оруулалт тавигдах гээд байна гээд.

Тойрогт сонгогдсон гишүүд тойрог дээр санаа зовох нь ойлгомжтой шүү дээ.

Тэгэхгүй улсын төсөв гэж баталчхаад бид яам, Тамгын газрын үүдийг сахиад манай тойргийн сургуулийн энэ асуудлыг шийдэж өгөөч гээд гуйгаад явахгүй нь ойлгомжтой шүү дээ. Баахан саналууд өгдөг. Дэмжигддэггүй. Улс төрийн өрсөлдөгч гэж хардаг.

Тийм учраас тойргийн гишүүд санал гаргадаг юм.

Манай тойрог дээр энэ сургууль, цэцэрлэгийн асуудлыг шийдэж өгөөч гээд төсөв рүү саналаа өгдөг. Тэрийг чинь тэр төсвийг захиран зарцуулаад байдаг асуудал байхгүй шүү дээ.

Тендер зарлаад.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн гишүүн хариулья.

Ц.Даваасүрэн: Х.Ганхуяг гишүүний хэлээд байгаа зөв, зөв. Тийм.

Ер нь энэ тойргийн гишүүдэд асуудал байгаа шүү дээ бас.

Яагаад гэвэл сонгуулиар явахад тухайн иргэд нь тулгамдсан асуудлаа л хэлж байгаа. Тэрийг нь л эд нар шийдэх гээд л санал гаргаад л явж байгаа.

Түүнээс биш гишүүд хувьдаа мөнгө авчих гээд байгаа юм шиг гишүүн бүр ярьж тэгж болохгүй байхгүй юу. Иргэдийгээ тэгж төөрөгдүүлж. Тийм юм байхгүй шүү дээ.

Тэр чинь аль нэг өөрийнх нь тойрогт нэг сум дээр ч юм уу, нэг дүүрэгт ч юм уу тулгамдаад байгаа асуудлуудыг л энэ гишүүд санал болгож ингэж тавьж байгаа.

Тэгээд ер нь саналаа оруулсан гишүүдийнх бол ингээд хураагдаад явж байгаа шүү дээ.

Ж.Баярмаа шиг, Б.Түвшин шиг байя л даа. Саналаа оруулаад л тэгээд л түүнийхээ араас хөөцөлдөөд л, хураалгаад л. Тэгээд унана уу, дэмжигдэнэ үү.

Тэгэхгүй нэг ч санал оруулаагүй байж одоо ингээд л тэр муу байна, энэ муу байна, тэр муу ажлаа хийсэнгүй гээд. Өөрөө нэг ч хуруугаа хөдөлгөөгүй байж амаа хөдөлгөөд суугаад байж болохгүй л дээ. Залуу улсууд.

Би хүүхэд шигээ та нартай маргалдаад байх онцгүй л дээ.

Тийм учраас би зүгээр хэлье.

Энэ үлгэр жишээ болж байгаа гишүүд шигээ саналаа гаргаад, хөөцөлдөөд, эхнээс нь ажиллах хэрэгтэй.

Галт тэрэг хөдөлчихсөн хойно араас нь хашхираад, гүйгээд байж ерөөсөө болохгүй.

Тийм учраас Х.Ганхуяг гишүүний хэлээд байгаа үнэн.

Нэгэнт боогдчихсон, тэгээд явчихсаны дараа тэгээд байх зарчмын хувьд зохимжгүй байгаад байгаа юм.

Ер нь энэ төсөв дээр танах зүйл байгаа юу. Байгаа. Ингэж 3, 4 жилийн дотор хоёр, гурав дахин төсвөө нэмсэн улс орон байхгүй.

Би бол 4 сар Төсвийн байнгын хорооны дарга хийж байна. Тэгвэл үүний өмнө хийж байсан улсууд яасан юм.

Яагаад энэ 3, 4 жилийн дотор энэ төсөв хоёр, гурав дахин нэмэгдчихсэн юм.

Нүүрсний үнэ унавал яах юм. Бүгдээрээ л байхгүй. Цалин, тэтгэврээ тавьж чадахгүй болно шүү дээ. Улс орон хямарна, бослого хөдөлгөөн гарна. Тийм эрсдэл байгаа шүү дээ энэ дээр чинь.

Тийм учраас би гишүүдийн зардлыг ер нь харъя. Хаанаа болохгүй байгааг нь харин олох ёстой.

Түүнээс биш механикаар хандаж болохгүй.

Ямар нь нөлөө үзүүлээд төсвөө, зардлаа нэмээд, орон тоогоо нэмээд яваад байгаа юм. Тэрийг олох хэрэгтэй. Үндэслэлийг нь олох хэрэгтэй. Төсөв нэмээд байгааг.

Тэгж байж тэр дураараа дургиад байгаа, төсвөөрөө наргиад байгаа тэр

төсвийн эрх захирагч нарын төсвийг л тайрах ёстой болохоос биш журмаараа төсвөө яг зарцуулаад явж байгаа улсуудыг хохироож бас болохгүй.

Тийм учраас энэ дээр ул суурьтай хандаад, судалгаа хийгээд, ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаад шийдсэн нь дээр байх.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Тэгэхээр яг энэ зардлыг танах тухай асуудал дээр бол тийм олон гишүүд санал гараагүй.

Ялангуяа Ж.Баярмаа гишүүн, Г.Тэмүүлэн гишүүн нар маш тийм тодорхой, Б.Түвшин бас тодорхой саналуудыг гаргасан.

Тэгэхээр яг энэ хүмүүс дэгийн тухай хуулийн дагуу яг л тэр дэгийнхээ хуулийн зарчмын дагуу шийдвэр гаргасан байгаа.

Тэгэхээр ер нь ажлын хэсэг дээр саналуудаа гаргаж болно.

Дээрээс нь Төсвийн байнгын хороо хуралдлаа гэхэд хоёр өдрийн өмнө саналаа гаргаад өгөх бүрэн боломж байгаа.

Энэ болгон дээр ингээд тэр дэгийн тухай хуулийн дагуу саналаа гаргасан тэр хүмүүс нь бурууддаг ийм байдал бас байж болохгүй гэж би хэлээд байгаа юм.

Тэгээд дээрээс нь одоо ингээд зарим Их Хурлын гишүүд үгээ хасуулаад байна л даа.

Тэгэхээр яадаг вэ гэхээр би дэгийн тухай хуулиар хэрвээ Төсвийн байнгын хороон дээр гишүүн нь байлаа ч гэсэн, үгүй байлаа ч гэсэн ороод үгээ хэлээд тэр Төсвийн байнгын хорооны танилцуулга дээр, гуравдугаар хэлэлцүүлэг дээр оруулаад ирэх юм бол яг түүнтэйгээ холбоотойгоор үг хэлэхэд ямарваа нэгэн асуудалгүйгээр минутаа хасуулалгүйгээр үгээ хэлэх боломжтой байдаг шүү гэдгийгээ хэлье.

Ингээд гишүүд тайлбар хийж, асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

Тав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэх асуудал. Тав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Засгийн газрын 2024 оны 8 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг. Энэ асуудалд орё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан танилцуулна. Индэрт урья.

Ж.Баясгалан: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 11 сарын 05-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг анхны

хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг баримтлан төслийн зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу дараах саналыг гүйцээн боловсруулж, хууль, тогтоолын төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдууллаа.

Монгол Улсын Их Хурал Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн жагсаалт болон гаалийн албан татварын хөнгөлөлтөд хамаарах боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг батлуулахаар холбогдох хуулийн төсөлд, мөн “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Монгол Улсын Засгийн газраас 2025 онд 4.0 их наяд хүртэл төгрөгтэй тэнцэх хэмжээний гадаад, дотоодын үнэт цаас гаргах “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга, байгууламжийн төсөвт магадлал хийн аудитын дүгнэлт гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, саналаа 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах үүргийг Монгол Улсын Засгийн газарт өгөхөөр тусгалаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг холбогдох хууль, тогтоолын төсөлд нэмж тусган агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хууль, тогтоолын төслүүд болон Төсвийн

байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Жадамбаагийн Баясгалан гишүүнд баярлалаа.

Хэлэлцүүлэгтэй холбоотой сайд нар бүгдээрээ байх ёстой. Одоогоор Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт ганцаараа сууж байна.

Сайд нарыг, Ч.Номин сайд сууж байна.

Ингээд сайд нарыг орж ирэхийг хүсэж байна.

Ажлын хэсгийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Пүрэвдоржийн

Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Лувсанванданы Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Жаргалсайханы Золжаргал гишүүн байхгүй байна. Мөнхтөрийн Нарантуяа гишүүн байхгүй байна. Г.Лувсанжамц гишүүн нэрээ татлаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Энэ төсөв дагаж орж ирсэн хуулиуд байна. Нийгмийн даатгалын хууль, “Эрүүл мэндийн даатгалын сан”-гийн тухай.

Тэгэхээр энэ дээр ер нь ямар тоо хэмжээтэй, ямар асуудлыг бид ингээд нэг чимээгүй гулсуулаад өнгөрч байгаа вэ гэдэг дээр бас нэг цөөн үг хэлье.

Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалтай холбоотой үндсэндээ ажилтан, ажил олгогчоос нийлээд 30-аад хувийг нь татвар, шимтгэл. Зөвхөн шимтгэл нэрээр 30-аад хувь гарч байгаа.

Үнэхээр яг өнөөдөр бизнес эрхэлж байгаа, ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн хувьд үнэхээр том асуудал үүний цаана явж байдаг.

Би энд цөөхөн тоо үзүүлчихье. Жишээ нь, “Нийгмийн даатгалын сан” чинь дотроо 4, 5 дэд сантай. Энэ сангуудын зөвхөн нэг сан “Тэтгэврийн даатгалын сан” гэхэд нэг жилдээ 800 тэрбум төгрөгийн алдагдалтай. Нэг жилдээ. Сүүлийн 5 жилээр 4 их наядын алдагдалд энэ сан. “Тэтгэврийн даатгалын сан” жилд 800 сая, хуримтлагдсан алдагдал нь 4 их наяд.

Энэ жилийн 800 сая, хуримтлагдсан нь 4 их наяд гэдэг ер нь хэр их тоо юм бэ гэдгийг бид нарын одоо нийт даяараа яриад байгаа эрчим хүчин дээр гарч байгаа мөнгөтэй ингээд харьцуулаад үзье.

Эрчим хүчин дээр жилдээ 350 орчим тэрбум төгрөгийн алдагдлын тухай л ярьж байгаа. Үүнээс чинь үндсэндээ 2 дахин их гаруй жилийн алдагдалтай “Тэтгэврийн даатгалын сан”-гийн тухай яриа одоо төсвийн хуулийг дагаад ингээд чимээгүйхэн гулсаад явж байгаа.

Эрчим хүчин дээр гарч байгаа алдагдлын хэмжээ хуримтлагдсан алдагдал 1 их наядын тухай л ярьж байгаа.

Гэтэл “Тэтгэврийн даатгалын сан”-гийн алдагдал чинь 4 их наяд. Ингээд харьцуулаад харах юм бол ийм тэнгэр, газар шиг ялгаатай. Энэ “Нийгмийн даатгалын сан”, “Эрүүл мэндийн даатгалын сан”-гийн асуудлууд үүний цаана ингээд л хуримтлагдаад явж байгаа.

Тэгэхээр ямар их том хэмжээний асуудал үүний цаана хуримтлагдсан. Эрчим хүчний энэ алдагдал гэдэг зүйл ямар их том нийгэм, эдийн засгийн бараг тусгаар тогтнолын асуудал болоод

хувирчихсан байхад үүнээс 4 дахин том “Тэтгэврийн даатгалын сан”, “Нийгмийн даатгалын сан” маань ингээд ийм буглаатай шарх болчихсон. Нөгөө дарьтай торх гэдэг шиг хэзээ мөдгүй дэлбэрэхэд бэлэн.

Тэр тусмаа одоо үндсэндээ 5 жилийн дараа очиход бараг улсын төсөв дээр гарч байгаа энэ урсгал зардлыг чинь бараг бүгдийг нь өгөөд ч дийлэхээргүй ийм том хэмжээний асуудал үүний цаана хуримтлагдчихсан.

Гэтэл одоо үндсэндээ яг одоо бид нарын хувьд энэ том асуудлыг аргацааж явсаар байгаад ийм хүнд байдалд аваад ирчихсэн. Зөвхөн нийгмийн даатгалын асуудал гэхэд сүүлийн 5 жилд 5 дахь сайд нь өнөөдөр солигдчихсон. 5 жилд 5 дахь сайд солигдчихсон. Ямар ч бодлогын өөрчлөлт, шинэчлэлт, алсын хараа юу ч байхгүй. Зүгээр асуудлыг аргацааж өнгөрүүлж байгаа. Яг одоо өнөөдрийн энэ хурлын хэлэлцүүлэг дээр ч гэсэн. Энэ чинь “Нийгмийн даатгалын сан”-гийн тухай, “Эрүүл мэндийн даатгалын сан”-гийн тухай дагалдах хуулиар хэлэлцэж байхад одоо асуулт асуумаар байдаг. Хурлын дарга аа, сайд нь байдаггүй.

Зүгээр одоо ингээд л ёстой олон нийт рүү хэлээд л өнгөрөхөөс өөр.

Эрчим хүчний хуримтлагдсан энэ их том асуудлаас чинь 4 дахин том хуримтлагдсан асуудал энэ хоёр сангийн цаана байж байгаа.

Ийм асуудлыг бид зүгээр л юу ч болоогүй юм шиг. Магадгүй 1 жилийн дараа, 2 жилийн дараа, 3 жилийн дараа энэ тэсрэхэд бэлэн. Улсын төсөв гэж ярьж байгаа, урсгал зардал гэж ярьж байгаа энэ зүйлийг чинь юун тэрбумаар

биш, их наядаар аваад хүндрэхэд бэлэн ийм л зүйл болчихож байна.

Гэтэл одоо бид нарын ярьж байгаа энэ төсөв чинь юу болж байгаа билээ. Ярьж байгаа төсөв чинь үндсэндээ хуучны нэг зохиол дээр байдаг “Дагдангийн эхнэрийн таргалсан Цэрмаагийн турсан хоёр яг тэнцэнэ” гэдэг дээр төрийн төсвийн мөнгө зарцуулагчдын эрх мэдэл, зардаг, зурдаг мөнгө нь хэчнээн их хэмжээнд оччихсон, ард иргэд ямар байдалд, бизнес эрхлэгчид ямар байдалд, тэр тусмаа энэ элдэв янзын хуримтлагдсан тэтгэврийн болоод нийгмийн даатгалын асуудлууд ямар том том суурь асуудлууд тэр төрийн өмчит компани дээр гарч байгаа.

Төрийн өмчит компани гэхэд энэ төсвөөс чинь 3 дахин их том төсөв үүний цаана бид чимээгүйхэн л үүний цаана асуудал урсаад л, хуримтлагдаад л явж байгаа.

Тэгэхээр одоо яг энэ дээр бодлогын ямар ч өөрчлөлт шинэчлэл.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хариулах хүн байхгүй байна.

Сангийн сайд танаас асуулт асуулаа. Алга байна. Нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан танаас асуулт асуулаа. Алга байна. Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танаас асуулт асуулаа. Алга байна.

Засгийн газар нь одоо энэ Их Хурлынхаа толгой дээр гарчхаад байгаа шүү.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя. Алга байна. Жамбалын

Ганбаатар гишүүн асуулт асууя. Алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя. Алга байна.

Энэ Ардчилсан намын гишүүд гишүүдийн урдуур орж үг хэлнэ гэж, асуулт асууна гэж нэр өгчхөөд алга болчихдог байж болохгүй. Ардын намынхан алга болбол болцгооно л биз.

Тийм учраас энэ Ардчилсан намын гишүүдэд нэр өгсөн бол тэр дээрээ хариуцлагатай сууж, асуулт асууж, бас энэ сөрөг хүчнийхээ үүргийг гүйцэтгэх хэрэгтэй.

Ж.Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: “Нийгмийн даатгалын сан”-тай холбоотой ужгирсан олон тэрбумын асуудал юу болж байгаа тухай, хэнд ямар хариуцлага тооцож байгаа тухай ямар ч мэдээлэл байдаггүй.

Дээрээс нь саяхан “Эрүүл мэндийн даатгалын сан” дээр бас том асуудал үүссэн. Бас удирдлага нь авлига, албан тушаал, хээл хахуулийн асуудалд орооцолдсон.

Тэгээд энэ авлагуудаа яаж авч байгаа талаар ер нь ямар нэгэн мэдээлэл байдаг юм болов уу гэж нэг асуулт асуумаар байх юм.

Дандаа л яригддаг мөртөө тодорхой хариулт ерөөсөө байхгүй.

Тэгээд одоо хуучин гишүүдийн амнаас нэг л ийм үг гараад байх юм. Энэ шинэ гишүүд ерөөсөө дэгээ мэдэхгүй байна, уншиж судлахгүй байна. Уншиж судлаад ч юу ч ойлгохгүй юм шиг байна. Эд нар т сургалт оруул гээд байх юм.

Үгүй ээ энэ чинь одоо 5, 6 удаа сонгогдоод дэгээ ойлгоогүй хүн байхад анхны удаа сонгогдоод дэгээ ойлгочихсон залуучууд хүмүүс зөндөө байгаа шүү дээ.

Тэр нэг усан тэнэг хүмүүс ороод ирчихсэн аятай л хүн болгон тэгж хэлээд байх юм. Энэ чинь дэг дээр чинь маш тодорхой биччихсэн байна шүү дээ. Жишээлбэл, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 3.2 дээр тусгайлан зохицуулаагүй асуудлыг хэлэлцэхдээ Улсын Их Хурал өөрөө дэгээ тогтооно гээд биччихсэн.

Тэгэхээр энэ төсөвтэй холбоотой асуудал дээр, магадгүй буцааж татаад дахиж яаж оруулах тухай асуудал нь тусгагдаагүй бол энэ бид нарын буруу биш.

Тэр 4, 5 удаа сонгогдсон гишүүдийн буруу. Яагаад ийм дутуу хөтүү юм энэ хуульдаа оруулсан юм гэдэг асуудал яригдана.

Гэхдээ эрх биш энэ чинь Монгол Улс юм байна. Бүх юмыг зохицуулсан.

Тэгэхээр магадгүй буцаж оруулах тэр асуудал нь энэ дэгд тусгагдаагүй бол саяын энэ 3 дугаар заалтыг бариад Улсын Их Хурал өөрөө дахиад дэгдээ өөрчлөлт оруулах бүрэн эрх нь байгаа.

Сая үүнийг хавар 5 сарын 31-ний дотор 2025 оныхоо хөгжлийн төлөвлөгөөг батлах ёстой байсан. Батлаагүй.

Аудитын буюу 2023 оны гүйцэтгэлийн дүгнэлтээ батлах ёстой байсан. Батлаагүй. Тэртээ тэргүй хуулиа зөрчихсөн яваа.

6 сарын 01-н дотор батлах ёстой байснаа батлаагүй. Дэгийн хуулиа зөрчсөн.

Тэгэнгүүтээ Их Хурал бүрэн эрхийнхээ дагуу 3 дугаар зүйлийг ашиглаад нэмэлт, өөрчлөлт оруулаад сая 9 сард баталсан.

Тэгэхээр бид одоо энэ төсвийг баталж чадахгүй байлаа гээд одоо ерөөсөө гамшиг болох гэж байгаа юм шиг худлаа яриад байж болохгүй. Цаана нь зөндөө хуулийн гаргалгаа байгаа. Энэ гурвынхаа дагуу дэгдээ өөрчлөлт оруулаад явах боломж бүрэн байгаа.

Тэгээд дэгээ уншаагүй болоод л хэдэн мангуу гишүүд нэг ийм санал гаргачхаад яваад байгаа юм шиг юм яриад байх юм. Тэр дэгийн чинь хуулийг нь уншаад, боломжийнхоо хэрээр тэр саналыг гаргаад явж байсан. Гаргаж яваад харамсалтай нь хаана ч дэмжигдээгүй. Ажлын хэсэг ч дэмжээгүй. Байнгын хороо ч дэмжээгүй. Чуулган ч дэмжээгүй.

Хэд дахиж энд санал хураалгаад бүгдээрээ унагаагаад л явж байсан шүү дээ. Хүмүүсийн гаргасан саналыг.

Тэгээд учраа олохгүй төөрч будилж аваад л гэнэтхэн өглөө сэрээд л ээ., та минь ээ, энэ чинь болохоо байлаа гээд л асуудал гаргаад яваад байгаа юм шиг ингэж битгий гүтгээд бай л даа.

Олон нийтэд нэг ийм ойлголт төрүүлээд байгаа байхгүй юу. Энэ нэг хэдэн гишүүд л хөөрхий амьтад дэгийнхээ ч учрыг олохгүй бүтэлгүйтэж яваад хамаг юм дууссаны дараа гэнэт

попорч гарч ирлээ гээд байх юм. Тийм юм байхгүй шүү дээ.

Энэ чинь цагаан дээр хараар биччихсэн юмыг хэн ч уншаад л ойлгоно шүү дээ. 4, 5 жил, 4, 5 удаа сонгогдчихоод тэгвэл та нар энэ төсвийнхөө цоорхойг хууль дээрээ тусгаад оруулчихгүй яасан юм.

Буцаад татлаа гэхэд буцаад яах нь үнэхээрийн шийдэгдээгүй. Тэгэхдээ дахиад хуульдаа өөрчлөлт оруулах боломж нь бол байгаа.

Тэгж ярих юм бол бүр хэрвээ хугацаандаа баталж чадаагүй бол төсөв яах вэ гээд бас дахиад заачихсан байна шүү дээ. Энэ төсвийн тухай хуулийн 41 дээр.

Өмнөх оныхоо түвшинд бариад явна гээд маш тодорхой заачихсан байна. Эрх биш энэ Монгол Улс чинь бас нэг хуультай улс юм болохоороо бас тодорхойгүй тийм зүйл байхгүй. Харьцангуй бүх юмыг нь зохицуулчихсан байгаа.

Тэгэхээр бүх тал дээр хуулийн гарц гаргалгаа нь байгаа.

Тэгэхээр ийм дампуу, асар ихээр тэлсэн, иргэдийн нуруун дээр.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ж.Баярмаа гишүүн Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханаас тэр салбар чинь авлигал, хээл хахууль, эмийн мафи энэ тэр, янз янзын юм болоод байна гэж асуугаад байна. Хариулах Т.Мөнхсайхан сайд алга байна.

“Нийгмийн даатгалын сан”-гийн тухай асуудлаар Л.Энх-Амгалан сайд хариулья.

Л.Энх-Амгалан: “Нийгмийн даатгалын сан”-гийн зарим хөрөнгө энэ хоёр банканд байршсанаас болж эрсдэл үүссэн.

Нэг банк нь дампуурлаа зарлачихсан. Энэ бол Капитал банк. Нөгөөдөх нь Чингис хаан банк байгаа. Чингис хаан банк дээр 100 тэрбумын мөнгө байршуулсан байгаа.

Гэхдээ би хоёр банкны эрх хүлээн авагчтай хоёулантай нь уулзсан. Ж.Баярмаа гишүүн ээ.

Одоо ингээд би ямар ч байсан нэг сайдаар томилогдоод 2 сар болж байна, 2 сар гаруй болж байна.

Ингээд үндсэндээ Нийгмийн даатгалын үндэсний хороогоо хуралдуулж өнөөдөр 3 дахь хурлаа хийлээ.

Ингээд үндсэндээ тэр Чингис хаан банк, одоо тэр Капитал банк дээр Нийгмийн даатгалын ерөнхий газар ерөөсөө гомдол гаргаж байсан тохиолдол байхгүй байсан юм билээ. Гомдол гараагүй.

Тийм учраас Үндэсний хорооноос чиглэл өгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газар прокурорт гомдол гаргасан. Гомдол гаргасан. Хохирогчийн хувиар.

Ингээд прокурор тэр хэргийг хянаад, Авлигатай тэмцэх газарт шилжүүлээд, одоо Авлигатай тэмцэх газар хэрэг нээгээд ингээд энэ

процессууд шинээр эхэлж байгаа ийм процессууд байгаа. Ямар ч байсан тодорхой дэвшил гарсан уу гэвэл гарсан.

Одоо бид өнөөдөр батлагдах гэж байгаа, маргааш, эсвэл нэг дэх өдөр батлагдах гэж байгаа энэ 2025 оны улсын төсөв дээр бид одоо манай Д.Үүрийнтуяа гишүүн санал гаргаад миний багцаас тодорхой зардлыг хасаад, 300 сая төгрөгийн хуулийн өмгөөлөл авах зардлыг Та бүгдээрээ батлуулж авч байна.

Яагаад ингэж байгаа юм бэ гэхээр одоо энэ 160 тэрбум төгрөг гэдэг бол маш их мөнгө. Тэгээд 160 тэрбум төгрөгийг одоо тэр банк дээр авч байршуулсан. Цааш нь үрэн таран хийсэн нөхдүүд Монголын хамгийн үнэтэй өмгөөлөгч нарыг авдаг юм билээ. Хамгийн үнэтэй өмгөөлөгч нарыг.

Тийм учраас тэр үнэтэй өмгөөлөгч нарын авсан тэр тойруулж хийж байгаа тэр схемээс дутахгүй хэмжээний хууль эрх зүйн зөвлөгөө авч байж бид одоо энэ хоёр банк дээр үүссэн, одоо энэ эрсдэлд орчихсон байгаа энэ мөнгөө буцааж авах л нэг ийм л бодитой алхмуудыг бас хийж байгаа шүү гэдгийг бас би танд мэдээлэл болгоод хэлчихье гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Чинбаатарын Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Асуулт байхгүй. Таны санаачилж байгаа ажлын хэсэг дээр орж ажиллаад энэ асуудлыг шийдвэрлээд явна.

Б.Пүрэвдорж: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Би энэ “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолтой холбоотой асуулт асууя.

Энэ дээр болохоор би одоо бас ингэж явдаг юм уу? Гайхаад л байна л даа.

4 их наядаар гээд энэ нэлээн маргаан болж байгаад 578 сая долларын “Номад” бондтой холбоотой энэ дахин санхүүжүүлдэгтэй холбоотойгоор дүнгүй, одоо дотоод, гадаад үнэт цаас гаргах эрх олгох тухай асуудал орж ирсэн.

Тэгэхдээ хэлэлцээд 4 тэрбум гэж бичсэн. Тэгээд яг энэ тогтоолын төсөл дээрээ болохоор яг тоо тавина гэж байгаад дахиад тавиагүй л явж байна л даа.

Тэгэхээр энэ нь ар талд нь нэг тэмдэглэл шиг юман дээр болохоор 4 их наяд гээд тавьчихсан.

Тэгэхээр үүнийг ингэж тоо тавина гэххээд тавихгүй ингээд явах нь зөв үү? Энэ эсвэл би өөр буруу юм хараад байна уу? Эцсийн найруулга гэхчхэн цаас харлаа л даа. Энэ дээр тайлбар өгөөч.

Харин тийм би буруу юм хараад байна уу? Энэ дээр болохоор. Тэгвэл тоотой явж байгаа юм байна. Тийм ээ. Энэ талаар асуулт авах гэсэн юм. Тэгвэл энэ асуулт байсан. Тэгвэл хариулагдаж байна.

Б.Пүрэвдорж: Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн хариулна.

Ц.Даваасүрэн: Тэр гадаад бондоос гадна байна шүү дээ. Тэр нөгөө нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

гээд энэ нөгөө төсвийн тараасан номын ард талд энэ баланс нь байж байгаа.

Энэ дээр алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр гээд байж байгаа. Тэр дотор байгаа эх үүсвэрүүдийг ингээд харах юм бол байна шүү дээ. Одоо ирэх жилийн хамгийн том гаргах бонд дотоод зах зээл дээр бол 400-гийн бонд. Нөгөө энэ нийслэл 1 их наяд 400-гийн бонд гээд ингээд 1.8 нь одоо тодорхой байгаа юм.

Түүнээс гадна мөн хэрвээ зээлийн хүү одоо нэлээн энэ нөгөө зээлжих зэрэгтэй холбоотой сайжрах нөхцөл үүсвэл 2026 оны зарим бондыг урьдчилж төлөх ийм боломжийг бас гаргаж өгөөч ээ гэсэн учраас бид 4 их наяд хүртэл гэж зааж өгсөн байгаа.

Засгаас орж ирэхдээ ямар ч тоогүй. Гишүүд юу гэж үзсэн гэхээр энэ одоо хязгааргүй бонд гарах ийм боломж олгож байна гэж үзсэн учраас энэ дээр Байнгын хороон дээр 4 их наяд хүртэл гэж хязгаар тавьж өгье гэж шийдсэн байгаа.

Б.Пүрэвдорж: Батбаярын Жаргалан гишүүн. Алга байна. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн. Алга байна.

О.Цогтгэрэл дарга аа, ялангуяа энэ Ардчилсан намынхныгаа бүлгийн гишүүдийн өмнүүр би үг хэлнэ, би үг хэлнэ гэж үг авчхаад тэгээд хэлэхгүй алга болчихдог энэ нөхдүүдийг дахиад үг хэлэхэд нь арга хэмжээ аваад 2, 3 удаа үг хэлэхийг нь хойшлуулах хэрэгтэй.

А.Ундраа гишүүн. Алга байна. Батын Батбаатар гишүүн. Алга байна.

Одоо ингээд хоёрхон хүн асуулт асуусны дараа санал хураалтууд явагдана. Их Хурлын гишүүдийг чуулгандаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Баярлалаа. Одоо яах вэ, мэдээж 2025 оны төсвийн хуулийг дагалдсан хуулиудын асуудлыг ярьж байгаа.

Би яах вэ өглөө бас нөгөө цэцийн хуралд оролцсон учраас яг төсвийн хэлэлцүүлэг дээр оролцож чадсангүй.

Тэгэхдээ бид хэд нэг зүйлийг ер нь цаашдаа анхаарч хаа хаанаа хариуцлагатай баймаар байна.

Ерөнхийдөө түрүүн хэд хэдэн гишүүд хэлж байна лээ. Энэ Засгийн газрын гишүүд нь өөрсдөө орж ирж санал гаргаж бужигнуулдгаа одоо нэгдүгээрт төсөв хэлэлцэхэд ер нь цаашдаа больчихмоор байгаа юм.

Засгийн газар дээрээ асуудлаа сайхан ярьчихдаг ийм байхгүй бол ингэнэ тэгнэ гэж одоо баахан саналууд гаргадаг. Хувь гишүүнийхээ үүднээс тойргоо гэдэг юм уу, эсвэл нутаг усаа маллаад явчихдаг ийм зүйлүүд байна.

Ийм юм гарсан шүү дээ. Ардын намын бүлгээс ч гарсан, Ардчилсан намын бүлгээс ч гарсан.

Тэр байтугай бэлэн сургуулиудыг авхуулахын тулд бас нэг гишүүнийг лоббидоод санал гаргуулж байгаа шүү дээ.

Ингэж өөрсдөө Засгийн газрын сайд нар нь хулгай хийх асуудал дээр оролцоно шүү. Би үүнийг бол одоо бүр хатуу хэлчихмээр байгаа юм. Эргээд энэ шинэ гишүүдийг зарим талаараа бас жоохон тэр мэдээлэл дутуу, гаргаж байгаа саналын томъёолол энэ тэр дээрээ бас багцаа авч чадахгүйг нь далимдуулаад боловсролын салбар дээр хүртэл 2 бэлэн байр авъя гээд л орж ирсэн шүү дээ.

Өнөөдөр хүүхдийн цэцэрлэгийн мөнгийг хасаж байгаад Сүхбаатар аймагт аудитын барилга авах гэж байгаа шүү дээ. Бэлэн барилга шүү. Ийм л төсвийг өнөөдөр Засгийн газрын гишүүд нь гаргаж байгаа юм.

Тэгэхээр би энэ дээр одоо юу гэдэг юм хүний тухай яримааргүй байна. Цаашдаа хэдүүлээ энэ төсвийг хэлэлцэхдээ дэгээ маш ойлгомжтой нарийн болгохоосоо гадна энэ Засгийн газрын гишүүд нь өөрсдөө санал гаргадгаа болимоор байна. Яг энэ үе дээр. Энэ дээр бас нэг татчихмаар байна. Яг Засгийн газарт ажиллаж байгаагийн хувьд Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн бас нэг жоохон совесттой баймаар байгаа юм.

Хоёрдугаарт, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдэх ёстой ч юм уу, орон нутгийн чиг үүргийн асуудлуудыг Засаг захиргаа, нэгжийн тухай хууль батлахдаа уг нь хийчихсэн юм.

Гэтэл энэ орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх ёстой маш олон ажлуудыг улсын төсөв дээр бас лоббидож тавиулсан.

Тэгэхээр үүнийгээ одоо бас больчихмоор байгаа юм. Тэгээд ийм зүйлүүдийг байхаар чинь энд ерөөсөө ингээд үл ойлголцол гарч байгаа ийм л зүйлүүд байгаа.

Хоёрдугаарт, манай шинэ гишүүд ч гэсэн зарим зүйлүүдийг хүлээж авах ёстой. Бидний асуудал бас байгаа шүү. Ямар цаг хугацаанд нь саналаа гаргахаа мэдэхгүй байна.

Санал бичиж байгаа томъёоллуудаа хар. Ерөөсөө балансаа барьдаггүй, аль зардлаас юуг нь хасаад гаргаж байгаагаа мэдэхгүй. Ийм юмнаас чинь болоод энэ хэрүүлүүд хоёрдугаар хэлэлцүүлэг дээр гарсан. Бид хэд хаа хаанаа үүнийгээ анхааръя.

Тэгээд хэдүүлээ шинэ хуучнаараа биш дэгтэйгээ сайн танилцъя. Санал гаргах томъёолол энэ тэр дээрээ бид хэд ч гэсэн одоо энэ орж ирсэн залуучуудаа анхаарахгүй бол буруу, зөрүү юм биччихээд тэрийгээ унадаг ч юм уу, ингээд хоёрын хооронд хоосон улс төр хийгээд байх юм. Яг бодитой саналаа гаргаад энэ дээрээ жинтэй явмаар байгаа юм.

Түүнээс биш одоо ингээд бас өөрсдийнхөө хариуцлагагүй алдаанаас болоод шинэ, хуучнаараа ялгараад ч юм уу, эсвэл жагсаалт, тойргийн гээд л ийм зүйл хэдүүлээ бас яримааргүй байна. Энэ дээрээ хэдүүлээ зарчим ярья.

Тэгээд энэ дагаж байгаа хуультай хоёр зүйл асууя. Энэ төрийн өмчийн энэ компанийн засаглалын асуудлыг сайжруулах асуудал энэ дээр байгаа юм. Энэ нь сайшаалтай. Тэгэхдээ ингэж өм цөм шийдэхгүйгээр Засгийн газар бас хэзээ ингэж төрийн өмчийн болон орон

нутгийн өмчит компанийн хуулийг өргөн барьж оруулж ирэх юм бэ?

Энэ төрийн өмчийн компанийн засаглалын асуудлын ард бол төсвөөс илүү хулгай байгаа шүү. Энэ асуудлуудыг өнөөдөр энэ төсвийн хууль дагаад одоо бас яригдаж байгаа үе дээр хурдан шийдмээр байна. Энэ дээр би Засгийн газрын яг холбогдох сайдын хариултыг авмаар байна.

Хоёрдугаарт, Ц.Даваасүрэн сайд хариулах болов уу? Уг нь Д.Амарбаясгалан дарга чиглэл өгөөд энэ Улсын Их Хурал батлах энэ жагсаалтуудыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр болгоё гээд тэгсэн. Энэ саналууд яагаад хэлэлцэгдээгүй юм бэ?

Ингээд өөрөө эргээд аж ахуйн тооцоотой, төсөв, санхүүгийн бууралт гэдэг юм уу, тооцоо, судалгаатай орж ирдэг зүйлүүдийг Улсын Их Хурал.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулна.

Ц.Даваасүрэн: Тэр нөгөө боловсруулах үйлдвэрийн жагсаалт, аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх жагсаалтыг Улсын Их Хурал батална гэдэгт.

Хэрвээ Засгийн газрын мэдүүлснээр гэхээр нэгдүгээрт одоо жишээлбэл, хууль санаачлагч, Ерөнхийлөгч гишүүдийн эрхэнд халдчихаад байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүдийг бол яах вэ зүгээр хуулиар юу гэж

хязгаарласан гэвэл анхдагч хууль, шинэчилсэн найруулга, татварын ийм хуулиудыг санаачлахад бас нэг жоохон хязгаарлалтууд бий.

Түүнээс биш Их Хурлын гишүүн хууль санаачлагч, Ерөнхийлөгч хууль санаачлагчийн эрхэнд халдаж болохгүй юм. Энэ тогтоол гараад одоо цэц дээр уначих магадлалтай гэж үзсэн учраас тэрийг оруулаагүй байгаа.

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна. Н.Учрал гишүүн хариулах уу? Н.Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал сайдын минутыг шинээр эхлүүлье.

Н.Учрал: Төрийн өмчит компанийн хуулийг ирэх долоо хоногт Засгийн газарт танилцуулахаар бэлтгэж байгаа.

Тэгэхээр 64 их наяд төгрөгийн орлого бүрдүүлж байгаа мөртлөө түүний 70 хувийг нь 5-хан компани бүрдүүлж байгаа энэ асуудлыг шийдэхгүй төсвөөс гадуур ийм хяналтгүй төсөв явж байна.

Тэгээд ер нь 5 компаниас бусад нь бүгдээрээ зарлагатай ажилладаг. Захирлын урамшуулал нь өөрөө зарлага болчихсон энэ байдлыг бол таслан зогсоох ёстой.

Тийм учраас Төрийн өмчийн компанийн хуулийг Их Хурлаар оруулж ирээд ашиггүй ажиллаж байгаа, зарлагатай ажиллаж байгаа компаниудыг татан буулгах хэрэгтэй. Заримыг нь нэгтгэх хэрэгтэй.

Ингээд төр хуушуур хийх, хоол хийх, бараг хүүхдийг нь орж халамжлахаас бусдыг нь хийдэг болчихсон энэ байдлыг таслан зогсоож аутсорсинг хэлбэрээр хувийн хэвшил рүү энэ ажлуудыг шилжүүлэх ажлуудыг хийнэ.

Тэгээд энэ ажлыг та бүхнийг бас дэмжихийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна. Г.Очирбат гишүүний дараа санал хураалт эхэлнэ. Гишүүд танхимдаа цугларъя.

Тийм үү. П.Сайнзориг гишүүн тодруулга 1 минут.

П.Сайнзориг: Н.Учрал сайдын ярианаас хуулийг тун удахгүй оруулж ирнэ гэдэг дээр хэлж байх шиг байна. Үүнийгээ яаралтай оруулж ирмээр байна.

Би Ц.Даваасүрэн сайдын юман дээр бас яах вэ зүгээр ойлголоо. Тэгэхдээ Ц.Даваасүрэн сайд энэ уг нь тооцоо, судалгаатай. Та өөрөө бас уг нь Сангийн яаманд ажиллаж байсан. Энэ нэг, хоёр гишүүн чинь нөгөө бүсчилсэн хөгжлийн бодлогоо бариад нөгөө яг л одоо юу гэдэг юм аль нэг аймагт нь барьж байгаа юмыг нөгөө аймагт нь тавиулах гэж энэ бүсийн онцлогийг үл харгалзаж одоо энэ Улсын Их Хурлын тогтоолыг чинь барьж гүйнэ.

Ингээд бид нэг зүйлээрээ аймаар гоё зүйл ярьдаг. Нөгөө зүйлээрээ өөрөө өөрсдөө энэ парадокстоо орж байна.

Би уг нь ийм зүйлүүдийг уг нь Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал нь батлаад явчихдаг байх нь л зүйтэй гэж үзэж байгаа юм.

Энэ бол Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдаж байгаа зүйл биш шүү дээ. Ингэхгүй байх юм бол аж ахуй тооцоотой, төсөвтэй холбоотой юман дээр бүгд одоо тантай адилхан бяслагийн үйлдвэр энэ 21 аймаг чинь барина гээд гүйнэ. Ийм л юм руу бид хэд ингээд энэ хуулийг чинь дагаад болчихлоо шүү дээ.

Тэгэхээр өнөөдөр яг энэ сүүн бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйгаа аль хэсэгтээ хөгжүүлэх гээд байгаа юм.../минут дуусав/

Д.Амарбаясгалан:
Ц.Даваасүрэн гишүүн нэмж хариулъя.

Ц.Даваасүрэн: Ерөнхийлөгч хууль санаачлагч. Би Их Хурлыг яриагүй ээ. Ерөнхийлөгч хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлагч.

Тийм учраас энэ жагсаалтад ийм юм оруулъя гэдэг эрх бүгдэд нь байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ цэц дээр очвол уначихна.

Хоёрдугаарт, үгүй ээ тэгээд бяслагийн үйлдвэр бариуллаа гээд надад ял байдаг бол өг л дөө.

Тэгээд тэр хувийн хэвшлийнхэн барих гээд байгаа юм бол тэр бусад сумдаа барилдаа. Хөвсгөлд яах вэ би бариулчихъя. Монголчууд юмаа хийг, юм хийдэг болог, экспорт хийдэг болог. Дан ганц нүүрсээр амьдарч болохгүй байхгүй юу. Тийм мунхаг байж болохгүй шүү дээ.

Тэгээд Хятадын хараат болчихсон. 90 хувь хараат болчихсон. Хятадуудыг хооллоё л доо хэдүүлээ. Би хятадуудыг бяслагаар хооллох гээд л юм хийж байна.

Буруу нь юу байгаа юм. Хятадуудын гар хөл болдгоо болих хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна.

Г.Очирбат: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе.

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн иргэд танаас асуулт асуугаад өгөөч ээ гээд баахан мессеж ирээд байна.

Та өчигдөрхөн энэ төрийн зохицуулалттай эдийн засаг явах ёстой гэж хэллээ. Нийт татвар төлөгч аж ахуйн нэгж, иргэд энэ дээр нэлээн бухимдалтай байна.

Энэ дээр та нэг байр сууриа илэрхийлээд өгөөч. Нэг.

Хоёрдугаарт гэх юм бол одоо энэ хамт өргөн мэдүүлсэн хууль болон тогтоолтой холбоотой бид ярьж байгаад ямар ч байсан орлогын албан татварын эрхийг Их Хурал дээрээ авахаар болж байх шиг байна. Одоо Их Хурлын гишүүд дэмжчих байх.

Мөн дээрээс нь тэр Засгийн газрын бонд гаргахтай холбоотой 4 их наяд төгрөг гэж түгжиж өглөө.

Тэгээд тэр яг 4 их наяд чинь Төсвийн байнгын хороон дээр яригдсан уу? Б.Жавхлан сайд байвал бас яг энэ дээр тодорхой хариулчихмаар байна.

4 их наяд төгрөг гэдэг бол өөрөө асар их мөнгө шүү. Яг юунд зориулагдаж, яаж зарцуулагдаж байгаа юм бэ гэдэг дээр нэг мэдээлэл авчихмаар байна.

Тэгэхгүй бол ингээд нэг том том их наяд, их наядаараа ярьдаг. Хэн ч тоодоггүй.

Мөн дээрээс нь би сүүлийн 10-аад орчим иргэдтэй гадуур ажиллалаа. Ялангуяа Сонгинохайрхан, Баянгол дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Хан-Уул дүүргийн иргэдтэй хогийн цэг дээр бас очиж ажиллалаа.

Яг төсөвтэй холбоотой байр суурь ямархуу байдалтай байна вэ гэх юм бол одоо иргэд дээр ирж байгаа татварын дарамт ямархуу байна гэдэг асуултуудыг асууж явлаа.

Иргэд бол яг энэ төсөвтэй холбоотой хэлэлцүүлэг яваагүй ээ. Хуулиар 9 сарын 01-нээс 10-ны хооронд танилцуулах ёстой байтал нэг ч танилцуулга яваагүй гэж. Ялангуяа том том аж ахуйн нэгж эрхэлж байгаа хүмүүс болон жижиг, дунд үйлдвэрлэгч нар хэлж байгаа.

Б.Жавхлан сайд байвал Нэмэгдсэн өртгийн албан татварынхаа хууль дээр бас. Их Хурлын гишүүд бид энэ татвартай холбоотой хууль санаачилж болохгүй.

Тэгэхээр Засгийн газар ямар байр суурь барьж байгаа. Ялангуяа энэ жижиг бичил бизнес эрхэлж байгаа хүмүүс дээр илүү их дарамт ирээд байна. Жижиг ногооны тариалалт эрхэлдэг, мах оруулж ирээд зардаг малчид маань 50 сая хүртэлх дээр ингээд НӨАТ төлөгч биш болохоор эргээд тэрийг нь авч байгаа худалдаа эрхлэгч нар НӨАТ төлөгч бол гэсэн дарамт нэгдүгээрт ирдэг.

Хоёрдугаарт гэх юм бол тэрийг нь авчихсан хүмүүс буцаагаад нөгөө хэрэглэгч нар руу зарахад тэндээс анхны

эх үүсвэр дээр НӨАТ байхгүй байгаа. Цаашаа иргэд НӨАТ нэхээд байдаг. Ингээд НӨАТ-ын татварын дарамтад ороод байна гэж байгаа. Энэ дээр Засгийн газар Б.Жавхлан сайд ямар байр суурьтай байгаа гэдгийг нэгдүгээрт асуух гэсэн юм.

Хоёрдугаарт гэх юм бол энэ хүн амын орлогын албан татварыг хөнгөлж байгаатай холбоотойгоор Б.Жавхлан сайд бол амаараа хэлээд байгаа. Бүх аж ахуйн нэгж ингээд хамаарна гээд байгаа юм. Тэгээд яг энэ төслийг нь харахаар болохоор 2025 оны 01 сарын 01-нээс авхуулаад одоо юу гэдэг юм Бүсчилсэн хөгжилтэй хамаарал бүхий компаниуд л гээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бас яг тодорхой яг иргэдээ бүх шатанд нь бичил бизнес, дээрээс нь дунд бизнес, том бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд дээр ингээд бүгд дээр нь хамаарах юм гэсэн ийм мэдээлэл байвал өгчихмөөр байдаг.

Ингээд иргэд бол нэлээн ялангуяа одоо энэ манай С.Нарантуяа гээд манай Хархорин захын худалдааны эрхлэгч байна. Мөн дээрээс нь энэ Ононтуул гээд энэ бас махны худалдаа эрхэлдэг эрхлэгч байна. Энэ Баатар гээд одоо газар тариалан эрхэлдэг иргэн байна. Хүнсний захын энэ худалдаа эрхлэгч нь Номинтуяа.

Ингээд бүгдийг хэлж байгаа ерөөсөө нэг л санал байна. Одоо яг энэ хөнгөлөлт, татварын хүн амын орлогын албан татвар дээр хөнгөлөлт ярьж байгаа энэ эрхийг нь Их Хурал руу шилжүүлээд, авч байгаа цаг хугацаанд яг энэ дээр бүх энэ жижиг, дунд болон бичил бизнес эрхэлж байгаа иргэдээ татвараар ямар

бодлогоор дэмжих гэж байгаа юм бэ гэсэн асуулт байгаад байгаа юм.

Тэгээд энэ дээр нэг хариулаад өгчихвөл их зүгээр байна. Үндсэндээ ингээд танаас 4 асуулт асуулаа. Ц.Даваасүрэн даргаас.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулъя.

Ц.Даваасүрэн: Тийм. Та өөрийнхөө асуултад хамгийн сүүлийнхээ асуултаар хариулчихлаа. Тийм.

Үнэхээр одоо энэ хүнсний ногоо эрхэлж байгаа улсууд ч байна уу, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа улсуудыг татвараар бид дэмжих ёстой байхгүй юу.

Хятадаас орж ирж байгаа төмс дээр бид татвар тавьж байж энд төмс үйлдвэрлэж байгаа хүнээ хамгаална. Ялангуяа хүнсний аюулгүй байдлын үүднээс бид энэ хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг татвараар заавал хамгаалах ёстой.

Үүнийг төрийн зохицуулалт гэж байгаа юм.

Экспортын одоо бүтээгдэхүүн гаргаж байгаа хүнийг бид дэмжих хэрэгтэй. Татвараар дэмжих хэрэгтэй. Энэ төрийн зохицуулалт. Жишээлбэл, Япон, ер нь тэгээд бусад бүх орондоо ер нь одоо цагаан будаа дотацитай. Төрийн зохицуулалттай.

Оросын Холбооны Улсад будаа, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн 570 миллиард рублийн дотацитай. Өөрөөр

хэлэх юм бол 5 тэрбум долларын дотаци хөдөө аж ахуйдаа өгдөг. Энэ салбартаа.

Тэгэхээр ер нь зохицуулалт байнгын шаарддаг салбар ялангуяа хүнсний салбар байдаг.

Тийм учраас төрийн зохицуулалт байдаг. Төрийн зохицуулалтгүй улс орон гэж хаана ч байхгүй.

Тийм учраас би ялангуяа бид импортын хэрэглээ өндөртэй улсын хувьд тэр гаднаас авч байгаа бүтээгдэхүүнийг орлох үйлдвэрлэл хийж байгаа хүн байх юм бол тэрийгээ хамгаалж, импортын татвар тавьж өгч байх ёстой. Үүнийг төрийн зохицуулалт гээд байгаа юм.

Бусад тэр асуулт дээр манай Сангийн яам энэ тэр хариулсан нь дээр юм байна даа.

Д.Амарбаясгалан: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн хариулт өгье. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Б.Тэлмүүн: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн. Г.Очирбат гишүүний асуултад хариулья.

НӨАТ-тай холбоотой төсөв дагаж Засгийн газарт чиглэл өгч байгаа Улсын Их Хурлын тогтоол дээр НӨАТ-ын босгыг нэмэгдүүлэх асуудлыг судалж Улсын Их Хуралд танилцуул гэдэг ийм чиглэл өгөгдөж байгаа.

Одоогийн байдлаар жилийн 50 сая төгрөгийн борлуулалтын орлоготой тохиолдолд НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлдэг. Энэ босгыг нэмэгдүүлэх асуудлыг бид судалж байгаа.

Энэ хоёр талтай байдаг. Нэг дэх нь яг таны хэлснээр НӨАТ суутган төлөгч биш компаниуд нь НӨАТ суутган төлөгч компаниудтайгаа бизнесийн харилцаанд ороход хүндрэл учирдаг. Нөгөө компаниуд нь бид НӨАТ-ын баримт өгдөг, НӨАТ-тай худалдан авалт хийдэг компаниудтай харьцана гэдэг. Нэг талдаа.

Тэгэхээр энэ дээр жижиг компаниудын хувьд томрох боломжууд нь буурах ийм эрсдэл байдаг. Нөгөө талдаа НӨАТ-ын босго жижиг компаниуд дээр НӨАТ-ын тайлан гаргах.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Г.Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Ингэхээр чинь Л.Даваасүрэн дарга аа, дургүй байгаад байгаа ард иргэд, энэ төсөв дээр чинь.

Би анхны хэлэлцүүлэг дээр хэлж байсан. Өөрсдөөсөө манлайллаа эхлүүлье. Их Хурлын Тамгын газар, Ерөнхий сайд, Ерөнхийлөгч төсвөө 120 тэрбум хүртэл нэмэгдүүлсэн. Үүнийгээ эхлээд татчихъя. Энэ дээрээ багасгах бололцоо байвал явчихъя.

Нийт урсгал зардал дээрээ 15-аас 20 хувь ингээд танах бололцоотой байна. Үүнийгээ таначихъя гэсэн ийм юм гаргасан.

Тэгэхээр та өнөөдөр ингээд яг одоо юу гэдэг юм төрийн оролцоотой эдийн засаг гэдэг бол та нийт дотоодын нийт бүтээгдэхүүний 37.7 хувийг төр шийднэ гэххэд.

Дээрээс нь зээл аваад үзэх юм бол бараг Монгол Улсын зах зээл дээр эргэж

байгаа мөнгөний 60 хувийг төр шийднэ гэдэг бол жишээ нь бизнес эрхлэгч нарыгаа, татвар төлөгч нарыгаа, аж ахуйн нэгж, иргэдийгээ боож унагааж байгаа л гэсэн үг шүү.

Миний түрүүний санаа ингээд мушгиад байна. Яг тэнд байгаа дунд нь үлдсэн хүмүүс бид ямар бодлогоор зохицуулалт хийх юм бэ гэдэг санаа л яваад байгаа юм. Яагаад гэхээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн нэмж хариулья.

Ц.Даваасүрэн: Гишүүн ээ, ийм шүү дээ. Төсвийн мөнгө хаашаа очих вэ гэж. Төсвийн зарлагын мөнгө хаашаа очих вэ гэж. Бизнес рүү л очно шүү дээ.

Төрийн албаны цалин хаашаа очих вэ. Худалдан авалт хийгээд бизнес рүү л очно шүү дээ. Төсвийн байгууллагын мөнгө хаашаа очих вэ. Ялгаа байхгүй одоо тэгээд л тэр эд хогшил авч байгаа бол бас нэг бизнесийг л худалдан авалт хийж байгаа биз дээ. Энэ хэтэрч болохгүй л байхгүй юу даа.

Түүнээс биш тэтгэврийн хөгшний мөнгө хаашаа очих юм. Бизнес рүү л очно. Худалдан авалт л хийнэ шүү дээ.

Тэгэхээр энэ зүгээр зарим зах зээлд бол нэг ийм юм байгаа юм. Хэрвээ хэрэглээгээ тэлж эдийн засгаа тэлж болно. Энэ чинь энэ байхгүй юу. Хэрэглээгээ өсгөж бизнесээ дэмжинэ гэж. Бизнесийн борлуулалт л нэмэгдэнэ шүү дээ.

Гэтэл нэг асуудал манайд байгаа юм. Валют. Бид өөрсдөө ерөөсөө ингээд

валютын эх үүсвэр ганцхан нүүрснээс хамаарч байгаа.

Хэрэглээ өсчхөөд харин валютын нөөц чинь хүрэлцэхгүй болчихвол валютын ханш чинь унаад инфляцид явчхаад байгаа байхгүй юу. Түүнээс биш зардал.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт хангалтгүй гэж үзвэл нэмэлт 1 минут өгөх боломжтой. Тийм ээ. Түрүүн П.Сайнзориг гишүүнийх бол үг хэлсэн учраас хариулт өгөөгүй шүү.

Г.Очирбат гишүүн.

Г.Очирбат: Яг наад байдал дээрээс чинь та өөрөө юмаа ерөөсөө ойлгохгүй байна шүү.

Таны хамаарал бүхий дарга нар албан тушаал дээр очоод тендер зарлаад, таны хамаарал бүхий гээд. Та өөрөө хариулсан болохоор тан дээр гэж би жишээ татаж ярьж байгаа шүү.

Хамаарал бүхий хүмүүс чинь тэр тендерийг шалгаруулаад, тантай хамаатай 2028 оны сонгууль руу энэ мөнгө чинь явж орж байгаа. Яг үнэнийг чинь л бодитойгоор хэлье.

Тэгээд юм хэлээд энэ аж ахуйн нэгжээ дэмжээ, бизнесүүдээ дэмжье гэхээр дэмжиж байгаа, төрөөр дамжуулж худалдан авалтаар нь дэмжиж байгаа гээд байгаа юм.

Үүнийг чөлөөт эдийн засаг гэдэг юм уу. Үүнийг төрийн оролцоотой эдийн засаг гэдэг юм. Таны хэлээд байгаа.

Төрийн оролцоотой эдийн засаг гэдэг бол хамаарал бүхий албан

тушаалтан, дарга, цэрэг нар өөрийнхөө төсвийг хамгаалдаг, өөрийнхөө хамаарал бүхий компаниар төсөв авдаг, тэндээсээ ашгаа хүртдэг. 5, 10 хувь чинь ерөөсөө л тэр шүү дээ. Нэгд.

Хоёрт, гэх юм бол одоо энэ төсөв дээр ч гэсэн шинэ 32-хон төсөл байгаа гээд байгаа юм. 602 төсөл чинь сүүлийн 10 жилийн.

Би хамгийн эхний чуулган дээр л хэлж байсан. Хамгийн сүүлийн 10 жилд идэж уусан юмаа дарах гэж л хийж байгаа шүү дээ. Одоо.

Бодитой юм хэдүүлээ ярья л даа.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй 5 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж дэмжсэн болон дэмжээгүй, дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно гэж байгаа юм.

Намын бүлгүүдээс ирүүлсэн болон одоо бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс нэр өгсөн дарааллын дагуу үг хэлэхээр байгаа.

Энэ чинь санал тус бүр дээр шүү дээ. Тийм ээ. Нэрс ирээгүй байна. /алх цохив/

Тэгвэл санал хураалт.

Өнөөдөр олон санал хураалт явагдахаар байгаа.

Тэгэхээр төхөөрөмж дээр зарим гишүүд хурууныхаа хээг уншуулж чадсангүй, саналаа өгч чадсангүй гээд янз янзын бас асуудлууд үүсдэг учраас өнөөдрийн санал хураалтыг бүгдийг нь гар өргөж санал хурааж явъя гэж бодож байна.

Дэгийн зохицуулалтаараа ил санал хураалтыг гар өргөж болон төхөөрөмжөөр явуулна гэж заасан байдаг учраас гар өргөж санал хураалтаа явуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:

Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.14 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.14.Энэ хуулийн 22.5.22-т заасан төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална.”

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Нэг дээрээ санал хураана.

Төсвийн байнгын хорооны гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гар өргөж санал хураана. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд бас гараа өргөх нь зөв байх аа. Тийм ээ. Дэмжээгүй гишүүд ээ бас тоолж байх нь зөв.

Дэмжээгүй гишүүд гараа өргөө.

Нэг, хоёр, гурав. 3 гишүүн дэмжээгүй байна.

Санал хураалттай холбогдож горимын санал гаргах юм уу?

Д.Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Дарга аа, цахимаар явахаар жишээлбэл ирээгүй хүмүүс нь сөрөг санал өгдөг шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээр сая эсрэг санал өгч байгаа хүмүүс нь гар өргөчихөөр ирээгүй хүмүүсийг гар өргөсөн гэж тоолж байгаа юу, эсвэл үүнийг яаж тоолж байгаа вэ?

Хэрвээ дэгээр хоёр тооллого чинь зарчмын хувьд өөр болоод байгаа учраас. Үүнийг зүгээр тодорхой болгочихвол зүгээр юм уу гэсэн ийм санал байна.

Д.Амарбаясгалан: Дэмжсэн гишүүд энд нэрсээрээ гарчихна.

Ирцэд бүртгэгдсэн мөртлөө байхгүй байгаа гишүүд эсрэг саналаараа гардгаараа гарна.

Тэгэхээр нийт гишүүдээс санал хураалт явж байгаа гэдгийг тайлбарлаж хэлье.

Хоёр.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “38.6” дахь хэсэг нэмэх:

“38.6.Энэ хуулийн 38.4-т хамаарах боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг Улсын Их Хурал батална.”

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. Алга байна. Танхимд байгаа гишүүдийн 100 хувийн саналаар.

П.Сайнзориг гишүүн дэмжээгүй байна. 108-аас 72 гишүүн дэмжсэн байна. 108 гишүүн бүртгэгдсэн. 72 гишүүн санал хураалтад оролцсон. Дэмжсэн байна.

Гурав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн 12 дахь заалтыг хасах.

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөө. 6, 7, 8 гишүүн дэмжээгүй байна. 8 гишүүн дэмжээгүй байна.

Үг авах боломжгүй.

Дөрөв. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1.Төслийн 1 дэх заалтын “2025 онд” гэсний дараа “4.0 их наяд хүртэл төгрөгтэй тэнцэх хэмжээний” гэж нэмэх.

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүдийг гараа өргөхийг хүсье. 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10. 10 гишүүн дэмжээгүй байна.

106 гишүүнээс 64 гишүүн дэмжиж байгаа юм байна. 10 гишүүн татгалзлаа.

Тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1.Төсөлд доор дурдсан агуулгатай “1 дэх заалт” нэмэх:

“1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник-эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим сан бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

2/нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийн, аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, саналаа 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах.”

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье.

Танхимд байгаа гишүүд 100 хувь дэмжлээ.

106-аас 78 гишүүн дэмжсэн байна.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах тогтоолын төслүүдийг батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудал.

Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Зургаа.Хуулийн төслүүдийг эцэслэн батална

Нийт 9 төсөл байгаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д “долоо хоногийн Баасан гарагийн 10.00 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно.” гэж заасны дагуу хуулийн төслүүдийн эцэслэн батлуулах хувилбарыг Төсвийн байнгын хороо бэлтгэж эцэслэн батлуулахад бэлэн болсон байна.

Одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж эхэлнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 44.2-т “...нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно.” гэж заасан байгаа.

Тэгэхээр 64 гишүүн дэмжсэнээр хууль эцэслэн батлагдана гэдгийг тодруулж хэлбэ.

Санал хураалт эхлүүлье.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө.

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. 1, 2, 3, 4. 4 гишүүн дэмжээгүй байна. 74 гишүүн дэмжсэн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн

1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье.

Танхимд байгаа 78 гишүүн дэмжиж санал өглөө. Эцэслэн батлагдлаа.

2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье.

1 гишүүн дэмжээгүй. 77 гишүүн дэмжсэн байна.

3. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье.

1. 79 гишүүн танхимд байна. 78 дэмжлээ.

4. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

79 гишүүн танхимд байна. 79 дэмжлээ.

5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье.

1, 2, 3 гишүүн. 76 гишүүн дэмжсэн. Танхимд байгаа гишүүдээс.

6. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье.

1, 2, 3, 4, 5. 79 гишүүнээс 5 гишүүн дэмжээгүй, 74 гишүүн дэмжиж эцэслэн батлагдаж байна.

7. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье.

79 гишүүн санал хураалтад оролцож 79 дэмжлээ.

Уучлаарай. 106 гишүүн санал
хураалтад оролцож, 79 дэмжлээ.

1 гишүүн дэмжсэнгүй. 106
гишүүнээс 78 гишүүн дэмжлээ.

8. “Тогтоолын хавсралтад нэмэлт
оруулах тухай” Улсын Их Хурлын
тогтоолын төслийг баталъя гэсэн саналын
томъёоллоор санал хураалт явуулна.
Санал хураалт. /алх цохив/

Хууль, тогтоолын төслүүд
батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд,
Ажлын хэсэгт баярлалаа.

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд
гараа өргөхийг хүсье.

Дараагийн асуудалд оръё.

**Долоо. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,
дөрөв дэх хэлэлцүүлэг/**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны
төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн
даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн дөрөв дэх хэлэлцүүлгийг
явуулна.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Одоо шууд санал хураалт эхэлнэ
шүү. Шууд санал хураалт явна.

Ажлын хэсгийн гишүүд хэвээрээ байгаа юм байна.

Төсвийн байнгын хороо төсвийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгэн
гишүүдэд тараасан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл зүйл, заалт бүрийг уншин
сонгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Санал хураалт. Дэмжье гэсэн гишүүд гараа өргөхийг хүсье. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. Даваагийн Цогтбаатар, Ч.Лодойсамбуу, Сайнхүүгийн Ганбаатар. 3 гишүүн дэмжээгүй байна.

106 гишүүнээс 74 гишүүн дэмжлээ.

2 дугаар зүйл.Монгол Улсын 2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Монгол Улсын 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. 1, 2. 2 гишүүн дэмжээгүй. 106-аас 78 гишүүн дэмжлээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХӨРӨНГӨ, ӨРИЙН УДИРДЛАГА

3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлого төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	185.0 185.0
2	Монгол Улсын Их Хурлын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.0 100.0
3	Монгол Улсын Ерөнхий сайд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	106,372.5 101,600.0 4,772.5

4	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	510.0 510.0
5	Монгол Улсын Ерөнхий аудитор Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	831.3 831.3
6	Төрийн албаны зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	200.0 200.0
7	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,000.0 4,000.0
8	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,388.3 2,388.3
9	Монгол Улсын Шадар сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	21,934.3 21,934.3
10	Монгол Улсын Шадар сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	115.9 115.9
11	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	300.0 300.0
12	Гадаад харилцааны сайд Дипломат төлөөлөгчийн газрууд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	16,100.0 13,000.0 3,100.0
13	Сангийн сайд Татварын ерөнхий газар үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	21,597,298.5 12,876,186.8 608,889.9 8,046,540.0 248,209.1 417,000.0 9,362.6
14	Хууль зүй, дотоод хэргийн сайд Улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар Шүүх шинжилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	81,156.8 45,730.0 2,370.0 300.0 1,052.5 31,704.4
15	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ашигт малтмал, газрын тосны газар Үндэсний геологийн алба Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	412,848.1 407,301.1 120.0 5,427.0
16	Батлан хамгаалахын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	43,187.2 43,187.2

17	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,320.7 2,320.7
18	Боловсролын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,534.8 5,534.8
19	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	304.0 304.0
20	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	75,221.6 1,000.0 3,035.1 71,186.4
21	Зам, тээврийн сайд Иргэний нисэхийн ерөнхий газар Зам, тээврийн хөгжлийн яам Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	110,656.0 80,000.0 300.0 30,356.0
22	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	54,173.6 54,173.6
23	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,663.3 8,663.3
24	Эрүүл мэндийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	7,945.3 7,945.3

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. 1, 2, 3, 4, 5, 6.

Нийт 69 гишүүн дэмжсэн байна.

4 дүгээр зүйл. Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого 23,140,589.3 сая төгрөг байна.

Санал хураалт. /алх цохив/

Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. 3 гишүүн дэмжээгүй байна.

71 гишүүн дэмжсэн байна.

5 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх үндсэн төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	387,133.9

2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	20,600.7
3	Боловсролын сайд	30,000.0
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	17,499.1

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. 1 гишүүн дэмжээгүй байна.

76 гишүүн дэмжсэн байна.

6 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсөв зарцуулна:

6.1. Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	39,753.6
	Урсгал зардал	38,753.6
	Хөрөнгийн зардал	1,000.0
2	Монгол Улсын Их Хурлын дарга	191,022.2
	Урсгал зардал	175,422.2
	Хөрөнгийн зардал	15,600.0
3	Монгол Улсын Ерөнхий сайд	630,245.6
	Урсгал зардал	370,196.5
	Хөрөнгийн зардал	260,049.0
4	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	6,068.7
	Урсгал зардал	6,068.7
5	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	32,895.7
	Урсгал зардал	27,295.7
	Хөрөнгийн зардал	5,600.0
6	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	343,468.2
	Урсгал зардал	276,428.7
	Хөрөнгийн зардал	67,039.5
7	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга	15,574.9
	Урсгал зардал	12,184.9
	Хөрөнгийн зардал	3,390.0
8	Улсын ерөнхий прокурор	161,897.3
	Урсгал зардал	131,095.6
	Хөрөнгийн зардал	30,801.7
9	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	23,320.2

	Урсгал зардал	23,320.2
10	Монгол Улсын Ерөнхий аудитор	56,839.7
	Урсгал зардал	54,066.2
	Хөрөнгийн зардал	2,773.5
11	Авлигатай тэмцэх газрын дарга	58,246.7
	Урсгал зардал	55,540.4
	Хөрөнгийн зардал	2,706.3
12	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	22,425.0
	Урсгал зардал	22,175.0
	Хөрөнгийн зардал	250.0
13	Төрийн албаны зөвлөлийн дарга	21,881.0
	Урсгал зардал	21,881.0
14	Үндэсний статистикийн хорооны дарга	36,935.1
	Урсгал зардал	34,435.1
	Хөрөнгийн зардал	2,500.0
15	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	18,561.5
	Урсгал зардал	18,561.5
16	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	1,436.2
	Урсгал зардал	1,436.2
17	Шүүхийн сахилгын хорооны дарга	6,440.5
	Урсгал зардал	6,140.5
	Хөрөнгийн зардал	300.0
18	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	328,824.2
	Урсгал зардал	126,178.7
	Хөрөнгийн зардал	202,645.5
19	Монгол Улсын Шадар сайд	404,765.9
	Урсгал зардал	333,245.5
	Хөрөнгийн зардал	71,520.4
20	Монгол Улсын Шадар сайд	8,558.7
	Урсгал зардал	8,558.7
21	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	153,264.5
	Урсгал зардал	128,433.8
	Хөрөнгийн зардал	24,830.7
22	Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга	24,107.4
	Урсгал зардал	19,291.2
	Хөрөнгийн зардал	4,816.2
23	Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга	31,893.0
	Хөрөнгийн зардал	31,893.0
24	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн	15,893.5

	Үндэсний хорооны дарга	
	Урсгал зардал	6,723.2
	Хөрөнгийн зардал	9,170.3
25	Гадаад харилцааны сайд	275,902.5
	Урсгал зардал	245,381.8
	Хөрөнгийн зардал	30,520.7
26	Сангийн сайд	5,778,970.6
	Урсгал зардал	2,925,807.6
	үүнээс: Зээлийн хүүгийн төлбөрт	1,303,370.7
	Хөрөнгийн зардал	227,163.0
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	2,626,000.0
27	Хууль зүй, дотоод хэргийн сайд	1,817,187.0
	Урсгал зардал	1,687,438.3
	Хөрөнгийн зардал	129,748.7
28	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	70,836.1
	Урсгал зардал	29,606.1
	Хөрөнгийн зардал	41,230.0
29	Батлан хамгаалахын сайд	853,371.5
	Урсгал зардал	769,029.4
	Хөрөнгийн зардал	84,342.1
30	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	337,772.2
	Урсгал зардал	246,282.4
	Хөрөнгийн зардал	91,489.8
31	Боловсролын сайд	4,573,880.2
	Урсгал зардал	4,074,286.7
	Хөрөнгийн зардал	499,593.5
32	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	4,556,107.0
	Урсгал зардал	4,501,834.7
	Хөрөнгийн зардал	54,272.3
33	Зам, тээврийн сайд	1,598,809.3
	Урсгал зардал	25,815.3
	Хөрөнгийн зардал	1,572,994.0
34	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	596,006.7
	Урсгал зардал	432,332.7
	Хөрөнгийн зардал	163,674.0
35	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	495,329.5
	Урсгал зардал	101,157.2
	Хөрөнгийн зардал	394,172.3
36	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	830,563.9
	Урсгал зардал	777,483.4
	Хөрөнгийн зардал	53,080.5
37	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	130,343.2

	Урсгал зардал	90,086.8
	Хөрөнгийн зардал	40,256.4
38	Эрчим хүчний сайд	310,328.5
	Урсгал зардал	115,835.3
	Хөрөнгийн зардал	194,493.2
39	Эрүүл мэндийн сайд	1,857,765.2
	Урсгал зардал	1,660,125.6
	Хөрөнгийн зардал	197,639.6

6.2. Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр доор дурдсан хэмжээтэй санхүүжилт олгоно:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	41,165.2
2	Боловсролын сайд	31,036.3
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	99,831.9
4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	5,000.0
5	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	45,985.7

Санал хураалт. /алх цохив/ Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд байна уу? 4.

62 гишүүн дэмжлээ.

7 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 26,485,278.0 сая төгрөг байна.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. 3.

62 гишүүн дэмжлээ.

8 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 3,932,432.9 сая төгрөгөөр санхүүжүүлнэ.

Санал хураалт. /алх цохив/

Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. 2 гишүүн дэмжээгүй.

65 гишүүн дэмжсэн байна.

9 дүгээр зүйл. "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд 131,200.6 сая төгрөгийн эргэн төлөлт хийнэ.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөө. 1 гишүүн дэмжээгүй байна.

66 гишүүн дэмжсэн байна.

10 дугаар зүйл. 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл 1,596,178.2 сая төгрөг байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2025 оны төсвийн жилд 608,889.9 сая төгрөг хуримтлуулна.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. 1 гишүүн дэмжээгүй байна.

66 гишүүн дэмжлээ.

11 дүгээр зүйл. 2025 оны төсвийн жилд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг доор дурдсанаар баталсугай:

11.1.Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.1, 12.1.3, 12.1.6 болон 28¹.1-д заасан зориулалтаар хийх гадаад, дотоод зээллэгийн дээд хэмжээг 300,000.0 сая төгрөг хүртэл;

11.2.Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 2,209,000.0 сая төгрөг хүртэл.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. 1 гишүүн дэмжээгүй байна.

68 гишүүн дэмжлээ.

12 дугаар зүйл. Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2025 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 1,932,825.6 сая төгрөг байна.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье. 2.

68 гишүүн дэмжлээ.

13 дугаар зүйл. Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ 2025 оны төсвийн жилд 3,500,000.0 сая төгрөг байна.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье. 2.

68 гишүүн дэмжлээ.

14 дүгээр зүйл. Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2, 12.1.4-т заасан зориулалтаар Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье. 1 гишүүн.

69 гишүүн дэмжлээ.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ОРОН НУТГИЙН
ТӨСВӨӨС ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН
САН БОЛОН УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ
ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ**

15 дугаар зүйл. 2025 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэг олгоно:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	52,186.4
2	Баян-Өлгий	34,200.2
3	Баянхонгор	41,955.9
4	Булган	24,117.3
5	Говь-Алтай	34,310.4
6	Дорнод	2,424.5
7	Дундговь	24,007.4
8	Завхан	53,371.4
9	Өвөрхангай	42,994.9

10	Сүхбаатар	28,334.3
11	Төв	9,001.9
12	Увс	42,073.9
13	Ховд	19,295.9
14	Хөвсгөл	60,435.3
15	Хэнтий	47,348.3
16	Говьсүмбэр	11,725.4
Нийт дүн		527,783.5

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

16 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Дорноговь	10,478.0
2	Өмнөговь	1,754,708.7
3	Сэлэнгэ	94.8
4	Дархан-Уул	1,362.8
5	Орхон	136,487.8
Нийт дүн		1,903,132.1

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

70 гишүүн дэмжсэн байна.

17 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Аймаг, хот	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	14,505.7
2	Баян-Өлгий	14,026.3
3	Баянхонгор	23,502.4
4	Булган	15,258.1

5	Говь-Алтай	24,990.2
6	Дорноговь	55,686.9
7	Дорнод	30,428.3
8	Дундговь	18,250.4
9	Завхан	17,294.9
10	Өвөрхангай	17,299.9
11	Өмнөговь	60,770.5
12	Сүхбаатар	26,562.7
13	Сэлэнгэ	31,299.0
14	Төв	28,947.2
15	Увс	16,422.8
16	Ховд	30,475.8
17	Хөвсгөл	20,848.6
18	Хэнтий	23,761.1
19	Дархан-Уул	21,288.8
20	Улаанбаатар	60,333.0
21	Орхон	38,727.7
22	Говьсүмбэр	8,374.3
Нийт дүн		599,054.5

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

Нийт 71 гишүүн дэмжсэн байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл.“Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье. 1 гишүүн дэмжээгүй байна.

70 гишүүн дэмжлээ.

19 дүгээр зүйл.“Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье. 1 гишүүн дэмжээгүй байна.

70 гишүүн дэмжлээ.

20 дугаар зүйл.“Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд эргэн төлөлт хийх концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

21 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

Хуулиа бүхэлд нь батлах санал хураалт явна.

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулна.

Нийт гишүүдийн олонхоор санал дэмжигдэх ёстой. Санал хураалт. /алх цохив/

Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье. 2 гишүүн дэмжсэнгүй.

69 гишүүн дэмжлээ.

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй холбоотой санал хураалт явуулна. 4 хууль байна.

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгох, хуримтлал үүсгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

69 гишүүн дэмжлээ.

2 дугаар зүйл.Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

69 гишүүн дэмжлээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО

3 дугаар зүйл.Үндэсний баялгийн санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхий сайд	507,114.8
	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	507,114.8
	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.2-т заасан уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ногдол ашиг	507,114.8
	Үүнээс: Хуримтлалын санд	507,114.8
2	Сангийн сайд	1,849,712.5

Татварын ерөнхий газар	1,849,712.5
Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.а-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгээс 40 хувь	1,849,712.5
Үүнээс: Ирээдүйн өв санд	1,849,712.5
Нийт орлого	2,356,827.3

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье. 1 гишүүн дэмжээгүй байна. 69 гишүүн дэмжлээ.

4 дүгээр зүйл. 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 3,687,339.3 сая төгрөг байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу Ирээдүйн өв санд 2025 оны төсвийн жилд 1,849,712.5 сая төгрөг хуримтлуулна.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн байна уу? Алга байна.

70 гишүүн дэмжлээ.

5 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу Хуримтлалын санд 2025 оны төсвийн жилд 562,125.2 сая төгрөг хуримтлуулна.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье. 1 гишүүн дэмжээгүй байна.

69 гишүүнээр дэмжигдлээ.

6 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562,125.2 сая төгрөгөөр баталсугай.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

69 гишүүн дэмжлээ.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье. Алга байна.

69 гишүүн дэмжлээ.

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж, сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулсан.

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулна. Нийт гишүүдийн олонхоор шийдэгдэнэ. Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье. 1 гишүүн дэмжсэнгүй.

68 гишүүнээр хууль эцэслэн батлагдлаа.

Одоо Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж, сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

69 гишүүнээр санал дэмжигдлээ. 70 болсон уу?

70 гишүүнээр санал дэмжигдлээ.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

70 гишүүн дэмжлээ.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА**

4 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	6,943,759.9
1.1	Ажил олгогчийн төлөх шимтгэл	2,844,337.7
1.2	Ажиллагчдаас төлөх шимтгэл	2,291,157.4
1.3	Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл	14,543.1
1.4	Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	146.6
1.5	Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	295,822.0
1.6	Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	6,158.8
1.7	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	2,353.8
1.8	Бусад орлого	36,740.6
1.9	Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас	1,452,499.9
Нийт орлого		6,943,759.9

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	67,232.2

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

5 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	5,882,758.8
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	5,391,992.2
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	281,082.7
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	66,698.6
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	142,985.3
Нийт зарлага		5,882,758.8

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсугай.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулна. Нийт гишүүдийн олонхоор 64 гишүүнээр дэмжигдэнэ.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж, сонсгож, зүйл тус бүрээр нь санал хураалт явуулна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

70 гишүүн дэмжлээ.

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжиж санал өглөө.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН
2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА**

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	2,525,575.8
	1.1 Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	1,156,409.8
	1.2 Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	353,036.7
	1.3 Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	966,297.8
	1.4 Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	49,831.5
Нийт орлого		2,525,575.8

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	77,600.0

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

5 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	2,293,894.9
1.1	Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт	985,316.6
1.2	Төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	1,119,081.9
1.3	Эмийн санд олгох	171,485.3
1.4	Үйл ажиллагааны урсгал зардал	18,011.0
Нийт зарлага		2,293,894.9

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалтыг явуулна. Нийт гишүүдийн олонхоор буюу 64-өөс дээш гишүүдээр дэмжигдэнэ.

Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүн гараа өргөхийг хүсье.

71 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Хуулийн төслүүд батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Дараагийн асуудалд орно.

**Найм. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан
авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/анхны хэлэлцүүлэг/**

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна.

Индэрт урьж байна.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал, дүгнэлт гарган Та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл баталсантай холбогдуулан төсвийн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс гаргасан санал, шаардлагыг харгалзан

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасны дагуу улсын төсөв, макро эдийн засгийн төлөв байдал болон төсвийн тусгай шаардлагыг баримтлахад нөлөөлөх талаар үнэлгээ хийж Монгол Улсын Их Хуралд танилцуулах, Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу төсвийн тодотголын төслийг 2024 оны 12 дугаар сард багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төсвийн тодотголын төслийг төрийн мөнгөний бодлогод нийцүүлэн төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөлтийг сайжруулах, төсвийн зарлагыг нэмэгдүүлснээр нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоолж, төсвийн урсгал зардлыг бууруулах чиглэл баримтлан боловсруулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар дээрх тогтоолын төсөлд тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал тогтоолын төсөлд төсвийн тодотгол өргөн мэдүүлэх хугацааг тусгахгүй байх, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг төсвийн тодотголын төслийг 2025 оны 1 дүгээр улиралд өргөн мэдүүлснээр төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болох тул хугацааг өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Т.Аубакир нар төсвийн тодотголын төслийг 2024 оны 12 дугаар сард багтаан өргөн мэдүүлэх

талаар, Улсын Их Хурлын гишүүн Төсвийн тодотголын төслийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан өргөн мэдүүлэх талаар санал гаргаж үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасныг баримтлан Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

7 гишүүнээр тасаллаа.

Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууна.

Н.Номтойбаяр: Асуулт алга. Үгээ хэлье.

Ер нь улсын төсөв хэлэлцэж байх үед шууд залгуулаад тодотгол хийх нөхцөл байдал үүсэж байгаагүй. Тэгээд эргээд яагаад ийм нөхцөл байдал үүсэв гэхээр төсөв Засгийн газраас хуулийнхаа хугацаанд өргөн баригдсан. Их Хурлын гишүүд Их Хурлаас төсвийн ажлын хэсэг гарахад албан ёсоор бичгээр болон ажлын хэсэгт байгаа гишүүд саналаа өгнө гэдэг байр суурьтайгаар явсан.

Харамсалтай нь ажлын хэсэг ерөөсөө хуралдаагүй. Цагийг нь тулгаж байгаад нэг л өдөр ажилласан.

Ингээд энэ маргаан явж явж өнөөдрийн энэ нөхцөл байдал үүсэж байгаа юм.

Тэгээд Д.Амарбаясгалан даргын хувьд бас энэ асуудлыг улс төрийн зөвшилцлөөр шийдье гэж санаачилга гаргаад явж байгаад баярлаж байна.

Нөгөө талдаа төсвийн урсгал зардлаас 3.6 их наядыг хасъя гэж анх санаачилга гаргасан Д.Энхтүвшин, Ж.Баярмаа, Г.Тэмүүлэн нарын хэдэн гишүүд бий.

Тэгээд зөвшилцөл маань энэ хүрч байна.

Гэхдээ энд нэг зүйлийг бас онцгойлон яримаар байна.

Яг үнэндээ төсвийн ажлын хэсэг ажиллаагүй. Яагаад энэ нөхцөл байдал үүссэн Ц.Даваасүрэн гишүүн тань дээр бүх асуудал очно.

Үндсэн хуулиар олгогдсон Их Хурлын бүрэн эрх зөрчигдөөд байна. Та

Засгийн газрын БЭТ_[бүрэн эрхт төлөөлөгч] биш ээ.

Тэгээд энэ тогтоолын төсөл батлагдлаа гээд энэ ондоо багтаад төсөв тодотголоо хийх ажлын хэсэг гаргаад явж таараа.

Таныг Төсвийн байнгын хорооны дарга байгаа цагт энэ бол амжилт олохгүй. Ц.Даваасүрэн гишүүн ээ, олохгүй. Энэ бол худлаа. Гөлөг төөрүүлж байгаа юм шиг л болно.

Үгүй, тийм шүү дээ, үнэн шүү дээ. Тантай би энэ Их Хуралд олон жил сууж байна. Ажлын чинь арга барил, тэр залиг чинь маш сайн мэднэ.

Тэгэхээр Ардын намын бүлэг энэ хариуцлагын асуудлаа дотроо ярьчихмаар байна.

Төсвийн байнгын хорооны гишүүд Төсвийн байнгын хорооныхоо даргыг зайлуулчихмаар байна. Асуудалд арай эрүүлээр ханддаг, гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийг сонсдог, байр суурийг нь бодит ажил хэрэг болох дээр ажилладаг, аливаа юмыг нэг хайрцаглаад зальдаад, гөлөг төөрүүлж байгаа мэт яваад байдаггүй нэг ийм хүнтэй болчихооч.

Ийм л санал дэвшүүлмээр байна.

Эцсийн дүндээ төсөв батлагдмагц төсвийн тодотголын асуудал дагаж орж ирж байсан түүх Монголын төрд ердөөсөө байхгүй. Тэгэхдээ яах аргагүй ийм нөхцөл байдал үүсчхээд байна.

Тэгэхээр дахиад ийм асуудал үүсэхгүй байх үүднээс бид энэ

хариуцлагынхаа асуудлыг давхар ярих ёстой.

Тэгэхээр Их Хурлын дарга аа, үүнийг та бас нэг онцгой анхааралдаа аваадхаач.

Их Хурлын дарга аа, ийм л санал дэвшүүлье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Зөв өө зөв. Энэ парламент дээр яах вэ бид ажил сайжруулах чиглэл дээр анхаараад хамтарч ажиллах боломжуудаа эрэлхийлэх нь зөв өө.

Ц.Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Би хариулахаас манай ажлын хэсэгт ажилласан гишүүд хариулсан нь дээр дээ.

3, 4 удаа бид хуралдсан байгаа.

Тэгэхдээ гудамжны хулигаан шиг ингэж худлаа ярьдгаа боль. Миний дүү. Чи засраагүй байгаа юм байна шүү дээ.

Тэгээд Их Хуралд орж ирчхээд л ингээд солироод л.

3 удаа хуралдсан. Чи тэр эндүүрээд байгаа чинь Төсвийн байнгын хорооны хурал байхгүй юу.

Зарлагын хяналтын дэд хороо хуралдаж байж манай Байнгын хороо хоёр дахь хэлэлцүүлгээ хийх ёстой учраас би гурван удаа цаг зарласан. Чи тэрийг эндүүрээд байна.

Зарлагын хяналтын дэд хороо хуралдаж байж төсвийн хоёр дахь хэлэлцүүлэг явна. Чи уг нь хуучин бас Их

Хуралд сууж байсан. Үүнийгээ уг нь нэг гадарлахтайгаа л баймаар юм.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Үгүй үгүй. Асуулт хариулт алга байна шүү дээ. Тийм. Тодруулах минутыг. Тийм. Яах юм бэ, яах юм.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна.

О.Номинчимэг: Гишүүд ээ, энэ нэг их тийм инээдэм ханиадам болоод байгаа ч юм хэрэггүй шүү дээ.

Асуултаа асууя.

Д.Амарбаясгалан:
О.Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Ер нь хувь хүнийхээ хувьд энэ удаагийн төсөв дээр төсвийн ажлын хэсэг муу ажилласан гэдэгтэй бид санал нэг байгаа.

Ер нь хангалттай хэлэлцүүлэг, мэдээллээр хангагдаагүйн улмаас л бид ийм нөхцөл байдалд хүрчээд байгаа гэж би хувьдаа дүгнэж байгаа.

Сая бид төсвөө яах вэ баталчихлаа.

Тэгээд төсвөө заавал 15-нд батлах ёстой. 15-наас өмнө.

Түүнээс хойш авах юм бол Улсын Их Хурал тарна гээд Үндсэн хуулиа зөрчсөн, Үндсэн хуулиа мэдэхгүй хариултауд өгч байгаа нь харамсалтай байна.

Тэгээд дэгийн хуулиараа Тамгын газар хэрвээ 15-наас хойш батлах юм бол дэг байхгүй, дахиж хэлэлцэх дэг байхгүй

гээд хуулийн асуудал ярьж байгаа юм бол бид дараагийн авах арга хэмжээгээ ч гэсэн хуулийн дагуу хиймээр байна.

Тэгэхээр дагалдуулж орж ирж байгаа тогтоолын төслөөс асуумаар байгаа юм.

2 дугаар хэсэг дээр төсвийн тухай хуулийн 34.1-д заасны дагуу төсвийн тодотголыг 12 сард өргөн барь гэхсэн байна.

Бид анх удаагаа бараг хэрэгжиж эхлээгүй төсөв дээр тодотгол хийх гэж байна.

Тэгээд энэ 34.1-ийн яг төсөв тодотгох үндэслэлүүдийн яг алинаар нь явна гэж ер нь ажлын хэсгийнхэн маань үзсэн юм.

Төсвийн орлого зарлагаа дээш, доош нь нэмэх гэж байгаа юм уу?

Хэрэгжиж эхлээгүй төсөв дээр бид үүнийгээ яаж тооцоолох гэж байгаа юм?

Ямар үндэслэл барьж бид энэ төсвийн тодотголоо 12 сард, Улсын Их Хурал тэрийг нь хүлээж аваад хэлэлцэнэ гэсэн байдалтайгаар бид өнөөдөр энэ тогтоолын төслөө хэлэлцэж байгаа юм бэ гэдгийг тодруулмаар байна.

Д.Амарбаясгалан:
Б.Баасандорж дарга хариулах уу, яах вэ?

Энэ мэдээж батлагдсан, хэрэгжиж эхлээгүй төсөвт тодотгол хийх гэлээ гээд бас эргэлзээтэй асуулт явж байгаа юм.

Батлагдсан төсөвт Засгийн газар үнэлгээ өгөх хуулийн заалттай байгаа юм.

Тэгэхээр батлагдсан төсөвтөө Засгийн газар үнэлгээ өгнө.

Харин тэр үйл ажиллагаанд нь Төсвийн байнгын хороо хяналт тавьж ажиллах чиг өөрөө энэ тогтоолоороо батлагдаж байгаа юм.

Улсын Их Хурал, Засгийн газрын хувьд хамтарч ажиллаад төсөв боловсруулах асуудал биш.

Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдаад Засгийн газрын батлагдсан төсөвт үнэлгээ өгч байгаа.

Үйл ажиллагаанд нь, үйл ажиллагааных нь хэрэгжилтэд нь хяналт тавьж, юу өгөх зорилготойгоор асуудал шийдэгдээд явж байгаа.

Б.Баасандорж дарга хуулийнх нь тодорхой заалтуудыг уншаад, бас тайлбарлаад өгчих.

Гишүүдийн асууж байгаа их зөв байгаа юм. Энэ заалтууд ямар учиртай юм бэ гэдэг асуудал.

Б.Баасандорж: Улсын Их Хурлын Тамгын газар Б.Баасандорж. Гишүүний асуусан асуултад хариулъя.

Би гишүүдийн саналыг ойлгож байна. Мэдээж гишүүд саналаа гаргаж байна.

Гэхдээ би Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1-д заасны дагуу Та бүхэнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль буюу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг л танилцуулж байгаа.

Яг төсвийн төслийг хэлэлцэхэд 9 дүгээр бүлэг буюу 5 зүйлээр яг тусгайлан нарийвчилж зааж өгсөн байдаг.

Сая О.Номинчимэг гишүүн сая татах тухай асуудал ярьж байна.

Яг энд 9 дүгээр бүлэг дээр хэрвээ Их Хурал баталж чадахгүй бол гэж байна. Тийм ээ. Хэрвээ Их Хурал батлахгүй бол.

11 сарын 15-ны дотор батлах ёстой гэсэн хуулиар үүрэг өгчихсөн байгаа.

Ганцхан төсвийн төсөл гэлтгүй ер нь Их Хуралд батлах хугацаа заасан хэд хэдэн асуудлууд байдаг.

Мөнгөний бодлого, Улсын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл 4 сарын 01-ний дотор, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл 6 дугаар сарын 01-ний дотор гээд энэ хугацаа заасан асуудлууд дээр хууль Засгийн газар татаж авах гэдэг асуудал байхгүй.

Яагаад гэвэл Засгийн газар ч тэр, Их Хурал ч тэр тухайн хугацаандаа өргөн мэдүүлээд, тухайн хугацаанд нь Улсын Их Хурал батлах ёстой.

Дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 3 дээр зөвхөн төсвийн тодотголыг хийвэл энэ 69, 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасан журмыг баримтална гэж байгаа.

Татаж авсан тохиолдолд ямар дэгээр хэлэлцэх вэ гэдэг нь энэ дэг дээр байхгүй байгаа шүү. Гишүүд ээ.

Тэгэхээр яг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дэг нь ийм

байгаа шүү гэдэг хуулийн зохицуулалтыг л Та бүхэнд би танилцуулж байгаа шүү.

Хэрвээ татаж аваад ахиад явах юм бол яг хууль зөрчсөн асуудалд орох байхгүй юу. Их Хурал өөрөө.

Д.Амарбаясгалан:

О.Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Үгүй, би энэ татаж авахтай холбоотой юм асуугаагүй шүү дээ.

Тэрийг түрүүн асуугаад хариултаа авчихсан.

Энэ дээр би энэ тогтоолын төсөл боловсруулж орж ирсэн ажлын хэсэг байдаг юм уу, хэлэлцсэн Байнгын хорооны даргаас асуух гээд байгаа байхгүй юу.

34.1-ийн дагуу тодотгол хийгээд ир гэж байна. 34.1 дээр чинь тоотой хэдхэн, 5 үндэслэл байгаа шүү дээ. Улсын төсөвт тодотгол хийх үндэслэл.

Энэ үндэслэлийн алиныг нь барина гэж бодож байгаа юм бэ? Үүнийгээ та хэд ярилцсан юм уу? Энэ дээр л хариулт авмаар байгаа юм.

Д.Амарбаясгалан:

Боловсруулсан хуулийн ажлын хэсгийнхэн хариулах нь зөв байх.

Б.Баасандорж дарга, 34 дээр 4 үндэслэлээр төсөвт тодотгол хийх зүйл заасан байгаа.

Төсвийн тогтвортой байдлын хуулийн 15.1-ээр бас үндэслэл байгаа. Энэ хоёр дээр тайлбар өгье.

Б.Баасандорж: Тогтоолын төсөл дээр Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг үндэслэсэн байгаа.

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйл маань өөрөө төсвийн тодотгол гэсэн зүйл байгаа. 34.1 маань Засгийн газар дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гээд 4 нөхцөлийг заасан байгаа. Үүнд:

→ *Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүй байх нөхцөл байдал;*

→ *34.1.2 дээр урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас улсын төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэмэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувиар нэмэгдэх;*

→ *Мөн 34.1.3 дээр энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ гээд;*

→ *Мөн төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх гээд.*

Энэ тохиолдлуудад Улсын Их Хурал батлагдсан төсөвтөө тодотгол хийгээрэй гэдэг Их Хурлын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан:

Б.Баасандорж даргад нэмж минут өгье.

Б.Баасандорж: Яг одоо 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнд бий болсон Улсын Их Хурал маань бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа.

Өмнөх 8 удаагийн сонгуулийн үр дүнд бий болсон Улсын Их Хурлын түвшинд энэ асуудлууд гарч байсан уу гэвэл гарч байсан.

Яг баталсан төсөвтөө хугацаатай үүрэг өгөөд тодотголын асуудлыг оруулж ирээрэй гэдэг чиглэлийг Засгийн газарт өгч байсан.

Жишээ нь, 2013 оны 11 сарын 15-ны өдөр төсвөө баталчхаад тухайн үеийн Их Хурлаас Монгол Улсын Засгийн газарт 2014 оны 4 дүгээр сарын 01-ний дотор өргөн мэдүүлээрэй гэдэг үүргийг өгч байсан.

Мөн 2014 оны Их Хурал маань төсвөө баталчхаад мөн 2015 оныхоо төсвийн төсөлд тодотгол хийгээд оруулж ирээрэй гэж үүрэг өгөөд тухайн жилийнх нь 12 сарын 30-нд өргөн мэдүүлж байсан ийм хоёр процессууд бол байгаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа.

Тэгэхээр өнөөдөр төсвийн хүрээ ярьснаас эхлээд л нэг тодотголын тухай л яригдаад байгаа. Дагалдаад л.

Миний хувьд яагаад төсөв тодотгох гээд байгааг үндсэндээ ойлгож чадсангүй. Энэ бодвол нөгөө шинэ, хуучин гишүүдийн ялгаатай холбоотой юм байгаа биз.

Тэгэхээр энэ одоо их данхар том төсөв болсон гээд тодотгол хийх гээд байгаа юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Засгийн газар энэ төсвийнхөө төсөл дотор хаа нэг газар нь ямар нэгэн юм нууж орж ирчхээд тэр нь одоо ил гараад, тэгээд тэрийг нь одоо тодотгож ил тод хуваах гээд байгаа юм уу?

Гуравдугаарт, ер нь Улсын Их Хурлын цөөн гишүүдийн эрх ашиг хөндөгдсөнөөс болоод тодотгол хийх гээд байгаа юм уу гэсэн ийм гурван асуулт надад үүсээд байгаа юм.

Үнэхээр төсөв данхар болоод тодотгож байна гэвэл би энэ дээр санал нэгдэхгүй байгаа.

Яагаад гэвэл улсын төсөв чинь улс орныхоо хөгжлийг дагаад, дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ өсөлтийг баримжаалаад төсөв дандаа л нэмэгдэж байж ёстой.

Ер нь энэ бол Б.Жавхлан сайдын ярьдгаар хуулиар нэмэх ёстой нэмэлтүүд энэ тэр гээд нэмэгдээд явж байх ёстой.

Тэгэхээр төсөв жилээс жилд нэмэгдээд явах нь ойлгомжтой асуудал байдаг.

Гэтэл Засгийн газар ямар нэг юм хаа нэг газар нуучхаад ороод ирсэн гэвэл энэ чинь одоо манай гишүүдийн яриад байгаа төсвийн хулгайтай холбогдох асуудал болно.

Тэгэхээр үүнийг тодруулах ёстой. Засгийн газар эндээ ийм мөнгө хийчхээд ашиглах гээд байна.

Тэгэхээр Их Хурал энэ мөнгийг нь гаргаж байгаад нийт ард түмнийхээ эрх ашгийн төлөө дахин хуваарилалт хийх ёстой юм гэж хэлбэл төсвийн тодотгол хийхэд их бодитой үндэслэл болж болохоор байгаа юм.

Зүгээр ер нь Их Хурлынхаа танхимд нуугаад яах вэ. Төсвийн хэлэлцүүлгийн дундуур гэнэтхэн аймгуудад тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хуваах тухай яригдсан.

Хоёр намын бүлэг л лав ярьсан. Энэ асуудлыг. Тэгээд аймгуудад ингээд хуваах тухай яригдаад ирэхээр одоо нөгөө ард түмний тархи толгойд маш тодоор бичигдээд үлдчихсэн. Их Хурлын гишүүний мөнгө гэдэг юм нь дахиад л асаад эхэлдэг.

Тийм учраас одоо жишээлбэл манай намын бүлэг ярьж байгаад одоо үүнийг больчихъё. Энэ дахин хуваарилалтыг больё гээд. Тойргийн гишүүд нэлээн хэсэг нь энэ дээр гомдсон. Яагаад гомдож байгаа нь ойлгомжтой.

Тэгэхдээ зөв шийдвэр гаргасан.

Тэгээд үүнийг хараад хаана нэг газар нь ямар нэгэн байдлаар дахин хуваарилах мөнгө байдаг юм байна л гэсэн ойлголтыг над мэтийн гишүүдэд төрүүлээд байгаа юм.

Тийм учраас яагаад тодотгол хийх болов гэдгээ надад хэн нэг нь тайлбарлаад өгвөл их сайн байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэлчихлээ. Тийм ээ.

Буланы Бейсен гишүүн асуулт асууна, үг хэлнэ.

Б.Бейсен: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбоотой хэд хэдэн асуулт, саналаа хэлье гэж бодож байна.

Ялангуяа хөдөөгөөс тойргоос сонгогдсон гишүүд ер нь энэ жил бүсчилсэн хөгжилтэй холбоотой, нөгөө талаар үйлдвэржилттэй холбоотой тойргийн гишүүдийн саналыг тавиулж чадсангүй. Яагаад гэвэл үйлдвэржилт явсантай холбоотой бас чимээгүй байлаа.

Гэхдээ төсвийн тодотголд гарцаагүй оруулах асуудлууд байж байгаа.

Ялангуяа эрүүл мэндийн салбар, боловсролын салбар дээр асуудал байгаа.

Засгийн газрын гишүүд салбарын сайдуудын төсөв хангалттай хэмжээгээр тавигдсан.

Эрүүл мэндийн салбарын хувьд бид ярьж байдаг. Эмийн үнэ буугаагүй байгаа. Сум, багийн түвшинд эмийн сангийн хангалтын асуудлыг Эрүүл мэндийн сайд багтааж зохион байгуулалтын асуудлыг шийдэх үү? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, эрүүл мэндийн байгууллагын бүтэц, стандарт гээд хуучин 1976 онд хэрэглэж байсан. Дараа нь 2012 оны сүүл, 2013 онд бас батлагдсан.

Одоо үүнийг шинэчлэхгүйгээр энэ төсвийн зарцуулалт чинь үрэн таран явна. Илүү орон тоо байгаа.

Тэгэхээр энэ зохицуулалтын бүтэц, орон тоог анагаахын шинжлэх ухааны эрүүл мэндийн зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэндийн тэнхимтэй хамтарч байж, яамных нь хамтарч байж энэ бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлахгүйгээр явал бас л энэ төсөв чинь үрэн таран хийгдэнэ. Үүнийг батлах уу гэдэг асуудал байна. Энэ ажлын хэсэг гаргаад ажиллуулах уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, боловсролын салбарын сайд дээр асуух асуулт байна. Та 5 минут хүлээж байхгүй юу.

Боловсролын хувьд энэ төсөв чинь зарим газар багш нарын 5 жилийн тэтгэмжийг олгохгүй, айлын хаус түрээслээд цэцэрлэг байгуулсан асуудлууд байж байгаа. Цалингийн доод хэмжээгээр цалинжуулаад. Спорт заал ч түрээсэлсэн. Сонгуултай холбоотой асуудлууд байж байгаа.

Үүнийгээ цэгцлэхгүй бол энэ төсөв чинь хүрэхгүй. Төсвийн тодотголд эд нарын зардал хүрээд ирнэ шүү. Аягүй бол хүүхдүүд нь 2 цэцэрлэгт давхар бүртгэлтэй ийм юм явж байгаа.

Тэгэхээр Төрийн хяналт шалгалтын тухай хууль дээр бас хяналт шалгалтыг нь энд анхаараад хяналт шалгалт хийхгүй бол дээд шат нь яах вэ байж байдаг, доод шат нь хяналт шалгалт маш сул байгаа шүү.

Тэгэхээр салбарын сайдууд маань Хяналт шалгалтын сайд нар хамтраад хяналтаа сайжруулахгүй бол төсвийн сахилга бат маш их алдагдаж байгаа гэдгийг хэлье. Саяын хоёр асуултад хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Энэ нөгөө хэлэлцэж байгаа асуудлаас гадуур асуулт асуучхаад хариулах хүн ерөнхийдөө байхгүй байдаг.

П.Наранбаяр сайд хариульа гэж байна.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээр ер нь энэ төрийн үр ашиггүй зардлыг бууруулах дээр би дэмжиж байгаа. Энэ бол зайлшгүй хэрэгтэй зүйл.

Гэхдээ боловсрол, эрүүл мэнд гэсэн энэ салбар чинь төрийн үзүүлэх ёстой үндсэн үйлчилгээ ийм байгаа.

Зүгээр одоо ингээд манай зардлыг харах юм бол ирэх жил гэхэд л 2300 гаруй хүн тэтгэвэртээ сууна. Тэнд олгох тэтгэмжүүд 5 жилийн. Тэрний дараах 3 жилийн тэтгэмжүүд.

Одоо ингээд ийм зүйлүүд байгаад байгаа.

Тэгэхээр урсгал зардал дотор байгаа зардлыг хасах ямар ч боломж байхгүй.

Таны хэлээд байгаа цэцэрлэгт давхцуулж явуулж байгаа бүртгэл юмыг бид нийслэлийн хүрээнд шууд “real time”-аар харж байна шүү дээ. Шууд.

Хөдөө орон нутагт сар сардаа ирцийг нь аваад харж байгаа.

Тэгэхээр энэ ажлаа бид цаашдаа нарийвчилж явна.

- ▶ Хүүхдийн хоолны зардлыг нэмж байгаа,
- ▶ түүхий эдийнх нь зардлыг нэмж байгаа,

▶ дотуур байрны үйлчилгээг сайжруулж, тэнд зардлыг нь нэмж байгаа.

Энэ болгон дээр бид энэ хяналт шалгалтыг давхар хамтад нь явуулна.

Тэгээд манай дээр “дотоодын томилолтын зардал” байгаа. Энэ чинь тэр хяналт шалгалтад зориулсан зардлууд байгаа.

КОВИД-оос болоод тэр үед хэмнэлтийн хуулиараа тавигдахгүй байсан зүйлүүд тавигдаж, орон нутагтаа очиж ажиллах зардал юмнууд ороод ирж байгаа.

Тэгэхээр би Баян-Өлгий аймагтай ч гэсэн хамтран ажиллахад бэлэн байна.

Энэ дээр нэлээн сайн хянаж, үүнийг нэлээн сайн харахгүй бол бас тэнд хуулийг зөрчиж байгаа, завхруулж байгаа, тэнд зөрчиж байгаа зөрчлүүд байгааг ойлгож байгаа.

Тэгээд эрхэм гишүүн тантай хамтарч ажиллаад явна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Б.Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Эрүүл мэндийн сайдаас төсвийн төсөөллийн тухай хууль батлагдсантай холбогдуулаад сум, багийн эмийн сангийн асуудал дээр төсөвтөө багтааж юм явуулах уу?

Тэгэхгүй бол урсгал маягаар бас л сум, багийн түвшинд хөнгөлөлттэй эм, бусад эмүүдээ авч чадахгүй асуудал гарах гээд байна.

Таны төсөв дээр багтах юм уу? Багтахгүй бол тэгээд төсвийн тодотгол 12 сард оруулах юм уу гээд асуусан л даа.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу? Т.Мөнхсайхан сайд.

Т.Мөнхсайхан: Ер нь энэ удаагийн төсөвт хөнгөлөлттэй эм дээр нэлээн төсөв мөнгө нэмэгдэж 197 тэрбум төгрөгөөр тусгагдсан байгаа.

Сум, багийн түвшинд хөнгөлөлттэй эм оччихгүй байгаа, олгогдохгүй байгаа, хүртээмж муу байгаагийн шалтгаан гол нь эмийн сангийнх нь асуудал байгаа юм.

Бид эргэлттэй эмийн сан гээд яг нэг хувийн ч биш, улсын ч биш нэг ийм эмийн сангууд. Яг төрийнхөөрөө явах юм уу, хувийнхаараа явах юм уу гэдэг нь тодорхойгүйгээс болоод багийн түвшинд, сумын түвшинд очих эм хангамжууд жоохон тааруу байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бид ер нь энэ чанартай эмийг хямд үнээр улсын хэмжээнд нийлүүлэх бодлогынхоо хүрээнд цаашид зөвхөн Улаанбаатарт биш, бүх сум, багийн түвшинд жигдхэн, ижил чанартай эмийг Улаанбаатарын түвшинд нэг үнээр нийлүүлэх бодлого, үйл ажиллагааг хийж хэрэгжүүлж байгаа юм.

Тэгээд үүнийгээ цаашид нь 100 хувь хэрэгжүүлээд иргэддээ хөнгөлөлттэй эмийг хүргэх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Үүнийг би дэмжиж байна.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын хэлбэрээр төсвөө дахиад ярилцъя л гэж арга зам хайж байна шүү дээ. Дахиад нэг ил тод ярилцъя хэдүүлээ.

Ингэхээр би гурван зүйл би хэлэх гэсэн юм.

Нэгдүгээрт, хэлэлцэх эсэх үед нэгдүгээр хэлэлцүүлэг дээр л гишүүд маань их сайн анхаарч, асуудлуудаа илэн далангүй, одоо хамаг юмыг нь, бөөс хуурсыг нь түүж ярьж байхгүй бол.

Би ч гэсэндээ эхний нэг жил гишүүн болчихоод ер нь хоёр, гуравдугаар хэлэлцүүлгийн үед л юм хэлмээр санагдаад л нэг хагас дутуу ойлгоод л яриад эхэлмээр санагддаг байсан.

Одоо яалт ч үгүй хуультай юм хойно хэлэлцэх эсэх, нэгдүгээр хэлэлцүүлэг дээр их ач холбогдол өгч баймаар байна.

Хоёрдугаарт, мэргэжлийн хөндлөнгийн дүгнэлт гаргадаг байгууллагууд болох Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, аудитын дүгнэлтүүд дээр маш сайн зүйлүүд гардаг юм шүү.

Одоо яриад байгаа зарлага их байна, зардал чинь бүр арай дэндчихлээ.

Ер нь нэг улсаас, нэг бүтээгдэхүүнээс хэт хамааралтай байна. Бүр гарц гаргалгаатай нь ярьсан зүйлүүд байгаа.

Н.Энхбаяр эдийн засагчийн ахлуулсан тэр зөвлөлийн дүгнэлтүүдийг маш сайн авч үзэж ярьж байхгүй бол

зүгээр л нэг цээжний пангаар 126-д цуглачхаад яриад байвал бас хол явахгүй гэсэн саналыг би гаргаад, “бушуу туулай борвиндоо баастай” гэдэг шиг одоо хэлэлцэхээс өөр аргагүй байдалд нэгэнт орчихсон байгаа энэ цаг үед миний асуух ганцхан асуулт гэвэл, Засгийн газрын сайд нар энд байна.

Та нар яг энэ төсвийн хэлэлцүүлгийн үед ард иргэдтэй, тэр холбогдох байгууллагуудтай нь зөвлөлдөж, зөвшилцөж орж ирэх ёстой ажлаа битгий гурилдаач. Яагаад гурилдсан юм бэ?

Миний хэлэлцэх эсэх үед асууж байсан нэг асуулт байгаа шүү. Ард иргэдээс болон тухайн нийгмийн зөвшилцлийн байгууллагуудаас асуусан нэг ч санал ирээгүй гэсэн хариултаар орж ирсэн шүү.

Би яг хэлэлцэх эсэх үедээ асууж байсан. Яагаад нэг ч санал ард иргэдээс төсөв дээр чинь байдаггүй юм бэ?

Тэгэхээр миний бодлоор ард иргэд болон тэр тухайн байгууллагуудад бурууг өгсөнгүй. Зүгээр зөвшилцсөн нэртэй тас хаятал хаалгаа хаачхаад л давхиж орж ирдэг юм байна л гэж ойлгож байна.

Өнөөдөр миний асуух гээд байгаа зүйл гэвэл Засгийн газрын холбогдох яамдууд надад хариулаач.

Та нар зөвшилцөх, манай Засаг дарга нар, Улсын Их Хурал, ер нь дарга нар мөнгөний тухай ард түмэнтэйгээ зөвшилцөж хэлэлцэх их дургүй л дээ.

Ялангуяа мөнгө өгсөн, татвар төлсөн хүмүүстэйгээ мөнгөнийх нь тухай

би яаж зарцуулах вэ гэдгээ ярилцахдаа үгүй мөн хойрго шүү. Өөрийнх нь мөнгө юм шиг л зүгээр чин сэтгэлээсээ итгээд л давхчих гээд байдаг.

Тэгэхээр энэ механизмдаа өөрчлөлт оруулах боломж байна уу? Би бүр нарийвчилж асууж байсан. Татвар төлөгч, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн холбоо, үйлдвэрчний байгууллагуудаасаа, татвар төлөгчдийн тэр мэргэжлийн байгууллагуудаасаа санал, зөвлөмжийг нь асуусан уу?

Огт байхгүй гэж та нар ярилаа. Тэгээд албан бичгээр та нарт тэд нар өгсөн үү гэж би асууж байсан.

Тэгэхээр татвар төлөгчдийн мөнгийг тэдэнтэй ярилцаж яаж зарцуулах вэ гэдэг саналыг нь авдаг механизмдаа өөрчлөлт оруулах уу, эсвэл одоо байгаа механизм нь хангалттай гэж үзэж байна уу гэдэг асуултыг яамдынхаа сайд нараасаа би асууж байгаа юм.

Засгийн газар, Улсын Их Хурал ард түмнээсээ хэт тасарчхаад байна.

Монголын ард түмэн Улсын Их Хурлын гишүүдийг сонгосон. Тэгэхдээ сайд нарыг сонгоогүй шүү. Сайд нарыг бид сонгосон.

Тэгэхээр Улсын Их Хурал дээр сайд нар, Засгийн газар энэ бэлтгэл ажлаа хангалттай оруулж ирээгүйгээс болж.

Төсвийн байнгын хороонд би буруу өгмөөргүй байна. Тэр ажлын хэсэгт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: С.Ганбаатар гишүүнтэй санал нэг байна.

Одоо бид ажлын хэсгээ байгуулаад төсөв хэлэлцэхтэй холбоотой бүх хуулиудыг л нэг эмхэлж цэгцэлье гэдэг дээр явж байгаа шүү дээ.

Одоо үүнийг нэг сайхан цэгцлэхгүй бол бас л янз янзын асуудлууд байгаа. Аль аль тал дээрээ, хаанаа учир дутагдлууд гараад байна вэ гэдгийг нь нэг сайн тодруулах. Тэгээд эмх цэгцэд нь оруулах ийм шаардлага байгаа.

Үүнийг энэ ондоо багтаж бид хийж чадна гэж харж байгаа.

Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу?

Ямартай ч цаг хугацааны хувьд хожимдсон байж магадгүй ч Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүд санаачилгыг гартаа аваад Засгийн газраас оруулж ирсэн төсөв дээр гишүүдийн бөгөөд иргэдийн хэлж байсан санал, шүүмжлэлүүдийг хүлээж авах байдлаар төсвөө батлахын зэрэгцээ ийм тогтоол оруулж ирж байгаад баяртай байна.

Угаасаа хэлэлцүүлэг бол хэзээ ч оройтдоггүй. Тэгээд ийм алдаа мадагуудаа залруулаад явах боломж хэзээд байдаг.

Тэгэхээр тогтоолын төсөлтэй холбоотой хэд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, энэхүү тогтоолоор Засгийн газарт албан даалгавар өгч байна гэж ойлгож байна.

Одоо ингээд 12 сардаа багтаагаад төсвөө тодотгоод оруулаад ир гээд.

Тэгэнгүүт 1.3 дээр болохоор төсвийн тодотголын төслийг “төрийн мөнгөний бодлогод нийцүүлэн төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөлтийг сайжруулах” гэсэн байдлаар томьёолсон байна л даа.

Энэ дээр илүү тодорхой мөнгөн дүн тавьдаг ч юм уу, эсвэл хувь хэмжээ тавьдаг ч юм уу, тийм байдлаар албан даалгавраа боловсруулах боломж байгаагүй юу?

Тэгэх юм бол Засгийн газарт ч гэсэн илүү ойлгомжтой, гишүүдийн хүсэл зориг, тэр санал санаачилгууд ч гэсэн илүү ойлгомжтой байдлаар тусах байгаагүй юу гэдэг ийм нэгдүгээр асуудал байна.

Хоёрдугаар асуудлын хувьд 12 сарын 05-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд орон нутгийн төсвөө хэлэлцэн батална.

Тэгэхээр энэ тодотгол чинь орон нутгийн төсвүүдэд хэрхэн яаж нөлөөлөх вэ гэдэг бас нэг асуулт байна.

Тэгээд эцэст нь нэг санал хэлэхэд, ерөнхийдөө Засгийн газрын гишүүд маань төсвийн тодотголоо боловсруулахдаа сая энэ хэлэлцүүлгийн үеэр нэгдүгээр хэлэлцүүлэг, хоёрдугаар хэлэлцүүлэг, гуравдугаар хэлэлцүүлэг дээр гишүүдийн чуулганы танхимд болон Байнгын хороон дээр гаргаж байсан санал санаачилгуудыг бас эргэж хараад, тэгээд анхнаасаа нэг тийм ул суурьтай байдлаар баримт бичгээ боловсруулаад оруулаад ирвэл хаана хаанаа хэрэгтэй байна гэдгийг дахин сануулья.

Д.Амарбаясгалан: Б.Жавхлан сайд аа, орон нутгийн хурлууд төсөв батлахтай холбоотой асуултад хариулчих уу?

Одоо төсвийн тодотгол хийхэд орон нутгийн хурлууд 12 сарын 05-нд багтаад төсвөө баталчхаар ямар нөхцөл үүсэх вэ гэж асууж байна. Нөлөөлөл.

Б.Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмэлт мэдээлэл гэх үү дээ.

Дагаад л тодотгол хүснэ л дээ. Тийм.

Д.Амарбаясгалан: Б.Жаргалан гишүүний тэр 1.3 дээр тодорхой тоо зааж болох уу гэж асуулаа. Хэн хариулах вэ?

Энэ бол одоо батлагдсан төсвөөс тэдэн төгрөгийг хас, тэдэн төгрөгийг тана гэдэг тогтоол гаргах нь хуулийн зөрчилтэй асуудал үүсэх учраас энэ дээр тоо оруулах боломжгүйгээр хоёр зүйл дээр үндэслэл болгож байна.

Нэгдүгээрт, төсвийн тодотгол хийх үндсэн шалтгаануудаас аль нэг нь үүсэх.

Хоёр дахь нь, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу батлагдсан төсөвт Засгийн газар өөрөө үнэлгээ хийх хуулийн заалттай.

Тэгэхээр үнэлгээг хийгээд, гишүүдээс шаардсан шаардлагыг хэрэгжүүлэх, харгалзан үзэх.

Сая Б.Жаргалан гишүүнтэй санал нэг байгаа зүйл нь мэдээж олон нийтийн

зүгээс, гишүүдийн зүгээс асуудал хөндөж ярьж байгааг ойлгож байна.

Үүнийг засаж залруулъя. Урагшаагаа алдаа дутагдал багатай явъя гэдэг л сонголт шүү дээ.

Гэхдээ нөгөө талдаа нэг зүйлийг маш сайн ойлгох ёстой. Гишүүд маань.

Төсвийн хэлэлцүүлэг дээр нэг дэх хэлэлцүүлэг, хоёр дахь хэлэлцүүлэг өнгөрсний дараа асуудал босож ирж байгаа юм.

Хуулиараа боломжгүй цаг үе дээр.

Гэхдээ гишүүдийнхээ саналыг хүндэтгээд өнөөдөр ийм процессыг бид гаргаж явж байна шүү дээ.

Өөр хуулийн төслүүд дээр байнга ингээд байх боломж байхгүй гэдгийг гишүүд маш сайн анхаарах ёстой.

Асуудал болгон дээр хэлэлцээд шийдчихсэнийх нь дараа хэдэн гишүүн нийлж гарын үсэг зураад шахаад, шаардаад явчхаж болох юм байна гэдэг ойлголт байхгүй гэдгийг би бүр албан ёсоор хэлье.

Яагаад вэ гэхээр төсөв өөрөө хугацаатай учраас энэ асуудал дээр бид олон талын ач холбогдлыг өгч, анхаарал тавьж ажиллаж байгаа юм.

Бусад хуулиуд дээр тэнд нөхцөл байдлыг энэ хэмжээнд харгалзан үзэх боломжгүй.

Тэгэхээр гишүүд энэ дээр анхаарч хандах ёстой гэж хэлье.

Б.Жавхлан сайд нэмж хариулъя гэсэн үү? Нэмж хариулъя.

Б.Жавхлан: Яах вэ, микрофон олдсон дээр хэлэхэд.

Энэ дээр тэр 3 дугаар заалт дээр мөнгөний бодлоготой нийцүүлж гэсэн байгаа. Үүнийг сайн бодох хэрэгтэй шүү.

Мөнгөний бодлоготой нийцэж төсөв явах уу, төсөв, мөнгөний бодлоготой нийцэх үү, эсвэл хоёулаа улсынхаа хөгжлийг дэмжээд том зургаар нь явах уу гээд.

Уг нь гурав дахь нь л байгаа юм.

Тийм ч учраас ер нь 34 жилийн хугацаанд “мөнгөний бодлого”, “төсөв” хоёр зэрэг нэг өдөр Улсын Их Хуралд өргөн барьж ирсэн. 10 сарын 01-нд.

Энэ жилээс нэг сарын урд, хойно орчхож байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ жилээс мөнгөний бодлого нь ард нь өргөн баригдаад, өмнө нь батлагддаг ийм болчхож байгаа юм.

Тэгэхээр энэ бас нэг жоохон зөрөөд, дараа нь дахиад нэг ийм тойрог үүсчих вий.

Тийм учраас үүнийг хэдүүлээ эргэж хармаар юм байна.

Хоёуланг нь 9 сарын 01-нд үү, эсвэл хоёуланг нь 10 сарын 01-нд юм уу.

Аль нь ч байсан ер нь цуг өргөн баригдах ёстой юм байна.

Тэгээд үүнийг гишүүд маань их сайн хараасай гэж бодож байна. Бид дараа дараагийн олон хэлэлцүүлгүүд явах учраас. Тийм. Тэрийг хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Одоо нэг гишүүн асуулт асууж, үг хэлээд санал хураалт явагдана.

Улсын Их Хурал улсын төсөв батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төсөл хэлэлцэгдэж байгаа. Батлагдах тогтоол явж байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй байх.

Ингээд Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Баярлалаа.

Сая Д.Амарбаясгалан даргын үгээс уг нь их тодорхой мессежүүдийг гишүүд ойлгоод авчих хэрэгтэй байгаа юм.

Ийм нөхцөл байдлуудыг яг бүрдүүлсэн гэвэл хаа хаанаасаа байгаа шүү гэдэг зүйлийг би хэлмээр байгаа юм. Гишүүд бидэнд ч байгаа.

Ер нь төсвийн тодорхой зардлуудыг танах асуудлыг зарчмын хувьд дэмжиж болно.

Тэгэхдээ уг асуудлуудыг Засгийн газарт чиглэл өгөх байдлаар хууль зөрчсөн тогтоол гаргаж хийлгэж болохгүй.

Б.Жавхлан сайд хариулах ёстой шүү дээ.

“Төсвийн тодотголыг хийх ийм дэгтэй байдаг юм” гээд хариулах байтал

“орон нутгийн төсөв яах вэ гэхээр дагаад тодотгоно” гэж байна.

Тэгэхээр ийм зүйл байхгүй.

Засгийн газар хуулиа зөрчиж тодотголыг 12 сард өргөн барина гэсэн зүйл байхгүй.

Ийм зүйл байх юм бол бид зүгээр нэг хэдэн хүмүүс төсвийн хэлэлцүүлгээр зохих ёстой, гарах тэр хэсэг дээр нь саналаа гаргаагүйн төлөө.

Ийм зүйлүүдийг эвлүүлэх гэж байна гээд л ийм жишиг тогтох юм бол энэ чинь болохгүй. Би энэ зүйлүүдийг хэлмээр байна.

Энэ төсвийн ажлын хэсэг чинь 25 хүнтэй, 70 хоног ажилласан шүү.

Дээрээс нь ажлын хэсэг ерөөсөө 10-хан санал оруулж ирсэн. Гишүүд 42 санал оруулж ирснээс 9 нь татагдсан байна лээ.

Хэн нь илүү их ажилласан байна гэж бодох хэрэгтэй.

Гишүүдийн гаргаж байсан саналууд томьёоллын хувьд алдаатай томьёоллуудаас болж маш олон асуудлууд үүсгэсэн.

Үүнийг гишүүд бид өөрсдөө бодох ёстой. Ийм зүйлүүдээсээ болж байгаа шүү.

Жишээ нь, би Ч.Номин сайдыг баалаад байгаа тэр Соёлын бүтээлч үйл ажиллагааны хуулийн 18.3 тэрбумыг.

Үнэхээр тэрийг хасья гэж байгаа бол Соёлын бүтээлч үйл ажиллагааны

тухай хуулийн 8.2, 8.3-ыг бас хасъя гэж саналаа оруулж ирэх ёстой шүү дээ. Баталчихсан хууль байгаа шүү дээ.

Тэгчхээд дутуу дулимаг дандаа улс төрийн өнцгөөс ийм өнгө аястай юмнууд ярьдаг.

Тэгээд эцэст нь цөөн хэдэн хүний эрх ашгийг гэдэг юм уу, нэг улс төр хийж байгаа өнцгийг нь дэмжиж төсвийг тодотгоно гээд Улсын Их Хурал нь хууль зөрчсөн, Засгийн газартаа чиглэл өгсөн тогтоол батлах гээд сууж байгаа нь харамсалтай байна.

Ийм зүйл байж болохгүй ээ.

Тэгэхээр гишүүд маань өөр өөрсдийнхөөрөө саналаа өгөх байх.

Хоёрдугаарт, гишүүдэд болон олон нийтэд төсвийн талаарх мэдээлэл өгөх арга хэлбэрээ бодъё.

Г.Тэмүүлэн дарга яг энэ дээр нэлээн ахиц авчирна гээд ийм хуулийг хавар батлуулсан гэж үзэж байсан.

Анх удаа төсвийг 9 сард барилаа. Үүнээс хойш олон нийт болон гишүүдэд яаж мэдээллээр хангагдаж ажилласан юм бэ гэдэг нь ерөөсөө ойлгомжгүй.

Тэгээд ерөнхийдөө том зургаараа Төсвийн байнгын хорооны даргаар ахлуулсан 25 хүн ажилласан мөртлөө ажлын хэсэг нь хуралдаж чадаагүй.

Байнгын хорооны дарга нь бяслагийн үйлдвэрээсээ болоод бусад бүх асуудлуудыг нь авч хэлэлцээгүй. Ийм байж болох юм уу.

энэ Байнгын хорооны дарга, бусад тэр.

Өнөөдөр тэр улс төр хийгээд байгаа гишүүд чинь бүгд ажлын хэсэг дотор байна лээ шүү.

П.Батчимэг гишүүн,
Ш.Бямбасүрэн гишүүн, өөр хэн хэн гишүүд байлаа.

Бүгд энэ төсвийн ажлын хэсэгт орж ажилласан мөртлөө дараа нь араас нь эргэж улс төрийн өнгө аястай юм хийдгээ одоо боль.

Тэгээд бяслагийн үйлдвэрээс болж өнөөдрийн төсөв ийм боллоо гэдгээ хэдүүлээ хүлээн зөвшөөрье.

Тэр хариуцлага хүлээх ёстой хүн нь хүлээх ёстой шүү. Энэ тогтоолыг баталж болохгүй.

Ингэж хууль зөрчсөн тогтоолыг батлах юм бол Улсын Их Хурал байгаад яах юм. Олонх гэж байгаад яах юм. Олонхоороо асуудлаа шийдээд явах ёстой.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Үг хэллээ. Асуулт үг хоёр хамт явж байгаа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Байнгын хороо “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Тоолоорой. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. 3, 4 гишүүн дэмжээгүй байна.

5 гишүүн дэмжээгүй байна.

Танхимд 106 гишүүнээс 70 гишүүн байна.

5 гишүүн дэмжээгүй буюу 65 гишүүний саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Дэмжээгүй гишүүд гараа өргөхийг хүсье. 1, 2, 3, 4 гишүүн дэмжээгүй байна.

Нийт 70 гишүүн дэмжсэн.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүддээ талархаж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд зааснаар улсын төсөв батлах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх бөгөөд Улсын Их

Хурал төсвийг хэлэлцэх эрх, мөн үүрэгтэй.

Энэ чиг үүргийнхээ хүрээнд бид өнөөдөр Монгол Улсын 2025 оны төсвийг баталлаа.

Бид төсвийн төслийг ямар хугацаанд яаж хэлэлцэх вэ гэдэг нарийвчилсан дэгтэй. Төсөв хэлэлцэх ажиллагаа бусад хуулийн төслийг хэлэлцэх үе шатаас өөр байдаг.

Энэхүү төсвийн төслийг хэлэлцэхэд үүнийг иргэд маань анзаарч харсан байх.

Харин Улсын Их Хурлын гишүүд хуульд заасан энэ дэгээ баримтлах үүрэгтэй.

Улсын Их Хурлын гишүүдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг ямагт хүндэтгэнэ.

Гэхдээ гишүүд хуульд заасны дагуу хэлэлцэх дэг гаргасан саналыг нь шийдвэрлэх хууль эрх зүйн боломжийг зөв үнэлж тунгааж, иргэд олон нийтийг бодитой мэдээллээр хангаж байх хэрэгтэй.

Ер нь парламент олон ургалч үзлийн талбар байх ёстой. Үүнийг миний бие тууштай дэмжиж, баримталж ажиллана.

Парламентын энэ индэрт санал бодлоо хэлж байгаа Улсын Их Хурлын гишүүд болон асуултад хариулж байгаа сайд, мэргэжилтнүүд аль ч бай Монгол Улсын Үндсэн хуулийг санан сахиж байх үүрэгтэйг хэлье.

Үндсэн хуульд хүнийг нас хүйс, эрхэлсэн шинэ, хуучин ажлаар нь ялгаварлан гадуурхаж үл болно гэж заасан байдаг.

Иймд бид бусдад хүндэтгэлтэй хандах, өөр үзэл бодолд хүлээцтэй байхад хаа хаанаа анхаарах нь зүйтэй юм.

Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурлын үндсэн зорилт нь ард түмний төлөөллийн дээд байгууллагын хувьд ард түмний засаглах эрхийг хангахад оршдог.

Тиймээс нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн, асуудлыг олон ургалч үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчим чухал байдаг.

Тиймээс Улсын Их Хурал өнөөдөр 2025 оны төсвийн хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолыг мөн баталлаа.

Өнөөдрийн хүргэсэн үр дүнг бэхжүүлэх, эдийн засгийн өсөлт, сэргэлтийг хадгалж, цаашид тогтвортой авч явах нь Улсын Их Хурлын гишүүн бүрийн чин эрмэлзэл байгаа гэдэгт огт эргэлзэхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс 2025 оны төсвийн төслийг олон талаас нь шүүн хэлэлцэж, Засгийн газраас дэвшүүлсэн арга хэмжээнүүдийн эрэмбэ, дэс дарааллын нягтлах талаар олон санал шаардлага гарлаа.

Иймд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг үндэслэн энэхүү батлагдсан 2025 оны төсвийг макро эдийн засгийн төлөв байдал болон төсвийн тусгай шаардлагыг баримтлахад нөлөөлөх нөлөөллийн талаар үнэлгээ

хийж, үр дүнг танилцуулахыг Засгийн газарт даалгаж байгаа юм.

Түүнчлэн хэлэлцүүлгийн явцад хөндөгдсөн олон асуудлуудыг Засгийн газраас дахин нягталж, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэх асуудлыг үүрэг болгож тогтоол батлагдсан.

Татвар төлөгчдийн мөнгийг үр ашигтай хэмнэлттэйгээр захиран зарцуулахын тулд төсвийн төлөвлөлтийг сайжруулж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг зөв үнэлж, эдийн засгийн бодлого хоорондын нийцлийг зөв хангаж ажиллах дээр Засгийн газар анхаарах ёстой.

Эдийн засгийн энэ эрчимтэй тэлэлтийг зөв зохистой удирдахын тулд Засгийн газар, Монголбанк төрийн бусад байгууллагуудын ажлын уялдаа холбоо, зохицуулалт нягт байж үр дүнд хүрнэ.

Төсөв хэлэлцэж эхлэхтэй холбоотойгоор үүссэн олон асуудлууд хуулиуд хоорондын нийцлээс шалтгаалж байгааг Та бүхэн анзаарч байгаа байх.

Төсвийн гүйцэтгэл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг боловсруулах, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлагдах хүртэлх энэ шат дарааллын цаглаврыг жигдрүүлж, ойлгомжтой болгох асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газар, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хамтран ажиллах болно.

Дахин хэлэхэд Улсын Их Хурал бол асуудлыг олон ургалч үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэх зарчмыг баримталж ажиллах ёстой.

Энэ зарчмыг баримталж бид өнөөдөр 2025 оны төсвийн хуулийг хэлэлцэн хуульд заасан хугацаанд нь баталж чадлаа.

Уг асуудлаар ажил хэрэгчээр хандсан нийт Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд, ажлын хэсгийн гишүүддээ талархал дэвшүүлье.

Та бүхэндээ ажлын амжилт хүсье.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Даргын зөвлөлийн хурал болно.

Хуралдаан 6 цаг 18 минут үргэлжилж, 16 цаг 23 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД